



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГААНЫ ТӨВ



МОНГОЛ УЛС ДАХЬ 2012 ОНЫ ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаанбаатар хот 2013 он



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГААНЫ ТӨВ



Албан хэрэгцээнд зориулав.

МОНГОЛ УЛС ДАХЬ 2012 ОНЫ ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаанбаатар хот 2013 он

Г А Р Ч И Г

ӨМНӨХ ҮГ

НЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ 2012 ОНЫ ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- §1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал
- §2. Захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлт, эрүүлжүүлэх үйл ажиллагааны мэдээлэл
- §3. Нийслэл, дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал
- §4. Аймгуудын эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал
- §5. Зарим төрлийн гэмт хэргийн криминологи шинж, тэдгээрийн шалтгаан нөхцөл
- Хүнийг алах гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Хүчиндэх гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Танхайрах гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - “Хар тамхины гэмт явдлын шалтгаан нөхцөл” судалгааны ажлын тайлан
 - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Захиргааны журмын эсрэг гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
 - Албан тушаалын гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл
- §6. Гэмт хэргийн онцлог, шалтгаан нөхцөл
- Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг
 - Бүлэг, зохион байгуулалттайгаар үйлдсэн гэмт хэрэг
 - Галт зэвсгээр үйлдсэн гэмт хэрэг
 - Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэрэг
 - Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг
 - Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг
 - Аж ахуйн нэгж, байгууллагад үйлдсэн гэмт хэрэг
 - Гудамж талбайд үйлдсэн гэмт хэрэг
- §7. Гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог
- Ажилгүй хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал
 - Эмэгтэйчүүдээс гэмт хэрэг үйлдсэн байдал
 - Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг болон гэмт халдлагад өртсөн байдал
 - Гадаадын иргэдээс гэмт хэрэг үйлдсэн, гэмт халдлагад өртсөн байдал

- Урьд ял шийтгэгдсэн болон захиргааны хяналтад байгаа хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал

§8. ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, илрүүлэлт, ангилал, төрөл
- Гэмт хэрэг үйлдэгдсэн онцлог байдал
- Гэмт хэрэг үйлдэгдсэн газар
- Гэмт хэрэг үйлдэгсэд, тэдгээрийн онцлог
- Гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон иргэн, байгууллага, учирсан хохирол
- Захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлт, эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн талаарх мэдээлэл

ХОЁР. ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭНИЙ ДҮГНЭЛТ

ГУРАВ. ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТӨВ, ОРОН НУТГИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

ӨМНӨХ ҮГ

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвөөс жил бүр эрхлэн гаргадаг "Монгол Улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал" нэртэй судалгааны номыг 2012 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээллийн сан дахь мэдээлэлд түшиглэн товхимол болгон бэлтгэж Та бүхэнд толилуулж байна.

Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал нь улс орны нийгэм, эдийн засгийн үзүүлэлтэд нэгэн хүчин зүйл болж, Үндэсний статистикийн хорооноос сар бүр гаргаж буй статистик мэдээнд ордогийг дурдахад илүүдэхгүй болов уу.

Энэ товхимолд 2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн байдал, хандлага, зарим төрлийн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн онцлог, тэдгээрийн шийдвэрлэлтийн байдал, нөлөөлж буй хүчин зүйл, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх санал, гэмт хэрэг, зөрчлийн байдалд хийсэн дүгнэлт, зөвлөмжийг оруулан та бүхний албан хэрэгцээнд зориулан хүртээл болгож байна.

Мэдээлэл, судалгааны төвийн үндсэн чиг үүрэг бол гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, төвлөрсөн статистик мэдээллийг шинжлэх, нэгтгэн дүгнэх замаар дүн шинжилгээ хийж, төр, засаг, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагууд, тэдгээрийн удирдлага, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагыг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь үнэн зөв, бодитой мэдээ, мэдээллээр хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн чимхлүүр, хариуцлагатай ажил билээ.

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст бүртгэгдсэн гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаар бодитой мэдээллийг цаг алдалгүй бүрдүүлэхэд нэгжид ажиллаж буй мэдээлэл, судалгааны ажил хариуцсан ахлах байцаагч, байцаагч, тоо бүртгэгч болон цагдаагийн төрөл мэргэжлийн албадын шат шатны дарга, алба хаагч бүр энэ чиглэлд онцгой анхаарал хандуулж, хийдэл гаргахгүй байх учиртай.

Энэ шаардлагын үүднээс мэдээлэл, судалгааны ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд анхаарч, тэдний ажил мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх замаар тус төвийн үндсэн чиг үүргийг үр дүнтэй, шуурхай, хүртээмжтэй, цаг үеийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлж хэрэгжүүлэх бодлого, чиглэлийг зорилго болгон ажиллаж байна.

Энэ зорилгын хүрээнд мэдээллийн сан бүрдүүлж буй үйл явц, системийг боловсронгуй болгох ажилд мэдээллийн техник, технологийн дэвшил, програм хангамжийн зөв, оновчтой шийдлийг түлхүү ашиглаж байхад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа мэдээлэл, судалгааны ажилтнуудыг ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллахад нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор энэ оны 6 дугаар сард нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Нэгдсэн сургалт, зөвлөгөөний явцад эрх зүйн шинэтгэлийн хүрээнд төр, засаг, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлж буй бодлого, чиглэл, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулагдсан хууль тогтоомжуудын төслийн үзэл баримтлал, мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалтын талаар

мэдээлэл өгч, мэдээлэл, судалгааны ажил, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хөгжүүлэхтэй холбоотой санал, бодлыг нь сонсон судлаж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах юм.

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн удирдлага, алба хаагч Та бүхэн Мэдээлэл, судалгааны төвөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааны чиглэлийг бүх талаар дэмжиж хамтран ажиллана гэдэгт итгэж байгаагаа илэрхийлж байна.

Монгол төр, ард иргэдийнхээ өмнө хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх үүргээ хэрэгжүүлэх үйлсдээ энэхүү товхимолд тусгасан статистик мэдээ, дүгнэлт, санал, ажлын чиглэлээс санаа авч түүнийг иргэд олон нийтэд үр дүн өгсөн, үр бүтээлтэй, бодит ажил хэрэг болгон амжилт гарган ажиллахыг хүсье.

МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГААНЫ ТӨВИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

П.БАТБААТАР

2013 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

НЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ 2012 ОНЫ ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

§1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Гомдол, мэдээлэл, тэдгээрийн шийдвэрлэлт: Цагдаагийн байгууллага 2012 онд иргэн, ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх 141276 гомдол, мэдээлэл хүлээн авсан,

- өмнөх оныхоос 12612 нэгжээр буюу 9.8 хувиар өссөн,
- Урьд оны шийдвэрлэгдээгүй үлдэгдэл 3267,
- нийт 144543 гомдол, мэдээллийг шалгасны дотор
- 62371 буюу 43.2 хувийг гэмт хэргийн, үүний дотор Эрүүгийн цагдаагийн албанаас эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад шилжүүлсэн 3372 материал,
- 72697 буюу 50.3 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл тус тус эзэлсэн байна.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн:

- 24273 буюу 39.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж,
- 36615 буюу 58.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаснаас 36167 буюу 98.8 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн:

- 12.2 хувийг баривчлах,
- 48.5 хувийг шийтгэврээр,
- 20.9 хувийг торгуулийн хуудсаар тус тус торгох,
- 14.3 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж,
- 2.8 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр шийдвэрлэсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, түүний хөдөлгөөн: Монгол Улсын хэмжээнд 2012 онд **22089** гэмт хэрэг бүртгэгдсэн:

- өмнөх оныхоос 2892 хэргээр буюу 15.1 хувиар,
- нийслэлд 2137 хэргээр буюу 19.8 хувиар тус тус өсчээ.
- 16 аймаг, нийслэлийн бүх дүүрэг, иргэний нисэхийн салбарт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны түвшингээс тодорхой хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

- 58.4 хувь нь нийслэлд,
- 40.8 хувь нь аймаг орон нутагт,


- 0.4 хувь нь төмөр замын салбарт,
- 0.4 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Хоногт дунджаар 60 гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 2 хүн нас барж, 23 хүн гэмтсэн байна.

Гэмт хэргийн гаралт Дундговь, Баянхонгор, Ховд, Хэнтий, Увс аймагт 2.4-15.7 хувиар, Төмөр замын салбарт 18.9, бусад салбарт 21.6 хувиар тус тус буурав.



Хөвсгөл, Дорноговь, Архангай, Завхан, Өмнөговь, Дархан-Уул, Сүхбаатар, Орхон, Сэлэнгэ, Говь-Алтай, Төв, Өвөрхангай, Булган, Говьсүмбэр, Баян-Өлгий, Дорнод аймагт 3.9-40.0 хувиар, нийслэлийн Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол, Налайх, Чингэлтэй, Багануур, Сүхбаатар, Баянзүрх, Багахангай дүүрэгт 4.8-81.8 хувиар тус тус өссөн байна.





- Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн**
- 43.6 хувийг хөнгөн,
 - 45.5 хувийг хүндэтэр,
 - 8.7 хувийг хүнд,
 - 2.2 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж, өмнөх оныхоос хөнгөн ангиллын гэмт хэрэг 20.8 хувиар өсч,
 - хүндэтэр ангиллын гэмт хэрэг 13.0 хувиар өсч,
 - хүнд ангиллын гэмт хэрэг 5.0 хувиар өсч,
 - онц хүнд ангиллын гэмт хэрэг 2.2 хувиар буурсан байна.



2012 онд 18 ба түүнээс дээш насны 10 000 хүн тутамд улсын дунджаар 117 гэмт хэрэг ногдож байгаа нь өмнөх оныхоос 13 хэрэг буюу 12.5 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн илрүүлэлт:

- улсын хэмжээнд 56.3 хувьтай,
- өмнөх оныхоос 5.2 нэгжээр,
- нийслэлийн хэмжээнд 51.7 хувьтай,
- өмнөх оныхоос 7.1 нэгжээр тус тус буурсан статистик үзүүлэлттэй байна.



Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт Тоогоор	Хувиар
1	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	19197	22089	2892	15.1

2	Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг Үүнээс:	6504	8140	1636	25.2
3	Яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдсон хэрэг	3999	4585	586	14.7
4	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	61.5	56.3	-5.2 нэгжээр буурсан	

Гэмт хэргийн илрүүлэлтийг ангиллаар нь тооцож үзвэл:

- Хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 53.8 хувь,
- хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 55.9 хувь,
- хүнд гэмт хэргийн илрүүлэлт 64.3 хувь,
- онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт 77.1 хувь,
- өмнөх оныхоос хөнгөн хэргийн илрүүлэлт 4.9 нэгжээр,
- хүндэвтэр ангиллын хэргийн илрүүлэлт 4.2 нэгжээр,
- хүнд ангиллын хэргийн илрүүлэлт 8.0 нэгжээр,
- онц хүнд хэргийн илрүүлэлт 12.2 нэгжээр тус тус буурчээ.




Улсын хэмжээнд 3555 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй дүн мэдээ гарсны

- 0.2 хувийг хүнийг санаатай алах,
- 0.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих,
- 0.6 хувийг хүчиндэх,
- 2.1 хувийг бусдын эд хөрөнгийг булаах,
- 2.3 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах,
- 3.8 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах,
- 4.8 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 5.1 хувийг бусдын эд хөрөнгийг дээрэмдэх,
- 5.3 хувийг танхайрах,
- 68.7 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, үүнээс 16.1 хувийг мал хулгайлах,
- 6.6 хувийг бусад төрлийн хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийн бүтэц, төрөл, хөдөлгөөн: 2012 онд бүртгэгдсэн нийт хэргийн

- 179 буюу 0.8 хувийг булаах,

- 231 буюу 1.0 хувийг хүнийг санаатай алах,
- 269 буюу 1.2 хувийг завших, үрэгдүүлэх,
- 305 буюу 1.4 хувийг хүчиндэх,
- 552 буюу 2.5 хувийг дээрэмдэх,
- 1098 буюу 5.0 хувийг залилан мэхлэх,
- 1238 буюу 5.6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих
- 1687 буюу 7.6 хувийг танхайрах,
- 6266 буюу 28.4 хувийг хулгайлах,
- 6546 буюу 29.6 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг тус тус эзэлж байна.



- Мал хулгайлах гэмт хэрэг 1376 бүртгэгдсэн,
- өмнөх оныхоос 17.7 хувиар өсч,
 - нийт хэргийн 6.2,
 - бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 22.0 хувийг,
- Тээврийн хэрэгсэл хулгайлах хэрэг 172 бүртгэгдсэн,
- өмнөх оныхоос 3.4 хувиар буурч,
 - хулгайлах хэргийн 2.7 хувийг,
- Халаасны хулгайн хэрэг 249 бүртгэгдсэн,
- өмнөх оныхоос 47.3 хувиар өсч,
 - хулгайлах хэргийн 4.0 хувийг тус тус эзэлж байна.

д/д	Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр	Гэмт хэрэг		Өсөлт	
		2011	2012	Тоогоор	Хувиар
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	96	138	42	43.8
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	6462	7155	693	10.7
3	Албан тушаалын	101	110	9	8.9

4	Захиргааны журмын эсрэг	280	332	52	18.6
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг	72	126	54	75.0
6	Өмчлөх эрхийн эсрэг	7232	9023	1791	24.8
7	Аж ахуйн эсрэг	115	185	70	60.9
8	Шүүн таслах ажиллагааны эсрэг	96	100	4	4.2
9	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг	1890	1999	129	6.9
10	Хүн амын эрүүл мэндийн эсрэг	261	295	34	13.0
11	Байгаль хамгаалах журмын эсрэг	270	410	140	51.9
12	Цэргийн албаны эсрэг	9	16	7	77.8
13	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	96	138	42	43.8

2012 оны байдлаар гэмт хэргийн дийлэнх хувь нь өсч, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 6.6 хувь буурчээ.

Д/д	Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр	Гэмт хэрэг		Бууралт	
		2011	2012	Тоогоор	Хувиар
1	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	1873	1749	-124	-6.6

Тодорхой зарим төрлийн гэмт хэргийн хувьд:

- Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэг 3.0 хувиар,
- бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 3.2 хувиар,
- бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 12.1 хувиар,
- ойн тухай хууль тогтоомж зөрчих хэрэг 18.0 хувиар,
- бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг 18.8 хувиар,
- эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх 22.2 хувиар,
- зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах хэрэг 27.3 хувиар,
- бусдын эд хөрөнгийг булаах хэрэг 30.7 хувиар,
- бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх хэрэг 33.2 хувиар,
- банкны тухай хууль тогтоомж зөрчих, хүн худалдаалах хэрэг тус бүр 50.0 хувиар,
- бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэг 59.6 хувиар,
- ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих хэрэг 60.7 хувиар,
- хүүхэд хаях, төөрүүлэх хэрэг 2.2 дахин,
- галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх хэрэг 2.7 дахин,
- татвар төлөхөөс зайлсхийх хэрэг 3.1 дахин,
- хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох хэрэг 6.0 дахин,
- мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах хэрэг 6.3 дахин тус тус өсчээ.

д/д	Тодорхой зарим төрлийн гэмт хэрэг	Гэмт хэрэг		Өсөлт	
		2011	2012	Тоогоор	Хувиар
1	Бусдын бие махбодид гэмтэл учруулах	5838	6546	708	12.1
2	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	536	552	16	3.0
3	Ойн тухай хууль тогтоомж зөрчих	222	262	40	18.0
4	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	5276	6266	990	18.8
5	Бусдын эд хөрөнгийг булаах	137	179	42	30.7
6	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	54	66	12	22.2
7	Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх	202	269	67	33.2
8	Банкны тухай хууль тогтоомж зөрчих	2	3	1	50.0
9	Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах	688	1098	410	59.6
10	Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих	25	45	17	60.7
11	Хүүхэд хаях, төөрүүлэх хэрэг Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу	6	13	7	2.2дах
12	хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх хэрэг	3	8	5	2.7дах
13	Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	13	79	66	6.0дах
14	Татвар төлөхөөс зайлсхийх	28	87	59	3.1дах
15	Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах	560	713	153	27.3
16	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг Хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах	12	75	63	6.3 дах

Бусдыг болгоомжгүй алах хэрэг 33.3 хувиар,
- жолоогоо бусдад шилжүүлэх хэрэг 28.6 хувиар,
- хүчиндэх хэрэг 16.9 хувиар,
- хээл хахууль авах хэрэг 15.8 хувиар,
- хүнийг санаатай алах хэрэг 11.8 хувиар,
- хээл хахууль өгөх хэрэг 9.1 хувиар,
- танхайрах хэрэг 7.5 хувиар,

- биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг 6.7 хувиар,


- тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих хэрэг 1.8 хувиар тус тус буурсан байна.

Д/д	Годорхой зарим төрлийн гэмт хэрэг	Гэмт хэрэг		Бууралт	
		2011	2012	Тоогоор	Хувиар
1	Танхайрах	1824	1687	-137	-7.5
2	Жолоогоо бусдад шилжүүлэх	7	5	2	-28.6
3	Хүчиндэх	367	305	-62	-16.9
4	Хүнийг санаатай алах	262	231	-31	-11.8
5	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих	1261	1238	-23	-1.8
6	Хээл хахууль өгөх	11	10	-1	-9.1
7	Хээл хахууль авах	19	16	-3	15.8
8	Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг	15	14	-1	-6.7
9	Бусдыг болгоомжгүй алах	21	14	-7	-33.3

Гэмт хэргийн улмаас учирсан хор хохирол: Гэмт хэргийн халдлагад 21294 иргэн хохирсны

- 37.5 хувь нь эмэгтэй,
- 0.8 хувь нь 7 хүртэлх насны,
- 1.5 хувь нь 8-13 насны,
- 3.7 хувь нь 14-17 насны,
- 17.7 хувь нь 18-24 насны,
- 16.9 хувь нь 25-29 насны,
- 14.9 хувь нь 30-34 насны,
- 13.2 хувь нь 35-39 насны,
- 10.2 хувь нь 40-44 насны,
- 8.5 хувь нь 45-49 насны,
- 5.9 хувь нь 50-54 насны,
- 3.0 хувь нь 55-59 насны,
- 1.6 хувь нь 60-64 насны,
- 1.0 хувь нь 65-69 насны,
- 1.1 хувь нь 70 ба түүнээс дээш насны хүн байна.

Хохирогчийн насны ангилал



Хохирогч иргэдийн дотор

- төрийн албан хаагч 1795, үүнээс цагдаа 111,
- хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 3017,
- төрийн бус байгууллагын ажилтан 657,
- хувиараа хөдөлмөр эрхлэгч 3965,
- малчин 2590,
- оюутан 974,
- сурагч 865,
- сургууль завсардсан хүүхэд 13,
- тэнэмэл 27,
- хоригдол 50,
- эрхэлсэн тодорхой ажилгүй 7341 хүн байгаа,
- хохирогчийн буруугаас 603, архидан согтуурсан үедээ 441 иргэн гэмт хэргийн халдлагад өртөж хохирчээ.

Хохирогчийн нийгмийн байдал



Гэр бүлийн хүчирхийлэлд 433 иргэн өртжээ

- *Хүчирхийллийн хэлбэрээр нь авч үзвэл,*
 - 370 нь бие махбодийн,
 - 112 нь сэтгэл санааны,

- 16 нь бэлгийн,
- 6 нь эдийн засгийн,
- *Хүчирхийлэлд өртсөн хугацаагаар нь авч үзвэл,*
- 0-1 жилд 228,
- 1-3 жилд 60,
- 3-5 жилд 17,
- 5-8 жилд 2,
- *Хүчирхийллийн давтамжаар нь авч үзвэл,*
- жилд 1-2 удаа 239,
- улиралд 1-2 удаа 34,
- сард 1 удаа 12,
- 14 хоног тутам 5,
- 3 хоног тутам 1,
- байнга 2,
- *Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор*
- эхнэр 260,
- нөхөр 18,
- хамтран амьдрагч 63,
- төрсөн эцэг, эх 5,
- хадам эцэг, эх 7,
- төрсөн ах, эгч 5,
- төрсөн дүү 9,
- төрсөн хүүхэд 7,
- дагавар 17 хүүхэд бүртгэгджээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын 121 иргэн гэмт хэргийн халдлагад өртсөн,
 - өмнөх оныхоос 9.0 хувиар өссөн,
 - 51 нь БНХАУ-ын,
 - 17 нь БНСУ-ын,
 - 15 нь ОХУ-ын,
 - 9 нь АНУ-ын,
 - 3 нь Япон улсын,
 - 26 нь бусад улсын иргэд байна.

Энэ хугацаанд гэмт хэргийн халдлагад 167 байгууллага өртсөнөөс
 - 52.7 хувь нь төрийн байгууллага,
 - 32.9 хувь нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж,
 - 14.4 хувь нь төрийн бус байгууллагууд байна.

Гэмт хэргийн улмаас төр, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 53.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан,
 - өмнөх оныхоос 48.3 хувиар өссөн,
 - учирсан хохирлын 25.1 тэрбум төгрөг буюу 47.2 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.



Хөнгөн ангиллын гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 4.4 тэрбум төгрөг буюу 66.7 хувийг хэрэг бүртгэх шатанд,

- хүндэвтэр, хүнд, онц хүнд ангиллын гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 20.7 тэрбум төгрөг буюу 44.4 хувийг мөрдөн байцаах шатанд нөхөн төлүүлж,
- хэрэг бүртгэх ажиллагааны явцад 811.3 сая,
- мөрдөн байцаах ажиллагааны явцад 3.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг тус тус битүүмжилжээ.

Гэмт хэргийн улмаас

- 901 хүн нас барж,
- 8436 хүн гэмтсэн,
- өмнөх оныхоос нас барсан хүний тоо 2.3 хувиар буурч,
- гэмтсэн хүний тоо 4.1 хувиар өсөв.


Нас барсан хүмүүсийн 25.6 хувийг эмэгтэй хүн эзэлж,

- өмнөх оныхоос 0.9 нэгжээр буурчээ.

Нас барсан хүмүүсийн дотор

- 7 хүртэлх насны 42,
- 8-13 насны 12,
- 14-17 насны 26,
- 18-24 насны 120,
- 25-29 насны 93,
- 30-34 насны 116,
- 35-39 насны 109,
- 40-44 насны 95,
- 45-49 насны 103,
- 50-54 насны 89,
- 55-59 насны 38,
- 60-64 насны 26,
- 65-69 насны 14,
- 70 ба түүнээс дээш насны 18 хүн байна.

Гэмт хэргийн улмаас нас барсан хүмүүсийн тоо (насаар)




Гэмтсэн хүмүүсийн дотор

- эмэгтэйчүүд 36.0 хувийг эзэлж,
- 7 хүртэлх насны 85,
- 8-13 насны 188,
- 14-17 насны 435,
- 18-24 насны 1902,
- 25-29 насны 1558,
- 30-34 насны 1269,
- 35-39 насны 981,
- 40-44 насны 747,
- 45-49 насны 534,
- 50-54 насны 380,
- 55-59 насны 180,
- 60-64 насны 74,
- 65-69 насны 40,
- 70 ба түүнээс дээш насны 63 хүн байна.

Тэдгээрийн 77.4 хувь нь хөнгөн,

- 15.1 хувь нь хүндэвтэр,
- 7.5 хувь нь хүнд хэлбэрээр гэмтжээ.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүмүүс (гэмтлийн зэргээр)



Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:

- Авто замд үйлдэгдсэн хэрэг 2.6 хувиар,
- гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 7.2 хувиар,
- гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 8.1 хувиар,
- олон нийтийн газар үйлдэгдсэн хэрэг 10.0 хувиар,
- төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 13.2 хувиар,

- нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг 27.3 хувиар,
- аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хэрэг 45.7 хувиар тус тус өсч,
- төрийн бус байгууллагад үйлдэгдсэн хэрэг 10.1 хувиар буурав.

Гэр, орон сууцанд 6450 хэрэг үйлдэгдсэний дотор

- гэрт 2643,
- орон сууцны байранд 1437,
- хувийн байшинд 1343,
- зуслангийн байшинд 87,
- хауст 17,
- гараашид 108,
- амбаарт 105,
- агуулахад 39,
- орцонд 289,
- подвальд 59,
- бусад газарт 323;

Гудамж талбайд 3764 хэрэг үйлдэгдсэний дотор

- гэр хорооллын гудамжинд 1513,
- орон сууцны хорооллын гудамжинд 1147,
- тоглоомын талбайд 16,
- ил зогсоолд 374,
- цэцэрлэгт хүрээлэнд 23,
- автобусны буудалд 205,
- төмөр замд 5,
- бусад газарт 481;

Олон нийтийн газарт 2944 хэрэг үйлдэгдсэний дотор

- үзвэрийн газар 59,
- нийтийн захад 295,
- бөөний худалдааны төвд 222,
- дэлгүүрт 619,
- ТҮЦ-д 19,
- зочид буудалд 313,
- саунд 20,
- бааранд 650,
- ресторан, зоогийн газарт 168,
- амралтын газарт 84,
- сувиллын газарт 11,
- жуулчны баазад 6,
- нисэх онгоцны буудалд 10,
- төмөр замын вокзалд 21,
- авто вокзалд 17,
- бусад газарт 430;

Нийтийн тээвэрт 275 хэрэг үйлдэгдсэний дотор

- нисэх онгоцонд 1,
- галт тэргэнд 18,
- том оврын автобусанд 76,
- дунд оврын автобусанд 4,
- микро автобусанд 16,
- таксинд 97,
- бусад газарт 63;

Төрийн байгууллагад 481 хэрэг үйлдэгдсэний дотор

- төрийн захиргааны байгууллагад 79,

- элчин сайдын яаманд 1,
 - шүүхэд 18,
 - прокурорын байгууллагад 9,
 - тагнуулын байгууллагад 1,
 - зэвсэгт хүчинд 14,
 - цагдаагийн байгууллагад 86,
 - дотоодын цэрэгт 2,
 - шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 52,
 - онцгой байдалд 1,
 - хилийн цэрэгт 9,
 - гаальд 32,
 - татварын байгууллагад 11,
 - нийгмийн даатгалын байгууллагад 15,
 - халамж үйлчилгээний байгууллагад 11,
 - газрын албанд 2,
 - ашигт малтмал геодези, зураг зүйн албанд 4,
 - мэргэжлийн хяналтын албанд 6,
 - бүртгэлийн албанд 9,
 - музейд 1,
 - бусад газарт 118;
- Төрийн бус байгууллагад 277 хэрэг үйлдэгдсэний дотор
- боловсролын 85,
 - соёл урлагийн 12,
 - эрүүл мэндийн 45,
 - спортын 6,
 - орчин ахуйн хөгжлийн 7,
 - энэрлийн 5,
 - улс төрийн намын 11,
 - эвслийн 1,
 - сүм хийдийн 7,
 - үйлдвэрчний эвлэлийн 2,
 - бусад газарт 96;
- Аж ахуйн нэгжид 1681 хэрэг үйлдэгдсэний дотор
- үйлдвэрийн газарт 294,
 - арилжааны банканд 155,
 - хадгаламж зээлийн хоршоонд 9,
 - валют арилжааны цэгт 4,
 - банк бус санхүүгийн байгууллагад 19,
 - тооцооны төвд 29,
 - хамгаалалтын албанд 5,
 - засвар үйлчилгээний газарт 49,
 - ашигт малтмал, геодези, зураг зүйн албанд 36,
 - шатахуун түгээх станцад 26,
 - нотариатын газарт 12,
 - төрийн өмчийн их, дээд сургуульд 24,
 - мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 10,
 - коллежид 4,
 - ерөнхий боловсролын сургуульд 48,
 - хүүхдийн цэцэрлэгт 14,
 - эмнэлэгт 40,
 - оношилгооны төвд 1,

- хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 13,
- их, дээд сургуульд 25,
- мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1,
- эмийн санд 14,
- оношилгооны төвд 3,
- хүүхдийн цэцэрлэгт 3,
- эмнэлэгт 10,
- бусад газарт 833;

Бусад газарт 4377 хэрэг үйлдэгдсэний дотор

- хилийн бүсэд 237,
- хөдөө хээр 789,
- бэлчээрт 1149,
- ойн сан бүхий газарт 234,
- гол усны ай сав газарт 44,
- ашигт малтмалын орд газарт 18,
- траншейнд 6,
- хууль бусаар алт олборлож байгаа газарт 16,
- ашиглаж байгаа уурхайд 48,
- баригдаж байгаа барилгад 187,
- гадаад улсад 5,
- бусад газарт 1644 хэрэг тус тус үйлдэгдсэн байна.

Авто замд 1840 гэмт хэрэг үйлдэгджээ.

Замын харьяаллаар нь авч үзвэл,

- олон улсын замд 7,
- улсын замд 71,
- орон нутгийн замд 664,
- хотын замд 1085,
- хувийн замд 3,
- аж ахуйн нэгж, байгууллагын замд 10,

Замын хэсгээр нь авч үзвэл,

- уулзвар дээр 163,
- явган хүний гарц дээр 68,
- автобусны буудал дээр 45,
- төмөр замын гарман дээр 4,
- гүүрэн дээр 15,
- хонгилд 1,

Замын ангиллаар нь авч үзвэл,

- ердийн замд 1006,
- хорооллын замд 68,
- тууш замд 235,
- хурдны замд 5,

замын хучилтаар нь авч үзвэл,

- асфальтан замд 1255,
- цементэн замд 23,
- бетон замд 78,
- сайжруулсан замд 57,
- хөрсөн замд 175,
- хайрган замд 28,

Замын гадаргуугаар нь авч үзвэл,

- хуурай замд 893,
- нойтон замд 47,

- мөстэй замд 118,
 - цастай замд 116,
 - эвдрэлтэй замд 18,
 - бохирдсон замд 2,
- Замын онцлогоор нь авч үзвэл,*

- тэгш замд 949,
 - хазгай замд 24,
 - шулуун замд 757,
 - өгсүүр замд 62,
 - уруу замд 93,
 - огцом эргэлттэй замд 28,
- Үзэгдэх орчноор нь авч үзвэл,*
- үзэгдэх орчин чөлөөтэй 1187,
 - хязгаарлагдмал 140,
 - хангалтгүй 28,
 - зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй 211,
 - гэрэлтүүлэггүй 178,


Цаг агаарын нөхцөлөөр нь авч үзвэл,

- таатай үед 1042,
- үүлэрхэг үед 45,
- бороотойд 26,
- цастайд 24,
- манантайд 11,
- шуургатайд 7 хэрэг тус тус үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн

- 3593 нь Даваа,
- 3342 нь Мягмар,
- 3243 нь Лхагва,
- 3212 нь Пүрэв,
- 3202 нь Баасан,
- 2714 нь Бямба,
- 2783 нь Ням гарагт,
- 17.3 хувь нь 06-14 цагт,
- 25.6 хувь нь 14-19 цагт,
- 17.9 хувь нь 19-22 цагт,
- 39.2 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгдсэн байна.



Гэмт хэрэг үйлдэгдсэн онцлог:

- Эмэгтэй хүн оролцсон хэрэг 85.2,
- хүүхэд оролцсон хэрэг 82.4,

- гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 27.1,
- бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг 17.5,
- согтуугаар үйлдэгдсэн хэрэг 17.4,
- галт зэвсгээр үйлдэгдсэн хэрэг 5.1 хувиар,
- урьдчилан үгсэж, тохиролцсон бүлэг үйлдсэн хэрэг 2.4,
- мансуурсан үед үйлдэгдсэн хэрэг 5.5,
- зохион байгуулалттай бүлэг үйлдсэн хэрэг 8.0 дахин хувиар тус тус өсөв.

Гэмт хэрэг үйлдэгчид:

Гэмт хэрэгт 19734 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан,

- өмнөх оныхоос 9.7 хувиар өсч,
- 13.5 хувийг эмэгтэй хүн эзэлж,
- өмнөх оныхоос 0.7 нэгжээр өсч,
- 6.3 хувийг хүүхэд эзэлж,
- өмнөх оныхоос 0.1 нэгжээр буурчээ.




Насны ангиллаар авч үзвэл,

- 15 хүртэлх насны 388,
- 16-17 насны 860,
- 18-24 насны 5541,
- 25-29 насны 3749,
- 30-34 насны 3030,
- 35-39 насны 2288,
- 40-44 насны 1634,
- 45-49 насны 1186,
- 50-54 насны 632,
- 55-59 насны 264,
- 60-64 насны 108,
- 65-69 насны 32,
- 70 ба түүнээс дээш насны 22 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдав.

Гэмт хэрэг үйлдэгчдийн

- 12.1 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч эзэлж,
- өмнөх оны мөн үеийнхээс 3.3 нэгжээр,
- 9.5 хувийг малчин эзэлж,
- өмнөх оны мөн үеийнхээс 0.7 нэгжээр,
- 4.4 хувийг оюутан эзэлж,

- өмнөх оны мөн үеийнхээс 0.7 нэгжээр,
- 0.5 хувийг тэнэмэл амьдралтай хүн эзэлж
- өмнөх оны мөн үеийнхээс 0.2 нэгжээр,
- 1.9 хувийг төрийн бус байгууллагын ажилтан эзэлж,
- өмнөх оны мөн үеийнхээс 0.1 нэгжээр,
- 0.3 хувийг хоригдол эзэлж,
- өмнөх оны мөн үеийнхээс 0.1 нэгжээр,
- 0.1 хувийг хугацаат цэргийн алба хаагч эзэлж,
- өмнөх оны мөн үеийнхээс 0.1 нэгжээр тус тус өсч,
- 52.7 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс эзэлж,
- өмнөх оны мөн үеийнхээс 3.4 нэгжээр,
- 11.1 хувийг хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч эзэлж,
- өмнөх оны мөн үеийнхээс 0.6 нэгжээр,
- 4.3 хувийг төрийн албан хаагч эзэлж,
- өмнөх оны мөн үеийнхээс 0.9 нэгжээр,
- 2.8 хувийг сурагч эзэлж,
- өмнөх оны мөн үеийнхээс 0.3 нэгжээр тус тус буурчээ.



Дээрх хүмүүсийг нийгмийн байдал, боловсролоор нь авч үзвэл,

- хугацаат цэргийн албан хаагч 16,
- хоригдол болон сургууль завсардсан хүүхэд тус бүр 62,
- тэнэмэл амьдралтай хүн 101,
- төрийн бус байгууллагын ажилтан 380,
- сурагч 552,
- төрийн албан хаагч 857,
- оюутан 864,
- малчин 1870,
- хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 2188,
- хувиараа хөдөлмөр эрхлэгч 2384,
- ажилгүй 10398 хүн,
- 3.7 хувь нь боловсролгүй,
- 10.5 хувь нь бага,
- 23.3 хувь нь суурь,
- 42.6 хувь нь бүрэн дунд,
- 0.2 хувь нь техникийн болон мэргэжлийн,
- 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд,
- 16.7 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна.

Гэмт хэрэг үйлдэгчдийн

- 19.9 хувь нь гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэсэн,
- өмнөх оны мөн үеийнхээс 0.1 нэгжээр,
- 0.1 хувь нь тус бүр гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэглэн, мансуурсан үедээ үйлдсэн

- өмнөх оны мөн үеийнхээс 0.1 нэгжээр тус тус өсч,

- 24.3 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн,

- өмнөх оны мөн үеийнхээс 1.3 нэгжээр,

- 4.6 хувийг урьд ял шийтгэгдсэн хүмүүс эзэлж,

өмнөх оны мөн үеийнхээс 1.0 нэгжээр,

- 0.1 хувь нь галт зэвсгээр үйлдсэн,

- өмнөх оны мөн үеийнхээс 0.1 нэгжээр тус тус буурсан статистик үзүүлэлт гарав.

Гэмт хэрэг үйлдэх үедээ захиргааны хяналтад байсан 71 хүн дахин гэмт хэрэг үйлдэж, гэмт хэрэг үйлдсэн гадаадын 89 иргэн (Үүнээс: БНХАУ-ын 46, ОХУ-ын 13, БНСУ-ын 15, Япон улсын 1, АНУ-ын 1, бусад улсын 13) бүртгэгдсэн байна.


§2. Захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлт, эрүүлжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл

§2.1. Захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлт

Улсын хэмжээнд 2012 онд 795923 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 142304 буюу 21.8 хувиар, зөрчил гаргасан 751571 иргэн бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 135226 буюу 21.9 хувиар тус тус өсч, 46 албан тушаалтан, 1700 аж ахуйн нэгж, байгууллагыг 4.6 тэрбум төгрөгөөр торгож, 28718 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 13888 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Үйлдэгдсэн бүх зөрчлийн 252794 буюу 31.8 хувь нь аймгуудад, 129071 буюу 16.2 хувь нь нийслэлийн дүүргүүдэд, 378606 буюу 47.6 хувь нь Замын цагдаагийн газарт, 12572 буюу 1.6 хувь нь Төмөр замын салбарт, 19850 буюу 2.5 хувь нь Хөдөлгөөнт эргүүлийн газарт, 3030 буюу 0.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Зөрчлийг шийдвэрлэсэн газар, хэлтэс



Зөрчил гаргасан 672853 иргэн буюу 84.5 хувийг *торгуулийн хуудсаар 3.0 тэрбум* төгрөгөөр, 123070 буюу 15.5 хувийг *шийтгэврээр*, үүний дотор 78718 иргэн, 46 албан тушаалтан, 1700 байгууллага, аж ахуйн нэгжийг 1611.4 сая төгрөгөөр торгож, 28718 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 13888 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл, 108635 буюу 88.3 хувьд цагдаагийн эрх бүхий алба хаагч, 14081 буюу 11.4 хувьд шүүгч, 354 буюу 0.3 хувьд Засаг дарга тус тус шийтгэл ногдуулжээ.

- Шийтгэврээр торгох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан бүх зөрчлийг хянаж шийдвэрлэсэн хууль тогтоомжоор нь авч үзвэл:
- 119869 буюу 97.4 хувийг “Захиргааны хариуцлагын тухай”,
- 2335 буюу 1.9 хувийг “Архидан согтуурахтай тэмцэх тухай”,
- 211 буюу 0.2 хувийг “Тамхины хяналтын тухай”,
- 158 буюу 0.1 хувийг “Галт зэвсгийн тухай”,
- 25 буюу 0.02 хувийг “Садар самуун явдалтай тэмцэх тухай”,
- 73 буюу 0.06 хувийг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай”,
- 6 буюу 0.005 хувийг “Жагсаал, цуглаан хийх журмын тухай”,
- 8 буюу 0.006 хувийг “Жолоочийн даатгалын тухай”,
- 1 буюу 0.001 хувийг “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих” хуулийн дагуу,
- 384 буюу 0.3 хувийг бусад хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэсэн байна.

Захиргааны шийтгэл ногдуулсан хууль тогтоомж

Бусад хууль	384
Жолоочийн даатгалын тухай	8
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	73
Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн..	1
Галт зэвсгийн тухай	158
Жагсаал цуглаан хийх журмын тухай	6
Садар самуун явдалтай тэмцэх тухай	25
Тамхины хяналтын тухай	211
Архидан согтуурахтай тэмцэх тухай	2335
Захиргааны хариуцлагын тухай	119869

Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан зөрчлийг төрлөөр нь авч үзвэл, 119869 зөрчил бүртгэгдсэний дотор хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих 95984, танхайрах 17447, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх 1923, согтуурах 1879, бусдын эд хөрөнгийг шунахай зорилгоор хувьдаа ашиглах 866, худалдаа, үйлчилгээний журам зөрчих 841, тамга тэмдгийн талаарх хууль тогтоомж зөрчих 515, төрийн төлөөлөгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэхгүй байх, эсэргүүцэх 241, бусдын эд хөрөнгийг бага хэмжээгээр ашиглан шамшигдуулах 66, гал түймрээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, журам зөрчих 16, төрийн ажилтны нэр барих, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих тус бүр 11, галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис хууль бусаар олж авах 9, хүйтэн зэвсэг хууль бусаар авч явах 7, садар самууныг сурталчлах, өнгөний өвчнийг эмчлүүлэхээс зайлсхийх 3, бусад төрлийн 50 зөрчил тус тус бүртгэгджээ.

Захиргааны зөрчлийн төрөл /ЗХТХ-ийн зүйлээр/

Бусад зүйл	34
50-р зүйл	1
42-р зүйл	711
41-р зүйл	3
37-р зүйл	86
36-р зүйл	1004
35-р зүйл	353
32-р зүйл	180
31-р зүйл	5
30"-р зүйл	1885
26-р зүйл	3
25'-р зүйл	3
25-р зүйл	80435
24-р зүйл	15
23-р зүйл	7
22-р зүйл	2083
21-р зүйл	17337

Шийтгэврээр торгох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан 123070 зөрчлийн 94974 буюу 77.2 хувь нь зам дээр, 12698 буюу 10.3 хувь нь гэр, орон сууцанд, 6851 буюу 5.6 хувь нь гудамж талбайд, 5033 буюу 4.1 хувь нь олон нийтийн газар, 1032 буюу 0.8 хувь нь аж ахуйн нэгжид, 523 буюу 0.4 хувь нь төрийн байгууллагад, 223 буюу 0.2 хувь нь төрийн бус байгууллагад, 281 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 1455 буюу 1.2 хувь нь бусад газарт үйлдэгджээ.


Дээрх зөрчлийн 19722 нь Даваа, 19814 нь Мягмар, 19062 нь Лхагва, 18435 нь Пүрэв, 17258 нь Баасан, 13025 нь Бямба, 15754 нь Ням гарагт, 17523 нь 06-12, 29022 нь 13-18, 61857 нь 19-24, 14668 нь 01-05 цагт тус тус үйлдэгдсэн байна.

Шийтгэврээр торгох болон тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан 123070 зөрчилд холбогдсон хүмүүсээс 13299 хүнийг эрүүлжүүлэх байранд хүргэн эрүүлжүүлж, захиргааны журмаар 258 хүнийг түр, 121 хүнийг албадан саатуулсан байна.

Зөрчил гаргасан 121370 иргэн, албан тушаалтан бүртгэгдсэнийг насны ангиллаар нь авч үзвэл,

- 14-15 насны 89, 16-17 насны 1167, 18-24 насны 27961, 25-29 насны 25753, 30-34 насны 21263, 35-39 насны 16764, 40-44 насны 11722, 45-49 насны 8544, 50-54 насны 4955, 55-59 насны 2005, 60-64 насны 741, 65-69 насны 258, 70 ба түүнээс дээш насны 148 хүн захиргааны зөрчил үйлдсэн ба нийт зөрчил үйлдэгчдийн 12226 буюу 10.1 хувь нь эмэгтэй, 1147 буюу 0.9 хувь нь урьд захиргааны шийтгэл хүлээж байсан хүн байна.

Зөрчил үйлдэгчдийн нас



Нийгмийн байдлаар нь авч үзвэл, төрийн албан хаагч 4399, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 14925, төрийн бус байгууллагын ажилтан 2020, хувиараа хөдөлмөр эрхлэгч 29662, малчин 6510, оюутан 4252, сурагч 373, тэнэмэл 86, сургууль завсардсан хүүхэд 5, ажилгүй 55916, бусад 3222;

Боловсролын байдлаар нь авч үзвэл, боловсролгүй 1116, бага 3459, суурь 20173, бүрэн дунд 65849, техникийн болон мэргэжлийн 47, тусгай мэргэжлийн 3785, дээд боловсролтой 26941 хүн бүртгэгдэв.

2012 онд гадаадын 6373 иргэн, 58 аж ахуйн нэгж, байгууллагыг 46.9 сая төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ.

Дээрх зөрчил гаргагч гадаадын иргэдээс 5972 хүнд торгуулийн хуудсаар 27.6 сая төгрөгөөр торгох, 401 иргэн, 58 аж ахуйн нэгж, байгууллагад шийтгэврээр 19.3 сая төгрөгөөр торгох, 66 хүнд баривчлах, 14 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан ба шийтгэврээр торгох, баривчлах, эрх хасах шийтгэл ногдуулсан гадаадын иргэдийн дотор БНХАУ-ын 260, ОХУ-ын 65, БНСУ-ын 50, АНУ-ын 12, Япон улсын 8, бусад улсын 86 иргэн бүртгэгдсэн байна.

Мөн хугацаанд шийтгэврээр торгох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан 123070 зөрчлийн 45008 буюу 36.6 хувь нь согтуугаар, 630 буюу 0.5 хувь нь бүлэглэн үйлдэгджээ.

Захиргааны шийтгэл ногдуулсан 1700 аж ахуйн нэгж, байгууллагыг төрөл, өмчийн хэлбэрээр нь авч үзвэл, төрийн 9, төрийн бус 25, хувийн хэвшлийн 1666, төрийн өмчийн 8, орон нутгийн өмчийн 14, хувийн өмчийн 1678 байгууллага байна. Зөрчлийн улмаас 10957 иргэнд 2.2 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 1.9 тэрбум төгрөг буюу 90.4 хувийг нөхөн төлүүлжээ.

Тодорхой зарим төрлийн зөрчлийн талаар:

1. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21-р зүйлд заасан танхайрах зөрчил, түүний шийдвэрлэлт: Улсын хэмжээнд 2012 онд **143465** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан **139791** иргэн, **3** албан тушаалтанд **622.1 сая** төгрөгөөр торгох, **3671** хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Үйлдэгдсэн бүх зөрчлийн 57666 буюу 40.2 хувь нь аймгуудад, 72276 буюу 50.4 хувь нь нийслэлийн дүүргүүдэд, 2740 буюу 1.9 хувь нь Төмөр замын салбарт, 10652 буюу 7.4 хувь нь Хөдөлгөөнт эргүүлийн газарт, 131 буюу 0.1 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Зөрчил гаргасан 126018 иргэн буюу 87.8 хувийг *торгуулийн хуудсаар* 462.2 сая төгрөгөөр, 17447 буюу 12.2 хувийг *шийтгэврээр*, үүний дотор 13773 иргэн, 3 албан тушаалтныг 159.9 сая төгрөгөөр тус тус торгож, 3671 хүнд *баривчлах шийтгэл ногдуулсан байна*. *Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл*, 13347 буюу 76.5 хувьд цагдаагийн эрх бүхий алба хаагч, 3834 буюу 22.0 хувьд шүүгч, 266 буюу 1.5 хувьд Засаг дарга тус тус шийтгэл ногдуулжээ.

Шийтгэврээр торгох болон тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан 17447 зөрчилд холбогдсон хүмүүсээс 8184 хүнийг эрүүлжүүлэх байранд хүргэн эрүүлжүүлж, захиргааны журмаар 63 хүнийг түр, 62 хүнийг албадан саатуулсан байна.

Зөрчлийн улмаас 4226 иргэнд 22.4 сая төгрөгийн хохирол учирсны 99.7 хувийг нөхөн төлүүлжээ.

2. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25-р зүйлд заасан хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих зөрчил, түүний шийдвэрлэлт: Улсын хэмжээнд 2012 онд **598422** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан **561850** иргэнд **3395.5** сая төгрөгөөр торгох, **28718** хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, **7854** хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Үйлдэгдсэн бүх зөрчлийн 187712 буюу 31.4 хувь нь аймгуудад, 36111 буюу 6.0 хувь нь нийслэлийн дүүргүүдэд, 363245 буюу 60.7 хувь нь Замын цагдаагийн газарт, 6925 буюу 1.1 хувь нь Төмөр замын салбарт, 2751 буюу 0.5 хувь нь Хөдөлгөөнт эргүүлийн газарт, 1678 буюу 0.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Зөрчил гаргасан 502438 иргэн буюу **84.0 хувийг *торгуулийн хуудсаар*** 2388.2 сая төгрөгөөр, 95984 буюу 16.0 хувийг *шийтгэврээр*, үүний дотор 59412 иргэнийг 1007.3 сая төгрөгөөр тус тус торгож, 28718 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 7854 хүнд *баривчлах шийтгэл ногдуулсан байна. Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл:* 88130 буюу 91.8 хувьд цагдаагийн эрх бүхий алба хаагч, 7840 буюу 8.2 хувьд шүүгч, 14 буюу 0.01 хувьд Засаг дарга тус тус шийтгэл ногдуулжээ.

Шийтгэврээр торгосон болон тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан 95984 зөрчлийн 94741 буюу 98.7 хувь нь зам дээр, 948 буюу 1.0 хувь нь гудамж талбайд, 295 буюу 0.3 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Дээрх зөрчлийн 15258 нь Даваа, 15283 нь Мягмар, 14878 нь Лхагва, 13211 нь Пүрэв, 13619 нь Баасан, 10229 нь Бямба, 12506 нь Ням гарагт, 15355 нь 06-12, 22536 нь 13-18, 45319 нь 19-24, 12774 нь 01-05 цагт тус тус үйлдэгдсэн байна.

Шийтгэврээр торгох болон тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан 95984 зөрчилд холбогдсон хүмүүсээс 2864 хүнийг эрүүлжүүлэх байранд хүргэн эрүүлжүүлж, захиргааны журмаар 165 хүнийг түр, 12 хүнийг албадан саатуулсан байна.

Шийтгэврээр торгосон болон тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан, баривчлах шийтгэл ногдуулсан 95984 иргэний 28013 буюу 29.2 хувь нь согтуугаар зөрчил үйлджээ.


Зөрчлийн улмаас 6112 иргэнд 2158.3 сая төгрөгийн хохирол учирсаны 90.1 хувийг нөхөн төлүүлжээ.

§2.2. Эрүүлжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 118030 хүн эрүүлжүүлсэний дотор 59529 буюу 50.4 хувь нь нийслэлд, 55868 буюу 47.3 хувь нь аймгуудад эрүүлжүүлэгдэж, үйлчилгээний төлбөрт 417.3 сая төгрөгийг төлүүлсэн байна.

Хоногт дунджаар 323, үүнээс нийслэлд 163, аймгуудад 153 хүн эрүүлжүүлэгджээ.

Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн нийгмийн байдал



Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 5419 буюу 4.6 хувь нь эмэгтэй, 1349 буюу 1.1 хувь нь 18 хүртэлх насны, 113 буюу 0.1 хувь нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.

Тэдгээрийн 1741 буюу 1.5 хувь нь хөнгөн, 109768 буюу 93.0 хувь нь дунд, 6521 буюу 5.5 хувь нь хүнд зэргийн согтолттой, 55229 буюу 46.8 хувь нь гэр, орон сууц, 51228 буюу 43.4 хувь нь гудамж талбай, 4341 буюу 3.7 хувь нь байгууллага, аж ахуйн нэгж, 3822 буюу 3.2 хувь нь баар, цэнгээний газар, 1645 буюу 1.4 хувь нь зочид буудал, 527 буюу 0.4 хувь нь үзвэр, үйлчилгээний газар, 1238 буюу 1.0 хувь нь бусад газраас тус тус эрүүлжүүлэгджээ.

Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг нийгмийн байдлаар нь авч үзвэл, **95390 буюу 80.8 хувийг ажилгүй**, 4333 буюу 3.7 хувийг малчин, 9286 буюу 7.9 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 2603 буюу 2.2 хувийг хувийн хэвшлийн байгууллагад ажиллагсад, 1488 буюу 1.3 хувийг оюутан, 1539 буюу 1.3 хувийг төрийн албан хаагч, 591 буюу 0.5 хувийг төрийн бус байгууллагын ажилтан, 217 буюу 0.2 хувийг сурагч, 130 буюу 0.1 хувийг тэнэмэл, 10 буюу 0.01 хувийг сургууль завсардсан хүүхэд, 2443 буюу 2.1 хувийг бусад хүн эзэлж байна.

Тэдгээрийн **74415 буюу 63.0 хувь нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан**, 14569 буюу 12.3 хувь нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, 10432 буюу 8.8 хувь нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас хаана байгаага болон очих газраа мэдэхгүй болсон, 10146 буюу 8.6 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 7100 буюу 6.1 хувь нь гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй, 1368 буюу 1.2 хувь нь гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасны улмаас тус тус эрүүлжүүлэгджээ.

§3. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

§3.1. Баянгол дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **9044** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **460** нэгжээр буюу 4.8 хувиар буурч, тэдгээрийн 94.7 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **6309** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 2021 буюу 32.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 4216 буюу 66.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 4214 буюу 99.9 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 1365 буюу 21.6 хувийг 5 хоногт, 4943 буюу 78.3 хувийг 6-19 хоногт, 1 буюу 0.1 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **2262** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 1193 буюу 52.7 хувийг торгуулийн хуудсаар, 220 буюу 9.7 хувийг шийтгэврээр тус тус торгож, 49 буюу 2.2 хувийг баривчлах, 800 буюу 35.4 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 85.8 хувийг 14 хоногт, 13.9 хувийг нь 15-28 хоногт, 0.2 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж шийдвэрлэжээ.

Баянгол дүүрэгт 2012 онд **2372** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 363 хэргээр буюу 18.1 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 10.7, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн **18.4 хувийг** тус тус эзэлж, төвийн 6 дүүргийн гэмт хэргийн дундаж түвшингээс 319 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 667 буюу 28.1 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 647 буюу 27.3 хувийг хулгайлах, 268 буюу 11.3 хувийг залилан мэхлэх, 163 буюу 6.8 хувийг танхайрах, 99 буюу 4.2 хувийг дээрэмдэх, 93 буюу 3.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 37 буюу 1.5 хувийг булаах, 36 буюу 1.5 хувийг тус бүр бусдыг амиа хорлоход хүргэх бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, 15 буюу 0.6 хувийг хүчиндэх, 12 буюу 0.5 хувийг хүнийг санаатай алах, 299 буюу 12.8 хувийг бусад төрлийн хэрэг, гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 694 гэмт хэрэг бүртгэгдсэний 449 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **64.7** хувьтай, өмнөх оныхоос 2.9 нэгжээр өссөн, 245 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*167 нь хулгайлах, 20 нь дээрэмдэх, 12 нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 10 нь булаах, 9 нь танхайрах, 8 нь залилан мэхэлж авах, 3 нь тус бүр бусдын бие махбодид гэмтэл учруулах болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 13 нь бусад төрлийн хэрэг*) байна.

Гэмт хэрэгт **1937** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 13.3 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 19.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 5.4 нэгжээр өсч, 6.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.4 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас **2309** иргэн өртөж **9.7** тэрбум төгрөгийн хохирол учирсны 2.1 тэрбум төгрөг буюу 21.5 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас **71** хүн нас барж, **1040** хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 2 буюу 2.7 хувиар, гэмтсэн хүний тоо 52 буюу 4.7 хувиар тус тус буурсан байна.

Тус дүүрэгт 2012 онд **23959** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 23176 иргэн, 392 аж ахуйн нэгж, байгууллагад 58.1 сая төгрөгөөр торгох, 391 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулжээ.

§3.2. Баянзүрх дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **9920** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **33** нэгжээр буюу 0.3 хувиар буурч, тэдгээрийн 95.1 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **6284** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 2908 буюу 46.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 3229 буюу 51.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 3216 буюу 99.6 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 2705 буюу 43.1 хувийг 5 хоногт, 3458 буюу 55 хувийг 6-19 хоногт, 121 буюу 1.9 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 3052 гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 56 буюу 1.9 хувийг торгуулийн хуудсаар, 1886 буюу 61.8 хувийг шийтгэврээр тус тус торгож, 730 буюу 23.9 хувийг баривчлах, 380 буюу 12.4 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 87.1 хувийг 14 хоногт, 12.8 хувийг 15-28 хоногт, 0.1 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж шийдвэрлэжээ.

Баянзүрх дүүрэгт 2012 онд **2739** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 602 хэргээр буюу 28.2 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 12.4, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн **21.2 хувийг** тус тус эзэлж, төвийн 6 дүүргийн гэмт хэргийн дундаж түвшингээс 686 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 799 буюу 29.2 хувийг хулгайлах /түүнээс 23 буюу 2.9 хувийг малын хулгай/, 741 буюу 27.1 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 367 буюу 13.4 хувийг танхайрах, 223 буюу 8.1 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 199 буюу 7.3 хувийг бусад төрлийн хэрэг, 143 буюу 5.2 хувийг залилан мэхлэх, 82 буюу 2.9 хувийг дээрэмдэх, 41 буюу 1.5 хувийг хүчиндэх, 39 буюу 1.4 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 38 буюу 1.4 хувийг булаах, 27 буюу 0.9 хувийг хүнийг санаатай алах, 27 буюу 0.9 хувийг завших, үрэгдүүлэх, 13 буюу 0.5 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 1534 гэмт хэрэг бүртгэгдсэний 607 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **39.6** хувьтай, өмнөх оныхоос 17.6 нэгжээр буурсан, 927 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*547 нь хулгайлах үүнээс 20 нь мал хулгайлах, 93 нь танхайрах, 82 нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 53 нь залилан мэхлэх, 51 нь дээрэмдэх, 41 нь бусад төрлийн, 25 нь булаах, 24 нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 11 нь хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг,*) байна.

Гэмт хэрэгт **1830** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 5.1 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 17.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.8 нэгжээр, 5.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.7 нэгжээр тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 2673 иргэн, 4 байгууллага өртөж, **8.3** тэрбум төгрөгийн хохирол учирсны 1.5 тэрбум төгрөг буюу 18.5 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 69 хүн нас барж, **1017** хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 12 буюу 21.0 хувиар, гэмтсэн хүний тоо 427 буюу 72.4 хувиар тус тус өссөн байна.

Баянзүрх дүүрэгт 2012 онд 18882 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 17719 иргэн, 1 албан тушаалтан, 356 аж ахуйн нэгж, байгууллагад 150.7 сая төгрөгөөр торгох, 805 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулжээ.

§3.3. Сүхбаатар дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **8008** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **1306** нэгжээр буюу 19.5 хувиар өсч, тэдгээрийн 91.0 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **4434** гомдол, мэдээллийн 1886 буюу 42.5 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 2407 буюу 54.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 2403 буюу 99.8 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 1843 буюу 41.6 хувийг 5 хоногт, 2526 буюу 56.9 хувийг 6-19 хоногт, 65 буюу 1.5 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 2880 гомдол, мэдээллийн 1491 буюу 51.8 хувийг торгуулийн хуудсаар, 805 буюу 29.5 хувийг шийтгэврээр тус тус торгож, 263 буюу 9.1 хувийг баривчлах, 276 буюу 9.6 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 90.4 хувийг 14 хоногт, 9.5 хувийг нь 15-28 хоногт, 2 буюу 0.1 хувийг 20 ба түүнээс дээш хоногт хянаж шийдвэрлэжээ.

Сүхбаатар дүүрэгт 2012 онд **2102** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 459 хэргээр буюу 27.9 хувиар өсчээ.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 9.5, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 16.3 **хувийг** тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 650 буюу 31.0 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 480 буюу 22.8 хувийг хулгайлах, үүнээс 14 буюу 0.7 хувийг тээврийн хэрэгсэл хулгайлах, 59 буюу 2.8 хувийг халаасны хулгай, 201 буюу 9.6 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 122 буюу 5,8 хувийг танхайрах, 83 буюу 4.0 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 77 буюу 3.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 75 буюу 3.6, хувийг бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, 22 буюу 1.0 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, 20 буюу 0.9 хүчиндэх, 19 буюу 0.9 хувийг тус бүр хүнийг санаатай алах, бусдыг амиа хорлоход хүргэх, 13 буюу 0.6 хувийг бусдын эд хөрөнгийг булаах, 11 буюу 0.5 хувийг татвар төлөхөөс зайлсхийх, 310 буюу 14.7 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 798 гэмт хэрэг бүртгэгдсэний 367 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **46.0** хувьтай, өмнөх оныхоос 12.4 нэгжээр буурсан, **431** гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*хулгайлах 237, үүнээс мал хулгайлах 2, бусдын бие махбодид гэмтэл учруулах, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэг тус бүр 37, дээрэмдэх 30, танхайрах 23, зам тээврийн ослын үед үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах 11, булаах 7, хүчиндэх 4, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих 2, бусад төрлийн 43 гэмт хэрэг*) байна.

Гэмт хэрэгт **1697** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 13.1 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 18.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.0 нэгжээр, 6.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.2 нэгжээр тус тус өссөн байна.

Гэмт халдлагад 1908 иргэн, 5 байгууллага өртөж 6.4 тэрбум төгрөгийн хохирол учирсны 3.2 тэрбум төгрөг буюу 50.6 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 39 хүн нас барж, 685 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 24 буюу 38.1, гэмтсэн хүний тоо 90 буюу 11.6 хувиар тус тус буурсан байна.

Тус дүүрэгт 2012 онд 12017 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 11326 иргэн, 10 албан тушаалтан, 125 аж ахуйн нэгж, байгууллагад 96.8 сая төгрөгөөр торгох, 554 хүнд баривчлах шийтгэл тус тус ноогдуулж, 5447 хүнийг эрүүлжүүлжээ.

§3.4. Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **7564** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **1162** нэгжээр буюу 18.2 хувиар өсч, тэдгээрийн 94.6 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **5826** гомдол, мэдээллийн 2142 буюу 36.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 58 буюу 10.0 хувийг нэгтгэн, 3626 буюу 62.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 3604 буюу 99.3 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 3630 буюу 62.3 хувийг 5 хоногт, 2176 буюу 37.3 хувийг 6-19 хоногт, 20 буюу 0.4 хувийг 20 ба түүнээс дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 1369 гомдол, мэдээллийн 6 буюу 0.4 хувийг торгуулийн хуудсаар, 689 буюу 50.3 хувийг шийтгэврээр тус тус торгож, 674 буюу 49.3 хувийг баривчилж шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 1344 буюу 98.1 хувийг 14 хоногт, 25 буюу 1.9 хувийг нь 15-28 хоногт шийдвэрлэжээ.

Сонгинохайрхан дүүрэгт 2012 онд 2127 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 204 хэргээр буюу 10.6 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 9.6, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 16.5 хувийг тус тус эзэлж, төвийн 6 дүүргийн гэмт хэргийн дундаж түвшингээс 74 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 635 буюу 29.8 хувийг хулгайлах, үүнээс /16 буюу 0.7 хувийг малын хулгай, 561 буюу 26.4 хувийг өмчийн хулгай, 19 буюу 0.9 хувийг авто тээврийн хэрэгслийн хулгай, 16 буюу 0.7 хувийг халаасны хулгай/, 526 буюу 24.7 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 222 буюу 10.4 хувийг танхайрах, 123 буюу 5.8 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 107 буюу 5.1 хувийг бусад төрлийн гэмт хэрэг, 102 буюу 4.8 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 94 буюу 4.4 хувийг дээрэмдэх, 86 буюу 4.0 хувийг залилан мэхлэх, 33 буюу 1.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 31 буюу 1.5 хувийг захиргааны журам зөрчсөн, 29 буюу 1.4 хувийг хүчиндэх, 28 буюу 1.3 хувийг хүнийг санаатай алах, 25 буюу 1.2 хувийг булаах, 24 буюу 1.1 хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчсөн, 16 буюу 0.7 хувийг хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 13 буюу 0.6 хувийг иргэдийн улс төрийн болон бусад эрх эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, 8 буюу 0.4 хувийг тус бүр аж ахуйн эсрэг гэмт хэрэг, 7 буюу 0.3 хувийг татвар төлөхөөс зайлсхийх, 3 буюу 0.1 хувийг бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, албан тушаалын гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны журам зөрчсөн, 1 буюу 0.05 хувийг тус бүр бусдыг болгоомжгүй алах, цэргийн албанаас зайлсхийсэн, хориглосон үйлдвэр, худалдаа эрхлэх, хууль бусаар ашигт малтмал олборлсон гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 892 гэмт хэрэг бүртгэгдсэний 525 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоон, гэмт хэргийн илрүүлэлт 58.9 хувьтай, өмнөх оныхоос 1.0 нэгжээр өссөн, 367 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (271 нь хулгайлах, үүнээс 4 нь мал хулгайлах, 37 нь дээрэмдэх, 12 нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 11 нь танхайрах, 6 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 10 нь бусад төрлийн хэрэг, 7 нь булаах, 5 нь хүчиндэх, 7 нь залилан мэхэлж авах, 1 нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих) байна.

Гэмт хэрэгт 1819 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 8.9 нэгжээр өсч, нийт шалгагдсан хүний 11.7 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.1 нэгжээр, 5.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.4 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 2145 иргэн, 4 байгууллага өртөж, 4.2 тэрбум төгрөгийн хохирол учирсны 3.02 тэрбум төгрөг буюу 72.1 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 78 хүн нас барж, 803 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 9 буюу 10.3 хувиар, гэмтсэн хүний тоо 13 буюу 1.6 хувиар тус тус буурсан байна.

Тус дүүрэгт 2012 онд 19848 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 19073 иргэнд, 103.3 сая төгрөгөөр торгох, 686 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 13033 хүнийг эрүүлжүүлжээ.

§3.5. Хан-Уул дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **3095** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **154** нэгжээр буюу 4,7 хувиар буурчээ.

Гэмт хэргийн талаарх **1939** гомдол, мэдээллийг шийдвэрлэсэний дотор 1087 буюу 56.1 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 829 буюу 42.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 743 буюу 89.6 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 799 буюу 41.2 хувийг 5 хоногт, 58.7 хувийг 6-19 хоногт, 0.1 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **1299** гомдол, мэдээллийн 16 буюу 1.2 хувийг торгуулийн хуудсаар, 702 буюу 54.0 хувийг шийтгэврээр тус тус торгож, 412 буюу 31.7 хувийг баривчлах, 168 буюу 12.9 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 94.6 хувийг 14 хоногт, 4.9 хувийг нь 15-28 хоногт, 0.4 хувийг 20 ба түүнээс дээш хоногт хянаж, шийдвэрлэжээ.

Хан-Уул дүүрэгт 2012 онд **1175** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 54 хэргээр буюу 4.8 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 5.3, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн **9.1** хувийг тус тус эзэлж, төвийн 6 дүүргийн гэмт хэргийн дундаж түвшингээс 878 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн, 344 буюу 29.3 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 259 буюу 22.0 хувийг хулгайлах (үүнээс 3 буюу 0.3 хувийг малын хулгай), 246 буюу 20.9 хувийг бусад төрлийн хэрэг, 79 буюу 6.7 хувийг танхайрах, 49 буюу 4.2 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 42 буюу 3.6 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 50 буюу 4.3 хувийг залилан мэхлэх, 25 буюу 2.1 хувийг дээрэмдэх, 16 буюу 1.4 хувийг хүчиндэх, 20 буюу 1.7 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 12 буюу 1.0 хувийг завших,

үрэгдүүлэх, 10 буюу 0.9 хувийг булаах, 9 буюу 0.8 хувийг хүнийг санаатай алах, 14 буюу 1.2 хувийг аж ахуйн эсрэг гэмт хэргүүд тус тус эзлэж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 447 гэмт хэрэг бүртгэгдсэний 261 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **58.4** хувьтай, өмнөх оныхоос 0.3 нэгжээр буурсан, 186 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*139 нь хулгайлах үүнээс 1 нь мал хулгайлах, 3 нь булаах, 2 нь залилан мэхлэж авах хэрэг, 13 нь бусад төрлийн гэмт хэрэг, 7 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 8 нь танхайрах, 5 нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах хэрэг, 9 нь дээрэмдэх хэрэг*) байна.

Гэмт хэрэгт **1033** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 0.2 хувиар буурч, нийт шалгагдсан хүний 18.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 4.2 нэгжээр, 6.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.5 нэгжээр тус тус өссөн байна.

Гэмт хэргийн халдлагад **1013** иргэн, 1 байгууллага өртөж **2.6** тэрбум төгрөгийн хохирол учирсаны 1.3 тэрбум төгрөг буюу 51.0 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас **44** хүн нас барж, **507** хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо урьд оны хэмжээнд, гэмтсэн хүний тоо 30 буюу 5.6 хувиар буурсан байна.

Тус дүүрэгт 2012 онд **8173** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 7706 иргэн, 39 аж ахуйн нэгж, байгууллагад 52.2 сая төгрөгөөр торгох, 422 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулжээ.

§3.6. Чингэлтэй дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **6784** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **547** нэгжээр буюу 7.5 хувиар буурч, тэдгээрийн 96.4 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **4291** гомдол, мэдээллийн 1788 буюу 41.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 2477 буюу 57.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 2471 буюу 99.8 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 1999 буюу 46.6 хувийг 5 хоногт, 52.4 хувийг 6-19 хоногт, 1.0 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **2182** гомдол, мэдээллийн 1711 буюу 78.4 хувийг шийтгэврээр торгож, 457 буюу 20.9 хувийг баривчлах, 9 буюу 0.4 хувийг нэгтгэн шалгаж, 5 буюу 0.3 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 98.7 хувийг 14 хоногт, 1.2 хувийг нь 15-28 хоногт, 0.1 хувийг түүнээс дээш хоногт хянаж шийдвэрлэжээ.

Чингэлтэй дүүрэгт 2012 онд **1807** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 338 хэргээр буюу 23.0 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 8.2, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн **14.0 хувийг** тус тус эзэлж, төвийн 6 дүүргийн гэмт хэргийн дундаж түвшингээс 246 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн, 488 буюу 27.0 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 446 буюу 24.7 хувийг хулгайлах, үүнээс 1 буюу 0.1 хувийг малын хулгай, 240 буюу 13.3 хувийг танхайрах, 185 буюу 10.2 хувийг бусад төрлийн хэрэг, 159 буюу 8.8 хувийг залилан мэхлэх, 32 буюу 1.8 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 61 буюу 3.4 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 45 буюу 2.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэг, 59 буюу 3.3 хувийг дээрэмдэх, 19 буюу 1.0 хувийг тус бүр бусдын эд

хөрөнгийг завших, үрэгдүүлэх, хүнийг санаатай алах, 20 буюу 1.1 хувийг хүчиндэх, 22 буюу 1.2 хувийг булаах, 12 буюу 0.7 хувийг татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 806 гэмт хэрэг бүртгэгдсэний 444 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **55.1** хувьтай, өмнөх оныхоос 4.9 нэгжээр буурсан, 362 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*хулгайлах хэрэг 222, бусад төрлийн хэрэг 37, танхайрах хэрэг 31, дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэг тус бүр 18, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 15, булаах хэрэг 11, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах хэрэг 8, хүнийг санаатай алах, тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэг тус бүр 1*) байна.

Гэмт хэрэгт **1590** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 24.8 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 15.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.0 нэгжээр буурч, 7.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.6 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас **1760** иргэн, **4** байгууллага өртөж, **5.0** тэрбум төгрөгийн хохирол учирсны 1.7 тэрбум төгрөг буюу 33.9 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас **52** хүн нас барж, **617** хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 18 буюу 25.7 хувиар, гэмтсэн хүний тоо 101 буюу 14.1 хувиар тус тус буурсан байна.

Тус дүүрэгт 2012 онд **11149** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 10589 иргэн, 91 аж ахуйн нэгж, байгууллагад 80.7 сая төгрөгөөр торгох, 469 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулжээ.

§3.7. Багануур дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **3115** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **482** нэгжээр буюу 18.3 хувиар өсч, тэдгээрийн 99.4 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **642** гомдол, мэдээллийн 284 буюу 44.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 344 буюу 53.6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 341 буюу 99.1 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 553 буюу 86.1 хувийг 5 хоногт, 13.9 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **2491** гомдол, мэдээллийн 1594 буюу 64.0 хувийг торгуулийн хуудсаар, 399 буюу 16.0 хувийг шийтгэврээр тус тус торгож, 163 буюу 6.5 хувийг баривчлах, 280 буюу 11.2 хувийг тээврийн хэрэгслэл жолоодох эрх хасч, 8 буюу 0.3 хувийг нэгтгэн, 47 буюу 1.9 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 99.8 хувийг 14 хоногт, 0.2 хувийг нь 15-28 хоногт тус тус шийдвэрлэжээ.

Багануур дүүрэгт 2012 онд **278** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 60 хэргээр буюу 27.5 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.3, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 2.1 хувийг тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн, 113 буюу 40.6 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 55 буюу 19.8 хувийг хулгайлах, үүнээс 18 буюу 32.7 хувийг мал хулгайлах, 31 буюу 11.1 хувийг танхайрах, 12 буюу 4.3 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 10 буюу 3.6 хувийг хүчиндэх, буюу 2.5 хувийг

бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, 5 буюу 1.8 хувийг тус бүр дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх, 3 буюу 3.6 хувийг татвар төлөхөөс зайлсхийх, бусдыг амиа хорлоход хүргэх 33 буюу 11.9 хэргүүд тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 64 гэмт хэрэг бүртгэгдсэний 43 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **67.2** хувьтай, өмнөх оныхоос 5.4 нэгжээр өссөн, 21 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*хулгайлах хэрэг 17, үүнээс малын хулгай 4, бусдын бие махбодид гэмтэл учруулах, хүчиндэх хэрэг тус бүр 1, бусад төрлийн хэрэг 2*) байна.

Гэмт хэрэгт **308** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 15.3 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 13.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.0 нэгжээр өсч, 3.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 5.5 нэгжээр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас **281** иргэн, **15** байгууллага өртөж, **252.0 сая** төгрөгийн хохирол учирсны 149.1 сая төгрөг буюу 59.2 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас **12** хүн нас барж, **186** хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 9 буюу 4.0 дахин, гэмтсэн хүний тоо 34 буюу 1.2 хувиар тус тус өссөн байна.

Тус дүүрэгт 2012 онд **11581** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 11104 иргэн, 10 аж ахуйн нэгж, байгууллагад 64.6 сая төгрөгөөр торгох, 296 жолоочийн тээврийн хэрэгслэл жолоодох эрхийг хасаж, 171 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулжээ.

§3.8. Багахангай дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **131** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **25** нэгжээр буюу 19.1 хувиар өсч, тэдгээрийг 100 хувь шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **104** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 25 буюу 24.1 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 79 буюу 75.9 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 72 буюу 91.2 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 80 буюу 77.0 хувийг 5 хоногт, 24 буюу 23.0 хувийг 6-19 хоногт хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Багахангай дүүрэг 2012 онд **20** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 9 хэргээр буюу 81.8 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.09, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 14 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 4 нь бусдын эд хөрөнгийг хулгайлах, 2 нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг байна.

Гэмт хэрэгт **23** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 91.6 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 17.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 7.6 нэгжээр буурсан байна.

Тус дүүрэгт 2012 онд **8821** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 8732 иргэн, 53.0 сая төгрөгөөр торгох, 59 тээврийн хэрэгслэл жолоодох эрхийг хасаж, 30 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулжээ.

§3.9. Налайх дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **3230** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **481** нэгжээр буюу 17.5 хувиар өсч, тэдгээрийн 99.9 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **848** гомдол, мэдээллийн 341 буюу 40.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 489 буюу 57.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 487 буюу 99.6 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 533 буюу 62.9 хувийг 5 хоногт, 37.1 хувийг 6-19 хоногт багтаан тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **2356** гомдол, мэдээллийн 1662 буюу 70.5 хувийг торгуулийн хуудсаар, 189 буюу 8.0 хувийг шийтгэврээр тус тус торгож, 132 буюу 5.6 хувийг баривчлах, 371 буюу 15.8 хувийг тээврийн хэрэгслэл жолоодох эрх хасч, 2 буюу 0.1 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус 14 хоногт шийдвэрлэжээ.

Налайх дүүрэгт 2012 онд **290** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 48 хэргээр буюу 19.8 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.3, нийслэлд бүртгэгдсэн 2.2 хувийг тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 119 буюу 41.0 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 60 буюу 20.8 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах *үүнээс 12 буюу 4.1 хувийг мал хулгайлах*, 21 буюу 7.2 хувийг танхайрах, 16 буюу 5.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 8 буюу 2.8 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 7 буюу 2.4 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 6 буюу 2.1 хувийг ойн тухайн хууль тогтоомж зөрчих, 4 буюу 1.4 хувийг тус бүр бусдыг амиа хорлоход хүргэх, хүчиндэх, 3 буюу 1.0 хувийг тус бүр хүнийг санаатай алах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, 1 буюу 0.3 хувийг завших, үрэгдүүлэх, 38 буюу 13.1 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 79 гэмт хэрэг бүртгэгдсэний 52 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт 65.8 хувьтай, өмнөх оныхоос 1.1 нэгжээр өсч, 27 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй *(23 нь хулгайлах, үүнээс 7 нь мал хулгайлах, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах 2, бусдын бие махбодид гэмтэл учруулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэг тус бүр 1)* байна.

Гэмт хэрэгт **292** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 6.6 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 18.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.7 нэгжээр өсч, 7.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.1 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт халдлагад 295 иргэн, 2 байгууллага өртөж 526.0 сая төгрөгийн хохирол учирсны 372.7 сая төгрөг буюу 70.9 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас **21** хүн нас барж, **176** хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 9 буюу 30.0, гэмтсэн хүний тоо 2 буюу 1.1 хувиар тус тус буурсан байна.

Тус дүүрэгт 2012 онд 14641 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 14075 иргэн, 2 албан тушаалтан, 22 аж ахуйн нэгж, байгууллагад 73.9 сая төгрөгөөр торгох, 403 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 139 хүнд баривчлах шийтгэл тус тус ноогдуулж, 3373 хүнийг эрүүлжүүлжээ.

§3.10. Төмөр замын салбар дахь эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **628** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **161** нэгжээр буюу 34.5 хувиар өсч, тэдгээрийн 95.3 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **269** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 119 буюу 44.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 12 буюу 4.5 хувьд нэгтгэн шалгаж, 138 буюу 51.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 114 буюу 42.4 хувийг 5 хоногт, 155 буюу 57.6 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **330** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 1 буюу 0.3 хувийг торгуулийн хуудсаар, 267 буюу 80.9 хувийг шийтгэврээр тус тус торгож, 17 буюу 5.2 хувийг баривчилж, 44 буюу 13.3 хувийг тээврийн хэрэгслэл жолоодох эрх хасч, 1 буюу 0.3 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 318 буюу 96.4 хувийг 14 хоногт, 12 буюу 3.6 хувийг 15-28 хоногт тус тус хянаж шийдвэрлэжээ.

Төмөр зам дахь салбарт 2012 онд **99** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 23 хэргээр буюу 18.8 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.4 хувийг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 32 буюу 32.3 хувийг хулгайлах, 19 буюу 19.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 14 буюу 14.2 хувийг эд зүйлийг хууль хил нэвтрүүлэх, 10 буюу 10.1 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, 4 буюу 4.1 хувийг танхайрах, 3 буюу 3.1 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 1 буюу 1.0 хувийг тус бүр бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, 15 буюу 15.1 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 35 гэмт хэрэг бүртгэгдсэний 26 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **74.3** хувьтай, өмнөх оныхоос 8.6 нэгжээр, 9 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*6 нь хулгайлах, 1 нь танхайрах, 2 нь бусад хэрэг*) байна.

Гэмт хэрэгт **120** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 8.4 хувиар буурч, нийт шалгагдсан хүний 25.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 3.7 нэгжээр, 18.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 13.0 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн халдлагад **87** иргэн, **6** байгууллага өртөж, **189.8 сая** төгрөгийн хохирол учирсны 136.8 сая төгрөг буюу 72.1 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас **25** хүн гэмтсэн нь өмнөх оныхоос 12 буюу 32.4 хувиар буурсан байна.

Тус салбарт 2011 онд **12572** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 12509 иргэнд, 65.0 сая төгрөгөөр торгох, 44 хүний тээврийн хэрэгслэл жолоодох эрхийг хасаж, 18 хүнийг баривчлах шийтгэл ногдуулжээ.

§3.11. Иргэний агаарын тээврийн салбар дахь эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **72** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос 29 нэгжээр буюу 67.4 хувиар өсч, тэдгээрийн 93.1 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **54** гомдол, мэдээллийн 15 буюу 27.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 39 буюу 72.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 32 буюу 59.3 хувийг 5 хоногт, 35.2 хувийг 6-19 хоногт, 3 буюу 5.6 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

Захиргааны зөрчлийн талаарх **4** гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байна.

Тус салбарт 2012 онд **13** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 2 хэргээр буюу 18.2 хувиар өсчээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 3 гэмт хэрэг бүртгэгдсэний 1 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **33.3** хувьтай, өмнөх оныхоос 41.7 нэгжээр буурсан, *танхайрах болон бусад төрлийн тус бүр 1 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй байна.*

Гэмт хэрэгт **9** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 80.0 хувиар өссөн, шалгагдсан хүний 2 нь эмэгтэй хүн байна.

Гэмт хэргийн халдлагад **11** иргэн өртөж, **26.3 сая** төгрөгийн хохирол учирч, гурван хүн гэмтсэн байна.

2012 онд **1778** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 1778 иргэнд, 8.9 сая төгрөгөөр торгох шийтгэл тус тус ногдуулжээ.

§3.12. Нийслэлийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **51160** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **2450** нэгжээр буюу 5.0 хувиар өсчээ.

Гэмт хэргийн талаарх **30677** гомдол, мэдээллийн 12482 буюу 40.6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 17696 буюу 57.6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 17551 буюу 57.2 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 13507 буюу 44.0 хувийг 5 хоногт, 55.1 хувийг 6-19 хоногт, 0.8 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **17921** гомдол, мэдээллийн 6018 буюу 33.5 хувийг торгуулийн хуудсаар, 6674 буюу 37.2 хувийг шийтгэврээр тус тус торгож, 2881 буюу 16.0 хувийг баривчлах, 652 буюу 3.6 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 1678 буюу 9.3 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 93.7 хувийг 14 хоногт, 6.1 хувийг нь 15-28 хоногт, 0.1 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж шийдвэрлэжээ.

Нийслэлд 2012 онд **12910** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 2137 хэргээр буюу 19.8 хувиар өсчээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 3662 буюу 28.3 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 3385 буюу 26.2 хувийг хулгайлах, үүнээс 76 буюу 0.6 хувийг малын хулгай, 1245 буюу 9.6 хувийг танхайрах, 920 буюу 7.1 хувийг залилан мэхлэх, 511 буюу 4.0 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 184 буюу 1.4 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 572 буюу 4.4 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 442 буюу 3.4 хувийг дээрэмдэх, 155 буюу 1.2 хувийг хүчиндэх, 146 буюу 1.1 хувийг завших, үрэгдүүлэх, 120 буюу 1.0 хувийг хүнийг санаатай алах, 145 буюу 1.1 хувийг булаах, 93 буюу 0.7 хувийг аж ахуйн эсрэг, 42 буюу 0.3 хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 5316 гэмт хэрэг бүртгэгдсэний 2748 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **51.7** хувьтай, өмнөх оныхоос 7.1 нэгжээр буурсан, **2568** гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (1625 нь хулгайлах, үүнээс 1292 нь хувийн өмчийг хулгайлах, 38 нь мал хулгайлах, 165 нь дээрэмдэх, 140 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 175 нь танхайрах, 70 нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 125 нь залилан мэхэлж авах, 63 нь булаах, 17 нь хүчиндэх, 12 нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 3 нь хүнийг санаатай алах, 173 нь бусад төрлийн хэрэг) байна.

Гэмт хэрэгт **10529** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 11.0 хувиар өссөн ч, нийт шалгагдсан хүний 16.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.3 нэгжээр өсч, 6.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.1 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас **12404** иргэн, **37** байгууллага өртөж **37039.7** сая төгрөгийн хохирол учирсны 13454.5 сая төгрөг буюу 36.3 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас **386** хүн нас барж, **5032** хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 41 буюу 9.6 хувиар буурсан, гэмтсэн хүний тоо 174 буюу 3.5 хувиар өссөн байна.

§4. АЙМГУУДЫН ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

§4.1. Архангай аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Архангай аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **2861** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **861** нэгжээр буюу 23.1 хувиар буурч, тэдгээрийн 99.8 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **712** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 423 буюу 59.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 9 буюу 1.3 хувьд нэгтгэж, 280 буюу 39.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 262 буюу 93.6 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 542 буюу 76.2 хувийг 5 хоногт, 170 буюу 23.8 хувийг 14 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **1966** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 822 буюу 41.8 хувийг торгуулийн хуудсаар, 292 буюу 14.8 хувийг шийтгэврээр тус тус торгож, 491 буюу 24.9 хувийг баривчлах, 360 буюу 18.3 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 1 буюу 0.1 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр шийтгэл ногдуулж тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 99.8 хувийг 14 хоногт, 0.2 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж, шийдвэрлэжээ.

Архангай аймагт 2012 онд **418** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 33 хэргээр буюу 8.6 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.9, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 4.6, хангайн бүсийн 6 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 15.7 хувийг тус тус эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 11 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 166 буюу 39.7 хувийг хулгайлах, 105 буюу 25.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 23 буюу 5.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 8 буюу 2.0 хувийг

танхайрах, 7 буюу 1.7 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 5 буюу 1.2 хувийг тус бүр залилан мэхлэх болон дээрэмдэх, 4 буюу 0.9 хувийг тус бүр хүнийг санаатай алах болон зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 3 буюу 0.7 хувийг хүчиндэх, 2 буюу 0.5 хувийг завших, үрэгдүүлэх, 1 буюу 0.2 хувийг булаах, 85 буюу 20.3 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 161 гэмт хэргээс 120 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **74.5** хувьтай, өмнөх оныхоос 12.3 нэгжээр өссөн статистик үзүүлэлттэй, 41 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*37 нь хулгайлах, үүнээс 23 нь мал хулгайлах, 2 нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 1 нь дээрэмдэх тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих хэрэг*) байна.

Гэмт хэрэгт **405** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 1.2 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 4.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.6 нэгжээр буурч, 8.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 4.6 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн халдлагад 353 иргэн, 7 байгууллага өртөж, 641.9 сая төгрөгийн хохирол учирсны 421.8 сая төгрөг буюу 65.7 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 23 хүн нас барж, 132 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 8 буюу 25.8 хувиар, гэмтсэн хүний тоо 33 буюу 2.0 хувиар буурсан байна.

Архангай аймагт 2012 онд **1990** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 1130 иргэнд 12.7 сая төгрөгөөр торгох, 363 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 497 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 856 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.2. Баян-Өлгий аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Баян-Өлгий аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **3547** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **626** нэгжээр буюу 21.4 хувиар өсч, тэдгээрийн 99.6 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1629** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 524 буюу 32.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 1000 буюу 61.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 978 буюу 97.8 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 1229 буюу 75.4 хувийг 5 хоногт, 400 буюу 24.6 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **1496** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 490 буюу 32.8 хувийг торгуулийн хуудсаар, 528 буюу 35.3 хувийг шийтгэврээр тус тус торгож, 197 буюу 13.2 хувийг баривчлах, 264 буюу 17.6 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 16 буюу 1.1 хувийг нэгтгэн шалгаж, 1 зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 98.1 хувийг 14 хоногт, 1.9 хувийг нь 15-28 хоногт шийдвэрлэжээ.

Баян-Өлгий аймагт 2012 онд 467 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 122 хэргээр буюу 35.4 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 2.1, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 5.2 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 37 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 238 буюу 50.9 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 110 буюу 23.6 хувийг хулгайлах (үүний 62 буюу 56.4 хувь нь малын хулгай), 25 буюу 5.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын

журмын эсрэг, 14 буюу 2.9 хувийг захиргааны журмын эсрэг, 13 буюу 2.9 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг (үүнээс 11 буюу 94.6 хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчих), 10 буюу 2.1 хувийг аж ахуйн эсрэг, 8 буюу 1.7 хувийг хүчиндэх, 7 буюу 1.5 хувийг завших, үрэгдүүлэх, 5 буюу 1.0 хувийг танхайрах, 4 буюу 0.8 хувийг залилан мэхлэх, 3 буюу 0.6 хувийг дээрэмдэх, 1 буюу 0.2 хувийг хүнийг санаатай алах, 29 буюу 6.2 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 92 гэмт хэргээс 57 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **62.0** хувьтай, өмнөх оныхоос 6.8 нэгжээр өссөн үзүүлэлттэй, 35 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*26 буюу 74.3 хувь нь хулгайлах, үүнээс 17 буюу 65.4 хувь нь мал хулгайлах, 2 буюу 5.7 хувь нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг, 2 буюу 5.7 хувь нь залилан мэхлэх, 5 буюу 14.3 хувь нь бусад төрлийн хэрэг*) байна.

Гэмт хэргэгт 500 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 38.8 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 4.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 4.0 нэгжээр, 3.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 3.9 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн халдлагад 417 иргэн, 5 байгууллага өртөж, 328.0 сая төгрөгийн хохирол учирсны 281.3 сая төгрөг буюу 85.8 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 6 хүн нас барж, 111 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 7 буюу 53.8 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 7 буюу 6.7 хувиар өссөн байна.

Баян-Өлгий аймагт 2012 онд **8450** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 7970 иргэн, 2 албан тушаалтанд 36.3 сая төгрөгөөр торгох, 266 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 212 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 1079 (хоногт 3 хүн) хүнийг эрүүлжүүлжээ.

§4.3. Баянхонгор аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Баянхонгор аймгийн цагдаагийн хэлтэс нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **4042** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **551** нэгжээр буюу 15.8 хувиар өсч, тэдгээрийн 100.0 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **922** гомдол, мэдээллийн 367 буюу 39.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 480 буюу 52.1 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 479 буюу 99.8 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 653 буюу 70.8 хувийг 5 хоногт, 29.2 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **3231** гомдол, мэдээллийн 1683 буюу 52.1 хувийг торгуулийн хуудсаар, 770 буюу 23.8 хувийг шийтгэврээр тус тус торгож, 258 буюу 8.0 хувийг баривчлах, 517 буюу 16.0 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 3 буюу 0.1 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 99.4 хувийг 14 хоногт, 0.6 хувийг нь 15-28 хоногт шийдвэрлэжээ.

Баянхонгор аймагт 2012 онд **336** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 11 хэргээр буюу 3.2 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.5, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 3.7 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 93 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 97 буюу 28.9 хувийг хулгайлах, үүнээс 42 буюу 43.2 хувийг малын хулгай, 86 буюу 25.6 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 38 буюу 11.3 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам

зөрчих, 19 буюу 5.7 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 18 буюу 5.3 хувийг танхайрах, 10 буюу 3.0 хувийг тус бүр хүн амын эрүүл мэндийн эсрэг хэрэг, байгаль хамгаалах журмын эсрэг, 9 буюу 2.7 хувийг хүчиндэх, 5 буюу 1.5 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 3 буюу 0.9 хувийг тус бүр хүнийг санаатай алах, завших, үрэгдүүлэх, 2 буюу 0.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 1 буюу 0.3 хувийг дээрэмдэх гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 81 гэмт хэргээс 56 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **69.1** хувьтай, өмнөх оныхоос 3.9 нэгжээр буурсан статистик үзүүлэлттэй, 25 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*24 нь хулгайлах, үүнээс 7 нь мал хэрэг, 1 нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах*) байна.

Гэмт хэрэгт **347** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 4.1 хувиар буурч, нийт шалгагдсан хүний 9.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.7 нэгжээр, 5.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны түвшинд байна.

Гэмт хэргийн халдлагад 338 иргэнд 432.9 сая төгрөгийн хохирол учирсны 275.0 сая төгрөг буюу 63.5 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 28 хүн нас барж, 147 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 9 буюу 47.4 хувиар өсч, гэмтсэн хүний тоо 51 буюу 25.8 хувиар буурсан байна.

Баянхонгор аймагт 2012 онд **7227** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 6428 иргэн, 1 байгууллагад, 42.6 сая төгрөгөөр торгох, 533 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 265 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 1530 (хоногт 4 хүн) хүнийг эрүүлжүүлжээ.

§4.4. Булган аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Булган аймгийн цагдаагийн хэлтэс нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **2326** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **1467** нэгжээр буюу 2,7 дахин хувиар өсчээ.

Гэмт хэргийн талаарх **754** гомдол, мэдээллийн 338 буюу 44.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 327 буюу 43.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 319 буюу 42.3 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 620 буюу 82.2 хувийг 5 хоногт, 17.8 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

Захиргааны зөрчлийн талаарх **1094** гомдол, мэдээллийн 332 буюу 30.3 хувийг торгуулийн хуудсаар, 285 буюу 26.1 хувийг шийтгэврээр тус тус торгож, 125 буюу 11.4 хувийг баривчлах, 188 буюу 17.2 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 161 буюу 14.7 хувийг нэгтгэн шалгаж, 3 буюу 0.3 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Булган аймагт 2012 онд **300** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 51 хэргээр буюу 20.5 хувиар өссөн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.4, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 3.3 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 129 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 78 буюу 26,0 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг, гэмт хэрэг, 67 буюу 22.3 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 127 буюу 42,3 хувийг хулгайлах гэмт хэрэг, 40 буюу 13,3 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 20 буюу 6,7 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 7 буюу 2,3 хувийг танхайрах, 4 буюу 1,3 хувийг дээрэмдэх гэмт хэрэг, 1 буюу

0,3 хувийг булаах гэмт хэрэг, 6 буюу 2 хувийг хүний амь насыг хохироосон хэрэг тус тус эзлэж байна

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 106 гэмт хэргээс 55 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **51.9** хувьтай, өмнөх оныхоос 7.7 нэгжээр өссөн статистик үзүүлэлттэй 51 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*48 нь хулгайлах хэрэг, үүнээс 24 нь мал хулгайлах, хүнийг санаатай алах, булаах, бусад хэрэг тус бүр 1*) байна.

Гэмт хэрэгт **285** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 10.5 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 6.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.3 нэгжээр, 5.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 3.2 нэгжээр буурчээ.

Гэмт хэргийн халдлагад **322** иргэн, 455,1 сая төгрөгийн хохирол учирсаны 293,8 сая төгрөг буюу 64,5 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 14 хүн нас барж, 77 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 5 буюу 55,5 хувиар өсч, гэмтсэн хүний тоо 7 буюу 8,3 хувиар буурсан байна.

Булган аймагт 2012 онд **6836** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 6490 иргэн, 2 албан тушаалтанд 42,3 сая төгрөгөөр торгох, 213 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 130 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 692 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.5. Говь-Алтай аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Говь-Алтай аймгийн цагдаагийн хэлтэс нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **1691** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **314** нэгжээр буюу 15.7 хувиар буурчээ.

Гэмт хэргийн талаарх **474** гомдол, мэдээллийн 196 буюу 41,3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 277 буюу 58.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 269 буюу 56.8 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 437 буюу 92.2 хувийг 5 хоногт, 7.8 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **1208** гомдол, мэдээллийг шийдвэрлэсэний дотор 710 буюу 58.8 хувийг шийтгэврээр торгож, 210 буюу 17.4 хувийг баривчлах, 288 буюу 23.8 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 99.9 хувийг 14 хоногт, 0.1 хувийг нь 15-28 хоногт хянаж шийдвэрлэжээ.

Говь-Алтай аймагт 2012 онд **169** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 21 хэргээр буюу 14.2 хувиар өссөн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.8, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 1.9 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 260 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн

5.9 хувийг хүчиндэх, 4.7 хувийг танхай, 39.6 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, (үүнээс: 34,3 % өмчийн хулгай, 7.5 % авто тээврийн хэрэгслийн хулгай, 32.8 % малын хулгай) 24.8 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 9.5 хувийг ТХХАБАЖЭ гэмт хэрэг, 4.1 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 0.6 хувийг аж ахуйн эсрэг гэмт хэрэг, 1.2 хувийг албан тушаалын гэмт хэрэг, 8.8 хувийг бусад гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 54 гэмт хэргээс 38 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **70.4** хувьтай, өмнөх оныхоос 9.8 нэгжээр өссөн статистик үзүүлэлттэй, 16 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*бусдын эд хөрөнгийг хулгайлах 13, үүний дотор мал хулгайлах 2 хэрэг, бусад хэрэг 3*) байна.

Гэмт хэрэгт **205** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 40.4 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 5.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2 нэгжээр, 7.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 5.7 нэгжээр тус тус өссөн байна.

Гэмт хэргийн халдлагад 177 иргэн, 2 байгууллага өртөж, 292,8 сая төгрөгийн хохирол учирсаны 223,5 сая төгрөг буюу 76,3 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 6 хүн нас барж, 40 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 9 буюу 60,0 хувиар, гэмтсэн хүний тоо 1 буюу 2.4 хувиар тус тус буурсан байна.

Говь-Алтай аймагт 2012 онд **8607** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 8066 иргэнд 55,1 сая төгрөгөөр торгох, 318 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 223 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 1086 хүнийг эрүүлжүүлсэн байна.

§4.6. Говьсүмбэр аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **1030** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **40** нэгжээр буюу 3.7 хувиар буурч, тэдгээрийн 98.9 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **420** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 179 буюу 42.6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 218 буюу 51.9 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 180 буюу 82.6 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 318 буюу 75.7 хувийг 5 хоногт, 98 буюу 23.3 хувийг 6-19 хоногт, 4 буюу 1.0 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 568 гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 241 буюу 42.4 хувийг шийтгэврээр торгож, 122 буюу 21.5 хувийг баривчлах, 202 буюу 35.6 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 3 буюу 0.5 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 99.8 хувийг 14 хоногт, 0.2 хувийг 20 ба түүнээс дээш хоногт шийдвэрлэжээ.

Говьсүмбэр аймагт 2012 онд **160** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 41 хэргээр буюу 34.5 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.7, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 1.8, төвийн бүсэд бүртгэгдсэн хэргийн 4.7 хувийг тус тус эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 270 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 73 буюу 45.6 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 28 буюу 17.5 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах үүнээс 11 буюу 6.9 хувийг малын хулгай, 12 буюу 7.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 10 буюу 6.2 хувийг танхайрах, 4 буюу 2.5 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 3 буюу 1.8 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 2 буюу 1.3 хувийг тус бүр хүнийг санаатай алах, бусдыг амиа хорлоход хүргэх, хүчиндэх, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, 22 буюу 13.7 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй **49** гэмт хэргээс **31** хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **63.3** хувьтай, өмнөх оныхоос 0.5 нэгжээр өсч, **18** гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*8 нь хулгайлах, үүнээс 3 нь мал хулгайлах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, хүчиндэх, танхайрах тус бүр 1, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах 2, бусад хэрэг 5*) байна.

Гэмт хэрэгт 162 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 31.7 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 14.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.4

нэгжээр өсч, 1.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 3.8 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн халдлагад 140 иргэн өртөж, 138.7 сая төгрөгийн хохирол учирсны 47.4 сая төгрөг буюу 34.2 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 4 хүн нас барж, 72 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 4 буюу 50.0 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 14 буюу 24.1 хувиар өссөн байна.

Говьсүмбэр аймагт 2012 онд 3481 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 3151 иргэн, 2 албан тушаалтан, 4 аж ахуйн нэгж, байгууллагад 18.9 сая төгрөгөөр торгох, 202 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 122 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 985 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.7. Дархан-Уул аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Дархан-Уул аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **3249** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **1738** нэгжээр буюу 2.2 дахин өсч, тэдгээрийн 99.5 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1620** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 726 буюу 44.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 873 буюу 53.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 99.6 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 827 буюу 51.1 хувийг 5 хоногт, 793 буюу 48.9 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **130** гомдол, мэдээллийн 43 буюу 33.1 хувийг торгуулийн хуудсаар, 54 буюу 41.5 хувийг шийтгэврээр тус тус торгож, 11 буюу 8.5 хувийг баривчлах, 9 буюу 6.9 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 13 буюу 10.0 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 70.0 хувийг 14 хоногт, 30.0 хувийг нь 15-28 хоногт хянаж шийдвэрлэжээ.

Дархан-Уул аймагт 2012 онд **619** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 62 хэргээр буюу 11.1 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 2.8, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 6.8, төвийн бүсийн 7 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 18.2 хувийг тус тус эзэлж байна. Аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 190 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 251 буюу 41.0 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 159 буюу 25.7 хувийг хулгайлах, 43 буюу 6.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 31 буюу 5.0 хувийг дээрэмдэх, 28 буюу 4.5 хувийг танхайрах, 11 буюу 1.7 хувийг завших, үрэгдүүлэх, 9 буюу 1.4 хувийг тус бүр бусдыг амиа хорлоход хүргэх, хүчиндэх, залилан мэхлэх, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 8 буюу 1.2 хувийг хүчиндэх, 4 буюу 0.6 хувийг тус бүр хүнийг санаатай алах, булаах, 44 буюу 7.2 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 174 гэмт хэргээс 104 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **59.8** хувьтай, өмнөх оныхоос 7.2 нэгжээр буурсан статистик үзүүлэлттэй, 70 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*52 нь хулгайлах, үүнээс 17 нь мал хулгайлах, 5 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 3 нь дээрэмдэх, 2 нь булаах, 1 нь танхайрах, 7 нь бусад төрлийн гэмт хэрэг*) байна.

Гэмт хэрэгт **639** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 12.3 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 13.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 3.0 нэгжээр буурч, 8.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.5 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн халдлагад 618 иргэн өртөж, 801.8 сая төгрөгийн хохирол учирсны 492.2 сая төгрөг буюу 61.4 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 28 хүн нас барж, 186 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 3 буюу 9.6 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 52 буюу 38.8 хувиар өссөн байна.

Дархан-Уул аймагт 2012 онд **16982** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 15970 иргэн, 61 аж ахуйн нэгж, байгууллагад 93.7 сая төгрөгөөр торгох, 659 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 292 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 5642 хүн эрүүлжүүлэгджээ.

§4.8. Дорноговь аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Дорноговь аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **2381** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **653** нэгжээр буюу 37.8 хувиар өсч, тэдгээрийн 98.0 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1205** гомдол, мэдээллийн 632 буюу 52.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 1 буюу 0.1 хувийг нэгтгэж, 572 буюу 47.5 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 571 буюу 99.8 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 784 буюу 65.1 хувийг 5 хоногт, 421 буюу 34.9 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 1144 гомдол, мэдээллийн 263 буюу 23.0 хувийг торгуулийн хуудсаар, 464 буюу 40.5 хувийг шийтгэврээр тус тус торгож, 150 буюу 13.1 хувийг баривчлах, 243 буюу 21.2 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 24 буюу 2.2 хувийг хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 1058 буюу 92.5 хувийг 14 хоногт, 85 буюу 7.4 хувийг 15-28 хоногт, 1 буюу 0.1 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж шийдвэрлэжээ.

Дорноговь аймагт 2012 онд 582 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 36 хэргээр буюу 6.2 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 2.6, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 6.3, төвийн бүсийн 7 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 17.1 хувийг тус тус эзэлж, аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 152 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 220 буюу 37.8 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 141 буюу 24.2 хувийг хулгайлах, үүнээс 35 буюу 6.0 хувийг малын хулгай, 37 буюу 6.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 22 буюу 3.7 хувийг бусад төрлийн гэмт хэрэг, 20 буюу 3.4 хувийг тус бүр эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, танхайрах, 13 буюу 2.2 хувийг тус бүр хүчиндэх, захиргааны журмын эсрэг гэмт хэрэг, 10 буюу 1.7 хувийг тус бүр бусдыг амиа хорлоход хүргэх, татвар төлөхөөс зайлсхийх, дээрэмдэх, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, 9 буюу 1.5 хувийг тус бүр залилан мэхлэх, хүнийг санаатай алах гэмт хэрэг, 7 буюу 1.2 хувийг тус бүр завших, үрэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 6 буюу 1.0 хувийг булаах, 5 буюу 0.8 хувийг тус бүр ан агнуурын хууль зөрчих, албан тушаалын гэмт хэрэг, 4 буюу 0.7 хувийг цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, зугтаах, 2 буюу 0.3 хувийг тус бүр бусдыг болгоомжгүй алах, шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 100 гэмт хэргээс 56 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн

илрүүлэлт 56.0 хувьтай, өмнөх оныхоос 4.5 нэгжээр буурсан үзүүлэлттэй, 44 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (35 нь хулгайлах, үүнээс 3 нь мал хулгайлах, булаах, дээрэмдэх, хүчиндэх хэрэг тус бүр 1, бусдын бие махбодид гэмтэл учруулах 3, бусад төрлийн хэрэг тус бүр 2) байна.

Гэмт хэрэгт 611 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 3.9, нийт шалгагдсан хүний 5.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 3.3 нэгжээр тус тус өсч, 12.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.5 нэгжээр буурсан байна.

Гэмт хэргийн халдлагад 529 иргэн, 24 байгууллага өртөж, 762.8 сая төгрөгийн хохирол учирсны 524.9 сая төгрөг буюу 68.8 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 31 хүн нас барж, 267 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 15 буюу 93.8 хувиар өсч, гэмтсэн хүний тоо 24 буюу 8.2 хувиар буурсан байна.

Дорноговь аймагт 2012 онд 13197 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 12270 иргэн, 1 албан тушаалтан, 18 аж ахуйн нэгж, байгууллагад 94.5 сая төгрөгөөр торгох, 574 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 334 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 3426 хүн эрүүлжүүлжээ.

§4.9. Дорнод аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Дорнод аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **5854** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **149** нэгжээр буюу 2.6 хувиар өсч, тэдгээрийн 98.1 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1791** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 680 буюу 37.9 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 987 буюу 55.1 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 930 буюу 98.9 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 584 буюу 32.6 хувийг 5 хоногт, 62.3 хувийг 6-19 хоногт, 5.1 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **4209** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 28 буюу 0.7 хувийг торгуулийн хуудсаар, 3339 буюу 79.3 хувийг шийтгэврээр тус тус торгож, 444 буюу 10.5 хувийг баривчлах, 366 буюу 8.7 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 97.9 хувийг 14 хоногт, 0.6 хувийг нь 15-28 хоногт, 1.5 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж, шийдвэрлэжээ.

Дорнод аймагт 2012 онд 578 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 165 хэргээр буюу 40.0 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 2.6, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 6.4 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 148 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 215 буюу 37.2 хувийг хулгайлах (үүний дотор 111 буюу 51.6 хувийг малын хулгай), 172 буюу 29.8 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 34 буюу 5.9 хувийг танхайрах, 33 буюу 5.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг, 12 буюу 2.1 хувийг залилан мэхлэх, 9 буюу 1.5 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 6 буюу 1.0 хувийг дээрэмдэх, 4 буюу 0.7 хувийг хүнийг санаатай алах, 4 буюу 0.7 хувийг булаах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 168 гэмт хэрэг бүртгэгдсэний 100 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт 59.5 хувьтай, өмнөх оныхоос 3.9 нэгжээр буурсан үзүүлэлттэй, 68 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (62 нь хулгайлах, үүнээс 32 нь мал хулгайлах, 3 нь танхайрах, 1 нь дээрэмдэх, бусад төрлийн хэрэг 2) байна.

Гэмт хэрэгт 568 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 30.9 хувиар буурч, нийт шалгагдсан хүний 9.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.4 нэгжээр өсөж, 4.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.4 нэгжээр буурсан байна.

Гэмт хэргийн халдлагад 553 иргэн, 23 байгууллага өртөж, 903.9 сая төгрөгийн хохирол учирсны 679.7 сая төгрөг буюу 75.2 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 25 хүн нас барж, 134 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 5 буюу 25.0 хувиар өсөж, гэмтсэн хүний тоо 20 буюу 12.9 хувиар буурсан байна.

Дорнод аймагт 2012 онд **18963** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 18137 иргэн, 11 аж ахуйн нэгж, байгууллагад 100.9 сая төгрөгөөр торгох, 368 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 445 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 7199 (хоногт 20) хүн эрүүлжүүлэгджээ.

§4.10. Дундговь аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Дундговь аймгийн цагдаагийн хэлтэс нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **1870** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **777** нэгжээр буюу 71.1 хувиар өсч, тэдгээрийг бүрэн шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **645** гомдол, мэдээллийг шийдвэрлэсний дотор 226 буюу 35.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 405 буюу 62.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 559 буюу 86.7 хувийг 5 хоногт, 86 буюу 13.3 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 1249 гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 591 буюу 47.3 хувийг торгуулийн хуудсаар, 279 буюу 22.3 хувийг шийтгэврээр тус тус торгож, 189 буюу 15.1 хувийг баривчлах, 187 буюу 15.0 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 3 буюу 0.2 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 14 хоногт бүрэн хянаж шийдвэрлэжээ.

Дундговь аймагт 2012 онд 201 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 5 хэргээр буюу 2.4 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.9, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 2.2, төвийн бүсийн 7 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.9 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 228 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн
80 буюу 39.8 хувийг хулгайлах, (
үүнээс 31 буюу 38.7 хувийг малын хулгай, 40 буюу 50.0 хувийг өмчийн хулгай, 1 буюу 1.2 хувийг авто тээврийн хэрэгсэл хулгайлах),
73 буюу 36.3 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
12 буюу 6.0 хувийг танхайрах,
9 буюу 4.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
2 буюу 1.0 хувийг тус бүр хүчиндэх, дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх,
5 буюу 2.5 хувийг залилан мэхлэх,
1 буюу 0.5 хувийг хүнийг санаатай алах гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 84 гэмт хэргээс 52 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоож, гэмт хэргийн илрүүлэлт

61.9 хувьтай, өмнөх оныхоос 16.1 нэгжээр буурсан статистик үзүүлэлттэй, 32 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй байна.

Гэмт хэрэгт **188** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 6.5 хувиар буурч, нийт шалгагдсан хүний 5.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.2 нэгжээр, 2.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 4.4 нэгжээр тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн хэргийн 64 буюу 31.8 хувь нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн халдлагад 205 иргэн өртөж 300.6 сая төгрөгийн хохирол учирсны 172.3 сая төгрөг буюу 57.3 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 4 хүн нас барж, 102 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 15 буюу 78.9 хувиар, гэмтсэн хүний тоо 11 буюу 12.1 хувиар тус тус буурсан байна.

Дундговь аймагт 2012 онд 4622 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 4244 иргэнд 26.9 сая төгрөгөөр торгох, 187 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 191 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 928 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.11. Завхан аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Завхан аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **2668** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **880** нэгжээр буюу 49.2 хувиар өсч, тэдгээрийн 99.9 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1254** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 421 буюу 33.6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 816 буюу 65.1 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 800 буюу 98.0 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 1113 буюу 88.7 хувийг 5 хоногт, 140 буюу 11.2 хувийг 6-19 хоногт, 1 буюу 0.1 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 1429 гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 144 буюу 10.0 хувийг торгуулийн хуудсаар, 676 буюу 47.3 хувийг шийтгэврээр тус тус торгож, 172 буюу 12.0 хувийг баривчлах, 281 буюу 19.7 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 156 буюу 11.0 хувийг нэгтгэн шалгаж шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 99.5 хувийг 14 хоногт, 0.5 хувийг 15-28 хоногт шийдвэрлэжээ.

Завхан аймагт 2012 онд **354** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос **34** хэргээр буюу 10.6 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.6, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 3.9, баруун бүсэд бүртгэгдсэн хэргийн 22.3 хувийг тус тус эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 76 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 139 буюу 39.3 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 111 буюу 31.4 хувийг хулгайлах үүнээс 59 буюу 16.7 хувийг малын хулгай, 19 буюу 5.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 14 буюу 4.0 хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчих, 12 буюу 3.4 хувийг танхайрах, 7 буюу 2.0 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 3 буюу 0.8 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 2 буюу 0.5 хувийг тус бүр хүнийг санаатай алах, хүчиндэх, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 1 буюу 0.3 хувийг тус бүр бусдыг болгоомжгүй алах, бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх, хориглосон үйлдвэр, үйлчилгээ худалдаа эрхлэх, ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих, 36 буюу 10.2 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 83 гэмт хэргээс 42 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **50.6** хувьтай, өмнөх оныхоос 28.5 хувиар өсч, **41** гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*37 нь хулгайлах, үүнээс 19 нь мал хулгайлах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон ашиглалтын журам зөрчих тус бүр 1, бусад хэрэг 2*) байна.

Гэмт хэргт 330 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 38.1 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 7.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.4 нэгжээр, 4.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.4 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн халдлагад 282 иргэн өртөж, 236.6 сая төгрөгийн хохирол учирсны 158.3 сая төгрөг буюу 66.9 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 10 хүн нас барж, 115 хүн гэмтэж, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеийн түвшинд, гэмтсэн хүний тоо 40 буюу 53.3 хувиар өссөн байна.

Завхан аймагт 2012 онд 12371 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 11789 иргэн, 2 албан тушаалтан, 2 аж ахуйн нэгж, байгууллагад 67.9 сая төгрөгөөр торгох, 288 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 290 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 2852 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.12. Орхон аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Орхон аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **7395** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **376** нэгжээр буюу 5.4 хувиар өсч, тэдгээрийн 98.0 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1395** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 609 буюу 43.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 716 буюу 51.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 717 буюу 99.9 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 1073 буюу 76.9 хувийг 5 хоногт, 22.4 хувийг 6-19 хоногт, 0.6 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **6127** гомдол, мэдээллийн 1466 буюу 23.9 хувийг торгуулийн хуудсаар, 2520 буюу 41.1 хувийг шийтгэврээр тус тус торгож, 822 буюу 13.4 хувийг баривчлах, 1221 буюу 19.9 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 30 буюу 0.5 хувийг нэгтгэн шалгаж, 68 буюу 1.1 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 96.2 хувийг 14 хоногт, 3.3 хувийг нь 15-28 хоногт, 0.4 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж шийдвэрлэжээ.

Орхон аймагт 2012 онд **545** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 64 хэргээр буюу 13.3 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 2.5, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 6.0 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 116 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 192 буюу 35.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 138 буюу 25.3 хувийг хулгайлах, үүнээс 9 нь малын хулгай, 43 буюу 7.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 38 буюу 7.0 хувийг танхайрах, 35 буюу 6.4 хувийг залилан мэхлэх, 16 буюу 2.9 хувийг дээрэмдэх, 11 буюу 2.0 хувийг хүчиндэх, 10 буюу 1.8 хувийг хүнийг санаатай алах, 9 буюу 1.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 8 буюу 1.5 хувийг бусдын эд хөрөнгийг завших,

үрэгдүүлэх, 8 буюу 1.5 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, 6 буюу 1.1 хувийг булаах, 31 буюу 5.7 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 221 гэмт хэргээс 129 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **58.4** хувьтай, өмнөх оныхоос 1.7 нэгжээр буурсан үзүүлэлттэй, 92 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*хулгайлах 62, үүнээс малын хулгай 2, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 10, булаах, дээрэмдэх хэрэг тус бүр 5, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэг 3, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах хэрэг 2, хүнийг санаатай алах, хүчиндэх хэрэг тус бүр 1, бусад төрлийн хэрэг 3*) байна.

Гэмт хэрэгт **547** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 23.8 хувиар буурч, нийт шалгагдсан хүний 19.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.5 нэгжээр өсч, 9.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.5 нэгжээр буурсан байна.

Гэмт хэргийн халдлагад 532 иргэн, 9 байгууллага өртөж, 930.4 сая төгрөгийн хохирол учирсны 655.0 сая төгрөг буюу 70.4 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 26 хүн нас барж, 282 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 3 буюу 13.0, гэмтсэн хүний тоо 67 буюу 31.2 хувиар тус тус өссөн байна.

Орхон аймагт 2012 онд **23403** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 21347 иргэн, 1 албан тушаалтан, 13 байгууллагад 129.6 сая төгрөгөөр торгох, 1221 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 821 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 5404 (хоногт 14 хүн) хүнийг эрүүлжүүлжээ.

§4.13. Өвөрхангай аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Өвөрхангай аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **2510** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **1262** нэгжээр буюу 2.0 дахин өсч, тэдгээрийн 99.3 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1179** гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 634 буюу 53.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 475 буюу 40.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 456 буюу 96.0 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 71.5 хувийг 5 хоногт, 28.5 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 790 гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс: 262 буюу 33.1 хувийг торгуулийн хуудсаар, 226 буюу 28.6 хувийг шийтгэврээр тус тус торгож, 164 буюу 20.7 хувийг баривчлах, 115 буюу 14.5 хувийг тээврийн хэрэгслэл жолоодох эрх хасах, 11 буюу 1.4 хувийг нэгтгэх, 12 буюу 1.5 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр арга хэмжээ авч тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 98.6 хувийг 14 хоногт, 1.4 хувийг 15-28 хоногт шийдвэрлэжээ.

Өвөрхангай аймагт 2012 онд **545** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 72 хэргээр буюу 15.2 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 2.5, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 6.0, хангайн бүсийн 6 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 20.5 хувийг тус тус эзэлж байна. Аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 116 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 191 буюу 35.1 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 182 буюу 33.4 хувийг хулгайлах, 44 буюу 8.1 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 17 буюу 3.1 хувийг танхайрах, 14 буюу 2.5 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх,

зугтаах, 11 буюу 2.0 хувийг хүчиндэх, 10 буюу 1.8 хувийг хүнийг санаатай алах, 7 буюу 1.3 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 5 буюу 0.9 хувийг залилан мэхлэх, 3 буюу 0.5 хувийг дээрэмдэх, 2 буюу 0.4 хувийг завших, үрэгдүүлэх, 59 буюу 10.9 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 212 гэмт хэргээс 141 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **66.5** хувьтай, өмнөх оныхоос 10.0 нэгжээр өссөн үзүүлэлттэй.

Гэмт хэрэгт **549** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 14.8 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 7.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.7 нэгжээр, 7.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.4 нэгжээр тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 34.1 хувь нь буюу 186 хэрэг согтуугаар үйлдэгдсэн бөгөөд яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 1 хэрэг байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 6 буюу 3,2 хувь нь хүүхэд оролцож, 3 буюу 1.6 хувь эмэгтэй хүн оролцсон байна.

Гэмт хэргийн халдлагад 555 иргэн өртөж, 719.9 сая төгрөгийн хохирол учирсны 438.9 сая төгрөг буюу 61.0 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 43 хүн нас барж, 251 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 13 буюу 43.3 хувиар, гэмтсэн хүний тоо 51 буюу 25.5 хувиар тус тус өссөн байна.

Өвөрхангай аймагт 2012 онд **8195** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 7308 иргэнд 42.8 сая төгрөгөөр торгох, 418 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 469 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 1516 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.14. Өмнөговь аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Өмнөговь аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **3789** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **599** нэгжээр буюу 18.8 хувиар өсч, тэдгээрийн 99.5 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **923** гомдол, мэдээллийг шийдвэрлэснээс 419 буюу 45.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 463 буюу 50.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 461 буюу 99.6 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 541 буюу 58.6 хувийг 5 хоногт, 382 буюу 41.4 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх **1966** гомдол, мэдээллийг шийдвэрлэснээс 204 буюу 10.4 хувийг торгуулийн хуудсаар, 1013 буюу 51.5 хувийг шийтгэврээр тус тус торгож, 213 буюу 10.8 хувийг баривчлах, 535 буюу 27.2 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 99.8 хувийг 14 хоногт, 0.2 хувийг 15-28 хоногт хянаж, шийдвэрлэжээ.

Өмнөговь аймагт 2012 онд **358** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 35 хэргээр буюу 10.8 хувиар өсжээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.6 хувь, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 3.9 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 72 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 126 буюу 35.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 73 буюу 20.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг, 69 буюу 19.3 хувийг хулгайлах (үүнээс 5 буюу 7.2 хувийг малын хулгай), 11 буюу 3.1 хувийг танхайрах, 9 буюу 2.5 хувийг завших, үрэгдүүлэх, 6 буюу 1.7 хувийг хүчиндэх, 6 буюу 1.7 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 5 буюу 1.4

хувийг хүнийг санаатай алах, 5 буюу 1.4 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг, 5 буюу 1.4 хувийг хүн амын эрүүл мэндийн эсрэг, 5 буюу 1.4 хувийг иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг, 4 буюу 1.1 хувийг залилан мэхлэх, 3 буюу 0.8 хувийг аж ахуйн эсрэг, 3 буюу 0.8 хувийг албан тушаалын, 3 буюу 0.8 хувийг захиргааны журмын эсрэг, 2 буюу 0.6 хувийг дээрэмдэх, 1 буюу 0.3 хувийг булаах гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 70 гэмт хэрэг бүртгэгдсэний 43 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт 61.4 хувьтай, өмнөх оныхоос 11.6 нэгжээр буурсан, 27 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*21 нь хулгайлах, 3 нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг, 1 нь аж ахуйн эсрэг, бусад төрлийн 2 хэрэг*) байна.

Гэмт хэрэгт 339 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 8.3 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 10.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.3 нэгжээр буурч, 6.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.5 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн халдлагад 358 иргэн, 5 байгууллага өртөж, 1.298.9 сая төгрөгийн хохирол учирсны 1.047.7 сая төгрөг буюу 80.7 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 29 хүн нас барж, 185 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос гэмтсэн хүний тоо 57 буюу 44.5 хувиар өссөн байна.

Өмнөговь аймагт 2012 онд 12457 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 11671 иргэн, 37 аж ахуйн нэгж, байгууллагад 89.1 сая төгрөгөөр торгох, 536 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 213 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 2504 (хоногт 7) хүнийг эрүүлжүүлжээ.

§4.15. Сүхбаатар аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Сүхбаатар аймгийн цагдаагийн хэлтэс нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 665 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос 41 нэгжээр буюу 6.6 хувиар өсч, тэдгээрийн 97.4 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх 577 гомдол, мэдээллийг шийдвэрлэснээс 259 буюу 44.9 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 288 буюу 49.9 хувьд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 414 буюу 71.7 хувийг 5 хоногт, 163 буюу 28.3 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 71 гомдол, мэдээллийг шийдвэрлэсний дотор 100 хувийг шийтгэврээр шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл 65 буюу 91.5 хувийг 14 хоногт, 6 буюу 8.5 хувийг нь 15-28 хоногт хянаж шийдвэрлэжээ.

Сүхбаатар аймагт 2012 онд 207 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 24 хэргээр буюу 13.1 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.9, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 2.3, зүүн бүсийн 3 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 14.6 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 223 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 79 буюу 38.2 хувийг хулгайлах, үүнээс 38 буюу 18.3 хувийг малын хулгай, 48 буюу 23.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 26 буюу 12.6 хувийг танхайрах, 18 буюу 8.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 10 буюу 4.8 хувийг бусад төрлийн гэмт хэрэг, 5 буюу 2.4 хувийг тус бүр хүчиндэх, залилан мэхлэх, 3 буюу 1.4 хувийг тус бүр бусдыг амиа хорлоход хүргэх, аж ахуйн эсрэг гэмт хэрэг, эд зүйл хууль бусаар нэвтрүүлсэн, 2 буюу 1.0 хувийг тус бүр захиргааны журам зөрчсөн, хүнийг санаатай алах, 1 буюу 0.5 хувийг тус бүр дээрэмдэх,

бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, хууль бусаар ашигт малтмал олборлосон, албан тушаал, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 49 гэмт хэргээс 40 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоож, гэмт хэргийн илрүүлэлт 81.6 хувьтай, өмнөх оныхоос 12.8 нэгжээр буурсан статистик үзүүлэлттэй, 9 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (8 нь *хулгайлах*, 1 нь *танхайрах хэрэг*) байна.

Гэмт хэрэгт 207 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 10.1 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 4.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны түвшинтэй ижил, 2.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 4.0 нэгжээр буурсан байна.

Гэмт хэргийн халдлагад 197 иргэн өртөж, 293.4 сая төгрөгийн хохирол учирсны 170.6 сая төгрөг буюу 58.1 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 15 хүн нас барж, 69 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 8 буюу 2.1 дахин, гэмтсэн хүний тоо 28 буюу 68.3 хувиар өссөн байна.

Сүхбаатар аймагт 2012 онд 7312 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 6764 иргэн, 8 аж ахуйн нэгж, байгууллагад 39.7 сая төгрөгөөр торгох, 392 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 148 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 3098 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.16. Сэлэнгэ аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **6090** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **820** нэгжээр буюу 15.6 хувиар өсч, тэдгээрийн 99.7 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1560** гомдол, мэдээллийг шийдвэрлэснээс 783 буюу 50.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 731 буюу 46.9 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 715 буюу 97.8 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 1274 буюу 81.7 хувийг 5 хоногт, 17.7 хувийг 6-19 хоногт, 0.6 хувийг 20 ба түүнээс дээш хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 4754 гомдол, мэдээллийг шийдвэрлэсний дотор 13 буюу 0.3 хувийг торгуулийн хуудсаар, 3183 буюу 67.0 хувийг шийтгэврээр тус тус торгож, 668 буюу 14.0 хувийг баривчлах, 858 буюу 18.0 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 99.8 хувийг 14 хоногт, 0.16 хувийг нь 15-28 хоногт, 0.04 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж шийдвэрлэжээ.

Сэлэнгэ аймагт 2012 онд **704** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 86 хэргээр буюу 13.9 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 3.2 аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 7.8 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 275 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 227 буюу 32.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 145 буюу 20.6 хувийг хулгайлах, үүнээс 56 буюу 24.7 хувийг малын хулгай, 61 буюу 8.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 52 буюу 7.4 хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчих, 37 буюу 5.2 хувийг танхайрах, 18 буюу 2.6 хувийг хүчиндэх, 16 буюу 2.3 хувийг хүнийг санаатай алах, 14 буюу 2.0 хувийг тус бүр бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, завших, үрэгдүүлэх, 10 буюу 1.4 хувийг дээрэмдэх, 4 буюу 0.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 3 буюу 0.4 хувийг

зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 2 буюу 0.3 хувийг булаах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 178 гэмт хэрэг бүртгэгдсэний 145 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **81.5** хувьтай, өмнөх оныхоос 0.2 нэгжээр өссөн, 33 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*хулгайлах 24, үүнээс мал хулгайлах 13, танхайрах хэрэг 2, хүнийг санаатай алах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, бусдын эд хөрөнгийг булаах хэрэг тус бүр 1, бусад төрлийн хэрэг 3*) байна.

Гэмт хэрэгт **837** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 13.7 хувиар, нийт шалгагдсан хүний 10.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.9 нэгжээр, 7.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 3.7 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 698 иргэн, 21 байгууллага өртөж, 1319.7 сая төгрөгийн хохирол учирсны 1166.3 сая төгрөг буюу 88.4 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 47 хүн нас барж, 312 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 4 буюу 7.8, гэмтсэн хүний тоо 16 буюу 4.9 хувиар тус тус буурсан байна.

Сэлэнгэ аймагт 2012 онд **26308** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 24761 иргэн, 1 албан тушаалтан, 16 аж ахуйн нэгж, байгууллагад 141.6 сая төгрөгөөр торгох, 862 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 668 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 4716 хүн (хоногт 12-13 хүн)-ийг эрүүлжүүлжээ.

§4.17. Төв аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Төв аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **4557** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **1409** нэгжээр буюу 44.8 хувиар өсч, тэдгээрийн 99.4 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1780** гомдол, мэдээллийг шийдвэрлэснээс 832 буюу 46.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 935 буюу 52.5 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 920 буюу 98.4 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 1159 буюу 65.1 хувийг 5 хоногт, 621 буюу 34.9 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 2750 гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 956 буюу 34.8 хувийг торгуулийн хуудсаар, 856 буюу 31.1 хувийг шийтгэврээр тус тус торгож, 305 буюу 11.1 хувийг баривчлах, 633 буюу 23.0 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 97.6 хувийг 14 хоногт, 2.4 хувийг 20 ба түүнээс дээш хоногт шийдвэрлэжээ.

Төв аймагт 2012 онд **772** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 101 хэргээр буюу 15.1 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 3.5, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 8.5 хувийг эзэлж, төвийн бүсэд бүртгэгдсэн хэргийн 22.7 хувийг тус тус эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 342 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 268 буюу 34.7 хувийг хулгайлах үүнээс 167 буюу 21.6 хувийг малын хулгай, 178 буюу 23.1 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 99 буюу 12.8 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 39 буюу 5.0 хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчих, 43 буюу 5.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 22 буюу 2.8 хувийг танхайрах, 20 буюу 2.6 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 11 буюу 1.4 хувийг бусдын эд хөрөнгийг завших,

үрэгдүүлэх, 10 буюу 1.3 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 9 буюу 1.2 хувийг тус бүр хүнийг санаатай алах, хүчиндэх, 7 буюу 1.0 хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, 4 буюу 0.5 хувийг ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих, 1 буюу 0.1 хувийг тус бүр бусдыг болгоомжгүй алах, бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх, 50 буюу 6.5 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 248 гэмт хэргээс 151 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт 60.9 хувьтай, өмнөх оныхоос гэмт хэргийн илрүүлэлт 6.1 хувиар буурч, **97** гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*87 нь хулгайлах, үүнээс 60 нь мал хулгайлах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон ашиглалтын журам зөрчих тус бүр 1, бусад хэрэг 6*) байна.

Гэмт хэрэгт 705 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 11.2 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 9.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.9 нэгжээр өсч, 1.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.1 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн халдлагад 816 иргэн, 12 байгууллага өртөж, 2.4 тэрбум төгрөгийн хохирол учирсны 2.0 тэрбум төгрөг буюу 83.4 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 92 хүн нас барж, 231 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 20 буюу 27.8 хувиар өсч, гэмтсэн хүний тоо 30 буюу 11.5 хувиар буурсан байна.

Төв аймагт 2012 онд 22987 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 22006 иргэн, 1 албан тушаалтанд 120.9 сая төгрөгөөр торгох, 657 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 323 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 1321 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.18. Увс аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Увс аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас **2535** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **565** нэгжээр буюу 28.7 хувиар өсч, тэдгээрийг бүрэн шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1009** гомдол, мэдээллийг шийдвэрлэснээс 336 буюу 33.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 661 буюу 65.5 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 890 буюу 88.2 хувийг 5 хоногт, 119 буюу 11.8 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 1061 гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 153 буюу 14.4 хувийг торгуулийн хуудсаар, 203 буюу 19.1 хувийг шийтгэврээр тус тус торгож, 375 буюу 35.3 хувийг баривчлах, 330 буюу 31.1 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 1056 буюу 99.5 хувийг 14 хоногт, 5 буюу 0.5 хувийг 15-28 хоногт хянаж шийдвэрлэжээ.

Увс аймагт 2012 онд 306 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 57 хэргээр буюу 15.7 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.4, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 3.4, баруун бүсийн 5 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 19.3 хувийг эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 123 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 8 буюу 2.6 хувийг үндэсний аюулгүй байдлын эсрэг, 3 буюу 1.0 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 5 буюу 1.6 хувийг хүүхэд, гэр бүл, нийгмийн

ёс суртахууны эсрэг, хүчиндэх, залилан мэхлэх, 4 буюу 1.3 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, 122 буюу 39.9 хувийг хулгайлах, (үүнээс 77 буюу 63.1 хувийг малын хулгай, 30 буюу 24.6 хувийг өмчийн хулгай, 1 буюу 0.8 хувийг авто тээврийн хэрэгсэл хулгайлах), 92 буюу 30.1 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 1 буюу 0.3 хувийг татвар төлөхөөс зайлсхийх, 15 буюу 4.9 хувийг танхайрах, 9 буюу 2.9 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг, 23 буюу 7.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 110 гэмт хэргээс 74 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоож, гэмт хэргийн илрүүлэлт 67.3 хувьтай, өмнөх оныхоос 8.5 нэгжээр буурсан статистик үзүүлэлттэй, 36 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй байна.

Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 36 хэргийг зүйл хэсгээр нь авч үзвэл, 34 буюу 94.4 хувь нь хулгайлах (үүнээс 22 буюу 64.7 хувийг мал хулгайлах), 1 буюу 2.8 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах болон бусад хэрэг байна.

Гэмт хэрэгт 289 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 27.0 хувиар буурч, нийт шалгагдсан хүний 5.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.4 нэгжээр, 5.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.1 нэгжээр тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн хэргийн 98 буюу 32.0 хувь нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.4 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн халдлагад 270 иргэн өртөж 559.1 сая төгрөгийн хохирол учирсны 403.0 сая төгрөг буюу 72.1 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 3 хүн нас барж, 103 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 2 буюу 40.0 хувиар, гэмтсэн хүний тоо 8 буюу 7.2 хувиар тус тус буурсан байна.

Увс аймагт 2012 онд 8737 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 8017 иргэнд 57.9 сая төгрөгөөр торгох, 330 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 385 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 2051 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.19. Ховд аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл

Ховд аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **1580** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **435** нэгжээр буюу 37.9 хувиар өсч, тэдгээрийн 99.2 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **969** гомдол, мэдээллийг шийдвэрлэснээс 302 буюу 31.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 656 буюу 67.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 645 буюу 98.3 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 720 буюу 74.3 хувийг 5 хоногт, 249 буюу 25.7 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 550 гомдол, мэдээлэл шийдвэрлэснээс 222 буюу 40.4 хувийг торгуулийн хуудсаар, 204 буюу 37.1 хувийг шийтгэврээр тус тус торгож, 60 буюу 10.9 хувийг баривчлах, 63 буюу 11.4 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 1 буюу 0.2 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл, 98.7 хувийг 14 хоногт, 1.3 хувийг 15-28 хоногт хянаж шийдвэрлэжээ.

Ховд аймагт 2012 онд **271** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 10 хэргээр буюу 3.6 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.2 хувь, аймгуудад

бүртгэгдсэн гэмт хэргийн 3.0 хувийг тус тус эзэлж байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 159 хэргээр бага байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 76 буюу 28.0 хувийг хулгайлах (үүнээс 44 буюу 57.9 хувийг малын хулгай), 88 буюу 32.5 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 45 буюу 16.6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг, 7 буюу 2.6 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг, 4 буюу 1.5 хувийг захиргааны журмын эсрэг, 4 буюу 1.5 хувийг танхайрах, 4 буюу 1.5 хувийг завших, үрэгдүүлэх, 3 буюу 1.1 хувийг хүчиндэх, 3 буюу 1.1 хувийг залилан мэхлэх, 1 буюу 0.4 хувийг булаах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 25 гэмт хэрэг бүртгэгдсэний 17 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **68.0** хувьтай, өмнөх оныхоос 5.2 нэгжээр өссөн статистик үзүүлэлттэй, 8 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (6 нь хулгайлах, үүнээс мал хулгайлах 1, дээрэмдэх хэрэг 1, ан агнуурын тухай хууль, тогтоомж зөрчих 1) байна.

Гэмт хэрэгт **303** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 3.8 хувиар, нийт шалгагдсан хүний 12.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 4.6 нэгжээр тус тус өсч, 6.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.3 нэгжээр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 263 иргэн, 3 байгууллага өртөж, 320.9 сая төгрөгийн хохирол учирсны 220.6 сая төгрөг буюу 68.7 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 123 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 18 буюу 72.0 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 19 буюу 18.3 хувиар өссөн байна.

Ховд аймагт 2012 онд 9481 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 8732 иргэн, 2 аж ахуйн нэгж, байгууллагад 50.2 сая төгрөгөөр торгох, 402 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 345 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 3919 (хоногт 11) хүнийг эрүүлжүүлжээ.

§4.20. Хөвсгөл аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Хөвсгөл аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **7749** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос **1501** нэгжээр буюу 19.3 хувиар өсч, тэдгээрийн 99.8 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **2019** гомдол, мэдээллийг шийдвэрлэснээс 613 буюу 30.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 65 буюу 3.2 хувийг нэгтгэн, 1341 буюу 66.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 1326 буюу 98.9 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 1237 буюу 61.3 хувийг 5 хоногт, 776 буюу 38.4 хувийг 6-19 хоногт, 6 буюу 0.3 хувийг 20 ба түүнээс дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх 4596 гомдол, мэдээллийн 1966 буюу 42.8 хувийг торгуулийн хуудсаар, 1573 буюу 34.2 хувийг шийтгэврээр тус тус торгож, 383 буюу 8.3 хувийг баривчлах, 663 буюу 14.4 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 11 буюу 0.3 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 4574 буюу 99.5 хувийг 14 хоногт, 12 буюу 0.3 хувийг 15-28 хоногт, 10 буюу 0.2 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж шийдвэрлэжээ.

Хөвсгөл аймагт 2012 онд 504 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 19 хэргээр буюу 3.9 хувиар өсчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 2.3, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 5.6, хангайн бүсийн 6 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 24.0

хувийг тус тус эзэлж байна. Аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 74 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 165 буюу 32.7 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 155 буюу 30.7 хувийг хулгайлах, үүнээс 61 буюу 12.1 хувийг малын хулгай, 55 буюу 10.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 25 буюу 5.0 хувийг бусад төрлийн гэмт хэрэг, 20 буюу 4.0 хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчих, 12 буюу 2.4 хувийг танхайрах, хүнийг санаатай алах, 10 буюу 2.0 хувийг хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 8 буюу 1.6 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, 6 буюу 1.2 хувийг тус бүр бусдыг амиа хорлоход хүргэх, хүчиндэх, 5 буюу 1.0 хувийг залилан мэхлэх, албан тушаал, аж ахуйн эсрэг гэмт хэрэг, ан агнуурын хууль тогтоомж зөрчих, 4 буюу 0.8 хувийг тус бүр татвар төлөхөөс зайлсхийх, шүүн таслах ажиллагааны журам зөрчих, 3 буюу 0.6 хувийг дээрэмдэх, 2 буюу 0.4 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 176 гэмт хэрэг бүртгэгдсэний 120 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоон, гэмт хэргийн илрүүлэлт 68.2 хувьтай, өмнөх оныхоос 5.1 нэгжээр буурсан, 56 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй, (43 нь хулгайлах, үүнээс 22 нь мал хулгайлах, бусдын бие махбодид гэмтэл учруулах 4, бусад төрлийн хэрэг 7, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих 1 хэрэг) байна.

Гэмт хэрэгт 523 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 5.3 нэгжээр, 6.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 8.3, нийт шалгагдсан хүний 7.4 хувь нь эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.3 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 506 иргэн, 6 байгууллага өртөж, 1.6 тэрбум төгрөгийн хохирол учирсны 1.144 тэрбум төгрөг буюу 71.5 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас 36 хүн нас барж, 206 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 10 буюу 38.5, гэмтсэн хүний тоо 10 буюу 5.1 хувиар өссөн байна.

Хөвсгөл аймагт 2012 онд 16223 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 15147 иргэн, 2 аж ахуйн нэгж, байгууллагыг 76.6 сая төгрөгөөр торгох, 668 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 406 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 2193 хүнийг эрүүлжүүлжээ.

§4.21. Хэнтий аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал

Хэнтий аймгийн цагдаагийн газар нь 2012 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн **6100** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оныхоос **858** нэгжээр буюу 16.4 хувиар өсч, тэдгээрийн 99.9 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх **1858** гомдол, мэдээллийг шийдвэрлэснээс 641 буюу 34.5 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 1154 буюу 62.1 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасны 1147 буюу 99.4 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 969 буюу 52.2 хувийг 5 хоногт, 47.8 хувийг 6-19 хоногт багтаан шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

Захиргааны зөрчлийн талаарх **3043** гомдол, мэдээллийн 51 буюу 1.7 хувийг торгуулийн хуудсаар, 2061 буюу 67.7 хувийг шийтгэврээр тус тус торгож, 363 буюу 11.9 хувийг баривчлах, 495 буюу 16.3 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж, 3 буюу 0.1 хувийг нэгтгэн, 70 буюу 2.3 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 94.7 хувийг 14 хоногт, 5.3 хувийг нь 15-28 хоногт хянаж, шийдвэрлэжээ.

Хэнтий аймагт 2012 онд **631** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 96 хэргээр буюу 13.2 хувиар буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 2.9, аймгуудад бүртгэгдсэн гэмт хэргийн 7.0 хувийг эзэлж тус тус байгаа ба аймгуудын гэмт хэргийн дундаж түвшингээс 202 хэргээр их байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 312 буюу 49.4 хувийг хулгайлах, үүнээс 221 буюу 70.8 хувийг малын хулгай, 89 буюу 14.1 хувийг танхайрах, 84 буюу 13.3 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 36 буюу 5.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 13 буюу 2.0 хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчих, 10 буюу 1.6 хувийг тус бүр хүчиндэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 9 буюу 1.4 хувийг дээрэмдэх, 8 буюу 1.3 хувийг хүнийг санаатай алах, 6 буюу 1.0 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, 5 буюу 0.8 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 4 буюу 0.6 хувийг булаах, 45 буюу 7.1 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 331 гэмт хэрэг бүртгэгдсэний 233 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт **70.4** хувьтай, өмнөх оныхоос 3.0 нэгжээр буурсан, 98 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (*хулгайлах 91, үүнээс мал хулгайлах 66, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 2, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэг 1, бусад төрлийн хэрэг 3*) байна.

Гэмт хэрэгт **489** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 20.6 хувиар буурч, нийт шалгагдсан хүний 9.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.2 нэгжээр буурч, 6.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.7 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 646 иргэн, 1 байгууллага өртөж 1118.5 сая төгрөгийн хохирол учирсны 700.8 сая төгрөг буюу 62.6 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.


Гэмт хэргийн улмаас 38 хүн нас барж, 225 хүн гэмтсэн нь өмнөх оныхоос нас барсан хүний тоо 8 буюу 26.7, гэмтсэн хүний тоо 12 буюу 5.6 хувиар тус тус өссөн байна.

Хэнтий аймагт 2012 онд **14965** захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 13992 иргэн, 1 албан тушаалтан, 9 аж ахуйн нэгж, байгууллагад 112.8 сая төгрөгөөр торгох, 568 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 395 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулж, 2871 хүн (хоногт 7-8 хүн)-ийг эрүүлжүүлжээ.

§5. ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН КРИМИНОЛОГИ ШИНЖ, ТЭДГЭЭРИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ

§5.1. Хүнийг алах гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл

1. Хүнийг санаатай алах (*Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйл*) гэмт хэрэг **231** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 31 хэргээр буюу 11.8 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 1.0 хувь болж, 0.4 нэгжээр тус тус буурсан байна.



Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Хүнийг санаатай алах гэмт хэрэг	262	231	31	-11.8
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	1.4	1.0	0.4 нэгжээр буурсан	
3	Хүнийг санаатай алах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	91.3	92.2	0.9 нэгжээр өссөн	

Хүнийг санаатай алах гэмт хэрэг Сэлэнгэд 16, Хөвсгөлд 12, Өвөрхангай, Орхонд тус бүр 10, Дорноговь, Төв аймагт тус бүр 9, Хэнтийд 8, Булганд 6, Өмнөговьд 5, Архангай, Дархан-Уул, Дорнодод тус бүр 4, Баянхонгор 3, Завхан, Говьсүмбэр, Сүхбаатарт тус бүр 2, Баян-Өлгий, Говь-Алтай, Дундговь, Увс, Ховдод тус бүр 1 бүртгэгдсэн байна. Нийслэлд 120, үүнээс Сонгинохайрханд 28, Баянзүрхэд 27, Чингэлтэй, Сүхбаатарт тус бүр 19, Баянголд 12, Хан-Уулд 9, Налайхад 3, Багануурт 3 бүртгэгджээ.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Ховд, Завхан, Баянхонгор, Булган, Орхон, Говьсүмбэр, Дорноговь, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад 1-3 дахин, нийслэлийн Сүхбаатар дүүрэгт 5.5 хувь, Хан-Уул дүүрэгт 28.5 хувь, Чингэлтэй дүүрэгт 58.3 хувиар, Багануурт 3 дахин тус тус өссөн байна. Нийслэлийн Баянзүрх дүүрэгт 28.9 хувиар, Сонгинохайрхан дүүрэгт 24.3 хувиар, Налайх дүүрэгт 50 хувиар тус тус буурсан өссөн байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хүнийг санаатай алах 77 гэмт хэргээс 71 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт 92.2 хувьтай байна.

Хүнийг санаатай алах гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 5.6 хувь нь хүүхэд, 11.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 73.4 хувь нь согтуугаар, 5.2 хувь нь бүлэглэн, 6.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1.3 хувь нь галт зэвсгээр,
- 2011 онд 1.5 гэмт хэрэг тутмын нэг нь согтуугаар үйлдэгдсэн бол 2012 онд 1.4 хэрэг тутмын нэг нь согтуугаар,
- 16.1 хувь нь гудамж талбайд, 59.7 хувь нь гэр, орон сууцанд, 5.2 хувь нь олон нийтийн газарт, 0.4 хувь нь нийтийн тээвэрт, 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 0.4 хувь нь төрийн байгууллагад, 2.2 хувь нь аж ахуйн нэгжид, 6.5 хувь нь хөдөө хээр газарт, 9.1 хувь нь бусад газарт,
- 10.8 хувь нь Даваа, 14.3 хувь нь Мягмар, 17.7 хувь нь Лхагва, 16.9 хувь нь Пүрэв, 14.4 хувь нь Баасан, 12.5 хувь нь Бямба, 13.4 хувь нь Ням гарагт,


- 12.5 хувь нь 06-14 цагт, 14.3 хувь нь 14-19 цагт, 16.9 хувь нь 19-22 цагт, 56.3 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.



Хүнийг санаатай алах гэмт хэргийн халдлагад **233** иргэн, үүний дотор 58 эмэгтэй хүн өртөж, 20 хүн гэмтэн, иргэдэд **293.2 сая** төгрөгийн хохирол учирсны 196.7 сая төгрөг буюу 67.1 хувийг мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, 5.0 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна.

Хүнийг санаатай алах гэмт хэрэгт **256** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 10.5 хувь нь эмэгтэй, 5.1 хувь нь хүүхэд,
- 20.7 хувь нь 18-24 насны, 16.5 хувь нь 25-29 насны, 12.5 хувь нь 30-34 насны, 17.9 хувь нь 35-39 насны, 7.8 хувь нь 40-44 насны, 9.4 хувь нь 45-49 насны, 6.2 хувь нь 50-54 насны, 3.1 хувь нь 55-59 насны, 0.4 хувь нь 60-64 насны, 0.4 хувь нь 70 ба түүнээс дээш насны,
- 54.3 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 5.1 хувь нь төрийн алба хаагч, 1.2 хувь нь төрийн бус байгууллагын ажилтан, 9.8 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 10.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 13.3 хувь нь малчин, 2.3 хувь нь оюутан, 2.3 хувь нь тэнэмэл, 1.6 хувь нь сурагч,
- 19.1 хувь нь бага, 2.7 хувь нь боловсролгүй, 30.6 хувь нь суурь, 33.9 хувь нь бүрэн дунд, 5.5 хувь нь тусгай мэргэжлийн, 8.2 хувь нь дээд боловсролтой,
- 69.5 хувь нь согтуугаар, 0.8 хувь нь галт зэвсэг хэрэглэж, 14.4 хувь нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн ба тэдгээрийн 9.4 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс байна.





Мэдээллийн санд бүртгэгдсэн хүнийг санаатай алах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 44.6 хувь нь архидаан согтуурснаас, 21.6 хувь нь хэрүүл маргаанаас, 6.1 хувь нь хүний ёс суртахууны доголдолтой байдлаас, 7.4 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүйгээс, 3.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1.7 хувь нь шунахайн сэдэлтээр, 14.7 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдсэн талаар дурдсан байна.


2. Бусдыг болгоомжгүй алах (Эрүүгийн хуулийн 94 дүгээр зүйл) гэмт хэрэг **14** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 6 хэргээр буюу 33.3 хувиар буурсан байна. *Зураг-26*

Бусдыг болгоомжгүй алах гэмт хэрэг Булган, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймагт тус бүр 1, Дорноговь аймагт 2 бүртгэгджээ. Нийслэлд 4, үүнээс Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт тус бүр 1, Налайхад 2 бүртгэгджээ.



Хүнийг болгоомжгүй алах гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 28.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 21.4 хувь нь согтуугаар, 7.1 хувь нь галт зэвсгээр, 7.1 хувь нь бүлэглэн,
- 5 хэрэг тутмын нэг нь согтуугаар,
- 64.3 хувь нь гэр, орон сууцанд, 7.1 хувь нь төрийн байгууллагад, 28.6 хувь нь бусад газарт,
- 28.6 хувь нь Даваа, 21.4 хувь нь Баасан, 14.3 хувь тус бүр Мягмар, Бямба, 7.1 хувь тус бүр Лхагва, Пүрэв, Ням гарагт,
- 06-14, 14-19, 22-06 цагт тус бүр 4, 19-22 цагт 2 хэрэг үйлдэгджээ.



Бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн халдлагад 14 иргэн, үүний дотор 5 эмэгтэй хүн өртөж, 1 хүн гэмтэн, иргэдэд 35.0 сая төгрөгийн хохирол учирсны 34.5 сая төгрөг буюу 98.6 хувийг мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Бусдыг болгоомжгүй алах гэмт хэрэгт **20** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 20.0 хувь нь эмэгтэй, 30.0 хувь нь 18-24 насны, 5.0 хувь нь 25-29 насны, 30.0 хувь нь 30-34 насны, 10.0 хувь нь 35-39 насны, 15.0 хувь нь 40-44 насны, 10. хувь нь 45-49 насны,
- 70.0 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 20.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 5.0 хувь нь төрийн албан хаагч, 5.0 хувь нь малчин, 40.0 хувь нь бага болон суурь, 45.0 хувь нь бүрэн дунд, 15.0 хувь нь тусгай дунд, дээд боловсролтой,
- 10.0 хувь нь согтуугаар, 35 хувь нь бүлэглэн үйлдэгдсэн байна.


Нийгэмд ядуурал газар авснаас хүний мөс чанар, иргэдийн мэдлэг, боловсрол улам бүр доройтож, ахуйн хүрээнд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, үүний улмаас хэрэлдэж маргалдах, ёс зүйгүй авирлах, боловсролын байгууллага, ялангуяа ерөнхий боловсролын сургуулиудад гэмт хэргийн болон хууль эрх зүйн мэдлэг олгох ажил дутмаг, хүүхдийн суурь хүмүүжилд эцэг эхээс тавих хяналт суларсан, хууль тогтоомжийн сурталчилгаа, мэдээлэл, хууль хэрэгжүүлэх ажил дутмаг, галт зэвсгийн бүртгэл, түүний ашиглалтад тавих хяналт хангалттай бус байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байна.

Үүний зэрэгцээ галт зэвсэгт тавих хяналт хангалттай бус, галт зэвсгийг бусдад дамжуулан хэрэглүүлдэг, өөрийн эзэмшилд байгаа галт зэвсгийг улсын бүртгэлд хамруулдаггүй, хэлбэрийг нь өөрчилдөг гэх мэтийн зөрчил, дутагдал байгаа нь сөргөөр нөлөөлж байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хуулийн хэрэгжилт, хөдөлгөөнт болон явган эргүүлийн хяналтыг сайжруулах, чиглэл маршрутыг шинэчлэх, хорихоос суллагдсан болон урьд өмнө нь гэмт хэрэг, зөрчил үйлдэж байсан иргэдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тэдэнд тавих хяналтыг сайжруулж, ажлын байраар хангах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага байна.

§5.2. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл

Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйл) **324** гэмт хэргийг өнгөрсөн онтой харьцуулж үзвэл 10 хэргээр буюу 3.2 хувиар өсөж, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 1.5 хувь болж, 0.2 нэгжээр буурчээ.



Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг	314	324	+10	+3.2
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	1.7	1.5	0.2 нэгжээр буурсан	

Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг Төв аймагт 43, Дорноговьд 10, Дорнод, Дархан-Уул, Орхонд тус бүр 9, Архангай, Завхан, Өвөрхангайд тус бүр 7, Өмнөговь, Хөвсгөлд тус бүр 6, Хэнтийд 5, Сэлэнгэд 4, Баян-Өлгий, Булган, Сүхбаатар, Увсад тус бүр 3, Говь-Алтай, Баянхонгор, Говьсүмбэрт тус бүр 2, нийслэлд 184, үүнээс Баянзүрхэд 39, Баянголд 36, Сонгинохайрханд 33, Чингэлтэйд 32, Хан-Уулд 20, Сүхбаатарт 19, Налайхад 4, Багануурт 1 бүртгэгджээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 21 гэмт хэргээс 1 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт 4.8 хувь, илрээгүй 20 хэрэг байна.

Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 1.2 хувь нь хүүхэд, 2.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 17.6 хувь нь согтуугаар, 0.3 хувь нь галт зэвсгээр, 0.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас,
- 48.5 хувь нь гэр, орон сууцанд, 11.4 хувь нь гудамж талбайд, 3.7 хувь нь олон нийтийн газарт, 3.7 хувь нь төрийн байгууллагад, 2.7 хувь нь төрийн бус байгууллагад, 3.4 хувь нь аж ахуйн нэгжид, 0.3 хувь нь нийтийн тээвэрт, 26.3 хувь нь бусад газарт,
- 12.3 хувь нь Даваа, 14.2 хувь тус бүр Мягмар, Лхагва, 18.8 хувь нь Пүрэв, 10.3 хувь нь Баасан, 15.1 хувь тус бүр Бямба, Ням гарагт,
- 23.7 хувь нь 06-14 цагт, 21.6 хувь нь 14-19 цагт, 17.9 хувь нь 19-22 цагт, 36.8 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.

Энэ төрлийн гэмт хэрэгт 16 хүн холбогдон шалгагдсаны дотор 25.0 хувь нь эмэгтэй, 18.7 хувь нь 16-17 насны, 25.1 хувь нь 25-29 насны, 18.7 хувь тус бүр 30-34, 35-39 насны, 12.5 хувь нь 40-44 насны, 6.3 хувь нь 45-49 насны, 25.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 12.5 хувь нь төрийн албан хаагч, 6.2 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 18.7 сурагч, 6.2 хувь нь хоригдол, 31.2 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 6.2 хувь нь бага, 31.2 хувь нь суурь, 25.1 хувь нь бүрэн дунд, 37.5 хувь нь дээд боловсролтой хүмүүс, 37.5 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлджээ.

Дүгнэлт, санал: Улсын хэмжээнд 2012 онд амиа хорлосон болон золгүй байдлаар 3099 хүн нас барж, нас барсан тохиолдол бүрийг Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгажээ. Үүнээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан “Гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэл”-ээр хэрэгсэхгүй болж, улмаар Цагдаагийн ерөнхий газрын даргын 2009 оны 636 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлийн заавар”-ын 12.4.2 дахь хэсгийн “а” (Гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй)-д зааснаар тоо бүртгэлээс хасна гэсний дагуу статистикийн мэдээллээс хасагддаг. Ийм учраас 3099 хүн нас барж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан ч оны жилийн эцсийн байдлаар мэдээ тайлан гарахад бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 324 гэсэн тоон мэдээлэл гарсан байна.

Дээрх амиа хорлосон болон золгүй байдлаар нас барсан 3099 хүний 515 буюу 16.6 хувь нь амиа хорлосон, 2584 буюу 83.4 хувь нь золгүй байдлаар нас барсан байна.

Золгүй байдлаар нас барсан хүмүүсийн тухайд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас хордох, осгох, хөлдөх, түлэгдэх, усанд живэх, аянга, хүчдэлд цохиулах, санамсар болгоомжгүйгээс дээвэр, тагт, мориноос унах зэрэг байдлаас шалтгаалсан бол амиа хорлосон нь гэр бүлийн таагүй орчин, хэрүүл маргаан, дарамт, айдас, амьдралд учрах элдэв хүндрэл бэрхшээлийг тэсвэрлэх сэтгэл зүйн тэнхээгүй улмаас өөрийгөө буудсан, боосон, хутгалсан байдлаар амиа хорлосон байна.

§5.3. Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл

Бусдын бие махбодид гэмтэл учруулах (Эрүүгийн хуулийн 96-100 дугаар зүйл) гэмт хэрэг **6546** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 708 хэргээр буюу 12.1 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 30.4 хувь болж, 1.0 нэгжээр тус тус өсөв.



Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг	5838	6546	708	12.1
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	30.4	29.6	0.8 нэгжээр буурсан	
3	Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	80.1	74.6	5.4 нэгжээр буурсан	

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг Дархан-Уулд 251, Баян-Өлгийд 238, Сэлэнгэд 227, Дорноговьд 220, Орхонд 192, Өвөрхангайд 191, Төвд 178, Дорнодод 172, Хөвсгөлд 165, Завханд 139, Өмнөговьд 126, Архангайд 105, Увсад 92, Ховдод 88, Баянхонгор 86, Хэнтийд 84, Говьсүмбэрт, Дундговь аймагт тус бүр 73, Булганд 67, Сүхбаатарт 48, Говь-Алтайд 42, нийслэлд 3662, үүнээс Баянзүрхэд 741, Баянголд 667, Сүхбаатарт 650, Сонгинохайрханд 526, Чингэлтэйд 488, Хан-Уулд 344, Налайхад 119, Багануурт 113, Төмөр замд 19, Багахангайд 14, Иргэний агаарын тээврийн салбар болон бусад газарт тус 4 гэмт хэрэг бүртгэгджээ.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Ховд, Баянхонгор, Төв аймагт 2.2-27.1 хувиар, Хан-Уул дүүрэг болон Төмөр замын салбарт 9.5-38.7 хувиар тус тус буурч, харин Баян-Өлгий, Завхан, Архангай, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт 6.3-50.6 хувиар, Говь-Алтай аймагт 2.2 дахин, нийслэлд 10.1 хувь, нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Багануур дүүрэг болон Иргэний агаарын тээврийн салбарт 3.3-20.7 хувиар, Багахангай дүүрэгт 2.8 дахин тус тус өссөн байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй энэ төрлийн 678 гэмт хэрэг бүртгэгдэн 506 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд **74.6** хувьтай байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- Гэмт хэргийн 80.0 хувийг хөнгөн, 14.5 хувийг хүндэвтэр, 5.5 хувийг хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байгаа ба 13.4 хувь нь эмэгтэй хүн, 3.8 хувь нь хүүхэд оролцож, 37.9 хувь нь согтуугаар, 6.4 хувь нь бүлгээр үйлдэгджээ.

- Гэмт хэргийн 42.6 хувь нь гэр, орон сууцанд, 21.6 хувь нь гудамж талбайд, 15.4 хувь нь олон нийтийн газарт, 1.6 хувь нь нийтийн тээвэрт, 1.3 хувь нь төрийн байгууллагад, 1.2 хувь нь төрийн бус байгууллагад, 4.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагад, 11.5 хувь нь бусад газарт, 0.3 хувь авто замд үйлдэгдсэн,
- 16.3 хувь нь Даваад, 15.9 хувь нь Мягмарт, 13.8 хувь нь Лхагвад, 14.2 хувь нь Пүрэвт, 13.8 хувь нь Баасанд, 13.1 хувь нь Бямбад, 12.9 хувь нь Нямд,
- 15.5 хувь нь 06-14 цагт, 26.8 хувь нь 14-19 цагт, 24.2 хувь нь 19-22 цагт, 33.5 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.

Гэмт хэргийн халдлагад 6607 иргэн, үүний дотор 2521 эмэгтэй хүн өртөж, 16 хүн нас барж, 5341 хүн гэмтэн, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 2.0 сая төгрөгийн хохирол учирсны 1.7 сая төгрөг буюу 82.3 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн байна.


Гэмт хэргийн улмаас 16 хүн нас барж, 5341 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтсэн нь гэмтсэн нийт хүний 63.3 хувийг эзэлж байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах төрлийн гэмт хэрэгт **6671** хүн холбогдон шалгагдсаны:

- 13.4 хувь нь эмэгтэй, 3.8 хувь нь хүүхэд,
- 24.6 хувь нь 18-24 насны, 20.6 хувь нь 25-29 насны, 17.6 хувь нь 30-34 насны, 13.6 хувь нь 35-39 насны, 8.9 хувь нь 40-44 насны, 5.9 хувь нь 45-49 насны, 3.0 хувь нь 50-54 насны, 1.3 хувь нь 55-59 насны, 0.4 хувь нь 60-64 насны, 0.2 хувь нь 65-69 насны, 0.1 хувь нь 70 ба түүнээс дээш насны,
- 5.4 хувь нь төрийн алба хаагч, 13.5 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 2.4 хувь нь төрийн бус байгууллагын ажилтан, 15.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 8.7 хувь нь малчин, 4.6 хувь нь оюутан, 2.3 хувь нь сурагч, 0.1 хувь нь тус бүр хугацаат цэргийн албан хаагч болон сургууль завсардсан хүүхэд, 0.2 хувь нь тус бүр тэнэмэл амьдралтай хүн болон хоригдол, 47.0 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй,
- 2.1 хувь нь боловсролгүй, 6.5 хувь нь бага, 20.7 хувь нь суурь, 47.0 хувь нь бүрэн дунд, 0.2 хувь нь техник болон мэргэжлийн, 3.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 20.1 хувь нь дээд боловсролтой хүмүүс байгаа,
- Тэдгээрийн 34.8 хувь нь согтуугаар, 9.4 хувь нь бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн, 2.6 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс байна.

§5.4. Хүчиндэх гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл

Хүчиндэх (Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйл) гэмт хэрэг **305** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 62 хэргээр буюу 17.0 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 1.4 хувь болж, 0.5 нэгжээр тус тус буурсан байна.



Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Хүчиндэх хэрэг	367	305	62	-17.0
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	1.9	1.4	0.5 нэгжээр буурсан	
3	Хүчиндэх гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	70.5	74.0	3.5 нэгжээр өссөн	

Хүчиндэх гэмт хэрэг Сэлэнгэд 18, Дорноговьд 13, Орхонд 11, Дорнод, Говь-Алтай, Хэнтийд тус бүр 10, Баянхонгор, Төвд тус бүр 9, Дархан-Уул, Баян-Өлгийд тус бүр 8, Хөвсгөл, Өмнөговьд тус бүр 6, Өвөрхангай Увс, Булган, Сүхбаатарт тус бүр 5, Архангай, Ховдод тус бүр 3, Дундговь, Говьсүмбэр, Завханд тус бүр 2, нийслэлд 155, үүнээс Баянзүрхэд 41, Сонгинохайрханд 29, Хан-Уулд 16, Баянголд 15, Чингэлтэй, Сүхбаатарт тус бүр 20, Багануурт 10, Налайх дүүрэгт 4 хэрэг тус тус бүртгэгджээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 77 гэмт хэргээс 57 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 74.0 хувьтай, 20 гэмт хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй (*Дорноговь, Орхон, Говьсүмбэр аймагт тус бүр 1, нийслэлд 17, үүнээс Баянзүрх дүүрэгт 7, Сонгинохайрхан дүүрэгт 5, Сүхбаатар дүүрэгт 4, Багануур дүүрэгт 1*) хэрэг байна.

Хүчиндэх гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 40.3 хувь нь хүндэвтэр, 38.0 хувь нь хүнд, 21.7 хувь нь онц хүнд ангиллын,
- 10.2 хувь нь хүүхэд оролцож, 52.1 хувь нь согтуугаар, 4.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 14.1 хувь нь бүлгээр,
- 2 гэмт хэрэг тутмын нэг нь согтуугаар,
- гэр, орон сууцанд 60.3, гудамж талбайд 12.8, бусад газарт 9.5 хувь, олон нийтийн газарт 7.7, нийтийн тээвэр, аж ахуйн нэгжид тус бүр 1.6, төрийн бус байгууллагад 6.5,
- 17.4 хувь нь Лхагва, 17.0 хувь нь Мягмар, 15.1 хувь нь Бямба, 14.7 хувь нь Даваа, 14.1 хувь нь Баасан, 12.5 хувь Ням гарагт, 9.2 хувь нь Пүрэв,
- 53.7 хувь нь 22-06 цагт, 18.4 хувь нь 19-22 цагт, 16.7 хувь нь 14-19 цагт, 11.2 хувь нь 06-14 цагт,
- 2 гэмт хэрэг тутмын нэг нь гэр, орон сууцанд, 22.00-06.00 цагийн хооронд тус тус үйлдэгджээ.




Хүчиндэх гэмт хэргийн халдлагад 299 иргэн өртсөнөөс 12 буюу 4.0 хувь нь 7 хүртэлх, 39 буюу 13.0 хувь нь 8-13 насны, 84 буюу 28.1 хувь нь 14-17 насны буюу хохирогсдын 135 буюу 45.1 хувь нь хүүхэд, 164 буюу 54.9 хувь нь 18-с дээш насны иргэд хохирчээ.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас иргэдэд 133.2 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсны 102.7 сая төгрөг буюу 77.1 хувийг мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба 2 хүн нас барж, 98 хүн гэмтжээ.


Гэмт хэрэгт 352 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсаны дотор:

- 4.3 хувь нь 15 хүртэлх насны, 7.9 хувь нь 16-17 насны,

- 42.3 хувь нь 18-24 насны, 17.6 хувь нь 25-29 насны, 13.1 хувь нь 30-34 насны, 5.4 хувь нь 35-39 насны, 4.0 хувь нь 40-44 насны, 3.4 хувь нь 45-49 насны, 1.1 хувь нь 50-54 насны, 0.3 хувь нь 55-59 насны, 0.6 хувь нь 60-64 насны,



- 58.8 хувь тодорхой эрхэлсэн ажилгүй, 8.5 хувь нь малчин, 7.7 хувь нь оюутан, 5.1 хувь нь сурагч, 7.9 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 8.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 2.3 хувь нь төрийн албан хаагч, 0.3 хувь нь сургууль завсардсан, 0.6 хувь нь тэнэмэл,



- 7.7 хувь нь боловсролгүй, 12.2 хувь нь бага, 30.1 хувь нь суурь, 41.2 хувь нь бүрэн дунд, 0.3 хувь нь техник мэргэжлийн, 2.0 хувь нь тусгай дунд, 6.5 хувь нь дээд боловсролтой,
- 2 буюу 5.5 хувь тус бүр хүргэн, нөхөр, 1 буюу 0.3 хувь тус бүр төрсөн эцэг, онц аюултай гэмт хэрэгтэн, 13 буюу 3.7 хувь нь хойд эцэг, 7 буюу 2.0 хувь нь төрөл садангийн хүн, 3 буюу 8.5 хувь нь хамтран амьдрагч, 317 буюу 74.2 хувь нь бусад,
- 5.4 хувь нь урьд ял шийтгэгдсэн, 44.6 хувь нь согтуугаар, 29.5 хувь нь гэмт хэргийг бүлэглэн үйлджээ.

Мэдээллийн санд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 27.2 хувь нь хувь хүний ёс суртахууны доголдол, 40.0 хувь нь архидан согтуурсан, 18.4 хувь нь бэлгийн гаж сонирхол, 3.4 хувь нь хохирогчийн өөрийн эрсдэл бүхий нөхцөл байдал, 4.0 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл, 0.3 хувь нь өш хонзон, хувийн ашиг сонирхол, хүслээ гүйцэлдүүлэх гэсэн, 6.7 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн байна.

§5.5. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн криминологи шинж, түүний шалтгаан нөхцөл

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 6266 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 990 хэргээр буюу 18.8 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 28.4 хувь болж, 0.9 нэгжээр тус тус өсөв.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг	5276	6266	990	18.8
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	27.5	28.4	0.9 нэгжээр өссөн	
3	Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	54.9	50.6	4.3 нэгжээр буурсан	

Хулгайлах гэмт хэрэг Хэнтийд 312, Төвд 268, Дорнодод 215, Өвөрхангайд 182, Архангайд 166, Дархан-Уулд 159, Хөвсгөлд 155, Сэлэнгэд 145, Дорноговьд 141, Орхонд 138, Булганд 127, Увсад 122, Завханд 111, Баян-Өлгийд 110, Баянхонгор 97, Дундговьд 80, Сүхбаатарт 79, Ховдод 76, Өмнөговьд 69, Говь-Алтай 67, Говьсүмбэрт 28, нийслэлд 3385, үүнээс Баянзүрхэд 799, Баянголд 647, Сонгинохайрханд 635, Сүхбаатарт 480, Чингэлтэйд 446, Хан-Уулд 259, Налайхад 60, Багануурт 55, Багахангайд 4, Төмөр замын салбарт 32, Иргэний агаарын тээврийн салбарт 1, бусад газарт 1 бүртгэгджээ.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дорнод, Сүхбаатар аймагт 8.2-42.4 хувиар, нийслэлд 32.3, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэгт 19.1-53.3 хувиар, Налайх дүүрэгт 2,5 дахин тус тус өсч, Хөвсгөл, Говьсүмбэр, Завхан, Увс, Ховд, Хэнтий аймагт 0.9-17.5 хувиар, Хан-Уул, Багануур, иргэний агаарын тээвэр, төмөр замын салбарт 9.8-50.0 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 4952 гэмт хэрэг бүртгэгдэн 2508 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт 50.6 хувьтай, 2444 гэмт хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй (Хэнтийд 91, Төвд 87, Өвөрхангайд 64, Орхон, Дорнод аймагт тус бүр 62, Дархан-Уулд 52, Булганд 48, Хөвсгөлд 43, Завхан Архангайд тус бүр 37, Дорноговьд 35, Увсад 34, Дундговьд 30, Баян-Өлгийд 26, Баянхонгор, Сэлэнгэд тус бүр 24, Өмнөговьд 21, Говь-Алтайд 13, Говьсүмбэр, Сүхбаатарт тус бүр 8, Ховдод 6, нийслэлд 1625, үүнээс Баянзүрхэд 547, Сонгинохайрханд 271, Сүхбаатарт 237, Чингэлтэйд 222, Баянголд 167, Хан-Уулд 139, Налайхад 23, Багануурт 17, төмөр замын салбарт 6, бусад газарт 1 хэрэг) байна.



Хулгайлах гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 32.4 хувь нь хөнгөн, 65.3 хувь нь хүндэвтэр, 1.6 хувь нь хүнд, 0.7 хувь нь онц хүнд,
- 7.5 хувь нь насанд хүрээгүй, 6.1 хувь нь эмэгтэй хүн оролцож, 6.6 хувь нь согтуугаар, 14.3 хувь нь бүлгээр,
- 10.5 хувь нь гудамж талбайд, 33.2 хувь нь гэр, орон сууцанд, 14.8 хувь нь олон нийтийн газарт, 1.3 хувь нь нийтийн тээвэрт, 0.6 хувь нь төрийн байгууллагад, 1.2 хувь нь төрийн бус байгууллагад, 8.0 хувь нь аж ахуйн нэгжид, 16.4 хувь нь бэлчээрт, 14.0 хувь нь бусад газарт,
- 13.9 хувь нь 06-14 цагт, 21.5 хувь нь 14-19 цагт, 12.5 хувь нь 19-22 цагт, 52.1 хувь нь 22-06 цагт, даваа гарагт 1021, мягмар гарагт 912, лхагва гарагт 920, пүрэв гарагт 924, баасан гарагт 957, бямба гарагт 730, ням гарагт 802 хэрэг тус тус үйлдэгджээ.

Хулгайлах гэмт хэргийн халдлагад **6179** иргэн, **52** байгууллага өртөж, **12.2 тэрбум** төгрөгийн хохирол учирсаны 6.1 тэрбум төгрөг буюу 50.0 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна.

Гэмт хэрэгт **4550** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 8.1 хувь нь эмэгтэй, 12.3 хувь нь насанд хүрээгүй, 35.8 хувь нь 18-24 насны, 17.9 хувь нь 25-29 насны, 13.4 хувь нь 30-34 насны, 8.2 хувь нь 35-39 насны, 5.7 хувь нь 40-44 насны, 4.1 хувь нь 45-49 насны, 1.7 хувь нь 50-54 насны, 0.6 хувь нь 55-59 насны, 0.2 хувь нь 60-64 насны, 0.02 хувь нь 65-69 насны, 0.1 хувь нь 70-аас дээш насны,
- 0.6 хувь нь төрийн албан хаагч, 3.9 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиглагч, 0.7 хувь нь төрийн бус байгууллагын ажилтан, 4.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 16.4 хувь нь малчин, 2.8 хувь нь оюутан, 4.6 хувь нь сурагч, 64.0 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 2.3 хувь нь бусад хүмүүс гэмт хэрэг үйлдэж, тэдний 9.6 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс,



Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн **6** хүн тутмын нэг нь тодорхой эрхэлсэн ажилгүй, **4** хүн тутмын нэг нь бүлэглэн гүйцэтгэсэн, **10** хүн тутмын нэг нь урьд өмнө шүүхээр ял шийтгэгдсэн байна.

Мэдээллийн санд бүртгэгдсэн бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 75.7 хувь нь ашиг олох шунахай зорилго 6.8 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, амжиргааны эх үүсвэргүй, 1.4 хувь нь мал хариулагагүй, 1.2 хувь нь сонор сэрэмжгүй, 0.5 хувь нь харуул манааны хариуцлагагүй, хяналт шалгалт сул, 0.2 хувь нь тус бүр итгэл эвдсэн, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, 0.1 хувь нь тус бүр өш хонзон, танхай, хувь хүний ёс суртахууны хэм хэмжээ дутмаг, доголтой байдал, 8.7 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон иргэдийн **29.0** хувь, учирсан эд материалын хохирлын 12.2 тэрбум төгрөг буюу **22.9** хувь нь хулгайлах гэмт хэргийн улмаас учирчээ. Бусдын эд хөрөнгөд халдан, өмчлөх, гэмт үйлдлийн арга, хэлбэр жилээс жилд улам нарийсч халаасны, орон байрны, малын гэх мэтчилэнгээр мэргэшсэн хулгайчид төрсөөр байна.

Улсын хэмжээнд 2012 онд мал хулгайлах гэмт хэрэг 1376 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 207 хэргээр буюу 17.7 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 6.2 хувь болж, 0.1 нэгжээр тус тус өсөв.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Мал хулгайлах гэмт хэрэг	1169	1376	207	17.7
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	6.1	6.2	0.1 нэгжээр өссөн	
3	Бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэгт эзлэх хувийн жин	22.2	22.0	0.2 нэгжээр буурсан	
4	Мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	66.2	61.0	5.2 нэгжээр буурсан	

Энэ төрлийн гэмт хэрэг Хэнтийд 221, Төвд 167, Дорнод 111, Архангайд 95, Увсад 77, Булган, Баян-Өлгийд тус бүр 62, Хөвсгөлд 61, Завханд 59, Сэлэнгэд 56, Өвөрхангайд 52, Ховдод 44, Баянхонгор 42, Дархан-Уулд 39, Сүхбаатарт 38, Дорноговьд 35, Дундговьд 31, Говь-Алтайд 22, Говьсүмбэрт 11, Орхонд 9, Өмнөговьд 5, нийслэлд 76, үүнээс Баянзүрхэд 23, Сонгинохайрханд 16, Багануурт 18, Налайхад 12, Хан-Уул, Сүхбаатарт тус бүр 3, Чингэлтэйд 1, төмөр замын салбарт 1 хэрэг тус тус бүртгэгджээ.

Гэмт хэргийн гаралт Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Ховд, Архангай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Төв, Дорнод, Сүхбаатар аймагт Хөвсгөл, Орхон, Завхан, Булган, Өвөрхангай, Увс, аймагт 10 хувиас 2.4 дахин, нийслэлд 43.4, нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан Багануур, Налайх дүүрэгт 43.4 хувиас-3,0 дахин тус тус өсч, Завхан, Увс, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл Хэнтий, Өмнөговь, аймагт 10.0-28.6 хувиар, нийслэлийн Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт 10.9-57.1 хувиар тус тус бууурч, Булган аймагт, өнгөрсөн оны түвшинд байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 1009 гэмт хэрэг бүртгэгдэн 615 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд **61.0** хувьтай, 394 гэмт хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй (Хэнтийд 66, Төвд 60, Дорнодод 32, Булганд 24, Архангайд 23, Увсад, Хөвсгөлд тус бүр 22, Завханд 19, Дархан-Уул, Баян-Өлгийд тус бүр 17, Сэлэнгэд 13, Өвөрхангайд 12, Дундговьд 8, Баянхонгорд 7, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорноговьд тус бүр 3 Говь-Алтайд, Орхонд тус бүр 2, Ховдод 1, нийслэлд 38, үүнээс Баянзүрхэд 20, Сонгинохайрхан, Багануурт тус бүр 4, Сүхбаатарт 2, Хан-Уулд 1, Налайхад 7 хэрэг) байна.

Мал хулгайлах гэмт хэргийн криминологи шинжсийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- Хэргийн 35.5 хувь нь хөнгөн, 57.6 хувь нь хүндэвтэр, 6.0 хувь нь хүнд, 0.9 хувь нь онц хүнд ангиллын,

- 2.8 хувь нь насанд хүрээгүй, 1.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 2.5 хувь нь согтуугаар, 0.2 хувь нь галт зэвсгээр, 0.5 хувь нь үгсэж тохиролцсон бүлэг, 27.0 хувь нь бүлэглэн,
- Мал хулгайлах 4 гэмт хэрэг тутмын 1 нь бүлгээр,
- Гэмт хэргийн 71.2 хувь нь бэлчээрт,
- 5.3 хувь нь 06-14 цагт, 11.8 хувь нь 14-19 цагт, 10.9 хувь нь 19-22 цагт, 72.0 хувь нь 22-06 цагт,
- Даваа гарагт 227, Мягмар гарагт 176, Лхагва гарагт 218, Пүрэв гарагт 200, Баасан гарагт 194, Бямба гарагт 168, Ням гарагт 193 хэрэг тус тус үйлдэгджээ.

Мал хулгайлах гэмт хэргийн халдлагад **1369** иргэн, 2 байгууллагад 3.2 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 1.9 тэрбум төгрөг буюу 59.4 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт **1246** хүн холбогдон шалгагдсаныдотор:

- 1.4 хувь нь эмэгтэй, 4.2 хувь нь насанд хүрээгүй, 29.3 хувь нь 18-24 насны, 20.9 хувь нь 25-29 насны, 17.5 хувь нь 30-34 насны, 11.1 хувь нь 35-39 насны, 8.2 хувь нь 40-44 насны, 5.4 хувь нь 45-49 насны, 2.0 хувь нь 50-54 насны, 0.9 хувь нь 55-59 насны, 0.3 хувь нь 60-64 насны, 0.2 хувь нь 70-аас дээш насны,
- 44.1 хувь нь малчин, 49.0 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс,
- 3.9 хувь нь согтуугаар, 52.2 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 1.6 хувь нь урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, 7.4 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлджээ.

Мэдээллийн санд бүртгэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 67.8 хувь нь ашиг олох, шунахай зорилгоор, 11.4 хувь нь малаа хариулага маллагаагүй, 7.3 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 1.6 хувь нь амжиргааны эх үүсвэргүй, 1.8 хувь нь сонор сэрэмжгүй, 0.2 хувь нь хяналт шалгалт сул, харуул манаа хариуцдаггүй, 14.1 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн байна.

Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 172 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 6 хэргээр буюу 3.4 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 0.8 хувь болж 0.1 нэгжээр тус тус буурав.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах хэрэг	178	172	-6	-3.4
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	0.9	0.8	-0.1 нэгжээр	буурсан
3	Бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэгт эзлэх хувийн жин	3.7	2.4	-1.3 нэгжээр	буурсан
4	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	54.1	51.1	-3.0 нэгжээр	буурсан

Авто тээврийн хэрэгслийг хулгайлах гэмт хэрэг Архангайд 12, Өвөрхангай, Дорноговьд тус бүр 8, Хэнтийд 6, Говь-Алтайд 5, Баян-Өлгий, Завханд 3, Дорнод, Дархан-Уул, Өмнөговь, Орхонд тус бүр 2, Увс, Ховд, Баянхонгор, Булган, Хөвсгөл, Дундговь, Сэлэнгэ, Төв, Ховд, Говьсүмбэрт тус бүр 1, нийслэлд 109, үүнээс Баянголд 29, Баянзүрхэд 27, Сонгинохайрханд 19, Чингэлтэйд 18, Сүхбаатарт 14, Хан-Уул, Налайхад тус бүр 1 хэрэг бүртгэгдсэн байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 139 гэмт хэрэг бүртгэгдэн 71 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд **51.1** хувьтай байна.

Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 27.9 хувь нь хөнгөн, 69.8 хувь нь хүндэвтэр, 1.2 хувь нь хүнд, 1.1 хувь нь онц хүнд ангиллын,

- 13.4 хувь нь согтуугаар, 17.4 хувь нь бүлгээр,
- 54.1 хувь нь гудамж талбайд, 19.2 хувь нь гэр, орон сууцны гаднаас, 5.2 хувь нь гараж, агуулахаас, 4.1 хувь нь олон нийт цугларсан газраас,
- 7.6 хувь нь 06-14 цагийн хооронд, 6.4 хувь нь 14-19 цагийн хооронд, 18.0 хувь нь 19-22 цагийн хооронд, 68.0 хувь нь 22-06 цагийн хооронд,
- Даваа гарагт 23, Мягмар гарагт 26, Лхагва гарагт 29, Пүрэв гарагт 30, Баасан гарагт 20, Бямба гарагт 27, Ням гарагт 17 хэрэг тус тус үйлдэгджээ.

Гэмт хэргийн халдлагад **175** иргэн өртөж, 537.7 сая төгрөгийн хохирол учирсаны 225.9 сая төгрөг буюу 42.0 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба тээврийн хэрэгсэл хулгайлах нэг гэмт хэрэгт 3.1 сая төгрөгийн эд хөрөнгөнийн хохирол ноогдож байна.

Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэгт **117** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 1.7 хувь нь эмэгтэй хүн,
- 9.4 хувь нь 16-17 насны, 47.0 хувь нь 18-24 насны, 21.4 хувь нь 25-29 насны, 8.6 хувь нь 30-34 насны, 5.1 хувь нь 35-44 насны, 8.5 хувь нь 45-аас дээш насны хүмүүс,
- 66.6 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс,
- 18.8 хувь нь согтуугаар, 37.6 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 6.0 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлджээ.

Мэдээллийн санд бүртгэгдсэн авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 78.5 хувь нь ашиг олох, шунахай зорилгоор, 5.8 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, амжиргааны эх үүсвэргүй, 2.5 хувь нь тус бүр сонор сэрэмжгүй, харуул манааны хариуцлагагүй, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, 9.9 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн тухай дурдсан байна.

Иргэдийн эд зүйлийг хулгайлах гэмт хэрэг 4094 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 625 хэргээр буюу 18.0 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 18.5 хувь, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 65.3 хувь болж, 0.4 нэгжээр тус тус өсөв.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Хувийн эд хөрөнгийг хулгайлах	3469	4094	625	18.0
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	18.1	18.5	0.4 нэгжээр өссөн	
3	Бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэгт эзлэх хувийн жин	65.8	65.3	-0.5 нэгжээр буурсан	
4	Хувийн эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	54.8	49.1	-5.7 нэгжээр буурсан	

Эд зүйл хулгайлах гэмт хэрэг Өвөрхангайд 114, Дархан-Уулд 110, Орхонд 101, Төвд 97, Хөвсгөлд 85, Хэнтийд 83, Дорноговьд 82, Дорнодод 75, Сэлэнгэд 70, Булганд 58, Архангайд 57, Өмнөговьд 54, Завханд 46, Дундговьд 40, Баянхонгор 36, Ховдод 25, Сүхбаатар, Увсад тус бүр 30, Баян-Өлгийд 27, Говь-Алтайд 23, Говьсүмбэрт 16, нийслэлд 2808, үүнээс Баянзүрхэд 642, Сонгинохайрханд 561, Баянголд 553, Сүхбаатарт 403, Чингэлтэйд 353, Хан-Уулд 226, Налайхад 47, төмөр замын салбарт 25, Багануурт 19, Иргэний агаарын тээврийн салбар, бусад газарт тус бүр 1 хэрэг бүртгэгджээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 3299 гэмт хэргээс 1621 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд **49.1** хувьтай, 1678 гэмт хэргийг үйлдсэн этгээдийг олж тогтоогоогүй (Орхонд 48, Өвөрхангайд 45, Дархан-Уулд 32, Дорноговь, Төвд тус бүр 26, Хэнтий, Булганд тус бүр 22, Дорнодод 21, Хөвсгөлд 20, Өмнөговь, Дундговьд тус бүр 19,

Завханд 17, Баянхонгор, Архангайд тус бүр 13, Сэлэнгэд 9, Увсад 7, Баян-Өлгий, Ховд, Говьсүмбэрт тус бүр 5, Говь-Алтай, Сүхбаатарт тус бүр 3, нийслэлд 1292, үүнээс Баянзүрхэд 429, Сонгинохайрханд 235, Сүхбаатарт 187, Чингэлтэйд 172, Баянголд 121, Хан-Уулд 120, Налайхад 15, Багануурт 11, төмөр замын салбарт 5, бусад газарт 1 хэрэг) байна.

Иргэдийн эд зүйлийг хулгайлах гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- Хэргийн 27.8 хувь нь хөнгөн, 71.3 хувь нь хүндэвтэр, 0.3 хувь нь хүнд, 0.6 хувь нь онц хүнд ангиллын,
- 8.7 хувь нь насанд хүрээгүй, 7.9 хувь нь эмэгтэй хүн оролцож,
- 9 гэмт хэрэг тутмын 1 нь бүлгээр үйлдэгдсэн байна.
- 46.0 хувь нь гэр орон сууцанд, 10.7 хувь нь гудамж талбайд, 18.3 хувь нь олон нийтийн газар, 0.8 хувь нь тус бүр төрийн байгууллага болон нийтийн тээвэрт, 1.6 хувь нь төрийн бус байгууллагад, 11.0 хувь нь аж ахуйн нэгжид, 10.8 хувь нь бусад газарт,
- 669 нь Даваа, 622 нь Мягмар, 581 нь Лхагва, 599 нь Пүрэв, 643 нь Баасан, 469 нь Бямба, 511 нь Ням гарагт,
- 16.2 хувь нь 06-14, 23.6 хувь нь 14-19, 13.0 хувь нь 19-22, 47.2 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.
- 8.0 хувь нь согтуугаар, 0.2 хувь нь үгсэж тохиролцсон бүлэг, 10.5 хувь нь бүлэглэн гүйцэтгэжээ.

Гэмт хэргийн халдлагад **4043** хүн, 32 байгууллага өртөж, **7.7** тэрбум төгрөгийн хохирол учирсаны **3.7** тэрбум төгрөг буюу **48.0** хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт **2766** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 11.2 хувь нь эмэгтэй, 15.0 хувь нь хүүхэд,
- 38.9 хувь нь 18-24 насны, 16.3 хувь нь 25-29 насны, 8.0 хувь нь 30-34 насны, 7.3 хувь нь 35-39 насны, 4.8 хувь нь 40-44 насны, 3.7 хувь нь 45-49 насны, 1.5 хувь нь 50-54 насны, 0.6 хувь нь 55-59 насны, 18.9 хувь нь 60-аас дээш насны хүмүүс,
- 1932 нь ажилгүй, 134 нь малчин, 153 нь сурагч, 155 нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 152 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 104 нь оюутан, 18 нь төрийн албан хаагч, 53 нь тэнэмэл, 37 нь сургууль завсардсан хүүхэд, 23 нь төрийн бус байгууллагын ажилтан, 5 нь хоригдол,
- 37.8 хувь нь бүрэн дунд, 31.9 хувь нь суурь, 16.9 хувь нь бага, 7.2 хувь нь боловсролгүй, 3.6 хувь нь дээд боловсролтой, 2.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 0.1 хувь нь техникийн болон мэргэжлийн,
- 13.1 хувь нь согтуугаар, 30.4 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 0.4 хувь нь урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, 11.1 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлджээ.

Мэдээллийн санд бүртгэгдсэн иргэдийн эд зүйл хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 83.3 хувь нь ашиг олох, шунахай зорилго, 3.9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, амжиргааны эх үүсвэргүй, 1.5 хувь нь сонор сэрэмжгүй, 0.7 хувь нь архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэснээс, 0.6 хувь нь харуул манааны хариуцлагагүй, хяналт шалгалт сул, 0.2 хувь нь тус бүр итгэл эвдсэн, хувь хүний ухамсар, ёс суртахууны төлөвшил, гэр бүлийн хүчирхийлэл, ажилдаа хайнга хандсан, 7.8 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн байна.

Халаасны хулгайн гэмт хэрэг 249 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 1.1, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 4.0 хувийг тус тус эзэлж байна.

Халаасны хулгайн гэмт хэрэг Орхонд 4, Өвөрхангайд 5, Баян-Өлгий, Дорнодод тус бүр 1, нийслэлд 235, үүнээс Баянголд 63, Сүхбаатарт 59, Чингэлтэйд 46, Баянзүрхэд 41, Сонгинохайрханд 16, Багануурт 1 хэрэг бүртгэгджээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 227 гэмт хэргээс 68 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд **30.0** хувьтай байна.

Халаасны хулгайн гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 36.8 хувь нь хөнгөн, 3.2 хувь нь хүндэвтэр ангиллын,
- 1.6 хувь нь согтуугаар, 6.8 хувь нь хүүхэд, 9.6 хувь нь эмэгтэй хүн оролцсон,
- 41.0 хувь нь олон нийтийн газарт, 11.6 хувь нь нийтийн захад, 10.4 хувь нь зах, дэлгүүрт, 31.7 хувь нь гудамж талбайд, 19.7 хувь нь нийтийн тээвэрт, (үүнээс 18.1 хувь нь том оврын автобусанд)
- 44 нь Даваа, 42 нь Мягмар, 41 нь тус бүр Лхагва, 41 нь Баасан, Пүрэв, 20 нь Бямба, 29 нь Ням гарагт,
- 26.1 хувь нь 0-14, 53.4 хувь нь 14-19, 10.0 хувь нь 19-22, 10.4 хувь нь 22-06 цагийн хооронд тус тус үйлдэгджээ.

Гэмт хэргийн халдлагад 241 иргэн өртөж, 160.1 сая төгрөгийн хохирол учирсаны 59.3 сая төгрөг буюу 37.0 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн байна.

Халаасны хулгайн гэмт хэрэгт **111** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 17.1 хувь нь насанд хүрээгүй хүн, 36.0 хувь нь 18-24 насны, 23.4 хувь нь 25-29 насны, 12.6 хувь нь 30-34 насны, 2.7 хувь нь 35-44 насны, 8.2 хувь нь 45-аас дээш насны хүмүүс,
- 86.5 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс, 5.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч,
- 4.5 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлджээ.

§5.6. Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн криминологи шинж, түүний шалтгаан нөхцөл

Бусдын эд хөрөнгийг булаах (Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйл) гэмт хэрэг **179** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 42 хэргээр буюу 30.7 хувиар өссөн. Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 0.8 хувь байна.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Бусдын эд хөрөнгийг булаах хэрэг	137	179	42	30.7
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	0.7	0.8	0.1 нэгжээр өссөн	
3	Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	53.6	43.5	-10.1 нэгжээр буурсан	

Орхон, Дорноговьд тус бүр 6, Дархан-Уул, Дорнод, Хэнтийд тус бүр 4, Сэлэнгэд 2, Завхан, Ховд, Архангай, Булган, Өвөрхангай, Өмнөговь, Төв аймагт тус бүр 1, нийслэлд 145, үүнээс Баянзүрхэд 38, Баянголд 37, Сонгинохайрхан 25, Чингэлтэй 22, Сүхбаатарт 13, Хан-Уул 10, төмөр замын салбарт 1 хэрэг бүртгэгджээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 131 гэмт хэрэг бүртгэгдэн 57 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд **43.5** хувьтай, 74 гэмт хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй, (Орхонд 5, Дархан-Уулд 2, Булган, Дорноговь, Сэлэнгэ, Төв аймагт тус бүр 1, нийслэлд 63, үүнээс Баянзүрхэд 25, Чингэлтэйд 11, Сүхбаатар, Сонгинохайрханд тус бүр 7, Баянголд 10, Хан-Уулд 3 хэрэг) байна.

Булаах гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:


- 56.4 хувийг хөнгөн, 42.4 хувийг хүндэвтэр, 0.6 хувийг тус бүр хүнд, онц хүнд ангиллын,
- 12.8 хувь нь хүүхэд, 20.0 хувь нь бүлгээр, 8.9 хувь нь согтуугаар, 18.4 хувь нь гэр орон сууц, 53.6 хувь нь гудамж талбай, 12.8 хувь нь олон нийтийн газар, 2.8 хувь нь нийтийн тээвэр, 3.9 хувь нь аж ахуйн нэгжид, 8.5 хувийг бусад газарт,
- 30 нь Даваа, 34 нь Мягмар, 36 нь Лхагва, 29 нь Пүрэв, 17 нь Баасан, 19 нь Бямба, 14 нь Ням гарагт,
- 12.3 хувь нь 06-14 цагт, 25.1 хувь нь 14-19 цагт, 22.4 хувь нь 19-22 цагт, 40.2 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.


Булаах гэмт хэргийн халдлагад **179** иргэн өртөж (94 нь эмэгтэй хүн), **214.6** сая төгрөгийн хохирол учирсаны **121.6** сая төгрөг буюу 56.7 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн байна.



Гэмт хэрэгт **115** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 3.4 хувь нь эмэгтэй, 22.6 хувь нь насанд хүрээгүй,
- 38.3 хувь нь 18-24 насны, 20.0 хувь нь 25-29 насны, 7.8 хувь нь 30-34 насны, 5.2 хувь нь 35-39 насны, 2.6 хувь нь 40-44 насны, 3.5 хувь нь 45-аас дээш насны,
- 1.7 хувь нь төрийн бус байгууллагын ажилтан, 3.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 4.3 хувь нь малчин, 8.7 хувь нь оюутан, 12.2 хувь нь сурагч, 0.9 хувь нь тус бүр сургууль завсардсан хүүхэд, хоригдол, 1.7 хувь нь тэнэмэл, 66.2 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс,
- 12.0 хувь нь согтуугаар, 31.6 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 6.8 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлджээ.





Гэмт хэргийн мэдээллийн санд бүртгэгдсэн бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 83.2 хувь нь ашиг олох, шунахай зорилго, 3.9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 1.1 хувь нь тус бүр танхай, сонор сэрэмжгүй, 0.2 хувь нь итгэл эвдсэн, 1.7 хувь нь тус бүр айлган сүрдүүлсэн, амжиргааны эх үүсвэргүй, 2.2 хувь нь архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ, 8.4 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн байна.

Булаах гэмт хэрэг нь ихэвчлэн орон сууцны болон гэр хорооллын гэрэлтүүлэггүй орчинд үйлдэгддэг ба гэмт хэргийг 24 хүртэлх насны эрхэлсэн тодорхой ажилгүй залуучууд, биеэ хамгаалах чадваргүй өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхэд зэрэг хүмүүсийг сонгож эд зүйлийг булаах гэмт хэргийг үйлдэж байна.

§5.7. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн криминологи шинж, түүний шалтгаан нөхцөл

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх (Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйл) гэмт хэрэг 552 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 16 хэргээр буюу 3.0 хувиар өсч, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 2.5 хувь болж, 0.3 нэгжээр буурав.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг	536	552	16	3.0
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	2.8	2.5	-0.3 нэгжээр буурсан	
3	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	64.7	55.7	-9.0 нэгжээр буурсан	

Дээрэмдэх гэмт хэрэг Дархан-Уулд 31, Орхонд 16, Дорноговь, Сэлэнгэд тус бүр 10, Хэнтийд 9, Дорнодод 6, Архангайд 5, Булганд 4, Баян-Өлгий, Өвөрхангай, Хөвсгөлд тус бүр 3, Дундговь, Өмнөговьд тус бүр 2, Ховд, Завхан, Баянхонгор, Төв, Сүхбаатарт тус бүр 1, нийслэлд 442, үүнээс: Баянголд 99, Сонгинохайрханд 94, Баянзүрхэд 82, Сүхбаатарт 75, Чингэлтэйд 59, Хан-Уулд 25, Багануурт 5, Налайхад 3, Төмөр замын салбарт 1 хэрэг тус тус бүртгэгджээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 406 гэмт хэргээс 226 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд **55.7** хувьтай, 180 гэмт хэргийг үйлдсэн этгээдийг олж тогтоогоогүй (*Орхонд 5, Дархан-Уулд 3, Баянөлгий, Завхан, Ховд, Архангай, Өвөрхангай, Дорноговь, Дорнодод тус*

бүр 1, нийслэлд 165 үүнээс Баянзүрхэд 51, Сонгинохайрханд 37, Сүхбаатарт 30, Баянголд 20, Чингэлтэйд 18, Хан-Уулд 9 хэрэг) байна.

Дээрэмдэх гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурьдвал:


- 26.0 хувь нь хүндэвтэр, 73.5 хувь нь хүнд, 0.5 хувь нь онц хүнд ангиллын,
- 22.3 хувь нь насанд хүрээгүй хүн оролцож, 23.6 хувь нь согтуугаар, 45.7 хувь нь бүлгээр, 10 хувь нь эмэгтэй хүн оролцож, 19.4 хувь нь гэр, орон сууцанд, 61.8 хувь нь гудамж талбайд, 6.0 хувь нь олон нийтийн газар, 1.8 хувь нь нийтийн тээвэрт, 0.9 хувь нь төрийн бус байгууллагад, 3.6 хувь нь аж ахуйн нэгжид, 6.5 хувь нь бусад газарт,
- 10.1 хувь нь 06-14 цагт, 13.0 хувь нь 14-19 цагт, 20.5 хувь нь 19-22 цагт, 56.4 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.

Гэмт хэргийн халдлагад **553** иргэн, үүнээс 143 эмэгтэй хүн өртөж, **483.9** сая төгрөгийн хохирол учирсаны **221.2** сая төгрөг буюу 45.7 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэргийн улмаас 218 хүн гэмтсэн байна.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэгт **565** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 31.8 хувь нь насанд хүрээгүй, 45.5 хувь нь 18-24 насны, 12.4 хувь нь 25-29 насны, 4.2 хувь нь 30-34 насны, 3.4 хувь нь 35-39 насны, 1.4 хувь нь 40-44 насны, 1.3 хувь нь 45-49 насны,
- 0.9 хувь нь төрийн албан хаагч, 3.2 хувь нь хувийн хэвийн байгууллагад ажиллагч, 0.5 хувь нь төрийн бус байгууллагын ажилтан, 4.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.6 хувь нь ажилчин, малчин, 22.5 хувь нь оюутан, сурагч, 1.8 хувь нь тэнэмэл, 1.2 хувь нь сургууль завсардсан хүүхэд, 0.4 хувь нь хоригдол, 63.8 хувь нь ажилгүй хүмүүс,
- 28.1 хувь нь согтуугаар, 66.4 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 9.6 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс байжээ.





Мэдээллийн санд бүртгэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл: 72.5 хувь нь ашиг олох, шунахай сэдэлт, 3.4 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 3.3 хувь нь айлган сүрдүүлсэн, 2.4 хувь нь архи согтууруулах ундаа хэрэглэсэн, 5.8 хувь нь танхай, 0.9 хувь өш хонзон, 1.5 хувь нь амжиргааны өөр эх үүсвэргүй, 1.0 хувь нь хувь хүний ёс суртахууны доголдол, 5.6 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь голдуу биеэ хамгаалах чадваргүй хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүд байх бөгөөд гэмт этгээд ч зориуд эдгээр хүмүүсийг сонгож гэмт хэргийнхээ хохирогч болгодог ба гэмт хэрэг үйлдэгчид нь тодорхой эрхэлсэн ажилгүй, бүрэн дундаас доош боловсролтой, 18-30 насны залуучууд архидан согтуурсан үедээ бүлэглэн бусдыг дээрэмдэх байдал сүүлийн ихээр бүртгэгдэж байна.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь цаг хугацааны хувьд харуй, бүрийгээр үйлдэгддэг бөгөөд ялангуяа өвлийн улиралд гэмт хэрэг өсөх хандлага харагдаж байгаа нь өвөл эрт харанхуй болдог, гудамж талбайн гэрэлтүүлэг муу байгаа газруудад ихээр үйлдэгдэж байна.

§5.8. Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн криминологи шинж, түүний шалтгаан нөхцөл

Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах (Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйл) гэмт хэрэг **1098** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 410 хэргээр буюу 59.6 хувь, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 5.0 хувь болж, 1.4 нэгжээр өссөн байна.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэг	688	1098	410	59.6
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	3.6	5.0	1.4 нэгжээр өссөн	
3	Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	56.6	54.2	- 2.4 нэгжээр буурсан	

Залилан мэхэлж авах гэмт хэрэг Орхонд 35, Төвд 20, Сэлэнгэд 14, Дорнодод 12, Хэнтийд 10, Дорноговь, Дархан-Уулд тус бүр 9, Увс, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Дундговь, Сүхбаатарт тус бүр 5, Баян-Өлгий, Өмнөговь, Булган,

Говьсүмбэрт тус бүр 4, Завхан, Ховдод 3, нийслэлд 920, үүнээс Баянголд 268, Сүхбаатарт 201, Чингэлтэйд 159, Баянзүрхэд 143, Сонгинохайрхан 86, Хан-Уулд 50, Налайхад 8, Багануурт 5, Төмөр замын салбар, бусад газарт тус бүр 3, Нисэхийн салбарт 1 хэрэг бүртгэгджээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 297 гэмт хэргээс 161 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд **54.2** хувьтай 136 хэргийг үйлдсэн этгээдийг олж тогтоогоогүй (*Орхонд 3, Баян-Өлгий, Говьсүмбэрт тус бүр 2, Өвөрхангай, Төвд тус бүр 1, нийслэлд 125, үүнээс Баянзүрхэд 53, Сүхбаатарт 37, Чингэлтэйд 18, Баянголд 8, Сонгинохайрханд 7, Хан-Уул 2, бусад газарт тус бүр 2 хэрэг*) байна.

Залилан мэхэлж авах гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:


- 41.5 хувь нь хөнгөн, 39.4 хувь нь хүндэвтэр, 7.4 хувь нь хүнд, 11.7 хувь нь онц хүнд ангиллын хэрэг,
- 37.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 8.0 хувь нь бүлгээр, гэмт хэргийн 21.9 хувь нь гэр орон сууцанд, 8.2 хувь нь гудамж талбайд, 19.1 хувь нь олон нийтийн газар, 0.5 хувь нь нийтийн тээвэрт, 2.7 хувь нь төрийн байгууллагад, 2.6 хувь нь төрийн бус байгууллагад, 26.4 хувь нь аж ахуйн нэгжид, 18.6 хувь нь бусад газарт,
- 208 нь Даваа, 165 нь Мягмар, 179 нь Лхагва, 167 нь Пүрэв, 182 нь Баасан, 94 нь Бямба, 103 нь Ням гарагт,
- 32.8 хувь нь 06-14 цагт, 46.3 хувь нь 14-19 цагт, 7.2 хувь нь 19-22 цагт, 13.7 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.

Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах 3 гэмт хэрэг тутмын нэгд эмэгтэй хүн оролцсон байна.


Гэмт хэргийн улмаас 1073 иргэн, 5 байгууллагад **12.1** тэрбум төгрөгийн хохирол учирсаны **4.4** тэрбум төгрөг буюу 37.2 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн байна.

Залилан мэхлэх гэмт хэрэгт **897** хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 43.4 хувь нь эмэгтэй, 1.7 хувь нь хүүхэд,
- 16.9 хувь нь 18-24 насны, 15.5 хувь нь 25-29 насны, 14.9 хувь нь 30-34 насны, 15.7 хувь нь 35-39 насны, 15.6 хувь нь 40-44 насны, 7.9 хувь нь 45-49 насны, 7.7 хувь нь 50-54 насны, 1.7 хувь нь 55-59 насны, 1.9 хувь нь 60-64 насны, 0.5 хувь нь 65-69 насны хүмүүс холбогдсон байна.



- 47.4 хувь нь бүрэн дунд, 39.4 хувь нь дээд боловсролтой, 7.9 хувь нь суурь, 2.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 1.8 хувь нь бага боловсролтой, 0.7 хувь нь боловсролгүй,




- 0.6 хувь нь согтуугаар, 12.0 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 0.1 хувь нь урьдчилан үгсээж тохиролцсон бүлэг, 4.1 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлджээ.

Гэмт хэргийн мэдээллийн санд бүртгэгдсэн бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 98.0 хувь нь ашиг олох, шунахай зорилго, 8.5 хувь нь итгэл эвдсэн, 5.1 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 0.9 хувь нь сонор сэрэмжгүй, 2.9 хувь нь амжиргааны өөр эх үүсвэргүй, 0.2 хувь нь ажилдаа хайнга хандсан, 0.1 хувь нь тус бүр хувийн ашиг хонжоо олох, хяналт шалгалт сул, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, хяналтын механизм сул, хувь хүний ёс суртахууны доголдол, 5.7 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгджээ.

§5.9. Танхайрах гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл

Танхайрах (Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйл) гэмт хэрэг 1687 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 137 хэргээр буюу 7.5 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 7.6 хувь болж, 1.9 нэгжээр тус тус буурав.



Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Танхайрах хэрэг	1824	1687	-137	-7.6
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	9.5	7.6	1.9 нэгжээр буурсан	
3	Танхайрах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	76.7	65.3	11.4 нэгжээр буурсан	

Гэмт хэрэг Хэнтийд 89, Орхонд 38, Сэлэнгэд 37, Дорнодод 34, Дархан-Уулд 28, Сүхбаатарт 26, Төвд 22, Дорноговьд 20, Баянхонгорд 18, Өвөрхангайд 17, Увсад 15, Дундговь, Завхан, Хөвсгөлд тус бүр 12, Өмнөговьд 11, Говьсүмбэрт 10, Архангай, Говь-

Алтайд тус бүр 8, Булганд 7, Баян-Өлгийд 5, Ховдод 4, нийслэлд 1245, үүнээс Баянзүрхэд 367, Чингэлтэйд 240, Сонгинохайрханд 222, Баянголд 163, Сүхбаатарт 122, Хан-Уулд 79, Багануурт 31, Налайхад 21, иргэний агаарын салбарт 1, төмөр замд 4, бусад газарт 4 бүртгэгджээ.

Гэмт хэргийн гаралт Баян-Өлгий, Завхан, Орхон, Өвөрхангай, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатарт 4.0-66.7 хувиар өсч, Говь-Алтай, Увс, Ховд, Архангай, Баянхонгор, Булган, Хөвсгөл, Дархан-Уул, Дорноговь, Дундговь Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймагт 4.0-63.6 хувиар тус тус буурав.

Нийслэлийн Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Багануур дүүрэгт 11.2-82.4 хувиар өсч, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Налайх дүүрэгт 3.0-31.8 хувиар буурав.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 544 гэмт хэрэг бүртгэгдэн 355 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд **65.3** хувьтай байна.

Хэргийн 67.7 хувь нь хүндэвтэр, 32.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа ба 4.4 хувь нь хүүхэд, 6.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 57.3 хувь нь согтуугаар, 21.6 хувь нь бүлэглэн гүйцэтгэжээ.

Гэмт хэргийн 23.6 хувь нь гэр орон сууцанд 36.4 хувь нь гудамж талбайд, 24.1 хувь нь олон нийтийн газар, 1.5 хувь нь нийтийн тээвэрт, 1.5 хувь нь төрийн байгууллагад, 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 2.1 хувь нь аж ахуйн нэгжид, 9.8 хувь бусад газарт, 0.5 хувь нь авто замд, 274 нь Даваа, 247 нь Мягмар, 235 нь Лхагва, 233 нь Пүрэв, 239 нь Баасан, 245 нь Бямба, 214 нь Ням гарагт, 10.8 хувь нь 06-14 цагт, 18.4 хувь нь 14-19 цагт, 25.7 хувь нь 19-22 цагт, 45.1 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 1713 хүн хохирсны 294 нь эмэгтэй хүн өртөж, 574.3 сая төгрөгийн хохирол учирсны 379.6 сая төгрөг буюу 66.1 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.


Гэмт хэргийн улмаас 6 хүн нас барж, 1291 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтсэн нь гэмтсэн нийт хүний 15.3 хувийг эзэлж байна.

Гэмт хэрэгт 1702 хүн холбогдон шалгагдсаны 6.9 хувь нь эмэгтэй, 5.2 хувь нь хүүхэд, 39.8 хувь нь 18-24 насны, 18.7 хувь нь 25-29 насны, 14.0 хувь нь 30-34 насны, 9.9 хувь нь 35-39 насны, 5.8 хувь нь 40-44 насны, 3.7 хувь нь 45-49 насны, 1.7 хувь нь 50-54 насны, 0.8 хувь нь 55-59 насны, 0.3 хувь нь 60-64 насны хүн гэмт хэрэгт холбогдсоны 52.5 хувь нь согтуугаар, 29.4 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 4.5 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлджээ.

Гэмт хэрэг үйлдэгсдийг нийгмийн байдал, боловсролоор нь авч үзвэл 940 нь ажилгүй, 220 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 160 нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 157 нь оюутан, 84 нь малчин, 53 нь төрийн албан хаагч, 35 нь сурагч, 34 нь төрийн бус байгууллагын ажилтан, 9 нь хоригдол, 4 нь тус бүр сургууль завсардсан хүүхэд болон тэнэмэл амьдралтай хүн, 2 нь хугацаат цэргийн албан хаагч, 51.9 хувь нь бүрэн дунд, 23.4 хувь нь суурь, 13.3 хувь нь дээд боловсролтой, 6.8 хувь нь бага, 2.3 хувь нь тус бүр тусгай мэргэжлийн дунд болон боловсролгүй хүн байна.

§5.10. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл

Байгаль хамгаалах журмын эсрэг (*Эрүүгийн хуулийн 202-214¹ дүгээр зүйл*) гэмт хэрэг **410** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 140 хэргээр буюу 51.9 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 1.8 хувь болж, 0.4 нэгжээр тус тус өсөв.



Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	270	410	140	51.9
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	1.4	1.9	0.5 нэгжээр өссөн	

Бүртгэгдсэн байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн:

- 262 буюу 64.0 хувь нь ойн тухай хууль тогтоомж зөрчих,
- 45 буюу 11.0 хувь нь ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих,
- 79 буюу 19.2 хувь нь хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох,
- 12 буюу 2.9 хувь нь тус бүр байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих, ой, хээрийн түймэр тавих гэмт хэрэг байна.

Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 262 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 40 хэргээр буюу 18.0 хувиар өссөн байна. Тухайлбал:

Булганд 2.6 дахин, Сэлэнгэд 26.8, Төвд 18.2, Нийслэлийн хэмжээнд 13.5, Завханд 7.0, Архангайд 2.1 хувиар өссөн ба үйлдэгчид нь ихэвчлэн оршин суудаг нутагтаа хулгайгаар мод бэлтгэж, бэлтгэсэн, мод модон бүтээгдэхүүний гарал үүслийг шалгуулалгүй өнгөрөх, хулгайн зам буюу хяналт, шалгалт хийгддэггүй замыг сонгож, баяр, амралтын өдрүүдэд тээвэрлэдэг.

Эргүүл шалгалтын талаархи мэдээллийг иргэдээс авах, урдаа суудлын автомашинтай явах, битүү чингэлэгтэй зориулалтын бус автомашинд ачих, хучлагаар хучиж дээр нь гэр бараа, хүнсний ногоо ачих зэргээр далдлан хяналт шалгалтаас зайлсхийдэг.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн 19.3 хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг эзэлж өмнөх оны мөн үеийнхээс 6 дахин өссөн байна.

Энэ төрлийн гэмт хэрэг Архангайд 49, Сэлэнгэд 12, Төвд 7, Баянхонгорт 4, Дорнодод 2, Дархан-Уул, Дундговь, Сүхбаатар аймагт тус бүр 1 хэрэг бүртгэгджээ.

Сүүлийн жилүүдэд манай оронд ашигт малтмалын хайгуул, ашиглах, олборлох үйл ажиллагаа идэвхижсэн нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтад нөлөөлж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол (экологи эдийн засгийн үнэлгээ)-ыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож байгаа хэдий ч үнэлгээ тогтоох аргачлал нь боловсронгуй бус байгаагаас хэргийн хувь заяа ихээхэн шалтгаалж байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн 63.7 хувийг иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн мөрөөр илрүүлэн, 36.3 хувийг цагдаа, болон бусад хууль хяналтын байгууллага илрүүлэн шалгасан байна.

Цагдаагийн байгууллагын ажилтнууд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдсанаас бусад үед энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох чиглэлд тогтмол анхаардаггүй, иргэдээс ирүүлсэн мэдээллийг шалгахаас өөрөөр санаачилга гарган хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлийн ажил зохион байгуулдаггүй, хяналт шалгалтыг сулруулснаас энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөх, зарим үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлж бүртгэж чадахгүй байх нөхцөл бий болж байна.

Тусгай хамгаалалттай газрын захиргаа, тухайн орон нутгийн Засаг дарга, байгаль орчин, мэргэжлийн хяналтын алба, хууль хяналтын байгууллагуудын идэвхи санаачилга, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын уялдаа холбоо, зохион байгуулалтаас шалтгаалан энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн сайнгүй байна.

Анхаарах асуудал: Цагдаагийн байгууллагын байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсээс цагдаагийн байгууллагын ажилтнуудад энэ төрлийн хэргийг

илрүүлэх, шалгах аргачлал бэлтгэж хүргүүлэх, зайны сургалт явуулах замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлийг эрчимжүүлэх;

Хулгайгаар мод тээвэрлэдэг зам, маршрутыг тогтоож эргүүл шалгалтыг оновчтой зохион байгуулах, мод, модон материалын захуудын үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалтыг тогтмол явуулж түүний эх сурвалжийг тогтооход үйл ажиллагаагаа чиглүүлэх;

Цагдаагийн байгууллагын ажилтнууд нутгийн захиргааны болон байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллага, нутгийн иргэдтэй нягт хамтран ажиллаж мод бэлтгэсэн, тээвэрлэсэн, борлуулсан үйл ажиллагааг илрүүлэхэд тэдний дэмжлэгийг авч ажиллах, энэ төрлийн гэмт хэргийн талаар, иргэдэд хууль сурталчлах, яриа таниулга хийж, урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, мэдээ, мэдээллийг бүх төрлийн хэлбэрээр авч тэднийг урамшуулах системийг боловсронгуй болгох;

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛЫН ТУХАЙ

Хүн төрөлхтөн байгаль экологийн асуудалд онцгой анхаарал тавих болсноор сүүлийн жилүүдэд аж үйлдвэрлэлийн технологи нэвтэрч буй шинжлэх ухаан, техникийн дэвшилтэт ололтыг эко системийн аюулгүй байдалд нийцүүлэх болсноор илэрч байна. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг нь ард түмний нийтлэг эрх ашгийг хөндөж хүрээлэн буй орчин, үндэсний болон бүс нутгийн аюулгүй байдалд нөлөөлдөг.

Байгаль хамгаалах гэмт хэргийн онцлог нь ард түмний нийтлэг эрх ашгийг хөндөж улмаар Үндэсний аюулгүй байдалд болон бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг ба гэмт хэргийн улмаас үүсэж байгаа хор уршгийн хувьд нэг нь нөгөөдөө нөлөөлж байдаг онцлогтой. Монгол орны байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх эрх зүйн орчин урьд жилүүдээс илүү бүрдсэн байна.

1. Байгаль хамгаалах гэмт хэргийн ерөнхий хандлага: (2009-2011) Сүүлийн 3 жилийн байдлаар цагдаагийн байгууллагад байгаль хамгаалах журмын эсрэг 819 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан байна. 2010 онд бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 87 хэргээр (27.4%) буурч, 2009 онд 41 хэргээр (14.8%) 2011 онд 39 хэргээр (16.9%) тус тус өссөн байна. Дээрхи статистик дүн мэдээнээс харахад байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг жил ирэх тусам нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 694 буюу **72.5 хувь** нь хөдөө, орон нутагт, 123 буюу **15.1 хувь** нь нийслэлд үйлдэгдсэн байна. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргүүдээс голлон ойн тухай хууль тогтоомж зөрчих хэрэг голлон үйлдэгдсэн байна. Сүүлийн 3 жилийн байдлаар дээрхи төрлийн гэмт хэрэг 651 бүртгэгдсэн ба энэ нь байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн **79.5 хувийг** эзлэж байна.

2. Өнөөгийн нөхцөл байдал: Улсын хэмжээнд 2012 оны эхний 9 сард байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 319 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 2.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 132 хэргээр буюу 70.6 хувиар өсч, нийслэлийн хэмжээнд 15 хэргээр буюу 50 хувиар өсч, 45 буюу 14.1 хувь нь нийслэлд, 279 буюу 87.5 хувь нь орон нутагт үйлдэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Ховд, Баянхонгор, Өвөрхөнгөй, Хөвсгөл, Өмнөговь, Төв, аймагт **22.2-100 хувиар**, Говь-Алтай, Архангай, Булган, Дорноговь, Дорнод аймагт **3-7.1 дахин**, нийслэлд **50 хувь**, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх, Налайх дүүрэгт **25.0-100 хувиар** тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн дотор ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 9.7 хувь, ойн тухай хууль тогтоомж зөрчих хэрэг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох хэрэг 62.7 хувь, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг 20.7 хувь, химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих хэрэг 0.9 хувийг эзэлж байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт 266 хүн холбогдон шалгагдсаны 3,8 хувь нь эмэгтэй, 11.3 хувь нь 18-24 насны, 19.9 хувь нь 25-29 насны, 22.2 хувь нь 30-34 насны, 46.6 хувь нь 35- дээш насны, 6.0 хувь нь төрийн алба хаагч, 3.4 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 11.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 23.7 хувь нь ажилчин, малчин, 55.3 хувь нь ажилгүй хүмүүс ба, 1.5 хувь нь урьд ял шийтгэгдсэн, 30.8 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 1024.1 сая төгрөгийн хохирол учирсанаас 762.8 сая төгрөг буюу 74.5 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, 498.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

3. Шалтгаан, нөхцөл: Цагдаагийн байгууллагын ажилтнууд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдсанаас бусад үед энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох чиглэлд тогтмол анхаардаггүй, иргэдээс ирүүлсэн мэдээллийг шалгахаас өөрөөр санаачилга гарган хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлийн ажил зохион байгуулдаггүй, хяналт шалгалтыг сулруулснаас энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөх, зарим үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлж бүртгэж чадахгүй байх нөхцөл бий болж байна.

Тусгай хамгаалалттай газрын захиргаа, тухайн орон нутгийн Засаг дарга, байгаль орчин, мэргэжлийн хяналтын алба, хууль хяналтын байгууллагуудын идэвхи санаачилга, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын уялдаа холбоо, зохион байгуулалтаас шалтгаалан энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн сайнгүй байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг үйлдэгдэн гарч байгаа үндсэн хэд хэдэн шалтгаан байна. Үүнд:

- Улсын байцаагч, ой хамгаалагч болон иргэдийн хуулийн мэдлэг дутмаг;
- Байгаль орчинд хийгдэж байгаа шалгалт хяналт сул;
- Төрөөс хуулийн хэрэгжилтэнд тавих хяналт хангалтгүй;
- Уул уурхай, хайгуулын лицензийг хяналт, шалгалтгүйгээр олгодог;
- Иргэдийн амжиргаа залгуулах нэг арга хэрэгслэл; (амжиргааны түвшин доогуур иргэд энэ төрлийн гэмт хэрэгт илүү холбогддог)
- Орон нутгийн түвшинд ажлын байр хангалтгүй, хомс байдаг;
- Барилгын материалын өртөг өндөр болсон;
- Эдийн засгийн хувьд бага зардал гарч их ашиг олдог;
- Зах зээлийн эрэлт хэрэгцээ өндөр;
- Ойн тухай хууль тогтоомж хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан хууль эрхийн актууд боловсронгуй бус;
- Орон нутгийн удирдлагын ажлын хариуцлага сул;
- Хөдөө орон нутагт ажилладаг байгаль хамгаалагч нарын ажлын хөлс бага, урамшууллын механизм муу байдгаас хүмүүсийн ажлын идэвхи сул;

Манай иргэд энэ төрлийн гэмт хэргийн хор уршиг, хүлээлгэх хариуцлагын талаар (телевиз, хэвлэл мэдээлэл, интернэт зэргээс) тодорхой хэмжээний мэдлэгтэй байгаа хэдий ч хувь хүний ёс суртахуун, ажилгүйдэл, хамгийн гол нь амар аргаар мөнгө олох гэсэн гэмт санаа давамгайлаад байгаа явдал нь энэ төрлийн гэмт хэрэг таслан зогсоогдохгүй харин ч өсөх хандлагатай байгаагийн бас нэг шалтгаан юм.

Энэ төрлийн гэмт хэрэг нь шүүхээр шуурхай шийдвэрлэхгүй удаах, хохирол экологийн эдийн засгийн үнэлгээг тогтоох аргачлал нь боловсронгуй бус байгаагаас зарим этгээдүүд ял завших, хөнгөн ял авах, түүнчлэн хөдөө орон нутгийн засаг дарга болон зарим нэг эрх бүхий албан тушаалтнууд хууль тогтоомжид байхгүй эрх хэмжээг эдлэн албан байгууллага, аж ахуй нэгжид дур мэдэн мод бэлтгэх зөвшөөрөл олгодог зэрэг нь гэмт хэрэг таслаг зогсоогдохгүй даамжирах хандлагатай байгаагийн нэг гол шалтгаан болж байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг ихэвчлэн бүлгээр үйлдэгддэг, энэ нь тухайн хэргийг захиалсан, үйлдсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан зэргээр тухайн хэрэгт

санаатай болон санамсаргүй байдлаар оролцсон хүн нэг бүр хариуцлага хүлээдэг нь иргэдийн хууль эрхийн мэдлэг дутмаг байгаатай холбоотой юм.

4. Дүгнэлт: Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд үндэслэн доорхи дүгнэлт хийж болохоор байна. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн 170 буюу 53.3 хувийг иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн мөрөөр илрүүлэн, 118 буюу 37.0 хувийг цагдаа, болон бусад хууль хяналтын байгууллага илрүүлэн шалгасан байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн 62.7 хувийг ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг эзэлж өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар, үүний дотор Архангай, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, аймагт **3.3-88.2 хувиар**, Булган аймагт **2.5 дахин** өссөн ба гэмт хэрэг үйлдэгчид нь хяналт, шалгалт хийгддэггүй замыг сонгож шөнө, үүрээр, амралт, баяр ёслолын өдрүүдэд эргүүл шалгалтын талаарх мэдээллийг дамжуулах, зорилгоор суудлын автомашин урдаа явуулж замын шалгалт байгаа эсэхийг шалгуулах, битүү чингэлэгтэй машинд ачих, брезентээр хучих, өнгөлөн далдлалт хийх (гэр бараа ачих) зэргээр хяналт шалгалтаас зайлсхийдэг.

Байгалийн баялаг дагасан хүн амын албан бус суурьшсан амьдрах орчин сүүлийн жилүүдэд ихээр бий болж байна. Энэ бол урьдаас төлөвлөөгүй суурин газрууд юм. Алт, зэс, жонш, нүүрс зэрэг байгалийн баялаг дагасан төлөвлөгдөөгүй суурин газрууд бараг бүх аймаг, сумдын нутаг дэвсгэрт бий болж байна. Эдгээр газруудад цагдаагийн нэгж байршиж хүрч ажиллах бололцоогүй, боломж төдийлөн хүрэхгүй байна. Хорих газраас суллагдсан хүмүүс амьдрахын эрхээр эдгээр газруудад очиж нөхцөл байдлыг хүндрүүлж, зарим онц ноцтой гэмт хэргүүд үйлдэх явдал цөөнгүй гарав. Гэмт хэрэг үйлдээд оргон зайлагсад ч тэнд орогнож хууль завшихыг оролдох, дахин гэмт хэрэг үйлдэх явдал нэлээдгүй гарч байна.

Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт нь байдаг хэдий ч энэ нь нэг мөр ойлголтгүй, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өөр өөрийн зүгээс тайлбарлаж хэрэгжүүлдгээс гэмт хэрэгтэн ял завших, зарим талаар эдийн засаг болон биемахбодийн хохирол учирч эрүүгийн хариуцлагад татагдах явдал цөөнгүй гарч байна. Тухайлбал: Аймаг, сумын Иргэдийн хурал, Засаг даргын тогтоол, захирамж нь ойн тухай хууль тогтоомжийн зарим зүйл заалттай нийцдэггүй, сум орон нутгийн төр захиргааны байгууллагууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх таслан зогсоох чиглэлээр албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд албан мэдэгдэл, санамж, зөвлөгөө өгдөг хэдий ч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байдаг.

Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэн шалгахад эрүү, захиргааны эрх зүйн мэдлэгээс гадна байгаль орчны салбарын бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, цаг үеийн байдалтай уялдан гарсан тушаал, шийдвэр, байгаль экологийн нарийн мэргэжил, мэргэшлийн ур чадвар өндөр байх шаарддагатай байна. Байгаль орчинд учирсан хохирол (экологи, эдийн засгийн үнэлгээ г.м) -ыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож дүгнэлт гаргуулж байгаа хэдий ч үнэлгээ тогтоох аргачлал нь боловсронгуй бус байгаагаас хэргийн хувь заяа ихээхэн шалтгаалж байна.

Түүнчлэн зарим алслагдсан аймаг сумдад харилцаа холбоо байхгүй, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хяналт шалгалт сул байдлыг ашиглан ойн тухай хууль тогтоомж зөрчих хэрэг илүүтэйгээр гарч байгаа бөгөөд өндөр хүчин чадал бүхий техник хэрэгслэл ашиглан хууль бусаар мод бэлтгэн модны зах зээлийн өртөг өндөр байгаа Дархан, Улаанбаатар хотруу тээвэрлэн ирж худалдан борлуулж байгаа явдал нь манай улсад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн бодлого чиглэл, авч хэрэгжүүлж байгаа ажлыг үр нөлөө төдийлөн үр дүнд хүрэхгүй байгааг харуулж байна.

Ойгоос хууль бусаар мод тээвэрлэж байгаа гэмт үйлдлийг цаг хугацааний давтамжийг авч үзвэл орон нутагт ойгоос мод бэлтгэн сум руу оруулахад улирал харгалзахгүйгээр 21-04 цаг, харин орон нутгаас төв суурин газар буюу Улаанбаатар хот руу тээвэрлэхэд мөн улирал харгалзахгүй 00 цагаас 06 цаг буюу шөнийн цагаар байдаг бөгөөд

намар, хаврын улиралд газар тариалагийн цаг хугацаатай давхцдаг байдлаас болж мод тээвэрлэх үйл ажиллагаа ерөнхийдөө зогсдог байна гэсэн судалгаа гарч байна.

Ойгоос хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн үйлдлийн арга хэлбэр, онцлогийн судлахад гэмт үйлдлээ хялбарчлах үүднээс цахилгаан хөрөө ашиглах, 2-3 хоногийн өмнө модоо бэлтгэж шөнийн цагаар автомашинаар зөөвөрлөх, ой цэвэрлэх нэрийдлээр хууль бусаар мод бэлтгэх, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү мод бэлтгэх, түлшний эрхийн бичгээр хэрэглээний мод бэлтгэх зэрэг аргуудаар үйлдэгдэж байна.

Монгол улсын үндсэн хуульд зааснаар “Газрын хэвлий түүний доорх эд баялаг, ан амьтан” ... зэрэг нь төрийн өмч байна гэсэн эрх зүйн хамгаалалт нь бодитой бус зарим тохиолдолд тунхаглалын гэмээр байдалтай хэрэгждэг нь байгаль орчинд хохирол учирсан, нөхөн сэргээгдэхгүй нөхцөл үүссэн үед улс буюу төрийг хохироодог гэсэн нэртэй боловч цаад утгаараа ард иргэдийг хохироож, амьдрах орчин нөхцөлд нь үл үзэгдэх байдлаар гэм хор, хохирол учруулсаар байна.

Хэрэв хууль бус ан агнуур, газрын хэвлий ашиглах хэргийг хувь хүн, иргэний өмчлөх эрхэд халдсан гэмт хэрэгтэй жишиж харьцуулж үзвэл тухайн хохирсон иргэн тухайн хэргийн эзэн холбогдогч тогтоогдсон тохиолдолд хохиролоо бүрэн нөхөн төлүүлж авдаг бол төрийн хамгаалалтанд байдаг ан амьтан, ой мод, ашигт малтмалын тухайд хүссэн хэн боловч байгаль экологид ямар ч байдлаар хор хохирол учруулж болдог, түүний араас хөөцөлдөх, эрэл хайгуул хийх асуудал нь харьцангуй эзэнгүйдсэн шинжтэй байдаг нь байгаль хамгаалалттай холбоотой хууль тогтоомжийг улам бүр боловсронгуй болгох, батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцсан байгууллага, албан тушаалтнууд үүргээ бүрэн биелүүлэх итгэл үнэмшил, чадвартай байх, тэдний үүргээ биелүүлэх баталгаа, (цалин хөлс, урамшуулал, шаардлагатай техник хэрэгсэл, бензин шатахуун зэрэг) ажиллах нөхцөлийг төр засгаас бүрдүүлэх асуудал дутагдалтай байгааг харуулж байна.

Эрүүгийн хуулинд “гэдэн жилийн хорих ял шийтгэнэ, торгоно, баривчлана” гэсэн санкцууд байхаас биш гэм хорыг арилгуулах, нөхөн сэргээлгэх” гэсэн албадлагын шинжтэй заалт байхгүй байгааг эргэн харж хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй юм.

Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичигт дурдагдсан зорилтыг хэрэгжүүлж иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүргээ хэрэгжүүлэхэд экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд цагдаагийн алба хаагч, байгаль орчны улсын байцаагч нарын хууль эрх зүйн мэдлэг, ажлын чадвар, туршлага өндөр түвшинд байх шаардлагатай болоод байна

5. Цаашид анхаарч, авч хэрэгжүүлэх зарим асуудлууд:

Төр засгийн хэмжээнд: Ойд байгаа унанги, хаягдал модыг ашиглах явдлыг төрөөс дэмжих бодлогыг баримтлах.

Хуулийг хэрэгжүүлэхэд хууль хяналтын болон байгаль орчны алба, бусад мэргэжлийн байгууллагууд нэг мөр ойлголттой болох, ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээ мэдээллийг түргэн шуурхай солилцох мэдээллийн бааз суурьтай болох.

Цагдаагийн байгууллагаас анхаарах зарим асуудал: Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр ажиллах алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах, бусад байгууллагуудтай хамтран ажиллах нөхцлийг хангах, шаардлагатай тусгай тоног төхөөрөмжөөр хангах;

Байгаль экологид учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр төлж барагдуулахаас гадна ялын төрлийг албадан ажил (тухайлбал: тайрсан модыг тариулах, нөхөн сэргээлт хийлгүүлэх гэх мэт) хийлгэх замаар учруулсан хохирлыг биеийн хөдөлмөр хийлгэж барагдуулдаг байх;

ЦЕГ-ын тэргүүн дэд даргын 2009 оны 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр хууль бусаар мод бэлтгэн, тээвэрлэдэг газруудад УМБГ, БОАЖЯам, Ойн газар болон дүүргийн холбогдох

байгууллагатай хамтран эргүүл шалгалтыг тогтмол явуулан хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах;

Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн, мэдээлсэн иргэнд мөнгөн урамшуулал олгох тухай Сангийн сайд, Байгаль орчны сайдын тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх; (далд үйлдэгдээд байгаа хэргийг илрүүлэхэд ач холбогдолтой)

Мод бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид тавих хяналтыг чангатгах;

Байгаль хамгаалах эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтнуудын ажлын уялдаа холбоо, хамтарсан хяналт шалгалтыг сайжруулах;

Замын цагдаа, Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газрын алба хаагчдад байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг хэрхэн шалгаж, харъяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлүүлэх талаар сургалт зохион байгуулах,

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар бичсэн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдлийн мөрөөр зохиож байгаа ажлын биелэлтийг газар дээр нь шалгах ажлыг бодитой болгох;

Төв, орон нутагт салбар зөвлөл байгуулан гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөлт, ойн санд учирсан нөхөн төлбөр, хураагдаж байгаа мод, модон материал зэрэг орлогыг тодорхой санд төвлөрүүлэн байгаль хамгаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зарцуулах санхүүгийн эх үүсвэртэй болох;

Хулгайгаар мод тээвэрлэдэг зам, маршрутыг тогтоож эргүүл шалгалтыг оновчтой зохион байгуулах, мод, модон материалын захуудын үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалтыг тогтмол явуулж түүний эх сурвалжийг тогтооход үйл ажиллагаагаа чиглүүлэх;

Төв, орон нутгийн төр захиргааны зүгээс: Цагдаагийн байгууллагын ажилтнууд нутгийн захиргааны болон байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллага, нутгийн иргэдтэй хамтран ажиллаж хулгайн замаар мод бэлтгэсэн, тээвэрлэсэн, борлуулсан үйл ажиллагааг илрүүлэхэд тэдний дэмжлэгийг авч ажиллахад түлхүү анхаарах;

Төв орон нутгийн салбар зөвлөл байгуулан гэмт хэргийн улмаас хохирсон, нөхөн төлөлт, ойн санд учирсан нөхөн төлбөр, хураагдаж байгаа мод, модон материал зэрэг орлогыг тодорхой санд төвөөрүүлэн байгаль хамгаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зарцуулах санхүүгийн эх үүсвэртэй болох;

Төв орон нутгийн байгаль хамгаалагч нарын ажлын хариуцлагыг өндөржүүлж, босоо тогтолцоотой болгох;

Уул уурхайн чиглэлээр ашигласан нөхөн сэргээлтээ хийгээгүй, улсад төлөх татвараа төлөөгүй уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компанид тухайн газрыг ашиглаж дууссаны дараа дахин олборлолт, хайгуул хийх зөвшөөрөл өгөхгүй хориг тавьдаг байх буюу үйл ажиллагааг нь зогсоох;

Холбогдох ажилтан, алба хаагчдыг байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд хамруулж чадавхийг дээшлүүлэх;

Орон нутаг, сумдад байгаль хамгаалах гэмт хэрэгтэй холбоотой хэргийг хүлээн авч шалгах чиглэлээр дагнан мэргэшүүлсэн алба буюу төлөөлөгчийн орон тоотой болгох;

Нөгөөтэйгүүр түлшний мод бэлтгэх үйл явцыг зохион байгуулалттай хийхгүйгээс болж орон нутгийн иргэд зайлшгүй түлшний мод бэлтгэх шалтгаанаар хууль зөрчих явдал тасрахгүй байгаад дүгнэлт хийж энэ чиглэлээр аймаг орон нутгийн хэмжээнд бодлого боловсруулж ажиллах;

Мод модон бүтээгдэхүүн боловсруулдаг үйлдвэр, мод зүсвэрийн хөрөө рам зэргийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих системийг сайжруулах;

Мод бэлтгэх эрхийн бичиг олголт, түүнийг ашиглалтанд тавих хяналтыг боловсронгуй болгох; (эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ зэргийг олон дахин ашиглах, хугацаа хэтрүүлэх боломжгүй болгоход голлон анхаарах)

Хууль бус ан агнуур, амьтан ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бусад байгалийн баялгийг хил давуулан худалдаалах зэрэг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр талууд хамтран ажиллаж, тодорхой цаг хугацаанд тухайн бүс нутгийн хэмжээнд нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулах, үйлдэгдсэн хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг холбогдох талуудад болон олон нийтэд мэдээлэх;

Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Байгаль орчны хууль тогтоомж, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилтод цуврал нэвтрүүлгийг холбогдох яам, агентлаг, төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран хийж иргэд олон нийтэд сурталчлах;

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийдвэрлэх үйл ажиллагаа болон амьтан ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, бусад байгалийн баялгийг хил давуулан худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүнг нэмэгдүүлэх, хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах;

Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр бодитой ажил, сургалтыг зохион байгуулах;

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах, үүнтэй холбоотойгоор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нь зөвхөн цагдаагийн байгууллагын үүрэг гэх сэтгэлгээнээс салах;

Хууль хяналтын байгууллагууд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын нягт уялдаа холбоотой ажиллах;

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсээс төв, орон нутгийн цагдаагийн алба хаагчдад энэ төрлийн хэргийг илрүүлэх, шалгах аргачлал бэлтгэж хүргүүлэх, зайны сургалт явуулах замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлийг эрчимжүүлж;

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга сурталчилгааны ажлыг тогтмол явуулж, уг төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах, өгсөн мэдээллийг урамшуулан дэмжих, байгаль хамгаалах гэмт хэрэгтэй тэмцдэг эрх бүхий албан тушаалтнуудад (ой хамгаалагч, цагдаа, хяналтын байцаагч г.м) сургалтыг тогтмол явуулж сүүлийн үеийн мэдээ мэдээллийг хүргэх;

Нутгийн иргэдийг байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгийг илрүүлэх ажилд татан оролцуулах, тэдгээрийн хүч тусалцааг авах, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй иргэдийн судалгааг гаргах, мэдээлэл цуглуулах;

Хууль бус ан агнуурын сүлжээг илрүүлэх зорилгоор хил зэргэлдээ аймаг болон хилийн цэргийн анги байгууллагатай хамтран ажиллах, иргэд олон нийтийн дэмжлэгийг авч, урамшуулж ажиллах;

§5.11. “Хар тамхины гэмт явдлын шалтгаан нөхцөл” судалгааны ажлын тайлан

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл судалгааны төв, хуучнаар Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэн хамтран аймаг, нийслэл, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн судалгааны багаас ирүүлсэн тайлан, гэмт хэргийн статистикийн мэдээлэл, холбогдох ном, эмхтгэл, судалгааны дүнд түшиглэн энэхүү судалгааны ажлын тайланг бэлтгэв.

1. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын (цаашид “хар тамхи” гэх) тархалт, хэрэглээ: Дэлхий нийтэд цагаан тахал гэж нэрлэгдэж байгаа энэхүү гэмт явдал улам бүр хүрээгээ тэлж байна. Тухайлбал, НҮБ-ын судалгаагаар хар тамхины хууль бус үйлдвэрлэл

сүүлийн 15 жилд 3 дахин нэмэгдэж, 190 сая хүн хар тамхи хэрэглэж байна гэжээ. Өнөөдөр хар тамхи хэрэглэгч улс орны тоо улам өссөөр байна. Хар тамхи хэрэглэхтэй холбоотой тоон үзүүлэлт бага хэдий ч нуугдмал хэлбэрт шилжиж, нийгэм дэх тархалт нь нэмэгдэж байна.

УИХ-ын 2010 оны 48 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.4-р бүлэгт “Иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах” төрийн бодлого тусгагдсан нь хар тамхитай холбоотой гэмт хэргийн тархалт, нийгмийн аюул улам өсч, улс орны үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрсэн гэж үзэж болох юм. Тийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Хар тамхи, мансууруулах бодисын аюул, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга зам” сэдэвт нээлттэй уулзалтын үеэр “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд энэ чиглэлээр мэдээлэл ирж байна. Өнөөдөр хар тамхийг хэрэглэж буй хүмүүсийн тоо 16000-д хүрсэн байна. Олон улсын дүгнэлтээр нэг хэрэглэгчийн ард дөрвөн далд хэрэглэгчээр үржүүлэхээр 64000 гэсэн тоо харагдаж байна. Энэ бол нэг аймгийн хүн амтай тэнцэхүйц тоо гарч байна. Ийм тоо сонсоод бид цочирдохгүй, түгшүүр төрөхгүй байхын аргагүй байна” гэж мэдэгдсэн.

Монгол Улс хар тамхины гол дамжуулагч бааз, тээвэрлэгч боллоо, хар тамхины мафи хүртэл байгуулагдаж байна гэдэг түгшүүрт мэдээ нийгэмд байгаа билээ. Сүүлийн жилүүдэд манай улсын иргэд хар тамхи хил дамнуулан зөөвөрлөх, хадгалах, бусдад дамжуулах гэмт хэрэгт холбогдох явдал ихсэж байгаа төдийгүй дотооддоо ч хэрэглэх явдал бий болсон нь сэтгэл эмзэглүүлж байна.

Хар тамхи хууль бусаар олж авах, хэрэглэх, боловсруулах, зарж борлуулах, хил дамнуулан тээвэрлэх явдал өсч, түүнд гадаадын иргэд холбогдох нь нэмэгдэж байгаа нь улс үндэстний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад бодит аюул учруулж болзошгүй байна.

Урлаг соёлын хүрээнийхэн, оюутан залуус, насанд хүрээгүй хүүхэд, хар тамхи хэрэглэх, ашиг хонжоо хайсан зарим этгээдүүд эдгээр бодисыг зохион байгуулалттайгаар олж авах, хэрэглүүлэх, энэ зорилгоор орон байр бэлтгэж ашиглуулах явдал даамжирсаар байгаа нь нууц биш боллоо.

Манай улсад хар тамхитай холбоотой гэмт хэрэг сүүлийн жилүүдийн эрүүгийн болон шүүхийн тоо бүртгэлээс харахад байнга өсч, энэ гэмт хэргийг биечлэн үйлдэх, насанд хүрээгүй хүүхэд энэ хэрэгт татагдах, бүлэглэн үйлдэх явдал улам ихсэж байгаа учраас төрөөс энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх тэмцлийг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа билээ.

НҮБ-аас батлаж гаргасан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын жагсаалтанд мансууруулах зүйлийн **118**, сэтгэцэд нөлөөлөх **115** төрлийн бодис багтсан байдаг бол Монгол Улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх **38** төрлийн бодисын жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2003 оны 306 дугаар тушаалаар батлан гаргасан байна. “Хар тамхи, мансууруулах бодис” гэдэгт Мансууруулах эмийн тухай НҮБ-ийн 1961 оны нэгдсэн конвенц, түүний 1, 2 дугаар жагсаалтад заасан эмийн найрлагаас агуулсан, байгалийн болон нийлэгжүүлж гарган авсан бөгөөд онцгой төрлийн мансууруулах үйлчилгээ үзүүлж, хүч тамир барагдуулдаг, удаан хэрэглэвэл сэтгэцийн өвчнөөр өвчлүүлдэг бодисуудыг хамааруулан ойлгодог байна.

Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэнгийн мэдээллээр манай улсад мансууруулагч, донтуулагч **8** төрлийн ургамал **13** аймгийн нутаг дэвсгэрт ургадаг байна. Монгол орны мансууруулагч ургамлын тархацын судалгаанаас үзэхэд:

- Зэрлэг олсны ургамал нь Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Завхан, Архангай, Булган, Төв зэрэг аймгийн 18 сумын нутгаар тархан ургадаг ба сүүлийн жилүүдэд манай орны төв хэсэг рүү өргөн нэвтэрч байна.
- Таримал олс нь Ховд, Увс, Дорнод аймгийн нутгаар ургадаг;

- Хорон тууз гэдэг хар тамхины төрлийн ургамал нь манай орны Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Хэнтий, Төв, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган аймгийн нутгаар тархан ургадаг;
- Их шүүдэргэнэ, Сибир хотой гэдэг ургамал Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Төв, Хэнтий, Дорнод аймгийн нутгаар ургадаг болох нь судалгаагаар тогтоогджээ.

Хар тамхины хэрэглээний асуудал хүмүүсийн амьдрах хэв маяг, эрүүл мэндэд нөлөөлөөд зогсохгүй, улс орны нийгэм, эдийн засгийг хямралд оруулдаг талтай. Урьд өмнө нь боловсруулаагүй байгалаараа хар тамхи оруулж ирдэг байсан бол сүүлийн жилүүдэд лабораторийн аргаар боловсруулсан, өндөр үйчлэл бүхий хар тамхи орж ирэх болжээ.

Өсвөр үеийнхний дундах мансууруулах бодисын хэрэглээний талаар судлахад манай улсын хүүхэд залуучуудын дунд хар тамхи, мансууруулах бодисыг үнэрлэх, татах, тариагаар хэрэглэх, уурыг нь сорж мансуурах хэлбэрээр мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэрэглэж байгаа нь шалгалтын явцад тогтоогдож байна. Хар тамхийг зөвхөн насанд хүрэгчид хэрэглэхээс гадна өсвөр үеийнхэн их хэрэглэж байгааг тэдний дунд явуулсан санал асуулга, судалгааны дүнгээс харж болох юм.


Өсвөр үеийнхний ойр орчинд мансууруулах бодисын хэрэглээ байгаа эсэхийг тэдний нас, хүйс, амьдарч буй орчин, анги, бүс нутаг зэрэг үзүүлэлтээр харьцуулан үзэхэд мансууруулах төрлийн бодис хэрэглэдэг хүүхдүүдийн 13.6 хувь нь эрэгтэй, 10.6 хувь нь эмэгтэй, 13.5 хувь нь Улаанбаатар хотод, 14.6 хувь нь, Баруун бүсэд, 13.6 хувь нь Хангайн бүсийн аймгуудад хэрэглэж үзсэн гэсэн дүн гарсан байгаа нь төвийн болон зүүн бүсээс 5-6 хувиар өндөр буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Мансууруулах бодисын хэрэглээг төрлөөр нь авч үзэхэд мансууруулах бодис хэрэглэдэг гэж хариулт өгсөн нийт хүүхдүүдийн 25.4 хувь нь цавуу, 18 хувь нь хорт хий, 17 хувь нь тайвшруулагч эм, 4.1 хувь нь кокаин, кофеин, метадон, 4.8 хувь нь амфетамин, героин, 5.4 хувь нь каннабис, 1.4 хувь нь опиум, 10.9 хувь нь бусад төрлийн бодисыг (*барааны саван, бензин, будаг, угаалгын нунтаг, гутлын тос, газ, өвс, ургамал, цахирмаа цэцэг, намуу цэцэг, үнэртэй ус гэх мэт*) хэрэглэдэг гэж хариулжээ. Тэд хар тамхи, мансууруулах бодис олж авдаг эх сурвалжаа 17.2 хувь нь захаас, 14.6 хувь нь тусгай газар, 13.4 хувь нь баар цэнгээний газар, 10.9 хувь нь найз нөхдөөсөө авч хэрэглэдэг гэсэн судалгаа байна¹. Монгол улсад хэрэглэгдэж байгаа мансууруулах бодисын төрлүүдээс цавуу, хорт хий, тайвшруулагч эм бодис ихэнхи хувийг эзэлж байна.

Өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд манай улсын баян чинээлэг хэсэг нь хэрэглэгч, дундаж орлогтой хэсэг нь зуучлагч, ядуу, орлого багатай хэсэг нь тээвэрлэгч болсон байна гэж дүгнэж болох юм.

2. Хар тамхины гэмт явдлын төлөв байдал: Манай улсын нийгэм, эдийн засгийн байдал, хөгжил, дэд бүтэц, хяналт шалтгалт, эрх зүйн орчин, иргэдийн эрх зүйн мэдлэг, төлөвшил зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөс энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Монгол Улсад сүүлийн 4 жилийн хугацаанд хар тамхитай холбоотой **60** холбогдогчтой **47** гэмт хэрэг бүртгэгдэж², цаашид улам бүр нэмэгдэх хандлага байна. Тухайлбал: Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг 2008 онд 8 холбогдогчтой 7 хэрэг, 2009 онд 9 холбогдогчтой 8 хэрэг, 2010 онд 34 холбогдогчтой 20 хэрэг, 2011 онд 9



¹ ХЗДХЯ, АМЭА, ДЗМОУ-ын байгууллагуудын 2011 онд хамтран хийсэн “Өсвөр үеийнхний дундах мансууруулах бодисын хэрэглээ, хор хөнөөлийн талаарх мэдлэгийн түвшин тогтоох” сэдэвт судалгааны тайлан, 24-р хуудас

² ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвийн статистикийн мэдээллээр

холбогдогчтой 12 хэрэг тус тус бүртгэгдсэн байна. 2012 оны эхний 5 сарын байдлаар 37 холбогдогчтой 41 гэмт хэрэг бүртгэгджээ. 2008-2011 онуудад улсын хэмжээнд 1,7 кг героин, 12.9 кг каннабис, 2.5 кг героин, 6.2 кг каннабис, 30 грамм метафитамины төрлийн мөс, 15978 ширхэг мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эм илэрч хураагдсан байх бөгөөд жилд дунджаар 12 гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн гаралт өсөх хандлагатай байна.

Дээрхи гэмт хэргийн 87.1 хувийг эрэгтэй, 43.5 хувийн 18-24 насны, 30.7 хувийг 25-29 насны хүмүүс үйлдсэн байна.

Орон нутгийн зарим аймгийн нөхцөл байдлаас үзэхэд:

Дорнод аймаг: Тус аймгийн зүүн хэсэг болох Халх гол, Нөмрөгийн сав газарт мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх ургамлын зарим нэг төрлийн ургамлын тархалттай, хойд талаараа ОХУ-тай хоёр талын байнгын ажиллагаатай авто зам, төмөр замын боомтоор хилэлдэг, зүүн болон зүүн урд талаараа БНХАУ-тай улирлын чанартай авто замын хилийн боомт, мөн түүнчлэн БНХАУ-ын Өвөр Монголын Хөлөн-буйр аймгийн Хайлаар хоттой олон улсын чанартай агаарын тээврийн боомтоор холбогдож, нийт 6 хилийн гарц үйл ажиллагаа явуулж байгаа нь дээрх төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх, дамжин өнгөрүүлэх гүүр байж болох магадлал өндөр байна. Тус аймгийн хэмжээнд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг бүртгэгдээгүй боловч аймгийн эрүүл мэндийн газраас гаргасан судалгаагаар өвчний улмаас, авто болон гэнэтийн ослын улмаас сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэдэг 71 өвчтөн байдаг бөгөөд эдгээр хүмүүсийн эм бэлдмэлийн хэрэглээнд мэргэжлийн байгууллага хяналт тавин ажилладаг байна. Аймгийн хувьд урд, хойд хөрштэй холбогддог авто замын болон агаарын тээврийн боомт, хилийн гарцууд дээр тавих хяналт шалгалтыг сайжруулах шаардлага байна.

Сүхбаатар аймаг: Энэ төрлийн гэмт хэрэг сүүлийн 3 жилийн байдлаар тус аймагт хэдийгээр бүртгэгдэж шалгагдаж байгаагүй боловч тус аймагт байнгын үйл ажиллагаа явуулдаг “Бичигт”-ийн хилийн боомт байдаг, мөн тус аймагт уул уурхай ихээр хөгжиж гадаадын иргэд олон тоогоор орж ирж ажиллах болсон зэрэг нөхцөл байдлуудаас болж гэмт хэрэг үйлдэгдэн гарч болзошгүй байна.

Төв аймаг: Аймгийн хэмжээнд Сүмбэр, Борнуур, Жаргалант, Баянхангай зэрэг сумын нутагт сэтгэцэд нөлөөлөх бодисын төрлийн ургамал бага хэмжээгээр ургадаг болохыг тогтоож устгал хийсэн байна. Үүнээс үзэхэд энэ төрлийн ургамалыг иргэд мэддэг болсонтой холбоотойгоор гэмт хэрэг үйлдэгдэх магадлалтай болж байна.

Сэлэнгэ аймаг: Сэлэнгэ аймгийн нутгийн хойд талаараа ОХУ-тай хиллэж, төмөр зам, авто замын дэд бүтэц хөгжсөн, олон үндэстэн, ястан, гадаадын иргэд оршин суудаг, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн төрлийн ургамлын тархац, байгалийн баялаг, эрдэс бодис ашиглах, олборлох уул уурхай ихтэй бүс нутаг юм. Дээрх нөхцөл байдлуудаас үүдэн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гарахад ихээхэн нөлөөлж байгаа ба ОХУ-аас БНХАУ-руу хар тамхи зөөвөрлөх, дамжин өнгөрүүлэх таранзит улс болох өндөр магадлалтай байна. Сүүлийн жилүүдэд хууль бусаар хориглосон эм, тариа хил нэвтрүүлэх, тээвэрлэх, мөнгөн ус ашиглах, зарж борлуулах гэмт хэрэг зонхилон үйлдэгдэх хандлагатай байна. Сэлэнгэ аймгийн 19 сумын нутаг дэвсгэрт хар тамхины гаралтай ургамал болох каннабис нилээн их хэмжээтэй ургадаг тул ургамлын тархацтай, талбайг шатаан устгал хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авчээ. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, илрүүлэх, урьдчилан сэргийлэх ОХУ-ын хуулийн хяналтын байгууллага, Хиагт хотын Хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Хил хамгаалах, гааль, Тагнуул зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага байна.

Ховд аймаг: Ховд аймгийн Булган сум нь БНХАУ-тай хиллэдэг 2 боомттой байгаа нь уг боомтоор дамжин, энэ төрлийн бодис тээвэрлэгдэн орж ирэхээс гадна, дамжин өнгөрүүлэгч цэг болж болзошгүй байна. Урд нь мансууруулах бодисыг гашиш, олсны төрлийн ургамлаар нь хэрэглэдэг байсан бол сүүлийн үед лабораторийн аргаар боловсруулсан мансууруулах бодис авчран хэрэглэж байгаа зэрэг нөхцөл байдлаас дүгнэхэд

мансууруулах бодисын нэр төрөл олширч, чанарын хувьд дээд түвшиний мансууруулах төрлийн бодис хэрэглэдэг, хэрэглэгчийн давхарга бий болж, донтогчдын нас залуужиж байна. Булган сумын нутаг дэвсгэрт энэ төрлийн ургамал ургадаг ба тус сумын Казак иргэд уг ургамлыг ахуйн хэрэгцээний зориулалтаар түүж хамрын тамхи, монгол архи зэрэгтэй хольж найруулан уруул шүдний заагт хийж хэрэглэж буй нөхцөл байдал эртнээс тогтсон бөгөөд энэ нөхцөл байдал нь цаашид гүнзгийрч гэмт хэргийн шинжтэй болж, хүүхэд залуучууд хэрэглэх нөхцөл байдал үүсч болзошгүй тул урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой төрлийн ажлыг сум, орон нутаг, ард иргэдийн зан заншил, ёс суртахуунд тохируулж шат дараалсан хэлбэрээр явуулах нь зүйтэй.

Дорноговь аймаг: Энэ төрлийн хэрэг тус аймагт 2010 онд 2, 2011 онд 4 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 50 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Дорноговь аймгийн нутаг дэвсгэрийн хувьд Замын-үүд болон Ханги мандлын боомт ажиллаж байгаатай холбогдон мансууруулах бодистой холбоотой гэмт хэргүүд үйлдэгдэх магадлал өндөр байгаад анхаарах нь зүйтэй.

Хэнтий аймаг: Аймгийн хэмжээнд Дадал сумын Чулуутын гарам гэх газар мансууруулах төрөлд ордог каннабис, хорон тууз, их шүүдэргэнэ зэрэг ургамалууд 80 га орчим газрыг хамран ургадаг байна. Бусад аймгийн тархацтай харьцуулахад бага хэмжээ мэт харагдаж байгаа боловч каннабис нь хор хөнөөлийн хувьд бусад төрлийн мансууруулах бодисоос илүүд тооцогддог тул эм, эмийн бүтээгдэхүүнд оруулахыг хориглосон байдаг. Аж ахуй нэгж, байгууллага, эмийн сангууд нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг ямар нэгэн хяналт зөвшөөрөлгүй ашигладаг, нутгийн ард иргэд энэ хэргийн талаар зохих мэдлэггүй, урьдчилан сэргийлэх талаар нэгдсэн ойлголтгүй байдаг зэрэгт дүгнэлт хийх нь зүйтэй.

Өвөрхангай аймаг: Аймгийн Цагдаагийн газар нь Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газартай хамтран аймгийн хэмжээнд мансууруулах хордуулах үйлчилгээтэй ургамал ургадаг газруудын судалгааг гарган үзэхэд аймгийн хэмжээнд нийт 77 овог, 340 төрөл, 938 зүйлийн ургамал ургадаг бөгөөд 21 зүйлийн нэн ховор, 25 зүйлийн ховор, 355 зүйлийн эмийн ба ашигтай зүйлийн, 655 зүйлийн тэжээлийн ач холбогдолтой ургамал ургаж байна. Мансууруулах, хордуулах үйлчилгээ үзүүлдэг байж болзошгүй, иргэдийн яриагаар эмийн журмаар түүж хэрэглэдэг, өвчин намдаах, тайвшруулах үйлчилгээ үзүүлдэг гэх Харлантанз, Чөдөр өвс, Зээргэнэ, Хоронхор-тууз, Рашаан зэрэг ургамалууд нь Баруунбаян-Улаан, Богд сумын Богд уул, Хархорин, Уянга сумдын нутгаар ургаж байна.

3. Хар тамхины гэмт явдалтай тэмцэх эрх зүйн зохицуулалт: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 23-р зүйлд согтуурал буюу мансуурлын байдалд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй. Ийм этгээдэд шүүх ял оногдуулахын зэрэгцээ энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх талаар заасан. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, тэдэнд харгалзан дэмжигч тогтоох журмыг Эрүүгийн хуулийн 68 дугаар зүйлд тогтоосон байдаг.

Эрүүгийн хуульд, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах (192-р зүйл), Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих (193-р зүйл), Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар авах (194-р зүйл), Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах (195-р зүйл), Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах (196-р зүйл) зэрэг хар тамхи, мансууруулах бодис, эмийн бус эргэлттэй холбоотой үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Эрүүгийн хуульд³:

192 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах

³ www.Legalingo.mn-ээс 2012.06.23-ны өдөр татаж авав.

192.1. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

192.2. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

192.3. Энэ хуулийн 192.2-г заасан хэргийг:

192.3.1. онц их хэмжээгээр;

192.3.2. насанд хүрээгүй хүн оролцуулж;

192.3.3. онц аюултай гэмт хэрэгтэн;

192.3.4. давтан;

192.3.5. урьдчилан үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

193 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих

193.1. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, тэдгээрийг үйлдвэрлэхэд хэрэглэгддэг бодис, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хадгалах, бүртгэх, худалдах, хуваарилах, тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх, устгах журмыг зөрчсөн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сарын хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. (Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон)

194 дүгээр зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар авах

194.1. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, завших зэргээр хууль бусаар авсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

194.2. Энэ хэргийг:

194.2.1. их буюу онц их хэмжээгээр;

194.2.2. мэргэжлийн болон албан тушаалын байдлаа ашиглаж;

194.2.3. урьд нь энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд;

194.2.4. давтан;

194.2.5. бүлэглэж үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

195 дугаар зүйл. Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах

195.1. Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарьсан, ургуулсан, хурааж авсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

196 дугаар зүйл. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах

196.1. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх байр байгуулсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

196.2. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. (Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон)

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой Эрүүгийн хуулийн 192-196-р зүйлүүдэд заасан гэмт хэргүүдийн талаарх хэм хэмжээ учир дутагдалтай, оновчтой бус, энэ талаар УДШ-ийн албан ёсны тайлбаргүй явж ирсэн, энэ төрлийн гэмт

хэргийн шийдвэрлэлтэнд сөргөөр нөлөөлж, зарим хууль хэрэглэгч субъектүүд хуулийг буруу хэрэглэх, гэмт хэргийг буруу зүйлчлэх тохиолдол судалгаанаас ажиглагдаж байна.

Тухайлбал, ЭХ-ийн 192-р зүйлийн объектив талын бэлтгэсэн, олж авсан үйлдлийг нэг мөр ойлгоогүйгээс зарим хэрэг мөрдөн шалгах шатанд хэрэгсэхгүй болж, манай орны тодорхой газар нутагт байгалийн жамаар ургаж байгаа зэрлэг олс (каннабис)-ыг хэн нэгэн этгээд түүж аваад будаг шингэлэгч зэрэг ямар нэгэн химийн бодистой хольж мансууруулах бэлтгэл хангасан үйлдэл дээр зөвхөн бэлтгэсэн объектив үйлдэл нь эрүүгийн зүйлчлэлд багтаж байна.

Байгалийн жамаар ургаж байгаа каннабисыг түүж аваад, цайруулж, ургамлаас нь мансууруулах хүч ихтэй цэцэг, давирхайг нь салгаж аваад, дараа нь өөр төрлийн эм, химийн бодистой хольж үнэрлэх, тамхинд хольж утааг уушиглан сороход бэлтгэсэн үйлдлүүдийг бэлтгэх, үйлдвэрлэх гэж 2 объектив шинжээр нь салгаж эрүүгийн хуулинд хуульчлаагүй нь энэ төрлийн гэмт хэргийг байгалийн жамаар ургаж байгаа ургамлыг олж авсан гэдгээр зүйлчилж, гэмт этгээдэд ял завшуулах, улмаар гэмт хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаагаар шийдвэрлэхэд шууд ба шууд бусаар сөрөг нөлөө үзүүлж байна.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 13¹-р зүйлд, “Цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан согтуурах, мансуурах донтой ... биеийн байцаалт тодорхойгүй этгээд зөрчил гаргасан бол 72 цаг хүртэл хугацаагаар албадан саатуулж болох бөгөөд энэ хугацаанд дээр дурдсан этгээдийн талаар эмнэлгийн дүгнэлт гаргуулах, албадан эмчлүүлэх тухай материалыг бүрдүүлж холбогдох байгууллагад шилжүүлнэ” гэж хуульчилсан.

Байгалийн ургамлын тухай хуулийн 20-р зүйлд “Мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалтыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлана. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгож, тэдгээрийг тусгай бүртгэлд бүртгэнэ. Иргэн, түүнчлэн 20-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарихыг хориглоно”⁴ гэж заасан.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2-р зүйлд “Даатгуулагч ... согтууруулах ундаа мансууруулах бодис хэрэглэсний болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журмыг санаатай зөрчсөний улмаас осолд өртсөн, гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн биед гэмтэл учруулсан нь нотлогдсон тохиолдолд түүнд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй”, Эмийн тухай хуулийн 16¹-р зүйлд зааснаар, Монгол улсад хэрэглэгдэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт, худалдах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн угтвар бодисыг үйлдвэрлэх, худалдах, тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу олгож, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.

Согтуурах, мансуурах донтой ⁵ өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх үйл ажиллагааг 2000 оны хуулиар зохицуулж байна.

Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих, тэмцэх зорилгоор УИХ 2002 оны 11-р сарын 28-нд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” бие даасан хууль батлан гаргасан нь энэ төрлийн бодисын эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм. Энэ хуульд зааснаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хуваарилах, худалдах,

⁴ Байгалийн ургамлын тухай хууль. УБ.,1995

⁵ “Мансуурах дон” гэж мансууруулах төрлийн бодисоос хамааралтай сэтгэцийг өвчнийг хэлнэ. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль. УБ.,2002

хэрэглэх, тээвэрлэх, хадгалах, устгах, Монгол улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх талаар энэ хууль, бусад хууль тогтоосон үйл ажиллагааг хэлнэ” гэж тайлбарлажээ.

НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай 1961 оны Нэгдсэн конвенци”⁶, “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” 1971 оны конвенци⁷, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц”⁸, “Мансууруулах бодисын тухай” 1961 оны нэгдсэн конвенцид засвар, өөрчлөлт оруулах тухай 1972 оны протокол.

Энэ конвенцийн 1 дүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний хууль бус эргэлтийн тухай ойлголт⁹ тусгагдсан нь мансууруулах бодисын борлуулалтыг хууль ёсны ба хууль бус гэдгийг зааглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Конвенцийн 2 дугаар зүйлд, хяналтад хамаарах бодисыг тодорхойлохдоо “бүх төрлийн мансууруулах бодис нь хяналт дор байна” гэжээ. 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “оролцогч тал нь тухайн орны хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралыг хамгаалах илүү тохиромжтой арга гэж үзвэл эмнэлгийн болон эрдэм шинжилгээ судалгааны ажилд шаардлагатайгаас бусад тохиолдолд түүнийг худалдаалахыг хориглох”¹⁰ тухай тусгасан болно.

Уг конвенциор мансууруулах бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлан, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн аливаа хэлбэрт хориг тавьсан юм. Энэ нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах явдалд тавих эрүүгийн эрх зүйн хоригийн үндэс болсон юм.

“Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” НҮБ-ын 1988 оны конвенцод Монгол улс 2001 онд нэгдэн орсон. Уг конвенцийн агуулга нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэхэд байнга хэрэглэгддэг угтвар бодис, түүхий эд, урвалуудын жагсаалтыг гаргаж тэдгээрийг хяналтанд авах асуудлыг олон улсын эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршжээ. Түүнчлэн энэ конвенц нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, түүнээс олох ашиг орлогыг олон улсын хяналтанд авах, хууль бус эргэлттэй тэмцэх, хууль бус эргэлтээс олсон ашиг орлого, эд хөрөнгийг хураан авах, энэ төрлийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг бүрдүүлэхэд талууд эрх бүхий байгууллагуудаараа дамжуулан харилцан туслалцаа үзүүлэх зэрэг боломжийг бүрдүүлж өгчээ.

4. Шалтгаан нөхцөл: Хар тамхи, мансууралтай холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын хүйс, нас, боловсрол, мэргэжил, эрхэлсэн ажил, сургууль, нийгэм, гэр бүл, хамт олны хүрээнд эзлэх байр суурь, нэр хүнд, сэтгэл зүйн байдал зэрэг нийгэм хүн ам зүйн шинж болон гэмт хэрэг үйлдэгдсэн газар, орон байр, цаг хугацаа, арга, хэрэгсэл зэрэг криминологи шинжийг оновчтой тодорхойлох нь энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх тэмцлийг үр дүнтэй болгох урьдчилсан нөхцөл болох юм.

Монгол Улсын хэмжээнд ядуурал, ажилгүйдэл, архидалт, нийгэм, эдийн засгийн тогтвортой бус байдал, төрийн үйл ажиллагааны зарим доголдол, уялдаа холбоо шаардлагын хэмжээнд хүрээгүй, эрх зүйн зохицуулалт зэрэг нийтлэг хүчин зүйлс хар тамхины гэмт явдалд нөлөөлж байна.

Мөн гадаад улсын нөлөөлөл, иргэдийн мансууруулах бодисын хэрэглээ, зах зээл, худалдан авалт ойрхон, манай улсын ихэнхи аймгийн нутаг дэвсгэрт хар тамхи, мансууруулах бодисын гаралтай ургамалын тархац байдаг, иргэдэд энэ төрлийн гэмт хэрэг, түүний хор уршгийн талаарх ойлголт хангалтгүй, хил гаалийн хяналт шалгалт сул, түүнтэй

⁶ UN United Convention on narcotic drugs, 1961 – Монгол Улс 1990.12.06-нд нэгдэн орсон.

⁷ Энэ конвенцийг Монгол Улс 1999.04.22-нд соёрхон баталсан

⁸ Энэ конвенцид Монгол Улс 2001.01.25-нд нэгдэн орсон

⁹ Дурьдсан конвенци. 5 дахь тал

¹⁰ Мөн тэнд

тэмцэх байгууллагуудын чадавхи, эрх зүйн орчин төгс бус зэрэг нөхцөл байдал хар тамхины гэмт явдалд шууд нөлөөлж байна.

Аливаа гэмт хэргийг тэр дундаа Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх гэмт хэргүүдийг тархан газар авсан хойно нь ял оногдуулах тухай ярихын оронд тухайн гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэргийг гаргуулахгүй байх талаар урьдчилан сэргийлэх ажлыг цогц хэлбэрээр авч явуулах шаардлагатай.¹¹

Монгол улсад хар тамхины хууль бус наймаа, хилээр нэвтрүүлэх болон тариалах ба түүж, боловсруулах явдал сүүлийн жилүүдэд эрс өсөх хандлагатай байна. Хар тамхины наймаачид хэрэглэгчдийг бий болгох үе шат явагдаж байна гэж дүгнэж болохоор байна. Олон улсын туршлагаас харахад үүний дараа хэрэглэгчдийг хар тамхиар хангах буюу хууль бус эргэлт, байнгын зах зээлийг бий болгох аюул нүүрлэж болзошгүй, гэхдээ энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд дан ганц улс орны тухайд ойлгох нь өрөөсгөл юм.

Түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын хууль бус үйл ажиллагааг олж илрүүлэх болон нотлох мэргэшил болон эрх зүйн мэдлэг дутмаг, шинжилгээний байгууллагууд нь дүгнэлт хийх туршлага, чадвар хангалтгүй, мансууруулагч, донтуулагч ургамлын төрөл, зүйлийн тархцыг тогтоож хяналтанд авч чадаагүй байдал, хар тамхи хэрэглэгч, донтогчдыг эмчлэх, нийгэмшүүлэх зэрэг мэргэжлийн байгууллагуудын практик үйл ажиллагааны дутагдал, бэрхшээлээс шалтгаалж хар тамхины **хууль бус эргэлтийг хяналтаас алдах** магадлал байна.

Манай оронд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдох, өөрөөр хэлбэл хар тамхи, мансууруулах бодис, эм бэлдмэлийг олж авах, хулгайлах, тээвэрлэх, зөөх, илгээх, борлуулах үйлдэл хийж байгаагийн **үндсэн шалтгаан бол:**

- ✓ манайд бодитойгоор оршин буй ажилгүйдэл, ядуурал;
- ✓ хууль тогтоомжийн хэрэгжилтийн хангалтгүй байдал;
- ✓ нийгмийн үнэт зүйлсийн үнэлэмж өөрчлөгдсөн;
- ✓ оюун санааны эрх чөлөө хэтэрч ёс суртахууны доголдолд автагдсан;
- ✓ ажил хөдөлмөр эрхэлж биеэ зовоохгүйгээр амар хялбар аргаар амьдрах хүсэл сонирхол нь давамгайлсан;
- ✓ иргэдийн хууль тогтоомжийн мэдлэг, ухамсар, соёл дорой байдал;
- ✓ шударга бус байдал хавтгайрч аливаа бизнес, хувийн амьдралынхаа асуудлыг хууль бус арга замаар шийдвэрлэх сүлжээ, бүлэглэл бий болсонд;
- ✓ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар хууль сахиулах, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу, явуулж байгаа үйл ажиллагаа хангалтгүй байгаа байдал;
- ✓ хүн амын хэт төвлөрлөөс үүдэлтэй сөрөг хүчин зүйлүүд бий болсон;
- ✓ хорих газраас суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх, амьдралд хөлөө олоход туслах төр олон нийтийн тогтолцоо байхгүй байдал;
- ✓ төрийн байгууллагуудад бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоо дутмаг, боловсронгуй биш;
- ✓ нийгэм дэх нээлттэй байдлын үр дүн болох хүмүүсийн зан төлөв, ёс суртахууны доройтол,
- ✓ байгууллага, хамт олон, сургууль, гэр бүлийн орчны харш нөлөөлөл зэрэг сөрөг хүчин зүйлс юм.

Иймд тагнуул, цагдаагийн байгууллагын орон тоо, төсөвт багтааж, хар тамхи, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлэх зорилгоор бие даасан алба нэгжүүдийг шинээр зохион байгуулах шаардлага байна.

НҮБ-ын "Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой асуудал эрхлэх алба"- наас дэлхийн улс орнуудын шүүхийн байгууллагад ашиглагдах хар тамхи, мансууруулах төрлийн бодисын жишиг үнэлгээг тогтоосон байдаг. Үүнийг манай хөрш хоёр орны хувьд

¹¹ Sodggg.blogspot.com –сайт Р.Содномцэрэн 2007.12 сар

дэлгэрэнгүй гаргасан байдаг бөгөөд манай улсын хувьд тодорхой төрлийн бодисын жишиг үнэлгээг НҮБ-аас тогтоосон байгаа. Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодис нь өөрийн эргэлтээсээ хамаарч үнэ ханш нь хэлбэлзэж байдаг бөгөөд судлаачдын үзэж байгаагаар мансууруулах бодисын хууль бус эргэлтийг таслан зогсоох үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байгаа улс орон, газар нутагт үнэ ханш нь өсч байдаг байна.¹²

Манай улсын иргэд нь хар тамхины олон улсын үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлийн үйл ажиллагаанд татагдан орох, гишүүнээр элсэх, мансууруулах бодисыг хил давуулан тээвэрлэх гэмт хэрэгт холбогдон шалгагдах болсон. Өнөөдрийн байдлаар Монгол улсын 46 иргэн гадаадын улс орнуудаас мансууруулах бодисыг Монгол Улс руу болон Европ, Зүүн Өмнөд Азийн улсуудын хооронд хууль бусаар тээвэрлэх, олж авах, худалдах гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байна.

Манай улсад хар тамхи мансууруулах төрлийн бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдож байгаа хүмүүсийн үйлдсэн хэргээс авч үзвэл доорх гурван төрөлд хуваан авч үзэж болохоор байна.

- Манай улсын нутаг дэвсгэрт ургаж байгаа каннабисийн өвсний төрлийн ургамлыг хүүхэд залуучууд түүж хэрэглэх хандлага ихсэж, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогчийн тоо өсөж байна. Энэ бүлэг хүмүүст өсвөр насны хүүхдүүд амьд хөгжим тоглодог, сонирхдог залуучууд хамаарна.
- Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогч нар нь боломжийн амьдралтай хөрөнгө чинээтэй айлын хүүхдүүд, мөн гадаадад сурч ажиллаж байгаа хүмүүс байна.
- Амьдралын орлого багатай өрх толгойлсон эмэгтэйчүүд болон амар хялбар аргаар мөнгө олох гэсэн залуучууд эмэгтэйчүүд энэ төрлийн гэмт хэргийн зуучлагч, өөрөөр хэлбэл золиос болж Зүүн өмнөд Азийн орнуудад хар тамхийг биедээ залгиж тээвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Манай улсад хар тамхины аюул нүүрлэн түүнд донтох хүүхэд залуусын тоо өдөр бүр нэмэгдэж байна. Түүгээр зогсохгүй манай иргэд Зүүн өмнөд Ази, Африк, Европыг хэрсэн хар тамхины мафийн сүлжээнд холбогдсон нь батлагдаж, **хар тамхи өмнөд хөршөөс оруулж ирдэг**, мансууруулах бодис худалдаж авдаг залуус байна.

Хар тамхины хэрэгцээг багасгах арга нь урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, эмчлэн эрүүлжүүлэх аргуудыг багтаасан цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хар тамхины эрэлт хэрэгцээг бууруулахад чиглэдэг, харин хор хөнөөлийг бууруулах арга нь мансууруулах бодистой холбоотой үүдэн гардаг хор уршиг, түүнийг нөхцөлдүүлж буй өртөмтгий хүчин зүйлүүдийг бууруулахад чиглэдэг. Дээрхи аргууд хар тамхийг хэрэглэхийг зогсоож чадахгүй ч хэрэглэгчид болон олон нийтэд аль болох бага хэмжээний хор хөнөөл гаргах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэдэг юм.

Монгол улсын хэмжээнд өсвөр үе, залуучуудын дунд архи, тамхи мансууруулах сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл бодисын хэрэглээ нэмэгдэж байгаа нь дэлхий нийтээр даяарчлагдаж хэвлэл мэдээллийн чөлөөт байдал, интернетийн дэвшилтэт техник технологи нэвтэрч байгаа өнөө үед улс орны хөгжлийг даган аливаа эрсдэл бий болдгийг харуулж байгаа томоохон илрэл юм.

Хар тамхины нөхцөл байдлын үнэлгээг олон улсын аргачлалаар тодорхой хугацаанд байнга хийж байх шаардлагатай. Учир нь энэ ажил нь хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээг өсгөхгүй, зогсоох, бууруулах нөхцөл байдлыг тогтооход чухал ач холбогдолтой.

Хар тамхи, согтууруулах ундаанаас гадна манай хмүүсийн, ялангуяа есвер веийнхний дунд тархсан **чимээгвй тахал бол тамхидалт**. Тамхины хэрэглээгээр манай улс эхний 10 орны тоонд ордог нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаанаас харагддаг.

Судалгааны дүнд гарсан тооноос харахад хар тамхийг нэг удаа хэрэглэж үзсэн хүний тоо давамгайлж байгаа нь сонирхож, шохоорхож, туршин эхэлж байгаа хүмүүс нэлээд

¹² Shudarga.mn saim 2012.03.26

байгаа нь тэднийг тогтмол хэрэглэгч болж донтохоос нь өмнө сургалт сурталчилгаа хийх, эмнэлэгийн үйлчилгээнд хамруулах шаардлага урган гарч байна.

Хар тамхитай холбоотой нэг гэмт хэргийн ард 10 гэмт үйлдэл байдаг судалгаа нь хар тамхитай холбоотой үйлдэл ямар хүрээгээр тэлж буйг илэрхийлж байна. Цагдаагийн байгууллагын мэдээлснээр 2011 онд 3 бүлэг зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүдийг баривчилжээ. Нэг бүлэглэлийн ард хар тамхийг үйлдвэрлэдэг, худалддаг, тээвэрлэдэг хэд хэдэн бүлэглэлүүд байгаа. Энэ бол Монгол улсын хүн ам ихтэй цэгүүдийг хамарч буй аймшигтай үзэгдэл болж харагдаж байна¹³.

Мөн манай улсын Эрүүгийн хуульд хар тамхи хэрэглэсэн, түүнд донтсон хүнд хүлээлгэх хариуцлагын талаар тусгагдаагүй бөгөөд энэ нь хуулийн цоорхой болон ашиглагдаж байна.

Монгол орон хэдийгээр хар тамхины хэрэглэгч болон үйлдвэрлэгч орны тоонд ордоггүй боловч олон улсын чөлөөт худалдаа өргөжин тэлж буй өнөө үед дамжин өнгөрүүлэгч орон болох магадлал тун өндөр бөгөөд тархаж дэлгэрэхээс нь өмнө сэргийлэх, хилээр орохоос нь өмнө цаг алдалгүй илрүүлж, таслан зогсоох шаардлага бүхнээс илүүд тавигдаж байна.

Гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтарч ажиллах нөхцөл бололцоог улс төр, эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн хувьд цогц байдлаар шийдвэрлэх.

Манай орны төвийн болон баруун бүсийн аймгууд, тухайлбал, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Завхан, Ховд аймгуудад олсны (каннабисын) зэрлэг ургамал ургадаг нь судалгаагаар нэгэнт тогтоогдоод байхад хууль сахиулах болон мэргэжлийн хяналтын байгууллагаас эдгээр бүс нутгийг хяналтдаа авах, ийм ургамлыг зохион байгуулалттайгаар устгах ажиллагаа хийдэггүй, нэг үгээр хэлбэл, зөнд нь орхисон явдал энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан юм.

Хар тамхийг анх удаа хэрэглэж үзсэн 100 хүний зөвхөн 20 нь л хар тамхины тухай бодлоо орхиж чаддаг. Үлдсэн наян хүн нь хар тамхинд татагдан ордог байна. Гэтэл манайд хар тамхи хэрэглэгчдийн дийлэнх нь 12-18 насны өсвөр үеийнхэн байгаа нь хамгийн харамсалтай. Тэд хар тамхины хор хөнөөлийг мэдэхгүй гэхээсээ илүү бусдын нөлөөнд автаж хар тамхинд ордог байна. Мансуурагчдын 63 хувь нь ууж, 18 хувь нь татаж, долоон хувь нь үнэрлэж, 12 хувь нь тарьж хэрэглэдэг байна.¹⁴

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг нэвтрүүлэх хил боомтыг тогтоож, шинжилгээ судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт, тэдгээрийг ашиглах журам, байгууллагын жагсаалт, зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журмыг Засгийн газрын тогтоолоор батлан мөрдүүлж байгаа боловч тэдгээрийн хэрэгжилтэнд тавих хяналт суларсныг далимдуулан сүүлийн үед иргэд ямар ч хяналтгүйгээр охид бүсгүйчүүдийн турах, галбиржих гэсэн сонирхол дээр дөрөөлөн ОХУ, БНХАУ-аас хар тамхины найрлагатай эмийг оруулж ирэн, хар зах дээр гар дээрээс хямд үнээр борлуулж байгаа нь мансуурч донтогчдыг бий болгож байна. Эм борлуулах байгууллага, эмийн сангууд болон эм борлуулах ажиллагааг төрийн хяналтаас гаргасан улс орон аажимдаа хар тамхи, мансууруулах бодисын далайд живж сүүрдэгийг амьдрал харуулсаар байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийг төрөөс хянах, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх үйл ажиллагааны дутагдал, энэ сөрөг үзэгдэлтэй хийх тэмцлийг зохицуулж буй хууль тогтоомжийн хийдэл, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг зүйлчлэх ажиллагааны дутагдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мэргэшсэн байгууллагын бүтэц, алба хаагчгүй явж ирсэн

¹³ МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Хар тамхи, мансууруулах бодисын аюул, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга зам”- сэдэвт уулзалтанд хэлсэн үг 2012.03.01

¹⁴ “Unen.mn”-сайт сэтгүүлч Д.Мягмаржаргалын нийтлэл “Хар тамхины хэрэглээ хүрээгээ тэлжээ” 2012,07,17

бодит байдал, түүнчлэн хар тамхи, мансууруулах бодист хяналт тавих, тухайлбал, шинжлэн илрүүлэх байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийн хангалт муу, хүчин чадал нь өнөөгийн шаардлагаас хоцрогдсон зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд зарим талаар нөлөөлж байгаа юм. Эдгээрийн дотроос Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн хийдэл, хэрэглэх явцад учирч буй хүндрэлийг тусгайлан авч үзэх шаардлагатай.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төр засаг, тагнуул, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гааль, нутгийн төр захиргааны байгууллагын зүгээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг **санал, зөвлөмж** болгож байна. Үүнд:

Төр засгийн түвшинд:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн эмнэлгүүд, эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагуудад тавих хяналтыг дан ганц ЭМЯ, УМХГ, Цагдаагийн байгууллагад хариуцуулаад орхих биш Гааль, Татвар, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудын үүрэг оролцоог өргөжүүлж энэ чиглэлээр төрөөс тодорхой бодлого хэрэгжүүлэх;
2. Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, энэ чиглэлийн байгууллагууд олон улсын ижил төстэй байгууллагуудтай туршлага солилцон суралцах боломжийг бий болгох;
3. Монгол Улсад НҮБ-ын Хар тамхинд хяналт тавих хорооноос шинжээчдийн баг урьж ирүүлэн, холбогдох дүн шинжилгээ, үнэлгээ хийлгэж цаашдын чиг хандлага, стратеги боловсруулах;
4. БНХАУ–тай мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис болон зохион байгуулалттай гэмт хэргийн чиглэлээр хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх;
5. Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой НҮБ-ын “Мансууруулах бодисын тухай” 1961 оны, “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” 1971 оны, “Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын тухай” 1988 оны конвенциудад заасан зарим нэр томъёо, ойлголтыг агуулсан зүйл заалтуудтай уялдуулан Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;
6. Хил гааль, хууль хяналтын байгууллагын алба хаагчдыг мансууруулах бодисыг таних, шинжлэх судлах техник хэрэгслээр хангаж, энэ төрлийн ажиллагаа явуулах бие даасан лабораторийг байгуулах;
7. Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчдийн болон, ургамлын тархацийн талаар үндэсний хэмжээнд судалгаа явуулах;
8. Гадаадын улс орнуудад болон дотоодод мэргэжлийн боловсон хүчинг сургаж дадлагажуулан, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, хуулийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох;
9. Иргэдэд үнэн бодит мэдээлэл өгөх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгон хамтран ажиллах нөхцөл боломжийг судлан хэрэгжүүлэх;
10. Монгол улсад өсвөр үеийнхний ойр орчимд, тэдний хүмүүжилд нөлөөлөхүйц мансууруулах бодисын хэрэглээ бий болсонтой холбоотой хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
11. Хар тамхины хор хөнөөлийн талаарх сургалт сурталчилгаа муу, бараг хийгддэггүй нь судалгаанаас харагдаж байна. Иймд төр засгийн зүгээс хар тамхитай тэмцэх талаар ард, иргэд, өсвөр үеийнхэнд нэгдсэн ойлголтыг тодорхой дэс дараатайгаар олгох, тэдэнд зөв хандлага, зан үйлийг эзэмшүүлэх, дөрөв дэх засаглал болох хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийн талаар сургалт, сурталчилгаа явуулах;

12. Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаарх үнэн зөв бодит сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэхээс гадна, тогтмол хэрэглэгч болоогүй, хэрэглээ газар аваагүй, хэрэглэж үзээгүй өсвөр үеийхэнд зөв мэдээлэл, боловсрол олгох сургалтыг (эхний үед 10-11 ангийн сурагчдад) оруулах;
13. Гэр бүлийн орчинд эцэг эх нь үр хүүхэддээ хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийг бүрэн дүүрэн ойлгуулан таниулж, тэднийг бага насны гэнэн томоогүй зангаар энэ төрлийн гэмт хэрэгт өртөх аюулаас урьдчилан сэргийлэх ажилд сургууль, эцэг эх хамтран оролцох;
14. Мансууруулах сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл бодисыг хилээр нэвтрүүлэх, тээвэрлэх, худалдаалах, хэрэглэх, устгах зэрэг холбогдох хуулиудыг боловсронгуй болгох, хууль бус худалдааг таслан зогсоох, хариуцлагын тогтолцоог чангатгах;
15. Хил гааль, шинжилгээний байгууллагын алба хаагчдын мэргэшүүлэх, шинжилгээний тоног төхөөрөмжийг өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүргэх, хил гаалийн хяналтыг сайжруулах;
16. НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн (2000 оны) болон мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг (1988 оны) конвенци болон бусад холбогдох хууль эрхийн актыг олон нийтэд сурталчлах, сурталчилгааны ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах;
17. Мансууруулах бодисын хэрэглээний талаарх, мэдээллийн санг бий болгох зорилгоор нийгмийн бүхий л төлөөллийг хамарсан тандалт судалгааг хийж, төр засгаас нотолгоонд суурилсан оновчтой бодлого боловсруулах;

Тагнуул, цагдаагийн байгууллагаас:

1. Мансууруулах бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэрэгтэй тэмцэхэд тагнуул, цагдаагийн байгууллагын төрөл, мэргэжлийн албадыг татан оролцуулах, албаны нийтлэг чиг үүргийн дагуу ажлын үзүүлэлтэд оруулж ажилтнуудын онол арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг явуулах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх;
2. Энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг тодорхой хэмжээнд хяналтанд авахад мансууруулах бодисын хууль бус эргэлт, хэрэглээтэй холбоотой мэдээ, мэдээлэл олж, баримтжуулах, эрүүгийн хариуцлагад татах, гэмт хэрэгтэн, сэжигтэнүүдийг бүртгэл судалгаанд авч, хяналтанд байлгах үүнтэй холбоотой мэдээ мэдээллийг солилцож хамтран ажиллах;
3. Өнөөдөр залуучууд олноор цуглардаг баар, цэнгээний газруудад олсны ургамал буюу марихуан худалдан борлуулдаг, улмаар худалдан борлуулагчид байнгын хэрэглэгчдийн сүлжээ үүсгэсэн байж болзошгүй нөхцөл байдал тулгараад байгааг анхаарч урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
4. Хар тамхитай холбоотой гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хяналт тавих, шүүн таслах, хуулийн байгууллагуудын хоорондын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах, мэдээлэл солилцон хамтарч ажиллах нөхцлийг бий болгох;
5. Хил орчмын Гааль, Тагнуул, Хил хамгаалах байгууллагатай хамтарсан уулзалт зөвлөгөөнийг жил бүрийн эхний сард зохион байгуулж, цаашид хамтран ажиллах бодлого чиглэлээ тодорхойлж өмнөх оны ажлаа дүгнэн хэлэлцэх, мэдээлэл, ажлын туршлага солилцох, сургалт зохион байгуулж хэвших;
6. Хөрш зэргэлдээ ОХУ, Хятад улсуудын хууль хяналтын байгууллагуудтай шуурхай мэдээлэл солилцох, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу процессын ажиллагаа явуулахад шат дамжлага олон, хугацаа ихээр алддаг байдлыг арилгах;
7. Орчин үед гэмт бүлэглэл нь үйл ажиллагаандаа үүрэн телефон, интернэт сүлжээг өргөнөөр ашиглах болжээ. Дээрх үүрэн телефон, интернэтийг гэмт хэрэг үйлдэхэд ашиглах явдлыг хянах техникийн хэрэгслийн хүчин чадлыг сайжруулах;

8. Шүүх, Прокурор, Хэрэг бүртгэх болон Мөрдөн байцаах байгууллагийн алба хаагчдад нэгдсэн сургалт зохион байгуулж хэргийг зүйлчлэх, байцаан шийтгэх ажиллагааны үндэслэл, журам, хар тамхи, мансууруулах бодис болон түүний түүхий эдийн талаар нэг ойлголтонд хүргэх;
 9. Хар тамхи мансууруулах бодистой гэмт хэргүүдийг шалгаж шийдвэрлэхэд хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалтад нэмэлт өөрчлөлт оруулах;
 - Хар тамхитай холбоотой эрүүгийн хэргийг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд зайлшгүй шаардлагатай нэг зүйл бол хар тамхины агууламж, үнэлгээг тооцож гаргах, хэдий хэмжээний хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисыг авч явсан, олж авсан, зарсан, хилээр оруулж ирсэн, хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хуулинд тодорхой тусгаж өгөх.
 - Энэ чиглэлээр мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх, Гүйцэтгэх ажил явуулах нэгжийг холбогдох бусад байгууллагуудтай хамтарч аль нэг төрийн захиргааны төв байгууллагын удирдлага дор мэргэшүүлж ажиллуулах; (Тухайлбал: Шинэ Зеланд улсын Хар тамхитай тэмцэх байгууллага нь Гааль, Эрүүл мэндийн яам болон Цагдаагийн байгууллагын алба хаагчдаас бүрдэх бөгөөд тухайн улсын цагдаагийн байгууллагын нэгж болж үйл ажиллагаагаа явуулдаг, энэ нь тухайн асуудлыг шалгаж шийдвэрлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг цогцоор нь шийдвэрлэх ач холбогдолтой байдаг)
 10. ОХУ болон БНХАУ-ын хилийн болон цагдаагийн байгууллагууд, Интерполтой нягт хамтран ажиллан тэдний ололт, туршлагаас суралцан, эдгээр орнуудаас манай улс руу дамжин орж ирэх хар тамхи, мансууруулах бодисын эргэлтийг багасгах хаах чиглэлд анхаарлаа хандуулах;
 11. Зүүн өмнөд Азийн улс орнуудын хар тамхи, мансууруулах төрлийн бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагатай харилцаа холбоо тогтоож, мэдээ, мэдээлэл солилцохоос гадна хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;
 12. Монгол иргэд олноор зорчиж, сурч ажиллаж, амьдарч гэмт хэрэгт холбогдож байгаа БНХАУ-ын Бээжин болон Хонконг, Макао, Эрээн, Хөх хот, Малайзын Куала Лампур, ОХУ-ын Улаан-Үд, Москва, Унгар улсын Будапешт, Солонгос улсын Сөүл, Турк улсын Анкара зэрэг улсуудад Монгол улсаас тус улсад суугаа Элчин сайдын яаманд илээр ажиллаж гэмт хэрэгт хохирсон болон холбогдон шалгагдаж байгаа өөрийн орны иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, үндэстэн дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ижил төстэй байгууллагуудын хоорондын уялдааг хангах чиг үүрэг бүхий цагдаагийн атташе томилон ажиллуулах;
- 13. Эрүүл мэндийн байгууллагаас:**
1. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх ухуулга сурталчилгааг сайжруулах, хүүхэд залуучуудыг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэнд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр нэгдсэн бодлого барьж ажиллах;
 2. Эм ханган нийлүүлэх болон эмнэлэг, эмийн сангуудыг мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бодисын хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, борлуулалтыг мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хянах, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 3. Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бус үйлдвэрлэлд ашигладаг уксусны хүчил, цууны ангидрид, хүхрийн болон давсны хүчил, ацетон, ургамлын гаралтай зээргэнэ (эфедрин) зэрэг түүхий эдийн хяналт, мөн түүнчлэн мансууруулах сэтгэцэд нөлөөт эм бодис, тэдгээрийн түүхий эдийн импорт, экспортын зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагуудын саналын үндсэн дээр олгодог болох;

4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, албадын үйл ажиллагаа, хийж гүйцэтгэх ажил, мэдээлэл солилцох, хяналт тавих чиглэлээр нэмэлт өөрчлөлтийг оруулах;
5. Эрүүл мэндийн яам нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 15.12.1, “мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэх, 15.12.4.-д “заасан мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бодис, тэдгээрийн угтвар бодис болон эмийн үйлдвэрлэл худалдаа эрхлэх, импортлох тусгай зөвшөөрөл”-ийг хууль зүйн дагуу олгох;
6. Мансуурах донтой хүмүүст үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгааллын талаар хууль эрх зүйн орчин бараг бүрдээгүй байна. Мансууран донтох явдалтай тэмцэж, урьдчилан сэргийлэх, донтогсдод үзүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний талаар авч хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх;

Мэргэжлийн хяналт, Хил, Гаалийн байгууллагаас:

1. Дэлхийн улс орны гаалийн байгууллагын нэг чухал үүрэг нь хилийн чанадаас шууд болон шууд бус хэлбэрээр учруулж болзошгүй аюулаас, нийгмээ хамгаалах, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисын хууль бус худалдаа эргэлтийг таслан зогсоох явдал байдаг. Өнөөдөр дэлхий дахинд гаалийн байгууллага хуурай газар, далай тэнгис, агаарын зайг нийтэд нь хамран ажиллаж, хууль бус эргэлтэнд орж байгаад хураагдсан нийт мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын 60 гаруй хувийг дангаараа илрүүлдэг байна.¹⁵ Монгол улсын хил, гааль хар тамхи, мансууруулах бодитой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх энэ харицулагатай үүргийг биелүүлэхийн тулд;
 - Ажилтнуудаа энэ чиглэлээр мэргэшүүлэх;
 - Үнэрч нохойн сургалтыг сайжруулах;
 - Мансууруулах бодисыг түргэн хугацаанд найдвартай таньж, илрүүлэхэд шаардагдах, лабораторийн тоног төхөөрөмжөөр хангах;
2. Мансууруулах бодисын олон улсын тээвэрлэлт, дамжин өнгөрөх зам, чиглэлүүдийг мэдэх, сэжигтэй тээвэрлэгч, зөөвөрлөгчийг илрүүлэх чиглэлээр хөрш орны гаалийн байгууллагуудтай мэдээлэл солилцох ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
3. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Гаалийн байгууллагаас ирүүлсэн материалыг үндэслэн мансууруулах сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ямар эм, бодис, түүхий эдийг хэзээ, хаанаас ямар боомтоор, ямар хэмжээтэй оруулж ирэх гэж байгаа талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад мэдэгдэн, хяналт тогтоож, холбогдох арга хэмжээг авч хамтран ажиллах;

Нутгийн төр захиргааны байгууллагаас:

1. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх, эм бэлдмэлийн хэрэглэх, хууль бусаар худалдах явдлыг таслан зогсоох зорилгоор эм бэлдмэл худалдах, үйлчлэх зөвшөөрөлтэй эмийн сангийн эмийн эргэлт, худалдан авалт зарцуулалтад хяналт тавьж ажиллах;
2. Мансууруулагч, донтуулагч ургамлын тархацын талаарх судалгааг тухайн орон нутгийн нутаг дэвсгэрийн хүрээнд төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын албадтай хамтран зохион байгуулж, мансууруулах бодис, хар тамхи агуулсан ургамлын тархац, төрлийг нарийвчлан тогтоож, зураглал гаргах, орон нутгийн байгаль орчны албатай хамтран жил бүр мансууруулах төрлийн ургамалын тархацтай бүс нутгийг шинэчлэн тогтоож, устгал хийх;
3. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийг илрүүлэх нь цагдаагийн ажилтны мэдлэг мэргэшил, ур чадвараас ихээхэн шалтгаалдаг тул энэ


¹⁵“Таны амьдрал-Мансууралгүй орчин” онод практикийн бага хурал, Гаалийн төв лабораторийн эрхлэгч Н.Цолмонгийн тависан мэдээлэл, 2009.06.26

чиглэлийг хариуцсан орон нутгийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтанд хамруулах;

4. Манай улсад олсны ургамал нь Орхон аймгийн нутаг дэвсгэрт нийт, Ховд аймгийн Үенч, Алтай сум, Хар-Ус нуурын сав газрууд, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Загдал, Мандал сумын Шивэрийн ам, Алтанбулаг, Ерөө, Жавхлант, Шаамар, Дулаанхаан, Түнхэл, Баруун хараа, Дархан-Уул аймгийн Хонгор сумын Салхит баг, Орхон сум, Дархан сумын Ширээ нуурын орчим, түүнчлэн Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн туршлагын талбай, Булган аймгийн Сэлэнгэ сумын Доод хоодын гол дагуу, Хангал сумын Хялганат баг, Хангал гол дагуу, Дорнод аймгийн Халх гол, Сүмбэр сумын нутагт ургадгийг анхаарч байнгын хяналтанд байлган, устгал хийж байх;

§5.12. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (Эрүүгийн хуулийн 215-225 дугаар зүйл) гэмт хэрэг 1999 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 129 хэргээр буюу 6.9 хувиар өсч, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 8.8 хувь болж, 0.9 нэгжээр буурав.



Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт Тоогоор	Хувиар
1	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1870	1999	29	6.9
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	9.7	8.8	-0.9 нэгжээр буурсан	
3	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	64.5	72.4	7.9 нэгжээр өссөн	

Энэ төрлийн гэмт хэрэг Төвд 110, Өмнөговьд 73, Сэлэнгэд 67, Өвөрхангайд 60, Баянхонгор 59, Хөвсгөлд 55, Дархан-Уулд 54, Орхонд 51, Дорноговьд 47, Ховдод 45, Хэнтийд 41, Булганд 40, Дорнодод 33, Архангайд 27, Баян-Өлгийд 25, Завханд 24, Увсад 23, Сүхбаатарт 18, Говь-Алтайд 16, Говьсүмбэрт 15, Дундговьд 9, нийслэлд 1105, үүнээс Сонгинохайрханд 230, Баянзүрхэд 223, Сүхбаатарт 222, Баянголд 188, Чингэлтэйд 107, Хан-Уулд 93, Налайхад 25, Багануурт 15, Багахангай дүүрэгт 2, төмөр замын салбарт 2 хэрэг тус тус бүртгэгджээ.

Дээрх гэмт хэргийн гаралт Завхан, Увс, Ховд, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар аймагт 9.1 хувиас 2.1 дахин, нийслэлд 9.6 хувиар, нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багануур, Налайх дүүрэгт 1.4-56.3 хувиар тус тус өсч, Говь-Алтай, Архангай, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Төв, Дорнод, Хэнтий аймагт 6.0-55.0 хувиар, нийслэлийн Баянгол, Багахангай дүүрэгт 3.0-33.1 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 369 гэмт хэргээс 267 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 72.4 хувьтай, 102 хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй (Архангай, Өмнөговь аймагт тус бүр 3, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймагт тус бүр 2, Завхан, Баянхонгор, Дундговь, Сэлэнгэ, Хэнтий аймагт тус бүр 1, нийслэлд 82, үүнээс Баянзүрхэд 24,


Сүхбаатарт 13, Сонгинохайрханд 13, Чингэлтэйд 9, Баянголд 15, Хан-Уулд 5, Налайхд 3, бусад газар 2) байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 1946 гэмт хэргийн:

- 1238 буюу 61.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 713 буюу 35.7 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах,
- 1 буюу 0.05 хувийг тус бүр, бүрэн бус тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй, согтуурсан буюу мансуурсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах,
- 5 буюу 0.25 хувийг жолоогоо бусдад шилжүүлэх,
- 223 буюу 11.1 хувийг авто тээврийн хэрэгслийг авч зугтаах,
- 18 буюу 0.9 хувийг төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 38.3 хувь нь хөнгөн, 60.3 хувь нь хүндэвтэр, 1.4 хувь нь хүнд ангиллын хэрэг,
- 21.5 хувь нь согтуугаар, 0.1 хувь нь мансуурсан үедээ, 0.9 хувь нь эмэгтэй, 0.4 хувь нь гадаадын иргэн, 2.05 хувь нь хүүхэд оролцсон,
- 15.4 хувь нь Даваа, 14.2 хувь нь Мягмар, 14.3 хувь нь Лхагва, 14.9 хувь нь Пүрэв, 14.6 хувь нь Баасан, 13.4 хувь нь Бямба, 13.2 хувь нь Ням гарагт,
- 22.2 хувь нь 06-14 цагт, 28.2 хувь нь 14-19 цагт, 20.4 хувь нь 19-22 цагт, 29.2 хувь нь 22-06 цагт,
- 89.1 хувь нь авто замд, 4.8 хувь нь гудамж талбайд, 0.3 хувь нь олон нийтийн газар, 0.05 хувь нь төрийн болон төрийн бус байгууллага, нийтийн тээвэрт, 0.2 хувь нь аж ахуйн нэгжид, 5.5 хувь нь бусад газарт тус тус үйлдэгджээ.



Авто замд үйлдэгдсэн 1756 хэргийг:


- замын харьяаллаар авч үзвэл, олон улсын замд 7, улсын замд 67, орон нутгийн замд 647, хотын замд 1049, хувийн замд 3, аж ахуйн нэгж, байгууллагын замд 6,
- замын хэсгээр авч үзвэл, уулзвар дээр 151, явган хүний гарцан дээр 67, автобусны буудалд 41, төмөр замын гарамд 3, гүүрэн дээр 15,
- замын ангиллаар авч үзвэл, ердийн замд 988, хорооллын замд 68, тууш замд 231, хурдны замд 5,
- замын хучилтаар авч үзвэл, асфальтан замд 1246, цементэн замд 22, бетон замд 75, сайжруулсан замд 56, хөрсөн замд 170, хайрган замд 28,
- замын гадаргуугаар авч үзвэл, хуурай замд 888, нойтон замд 46, мөстэй замд 118, цастай замд 116, эвдрэлтэй замд 17, бохирдсон замд 2,
- замын онцлогоор авч үзвэл, тэгш замд 946, хазгай замд 24, шулуун замд 749, өгсүүр замд 62, уруу замд 93, огцом эргэлттэй замд 28,

- үзэгдэх орчноор нь авч үзвэл, үзэгдэх орчин чөлөөтэй 1179, хязгаарлагдмал 138, хангалтгүй 27, зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй 210, гэрэлтүүлэггүй 177,
- цаг агаарын таатай үед 1036, үүлэрхэг үед 45, бороотойд 26, цастайд 24, манантайд 11, шуургатайд 7 хэрэг тус тус үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 2122 иргэн, 8 байгууллага хохирч, 5.2 тэрбум төгрөгийн хохирол учирсны 3.9 тэр бум төгрөг буюу 75.1 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, 326.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн ба 369 хүн нас барж, 1078 хүн гэмтсэн байна.

Нас барсан хүмүүсийн 8.9, гэмтсэн хүмүүсийн 12.1 хувийг хүүхдүүд эзэлж, гэмтсэн хүмүүсийн 29.7 хувь нь хөнгөн, 51.9 хувь нь хүндэвтэр, 18.4 хувь нь хүнд хэлбэрээр гэмтжээ.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 4 гэмт хэрэг тутмын нэг нь согтуугаар үйлдэгдэж, 5 гэмт хэрэг тутамд нэг хүн нас барж , 2 гэмт хэрэг тутамд нэг хүн гэмтсэн байна.



ТХХАБАЖЭсрэг 1999 гэмт хэргт 1887 хүн холбогдон шалгагдсаны дотор:


- 9.5 хувь нь эмэгтэй, 2.1 хувь нь 14-17 насны, 25.4 хувь нь 18-24 насны, 23.7 хувь нь 25-29 насны, 15.2 хувь нь 30-34 насны, 11.9 хувь нь 35-39 насны, 8.7 хувь нь 40-44 насны, 7.0 хувь нь 45-49 насны, 3.3 хувь нь 50-54 насны, 1.5 хувь нь 55-59 насны, 0.5 хувь нь 60-64 насны, 0.3 хувь нь 65-69 насны, 0.4 хувь нь 70 ба түүнээс дээш насны,



- 46.1 хувь нь ажилгүй, 18.4 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 14.9 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 6.7 хувь нь ажилчин малчин, 5.3 хувь нь төрийн албан хаагч, 5.0 хувь нь оюутан, 2.3 хувь нь төрийн бус байгууллагын ажилтан, 1.2 хувь нь сурагч, 0.1 хувь нь хоригдол,
- 19.6 хувь нь согтуугаар, 1.0 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс, 0.7 хувь нь гадаадын иргэн үйлдсэн байна.

Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг өсч байгаа нь жолооч бэлтгэж буй дамжаануудын сургалтын чанар муугаас жолооч дүрмээ мэддэггүй, биелүүлдэггүй, жолоодох ур чадвар дутмаг, замын хөдөлгөөний хууль, дүрэм зөрчсөн жолоочид хүлээлгэх зарим хариуцлага оновчгүй, хотжих байдалаас шалтгаалан хүн амын хэт төвлөрөл, түүнийг дагасан тээврийн хэрэгслийн өсөлт, техник бүрэн бус, хөдөлгөөнд оролцох боломжгүй тээврийн хэрэгсэл, замын нөхцөл байдал шаардлагын түвшинд хүрэхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

1. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих (Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйл) гэмт хэрэг 1238 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 23 хэргээр буюу 1.8 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 5.6 хувь болж, 1.0 нэгжээр тус тус буурав.



Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэг	1261	1238	-23	-1.8
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	6.6	5.6	-1.0	нэгжээр буурсан
3	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих	53.8	54.8	1.0	нэгжээр өссөн

Төвд 99, Сэлэнгэд 61, Өмнөговьд 51, Өвөрхангайд 44, Орхон, Дархан-Уулд тус бүр 43, Булган 39, Баянхонгор 38, Дорноговь, Ховдод тус бүр 37, Хөвсгөл, Хэнтийд тус бүр 36, Дорнод 28, Архангай, Увсад тус бүр 23, Баян-Өлгийд 20, Завханд 19, Сүхбаатарт 16, Говь-Алтайд 15, Говьсүмбэрт 12, Дундговьд 5, нийслэлд 511, үүнээс Баянзүрхэд 115, Сонгинохайрханд 102, Баянголд 93, Сүхбаатарт 77, Хан-Уулд 49, Чингэлтэйд 45, Налайхад 16, Багануурт 12, Багахангай дүүрэгт 2, төмөр замд 2 бүртгэгджээ.

Гэмт хэргийн гаралт Завхан, Увс, Ховд, Баянхонгор, Булган, Сүхбаатар, Орхон, Хөвсгөл, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь аймагт 12.1 хувиас 2.0 дахин, нийслэлийн Багануур дүүрэгт 9.1 хувиар тус тус өсч, Сэлэнгэ, Төв, Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Хэнтий, Говь-Алтай, Өмнөговь, Дорнод, Дундговь аймагт 1.9-32.1 хувиар, нийслэлд 4.1 хувиар нийслэлийн Баянзүрх, Налайх, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, 1.3-20.5 тус тус буурч, Сүхбаатар дүүрэг өмнөх оны түвшинд байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 42 гэмт хэргээс 23 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 54.8 хувьтай, 19 хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогоогүй (*Завхан, Архангай, Хөвсгөл, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймагт тус бүр 1, нийслэлд 12, үүнээс Баянголд 3, Баянзүрхэд 4, Сүхбаатарт 2, Сонгинохайрхан, Налайх, Чингэлтэйд тус бүр 1*) байна.

Энэ төрлийн гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 37.1 хувь нь хөнгөн, 60.7 хувь нь хүндэвтэр, 2.2 хувь нь хүнд ангиллын,
- 23.8 хувь нь согтуугаар, 0.2 хувь нь мансуурсан үедээ, 1.1 хувь нь хүүхэд, 0.6 хувь нь гадаадын иргэн, 9.8 хувь нь эмэгтэй хүн оролцсон,
- 14.9 нь Даваа, 13.1 нь Мягмар, 14.5 нь Лхагва, 15.3 нь Пүрэв, 14.5 нь Баасан, 13.3 нь Бямба, 14.4 нь Ням гарагт,
- 24.1 хувь нь 06-14 цагт, 29.3 хувь нь 14-19 цагт, 2.1 хувь нь 19-22 цагт, 44.5 хувь нь 22-06 цагт,
- 88.5 хувь нь авто замд, 3.9 хувь нь гудамж талбайд, 0.3 хувь нь олон нийтийн газар, 0.1 хувь нь нийтийн тээвэрт, төрийн болон төрийн бус байгууллага, 0.2 хувь нь аж ахуй нэгжид, 7.0 хувь нь бусад газарт тус тус үйлдэгджээ.

ТХХАБАЖ зөрчих 1199 гэмт хэрэг авто зам дээр үйлдэгдсэнийг:

- замын харьяаллаар авч үзвэл, олон улсын замд 5, улсын замд 54, орон нутгийн замд 539, хотын замд 492, хувийн замд 2, аж ахуйн нэгж, байгууллагын замд 4,
- замын хэсгээр авч үзвэл, уулзвар дээр 79, явган хүний гарцан дээр 67, автобусны буудалд 41, төмөр замын гарамд 3, гүүрэн дээр 11,
- замын ангиллаар авч үзвэл, ердийн замд 596, хорооллын замд 43, тууш замд 134, хурдны замд 5,
- замын хучилтаар авч үзвэл, асфальтан замд 706, цементэн замд 17, бетон замд 52, сайжруулсан замд 52, хөрсөн замд 138, хайрган замд 19,
- замын гадаргуугаар авч үзвэл, хуурай замд 536, нойтон замд 38, мөстэй замд 64, цастай замд 70, эвдрэлтэй замд 14, бохирдсон замд 2,
- замын онцлогоор авч үзвэл, тэгш замд 537, хазгай замд 19, шулуун замд 441, өгсүүр замд 42, уруу замд 76, огцом эргэлттэй замд 24,
- үзэгдэх орчноор нь авч үзвэл, үзэгдэх орчин чөлөөтэй 701, хязгаарлагдмал 100, хангалтгүй 22, зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй 110, гэрэлтүүлэггүй 131,
- цаг агаарын таатай үед 605, үүлэрхэг үед 34, бороотойд 17, цастайд 19, манантайд 9, шуургатайд 7 хэрэг тус тус үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 21221349 иргэн, 8 байгууллага хохирч, 4.4 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 335.1 сая төгрөг буюу 0.7 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах

ажиллагааны явцад нөхөн төлүүлж, 321.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн ба 361 хүн нас барж, 748 хүн гэмтсэн байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 4 гэмт хэрэг тутмын нэг нь согтуугаар үйлдэгдэж, 3 гэмт хэрэг тутамд нэг хүн нас барж, 2 гэмт хэрэг тутамд нэг хүн гэмтсэн байна.

ТХХАБАЖЗ 1238 гэмт хэрэгт 1212 хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 10.1 хувь нь эмэгтэй, 0.9 хувь нь 16-17 насны, 23.6 хувь нь 18-24 насны, 23.7 хувь нь 25-29 насны, 16.2 хувь нь 30-34 насны, 11.8 хувь нь 35-39 насны, 9.5 хувь нь 40-44 насны, 7.7 хувь нь 45-49 насны, 3.4 хувь нь 50-54 насны, 1.9 хувь нь 55-59 насны, 0.6 хувь нь 60-64 насны, 0.3 хувь нь 65-69 насны, 0.4 хувь нь 70 ба түүнээс дээш насны,
- 43.1 хувь нь ажилгүй, 18.5 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 16.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 8.2 хувь нь ажилчин малчин, 6.4 хувь нь төрийн албан хаагч, 4.1 хувь нь оюутан, 2.7 хувь нь төрийн бус байгууллагын ажилтан, 0.6 хувь нь сурагч,
- 21.1 хувь нь согтуугаар, 8.2 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс, 0.6 хувь нь гадаадын иргэн үйлдсэн байна.


Мэдээллийн санд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 52.7 хувь нь анхаарал болгоомжгүй, 22.5 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 8.6 хувь нь хурд хэтрүүлсэн, 5.9 хувь нь зогсоох арга хэмжээ аваагүй, 2.0 хувь нь замын хөдөлгөөний хууль дүрмийн мэдлэг дутмаг, 0.9 хувь нь бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон, 1.0 хувь нь уулзвар, гарц нэвтрэх журам зөрчсөн, 3.0 хувь нь эсрэг урсгалд орсон, 0.5 хувь нь тус бүр хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн, гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийсэн, явган ба дугуйтай хүний буруугаас, 0.2 хувь нь эгнээ, байр буруу эзэлсэн, 0.3 хувь нь замын нөхцөл байдлаас, 0.4 хувь нь тус бүр ухрах үйлдэл буруу хийсэн, 1.0 хувь нь эргэх үйлдэл буруу хийсэн, 0.6 хувь нь тус бүр хажуу хоорондын зай тохируулаагүй, гэрэл, дохио зөрчсөн, эрхийн үнэмлэхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулсан, 0.1 хувь нь тус бүр тээврийн хэрэгслийн холбоо, дохиоллын болон бусад тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах мэдлэг дутмаг, техник хэрэгслийн засварыг шаардлагын түвшинд хийгээгүй, техникийн гэмтэл, байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас, 2.4 хувь нь бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн тухай дурдсан байна.

Монгол улсад жил ирэх тусам тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэхийн хирээр нийслэлийн замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн тоо өсч байгаагаас шалтгаалан жолооч нарын хөдөлгөөнд оролцох сахилга, замын хөдөлгөөний соёл, үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх шаардлага бий болж байгаагийн дээр жолооч бэлтгэх сургууль, дамжааны сургалтын чанар муу байгаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл болж байна.

Жолоочид хүлээлгэж буй хариуцлага болон эрүүгийн ял шийтгэл нэр төдий, цээрлүүлэх зорилго агуулахгүй байна.

Жолооч нар архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгслэл жолоодох, техникийн бүрэн бүтэн байдлыг хангахгүйгээр хөдөлгөөнд оролцох, хурд хэтрүүлэхээс гадна замын нөхцөл муу, явган зорчигчийн хөдөлгөөнд замбараагүй, дүрэм журамгүй оролцож байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтад шууд нөлөөлж байна.

2. Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах (Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйл) гэмт хэрэг **713** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 153 хэргээр буюу 27.3 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 3.2 хувь болж, 0.3 нэгжээр тус тус өсөв.




Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах хэрэг	560	713	153	27.3
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	2.9	3.2	0.3	нэгжээр өссөн
3	Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	65.8	74.2	8.4	нэгжээр өссөн

Баянхонгор 19, Өмнөговь, Хөвсгөлд тус бүр 17, Өвөрхангайд 14, Дорноговь, Төвд тус бүр 10, Дархан-Уулд 9, Ховд, Орхон тус бүр 8, Баян-Өлгий, Архангай, Дорнод, Дундговьд тус бүр 4, Говьсүмбэр, Сэлэнгэд тус бүр 3, Сүхбаатар, Хэнтий, Завханд тус бүр 2, Булганд 1, нийслэлд 572, үүнээс Сүхбаатарт 140, Сонгинохайрханд 123, Баянзүрхэд 104, Баянголд 93, Чингэлтэйд 61, Хан-Уулд 42, Налайхад 7, Багануурт 2 тус тус бүртгэгджээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 314 гэмт хэргээс 233 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 74.2 хувьтай, 81 хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй (Архангай, Орхон, Өмнөговь, Өвөрхангайд тус бүр 2, Баянхонгор, Хөвсгөл, Дундговьд тус бүр 1, нийслэлд 70, үүнээс Баянзүрхэд 20, Баянгол, Сонгинохайрханд тус бүр 12, Сүхбаатарт 11, Чингэлтэйд 8, Хан-Уулд 5, Налайхад 2 хэрэг) байна.

Энэ төрлийн гэмт хэргийн криминологи шинжийг илтгэх статистикийн зарим үзүүлэлтээс дурдвал:

- 270 буюу 37.8 хувь нь хөнгөн, 443 буюу 62.2 хувь нь хүндэвтэр,
- 15.0 хувь нь согтуугаар, 2.8 хувь нь хүүхэд, 8.0 хувь нь эмэгтэй хүн оролцсон,
- 16.3 хувь нь Даваа, 16.0 хувь нь Мягмар, 14.0 хувь нь Лхагва, 14.4 хувь нь Пүрэв, 14.3 хувь нь Баасан, 13.7 хувь нь Бямба, 11.3 хувь нь Ням гарагт,
- 19.2 хувь нь 06-14 цагт, 26.5 хувь нь 14-19 цагт, 19.6 хувь нь 19-22 цагт, 34.7 хувь нь 22-06 цагт үйлдэгджээ.



Энэ төрлийн 713 гэмт хэрэгт 628 хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 8.9 хувь нь эмэгтэй, 2.5 хувь нь 14-17 насны, 28.5 хувь нь 18-24 насны, 23.2 хувь нь 25-29 насны, 14.3 хувь нь 30-34 насны, 12.6 хувь нь 35-39 насны, 7.8 хувь нь 40-44 насны, 5.7 хувь нь 45-49 насны, 3.2 хувь нь 50-54 насны, 0.9 хувь нь 55-59 насны, 1.3 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс,
- 50.7 хувь нь ажилгүй, 19.4 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 3.7 хувь нь тус бүр малчин, төрийн албан хаагч, 12.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 7.0 хувь нь оюутан, 1.7 хувь нь төрийн бус байгууллагын ажилтан, 1.4 хувь нь сурагч,
- 19.2 хувь нь согтуугаар, 0.8 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлдсэн байна.

Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэрэг нь осол гаргасан этгээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээхээс зайлсхийх, замын хөдөлгөөний дүрэм, эрх зүйн мэдлэг дутмаг зэрэг шалтгаанаар үйлдэгдэж байна.

§5.13. Захиргааны журмын эсрэг гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл

Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг:
(Эрүүгийн хуулийн 230-244 дүгээр зүйл) гэмт хэрэг **332** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 52 хэргээр буюу 18.6 хувиар өсч, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 1.5 хувь болж, өмнөх оны түвшинд байна.




Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	280	332	52	18.6
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	1.5	1.5	Өмнөх оны түвшинд	

Захиргааны журмын эсрэг гэмт хэргийн:

- 149 буюу 44.9 хувь нь хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах,
- 100 буюу 30.1 хувь нь төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх,
- 51 нь дураараа аашлах,
- 15 нь мөрийтэй тоглох,
- 12 нь баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягтыг хулгайлах, устгах, гэмтээх, нуух,
- 2 нь төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох хэрэг,
- 1 нь битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах байна.

Хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах (Эрүүгийн хуулийн 233 дүгээр зүйл) гэмт хэрэг **149** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 31 хэргээр буюу 26.3 хувиар өсчээ.

Баян-Өлгийд 8, Дорноговьд 5, Төв аймагт 3, Сэлэнгэ, Говьсүмбэр, Орхон, Ховдод тус тус 2, Дорнод, Өмнөговь, Баянхонгор, Архангайд тус тус 1, нийслэлд 121 Хан-Уул, Чингэлтэйд тус бүр 36, Сүхбаатарт 18, Баянголд 14, Баянзүрхэд 11, Сонгинохайрханд 5, Багануурт 1 үйлдэгджээ.



Энэ хэргийг 32.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 3.3 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн ба энэ төрлийн хэрэгт нийт 101 хүн холбогдон шалгагдсаны 31.7 хувь нь эмэгтэй, 49.5 хувь нь ажилгүй, 21.8 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 14.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 8.9 хувь нь төрийн албан хаагч, төрийн бус байгууллагын ажилтан, оюутан тус бүр 2.0 хувь, 1.0 хувь нь малчин хүмүүс байна.

Гэмт хэргийн улмаас нийт 3.5 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 167.9 сая төгрөгийн хохирлыг хэрэг бүртгэх болон мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Энэ гэмт хэргийг иргэний болон жолооны үнэмлэх, гадаад паспорт, их, дээд сургуулийн диплом, банкны баталгаа, төлбөрийн баримт, тусгай зөвшөөрлийг хуурамчаар хийж ашиглах, ажил сургуульд орох, улсын хил нэвтрэх, хуурч мэхлэхийн зэрэгцээ хуулийн этгээдийн тамга, тэмдэгийг дуурайлган хийх, нотариатын тамга, тэмдэгийг хуурамчаар хийж үл хөдлөх хөрөнгийг хууль бусаар шилжүүлэх байдлаар ихэвчлэн үйлдэгджээ. Иймд иргэний үнэмлэх удахгүй цахим хэлбэрт шилжих тул үүнийг даган үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, жолооны үнэмлэхийг хуурамчаар хийж ашиглах явдал их байгаад дүгнэлт хийх нь зүйтэй байна.

Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 230 дүгээр зүйл) 100 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 8 хэргээр буюу 2.0 хувиар өссөн байна.

Дорноговьд 6, Хэнтийд 5, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Говьсүмбэрт тус бүр 4, Дорнод, Дундговьд тус бүр 3, Өмнөговь, Завханд тус бүр 2, Сүхбаатар, Өвөрхангай, Орхон, Булган, Баянхонгор, Увс, Говь-Алтай, Баян-Өлгийд тус бүр 1, нийслэлд 52, Сонгинохайрханд 15, Баянзүрхэд 11, Сүхбаатарт 9, Баянгол, Чингэлтэйд тус бүр 5, Хан-Уулд 2, Багануурт 3, Налайхад 2, төмөр замын салбарт 3 хэрэг тус тус бүртгэгджээ.

Энэ төрлийн гэмт хэргийн 11 буюу 11.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 20 буюу 20,0 хувь нь бүлэглэн үйлдэгджээ.

Дээрх гэмт хэрэгт 106 хүн холбогдон шалгагдсаны дотор 10.4 хувь нь эмэгтэй, 42.4 хувийг ажилгүй, 6.7 хувь нь малчин, 16.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.9 хувийг төрийн бус байгууллагад ажилтан, 16.0 хувь нь хувийн хэвшийн байгууллагад ажиллагч, 11.4 хувийг төрийн албан хаагч, 4.7 хувийг оюутан, 0.9 хувь нь хоригдол хүмүүс байна.

Гэмт хэргийн улмаас төр засагт 30.3 сая төгрөгийн хохирол учирсаны 29.0 сая төгрөгийн хохирлыг мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.


Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь гол төлөв төрийн алба хаагч 95 буюу 95.0 хувь, үүний дотроос цагдаагийн алба хаагч 53.0 хувийг эзэлж байна.

Үүний дотор ялангуяа цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх гэмт хэрэг ихэвчлэн үйлдэгджээ. Иймд энэ гэмт хэргийн гаралтыг бууруулах гэхээсээ илүү нийгэмд бий болсон энэ төрлийн гэмт үйлдлийг таслан зогсоох ажилд анхаарал хандуулах бус урьдчилан сэргийлэх, иргэдэд хууль зүйн цогц мэдлэг олгох ажлыг төрийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах шаардлагатай байна. Энэ ажил нь нийгэмд дэг журам хангагдах, иргэд хуулиа яанд сахин биелүүлэх нэг үндэс суурь болно.

§5.14. Албан тушаалын эсрэг гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл

Албан тушаалын эсрэг (Эрүүгийн хуулийн 263-273 дугаар зүйл) гэмт хэрэг **110** бүртгэгдсэн нь ба нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 0.5 хувь болж, өмнөх оны түвшинд байна.

Сэлэнгэд 7, Хөвсгөл, Дорноговь, Дархан-Уулд тус бүр 5, Баян-Өлгий, Баянхонгор, Өмнөговь, Орхонд тус бүр 3, Дорнод, Говь-Алтайд тус бүр 2, Ховд, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтийд тус бүр 1, нийслэлд 67, үүнээс Сүхбаатарт 23, Чингэлтэйд 16, Хан-Уулд 10, Баянзүрхэд 6, Баянголд 5, Сонгинохайрханд 3, Багануур, Налайхад тус бүр 2, төмөр замын салбарт 1 гэмт хэрэг бүртгэгджээ.



Гэмт хэргийн 10.9 хувь нь хөнгөн, 79.1 хувь нь хүндэвтэр, 10.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа ба 16.4 хувь нь эмэгтэй хүн оролцсон, 12.7 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг байна.

Албан тушаалын эсрэг 110 гэмт хэргийн дотор:

- Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 36,
- Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 8,
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 16,
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 2,
- Хээл хахууль авах 16,
- Хээл хахууль өгөх 10,
- Албан тушаалтан хуурамч баримт бичиг үйлдэх 5,
- Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах 16,
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 1 хэрэг тус тус бүртгэгдэв.

Төрийн байгууллагад 72, аж ахуйн нэгжид 19, гудамж талбайд 5, олон нийтийн газар, төрийн бус байгууллагад тус бүр 3, гэр орон сууцанд 1, бусад газарт 7 хэрэг тус тус үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 8 иргэн, 2 байгууллагад 307.2 сая төгрөгийн хохирол учирсны 271.2 сая төгрөг буюу 88.3 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 62 хүн холбогдон шалгагдсаны дотор:

- 22.6 хувь нь эмэгтэй, 3.2 хувь нь 18-24 насны, 6.5 хувь нь 25-29 насны, 12.9 хувь нь 30-34 насны, 9.7 хувь нь 35-39 насны, 11.3 хувь нь 40-44 насны, 30.6 хувь нь 45-49 насны, 11.3 хувь нь 50-54 насны, 11.3 хувь нь 55-59 насны, 3.2 хувь нь 65-69 насны,
- төрийн албан хаагч 72.6, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 21.0, төрийн бус байгууллагын ажилтан 1.6, хувиараа хөдөлмөр эрхлэгч 4.8 хувийг тус тус эзэлж байна.
- *Субъектийн онцлогоор нь авч үзвэл*, Засаг дарга 13, УИХ-ын гишүүн 1, татварын 2, нийгмийн даатгалын 2, гаалийн 2, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 1, цагдаагийн байгууллагын 9, боловсролын 3, эрүүл мэндийн 2, аж ахуйн нэгжийн захирал 10 хүн байна
- 88.7 хувь нь дээд боловсролтой,
- 12.9 хувь нь бүлгээр үйлджээ.

Мэдээллийн санд бүртгэгдсэн албан тушаалын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл, 48.5 хувь нь нийгмийн буруу төлөвшил, хувь хүний ёс суртахууны хэм хэмжээ, шударга байх асуудал хомсдсон, 4.6 хувь нь хяналтын механизм сул, 4.8 хувь нь хувь хүн, бүлэг этгээдүүдийн шунал, ашиг сонирхол, 10.4 хувь нь иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, 8.3 хувь нь гуйлт их, 2.7 хувь нь зохицуулж буй эрх зүйн зохицуулалт алдаа, хийдэлтэй, 6.8 хувь нь төрийн үйлчилгээ авахад дамжлаг их, 10.2 хувь нь танил талын хүрээ өргөн бусад шалтгаан нөхцөлийн улмаас үйлдэгдсэн тухай дурдсан байна.

Төрийн болон хувийн хэвшлийн салбарт, нийгмийн бүхий л харилцаанд шударга бус байдал газар авсан байна. Нөгөө талаар төрийн албаны олон шат дамжлага, давхардал, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул, шийдвэр гаргах ажиллагааны ил тод, нээлттэй байдал хангалтгүй, төсвийн хөрөнгийн зориулалтын бус зарцуулалт, хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал, төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын туршлага, ур чадвар дутагдалтай, төрийн албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй байгаа нь албан тушаалын эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байна.

§6. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ОНЦЛОГ, ТЭДГЭЭРИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ

§6.1. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг: Улсын хэмжээнд 2012 онд согтуугаар үйлдэгдсэн **5063** гэмт хэрэгт **4748** сэжигтэн бүртгэгдсний 280 нь эмэгтэй хүн, 159 нь хүүхэд, үүний 33 нь 14-15 насны хүүхэд байна.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	4312	5063	+751	+17.4
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	22.5	22.9	0.4 нэгжээр өссөн	

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны түвшинтэй харьцуулахад 17.4 хувиар өссөн байна.

Согтуугаар үйлдэгдсэн нийт хэргийн 40.4 хувь буюу 2046 нь хөнгөн ангиллын хэрэг бүртгэгдсэний 174 нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүйгээс 147 хэргийн сэжигтэн этгээдийг олж баривчлан ял сонгосноор илрүүлэлт 84.5 хувьтай, 27 хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй, 39.6 хувь буюу 2006 нь хүндэвтэр ангиллын хэрэг бүртгэгдсэний 539 нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй байсны 433 хэргийн сэжигтэн этгээдийг олж баривчлан ял сонгосноор илрүүлэлт 80.3 хувьтай, 106 хэргийн үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй, 15.8 хувь буюу 801 нь хүнд ангиллын хэрэг бүртгэгдсэний 190 нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй байсны 144 хэргийн сэжигтэн этгээдийг олж баривчлан ял сонгосноор илрүүлэлт 75.8 хувьтай, 46 хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй, 4.1 хувь буюу 210 нь онц хүнд ангиллын хэрэг бүртгэгдсэний 61 нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй байсны 56 хэргийн сэжигтэн этгээдийг олж баривчлан ял сонгосноор илрүүлэлт 91.8 хувьтай, 5 хэргийг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй байна.

Нийт үйлдэгдсэн хэргийн 2214 буюу 43.7 хувь нь нийслэл хотод үйлдэгдсэний 451 нь Чингэлтэйд, 432 нь Баянзүрхэд, 368 нь Сүхбаатарт, 355 нь Сонгинохайрханд, 280 нь Баянголд, 118 нь Хан-Уулд, 120 нь Багануурт, 81 нь Налайхад, 9 нь Багахангайд тус тус үйлдэгджээ.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 3 буюу 0.06 хувийг бусдыг болгоомжгүй алах, 16 буюу 0.3 хувийг булаах, 57 буюу 1.1 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 115 буюу 2.3 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 130 буюу 2.6 хувийг дээрэмдэх, 170 буюу 3.4 хувийг хүнийг санаатай алах, 159 буюу 3.1 хувийг хүчиндэх, 415 буюу 8.2 хувийг хулгайлах, 295 буюу 5.8 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, **967 буюу 19.1 хувийг танхайрах, 2483 буюу 49.0 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах** хэрэг тус тус эзэлж байна.

Хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдэгсдийн 73.6 хувь нь, хүчингийн гэмт хэргийн 52.1 хувь нь, танхайн гэмт хэрэг үйлдэгсдийн 57.3 хувь нь, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг үйлдэгсдийн 37.9 хувь нь, дээрмийн гэмт хэргийн 23.6 хувь нь, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн 16.1 хувь нь, ТХХАББАЖЗ гэмт хэрэг үйлдэгсдийн 23.8 хувь нь, амиа хорлосон болон золгүй байдлаар нас барсан хүмүүсийн 17.6 хувь нь архидан согтуурсны улмаас үйлдэгджээ.

Нийт хүүхэд үйлдсэн хэргийн 14.9 хувийг, эмэгтэй хүн үйлдсэн хэргийн 11.8 хувийг, галт зэвсгээр үйлдэгдсэн хэргийн 17.1 хувийг, бүлэглэн үйлдсэн хэргийн 27.6 хувийг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хэргийн 38.9 хувийг согтуугаар үйлдсэн байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 38.9 хувь нь гэр, орон сууцанд үйлдэгдсэний 1018 нь гэрт, 431 нь хувийн байшинд, 338 нь орон сууцанд, 24.2 хувь нь гудамж талбайд

үйлдэгдсэний 598 нь гэр хороололд, 350 нь орон сууцны хороололд, 14.2 хувь нь олон нийтийн газар үйлдэгдсэний 117 нь зочид буудалд, 301 нь бааранд, 7.2 хувь нь авто замд, 2.8 хувь нь аж ахуйн нэгжид, 1.5 хувь нь төрийн болон төрийн бус байгууллагад, 0.7 хувь нь нийтийн тээвэрт, 10.4 хувь нь бусад газарт үйлдэгдсэний 161 нь хөдөө хээр үйлдэгджээ.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг гарагаар авч үзвэл, даваад 811 буюу 16.0 хувь, мягмарт 808 буюу 15.9, лхагвад 661 буюу 13.1, пүрэвт 722 буюу 14.3, баасанд 733 буюу 14.5, бямбад 658 буюу 12.9, нямд 670 буюу 13.2 хувь нь, цагаар авч үзвэл 06-14 цагийн хооронд 516 буюу 10.2 хувь, 14-19 цагийн хооронд 1083 буюу 21.4 хувь, 19-22 цагийн хооронд 1165 буюу 23.0 хувь, 22-06 цагийн хооронд 2299 буюу 45.4 хувь нь үйлдэгджээ.

Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн **4748** сэжигтнийг насны ангиллаар авч үзвэл, 14-15 насны 33, 16-17 насны 126, 18-24 насны 1394, 25-29 насны 980, 30-34 насны 783, 35-39 насны 604, 40-44 насны 377, 45-49 насны 243, 50-54 насны 124, 55-59 насны 58, 60-64 насны 17, 65-69 насны 7, 70-аас дээш насны 2 хүн;

Нийгмийн байдлын хувьд авч, үзвэл төрийн алба хаагч 183, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 482, төрийн бус байгууллагын ажилтан 110, хувиараа хөдөлмөр эрхлэгч 535, ажилчин, малчин 486, оюутан 248, сурагч 61, сургууль завсардсан 7, тэнэмэл 16, хоригдол 6, хугацаат цэргийн албан хаагч 3, эрхэлсэн ажилгүй 2611 хүн;

Боловсролоор нь авч үзвэл, боловсролгүй 157, бага боловсролтой 475, суурь боловсролтой 1213, бүрэн дунд боловсролтой 2104, техникийн болон мэргэжлийн 15, тусгай дунд 157, дээд боловсролтой 627 хүн согтуугаар тус тус гэмт хэрэг үйлдсэн байна.

Согтуугаар гэмт хэрэг үйлдэх үедээ ашигласан багаж зэвсэг хэрэгслэлийг ангилбал: тэсэрч дэлбэрэх бодис 2, ташуур 4, хүрз 19, галт зэвсэг 11, түлхүүр 22, лоом 19, олс дээс 14, зодооны хэрэгсэл 29, архины шил 130, чулуу 123, хутга мэс 610-ыг ашиглаж согтуугаар гэмт хэрэг үйлдэн, 595 тээврийн хэрэгслэлийг жолоодон явсан байна.

Согтуугаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгч 233 иргэнээс нөхөр 158, хамтран амьдрагч 24, төрсөн эцэг 4, хойд эцэг 9, төрөл садангийн хүн 11, хүргэн 8, төрсөн ах 8, эхнэр 3, төрсөн дүү 3, төрсөн хүү 5 холбогдсон байна.

Хэрэг үйлдэх үедээ өмнө нь гэмт хэрэг үйлдээд эрэн сурвалжлагдаж байсан 17, захиргааны хяналтанд байсан 16, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд шалгагдаж байсан 23, урьд ял шийтгэгдэж байсан 212 этгээд согтуугаар гэмт хэрэг дахин үйлдсэн байна.

Захиргааны зөрчил: Улсын хэмжээнд 2012 онд 795923 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 142304 буюу 21.8 хувиар, зөрчил гаргасан 751571 иргэн бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 135226 буюу 21.9 хувиар тус тус өсч, 46 албан тушаалтан, 1700 аж ахуйн нэгж, байгууллагыг 4.6 тэрбум төгрөгөөр торгож, 28718 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 13888 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Шийтгэврээр торгох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан бүх зөрчлийг хянаж шийдвэрлэсэн хууль тогтоомжоор нь авч үзвэл, 119869 буюу 98.0 хувийг “Захиргааны хариуцлагын тухай”, 2335 буюу 1.9 хувийг “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуульд зааснаар шийдвэрлэсэн байна.

Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан зөрчлийг төрлөөр нь авч үзвэл, 119869 зөрчил бүртгэгдсэний дотор хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих 95984, танхайрах 17447, согтуурах 1879, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх 1923, төрийн төлөөлөгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэхгүй байх, эсэргүүцэх 241 тус тус бүртгэгджээ.

Шийтгэврээр торгох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан 123070 зөрчлийн 94974 буюу 77.2 хувь нь зам дээр, 12698 буюу 10.3 хувь нь гэр, орон сууцанд, 6851 буюу 5.6 хувь нь гудамж талбайд, 5033 буюу 4.1 хувь нь олон нийтийн газар, 1032 буюу 0.8 хувь нь аж ахуйн нэгжид, 523 буюу 0.4 хувь нь төрийн байгууллагад, 223 буюу 0.2 хувь нь төрийн бус байгууллагад, 281 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 1455 буюу 1.2 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Шийтгэврээр торгох болон тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан 123070 зөрчилд холбогдсон хүмүүсээс 13299 хүнийг эрүүлжүүлэх байранд хүргэн эрүүлжүүлж, захиргааны журмаар 258 хүнийг түр, 121 хүнийг албадан саатуулсан байна.

Зөрчлийн улмаас хохирсон иргэдийн 7.7 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд автсан бол 382 буюу 3.5 хувь нь өөрөө архидаан согтуурсны улмаас хохирчээ.

Эрүүлжүүлэгдсэн хүн: Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 118030 хүн эрүүлжүүлсэний дотор 59529 буюу 50.4 хувь нь нийслэлд, 55868 буюу 47.3 хувь нь аймгуудад эрүүлжүүлэгдэж, үйлчилгээний төлбөрт 417.3 сая төгрөгийг төлүүлсэн байна.

Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 5419 буюу 4.6 хувь нь эмэгтэй, 1349 буюу 1.1 хувь нь 18 хүртэлх насны, 113 буюу 0.1 хувь нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.

Тэдгээрийн 1741 буюу 1.5 хувь нь хөнгөн, 109768 буюу 93.0 хувь нь дунд, 6521 буюу 5.5 хувь нь хүнд зэргийн согтолттой, 55229 буюу 46.8 хувь нь гэр, орон сууц, 51228 буюу 43.4 хувь нь гудамж талбай, 4341 буюу 3.7 хувь нь байгууллага, аж ахуйн нэгж, 3822 буюу 3.2 хувь нь баар, цэнгээний газар, 1645 буюу 1.4 хувь нь зочид буудал, 527 буюу 0.4 хувь нь үзвэр, үйлчилгээний газар, 1238 буюу 1.0 хувь нь бусад газраас тус тус эрүүлжүүлэгджээ.

Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг нийгмийн байдлаар нь авч үзвэл, 95390 буюу 80.8 хувийг ажилгүй, 4333 буюу 3.7 хувийг малчин, 9286 буюу 7.9 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 2603 буюу 2.2 хувийг хувийн хэвшлийн байгууллагад ажиллагсад, 1488 буюу 1.3 хувийг оюутан, 1539 буюу 1.3 хувийг төрийн албан хаагч, 591 буюу 0.5 хувийг төрийн бус байгууллагын ажилтан, 217 буюу 0.2 хувийг сурагч, 130 буюу 0.1 хувийг тэнэмэл, 10 буюу 0.01 хувийг сургууль завсардсан хүүхэд, 2443 буюу 2.1 хувийг бусад хүн эзэлж байна.

Тэдгээрийн 74415 буюу 63.0 хувь нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, 14569 буюу 12.3 хувь нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, 10432 буюу 8.8 хувь нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас хаана байгаага болон очих газраа мэдэхгүй болсон, 10146 буюу 8.6 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 7100 буюу 6.1 хувь нь гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй, 1368 буюу 1.2 хувь нь гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасны улмаас тус тус эрүүлжүүлэгджээ.

Мөн хугацаанд 745 хүн (Орхон 30, Өвөрхангай 19, Дархан-Уул, Булган аймаг тус бүр 6, Говь-Алтай, Дорноговь, Төв аймаг тус бүр 1, нийслэлийн Хан-Уул 150, Баянгол 139, Баянзүрх 114, Сонгинохайрхан 105, Сүхбаатар 80, Чингэлтэй 60, Налайх 20, Багануур 10, Багахангай 1, Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс 2)-ийг архины албадан эмчилгээнд хамруулсан байна.

Дүгнэлт: Улсын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн 57.1 хувь нь оройн 19.00 цагаас өглөөний 06 цагийн хооронд байгаа ба гэмт хэргийн 22.9 хувь нь архидаан согтуурснаас үйлдэгдсэн байгаа нь согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газруудад 00-06 цагт согтууруулах ундаа худалдах, үйлчлэхийг хориглосон хуулийн заалт төдийлөн хэрэгждэггүй, архины хэрэглээ ихэссэнтэй холбоотой байна.

Согтуугаар үйлдэгдсэн танхайрах, хүнийг санаатай алах, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх, бусдын биед гэмтэл учруулах хэрэг өнгөрсөн оны мөн үеийнхээс өсчээ.

Энэ нь хүн амын хэт төвлөрөл, ажилгүйдэл, ядуурал, хүмүүсийн төлөвшил, ёс суртахуун, гэр бүлийн орчин, байгууллага, хамт олон, найз нөхдийн харилцаа, нөлөөлөл зэргээс шалтгаалан архидаан согтуурах явдал улам бүр газар авч, архины хэрэглээ ба түүнээс улбаалан гарах сөрөг үр дагавар, хор уршиг нь жил ирэх тутам нэмэгдэх хандлагатай байна.

Согтуугаар үйлдэгдсэн нийт хэргийн сэжигтний 3.3 хувийг насанд хүрээгүй хүн, 29.4 хувийг 18-24 насны, 20.6 хувийг 25-29 насны залуучууд эзэлж байгаа нь гэмт хэрэг согтуугаар үйлдэгчид насны хувьд улам залуужиж байгаагийн нэг илрэл юм.

Улсын хэмжээнд давхардсан тоогоор 118030 хүн эрүүлжүүлэгдсэний 1488 нь оюутан, 217 нь сурагч, 130 нь тэнэмэл, 10 нь сургууль завсардсан хүүхэд байгаа нь хүүхэд, залуусын дунд архидаан согтуурах явдал газар авч байгааг харуулж байна.

Монголын өсвөр үеийнхний /12-17 нас/ 70.6 хувь нь согтууруулах ундааг хэрэглэж үзсэн гэж Дэлхийн зөн, Архидалт мансуурлын эсрэг ассоциацийн хийсэн судалгаагаар гарчээ. Тэдэнд согтууруулах ундааны анхны ойлголтыг гэр бүлийн хамгийн хайртай хүмүүс болох аав, ээж, ах, эгч, өвөө, эмээ нь олгодог байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 81.9 хувь нь согтууруулах ундааны хэрэглээтэй орчинд амьдардаг гэжээ.

Хүүхэд, залуучуудыг архидаан согтуурч байгааг төр засаг, төрийн бус байгууллага, цагдаагийн байгууллага, сургууль хамт олон эцэг эхчүүд бүгд мэдэж байгаа боловч тэдэнд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газруудыг бий болгох талаар хийж байгаа хийхээр бусдыг уриалан дуудсан байгууллага ч алга гэж хэлж болохоор байна.

Хүнийг санаатайгаар алах, бусдыг хүчиндэх, танхайрах 2 хэрэг тутмын 1 нь согтуугаар үйлдэгдэж байгаа бол согтуугаар гэмт хэрэг үйлдэгсдийн:

- 29.4 хувь нь 18-24 насны залуучууд,
- 54.9 хувь нь эрхэлсэн ажилгүй хүн,
- 44.3 хувь нь бүрэн дунд боловсролтой,
- Урьд ял шийтгэгдэж байсан 212 этгээд согтуугаар дахин гэмт хэрэг үйлдсэн,
- Гэмт хэрэг үйлдэх үедээ 11 галт зэвсэг, 610 хутга мэс ашигласан,
- 595 этгээд согтуугаар тээврийн хэрэгслэлийг жолоодсон,
- Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 80.8 хувь нь ажилгүй, 63.0 хувь нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, 12.3 хувь нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсоны улмаас эрүүлжүүлэгдсэн байна.

Түүнчлэн хүүхдүүд тоглоомын газар цус нөж, алаан хядаантай тоглоомд донтож, интернэтэд ямар ч хараа хяналт, хориглолтгүй насанд хүрэгчдийн сайт руу орж байгаа нь хүнийг хүндэтгэх, хайрлах үзлээс холдуулж, хувийн жаргал хөөсөн кафе, баар, караоке, диско хэссэн архи согтууруулах ундаагаар бие биеэ дайлж нэгнийгээ уруу татсан хүмүүс болон хүмүүжиж байгаа нь зөвхөн эрүүлжүүлэгдсэн 18 нас хүртэлх хүүхдийн тоо 2006 онд 175, 2007 онд 231, 2008 онд 264, 2009 онд 288, 2010 онд 956, 2011 онд 1416 болж тасралтгүй өссөн үзүүлэлт харагдаж байна. Харин 2012 онд эрүүлжүүлэгдсэн хүүхдийн тоо 1349 болж өмнөх оныхоос 4.7 хувиар буурсан эсрэг үзүүлэлттэй байна.

Архидаан согтуурахтай тэмцэх тухай хуульд 21 нас хүрээгүй бол архи худалдахыг хориглоно гэж тодорхой заасан байдаг ч үүнийг мэддэг дэлгүүрийн худалдагч баар, рестораны эзэн бараг байхгүйтэй адил болсон нь хүүхэд архидаан согтуурахын бас нэг шалтгаан болж байна.

Санал:

1. Үйлдвэр, худалдааны сайдын 2008 оны 05 тоот тушаалд 2000 хүн тутамд 1 аж ахуйн нэгж үйлчлэхээр заагдсан байдаг боловч зөвхөн Нийслэл хотын хэмжээнд спиртийн 7, архины 24, шар айргийн 11, дарсны 5 үйлдвэр үйл ажиллагаа явуулж согтууруулах ундаа худалдаж борлуулдаг, түүгээр үйлчилдэг 3600 орчим аж ахуйн нэгж байгаа нь согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоог цөөрүүлэх, ажиллах цагийн хуваарийг баримтлан ажиллах асуудлыг төр засгийн хэмжээнд дахин тавьж, шийдвэрлүүлэх; хариуцлагыг дээшлүүлэх.

2. Согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих хяналт шалгалтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, ялангуяа үйлдвэр үйлчилгээ, мэргэжлийн хяналтын байгууллагуудаас тавих хяналтыг тогтмолжуулах;

3. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран архидаан согтуурахын хор уршгаас сэрэмжлүүлсэн санамж, зөвлөмжийг иргэд, олон нийтэд хүргэж, архидалтыг багасгахад нөлөөлөхүйц арга хэмжээг оновчтой зохион байгуулах;

4. Хууль зүйн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамтай хамтран Архины хор хөнөөл, архидаан согтуурах

явдал хүний биед хэрхэн нөлөөлдөг, уураг тархинд нөлөөлсний улмаас хүн өөрийгөө жолоодох чадваргүй болж гэмт хэрэг, зөрчил үйлддэг болон түүнээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар дунд, их, дээд сургуулийн эрүүл мэндийн хичээлийн програмд түлхүү оруулах асуудлыг шийдвэрлүүлэх;

5. Эрүүлжүүлэх байранд эрүүлжүүлэгдэж байгаа хүүхэд бүртэй тулж ажиллах, тэднийг хэн хэнтэй хаана архи ууж согтуурсан, аль дэлгүүрээс архи худалдаж авсан, ямар баар, ресторанаар үйлчлүүлснийг нарийн тогтоож хүүхдэд согтууруулах ундаа зарсан, тэдэнд үйлчилсэн хүмүүст хүлээлгэх хариуцлагыг чангатгах, эрүүлжүүлэх байрны ахуй нөхцөл, материаллаг хангамжийг сайжруулах, хүүхдүүдийг эрүүлжүүлж байгаа тохиолдолд архаг архичдаас тусгаарлан үйлчлэх шийдвэр гаргуулах;

6. Орон гэргүй тэнэмэл буюу орон сууцны орц, хонгилд орогнож буй архаг архичид нь орчныг бохирдуулах, гуйлга гуйх, хог түүх, гэр орон ахуйн хүрээндээ түгшүүр төрүүлж бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, танхайрах, хүчирхийлэх гэмт хэрэг үйлдэх, өөрсдөө амь нас, эрүүл мэндээрээ хохирох явдал ихсэх хандлагатай байгаа тул эдгээр хүмүүсийг тодорхой хугацаанд нийгмээс тусгаарлан суурь өвчнийг нь эмчилж албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх боломж бүрдүүлэх зэрэг арга хэмжээг авах;

7. Зөрчил гаргаж торгуулийн хуудсаар торгогдон арга хэмжээ авагдаж байгаа хүмүүсийн ихэнх хувь архидан согтуурсан байдаг боловч торгуулийн хуудсан дээр “согтуугаар” гэсэн заалт байдаггүйг нэмж оруулах санал өмнөх жил гаргасан боловч өөрчлөгдөөгүйг шийдвэрлүүлэх;

8. Согтууруулах ундаа үйлдвэрлэж байгаа спирт, архины үйлдвэрүүдэд чанарын шалгалт явуулах;

9. Амралт, баяр ёслол, шөнө оройн цагаар баар цэнгээний газраар үйлчлүүлж байгаа хүмүүсийн дийлэнх нь сургуулийн сурагчид, оюутан, залуучууд байгаад дүгнэлт хийж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлэх дорвитой арга хэмжээг авах нь зүйтэй байна.

§6.2. Бүлэг, зохион байгуулалттай үйлдэгдсэн гэмт хэрэг

Бүлгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 2427 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 361 хэргээр буюу 17.5 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 11.0 хувь болж, 0.2 нэгжээр тус тус өсөв.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Бүлгээр үйлдэгдсэн хэрэг	2066	2427	361	17.5
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	10.8	11.0	0.2 нэгжээр өссөн	

Бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэргийн гаралт Төв, Хэнтий, Булган, Завхан, Увс, Өмнөговь, Хөвсгөл аймгууд 8.9-47.1 хувиар, нийслэлийн Сүхбаатар, Багануур, Налайх дүүрэгт 0.6-30.0 хувиар, иргэний агаарын тээврийн салбарт 50.0 хувиар тус тус буурч, Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ, Дорнод, Орхон, Сүхбаатар, Дархан-Уул, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Ховд, Говь-Алтай, Дундговь аймагт 9.5-92.3 хувиар, нийслэлд 35.0 хувиар, нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Баянзүрх дүүрэгт 12.2 хувиас 2.2 дахин тус тус өссөн байна.

Бүлгээр үйлдэгдсэн гэмт хэргийн дотор хулгайлах хэрэг 37.0, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 17.2, танхайрах хэрэг 15.0, дээрэмдэх 10.4, залилан мэхэлж авах хэрэг 3.6, ойн тухай хууль тогтоомж зөрчих хэрэг 2.4, хүчиндэх хэрэг 1.8, булаах хэрэг 1.8, завших, үрэгдүүлэх хэрэг 1.3, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэг 1.1, татвар

төлөхөөс зайлсхийх 0.9, ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих хэрэг 0.7, хүнийг санаатай алах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах хэрэг тус бүр 0.5, галт зэвсэг, байлдааны хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, хээл хахууль авах хэрэг тус бүр 0.2, хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг тус бүр 0.1 хувийг тус тус эзэлж байна.

Хэргийн 6.0 хувь нь хөнгөн, 71.0 хувь нь хүндэвтэр, 20.8 хувь нь хүнд, 2.2 хувь нь онц хүнд ангиллын хэрэг байгаа ба 17.9 хувь нь гэр, орон сууцанд, 25.3 хувь нь гудамж талбайд, 13.0 хувь нь олон нийтийн газарт, 1.1 хувь нь нийтийн тээвэрт, 1.8 хувь нь төрийн байгууллагад, 0.7 хувь нь төрийн бус байгууллагад, 8.0 хувь нь аж ахуйн нэгжид, 0.2 хувь нь авто зам дээр, 32.0 хувь нь бусад газарт, 15.3 хувь нь Даваад, 15.0 хувь нь Мягмарт, 16.1 хувь нь Лхагвад, 13.3 хувь нь Пүрэвт, 14.1 хувь нь Баасанд, 12.9 хувь нь Бямбад, 13.3 хувь нь Нямд, 10.8 хувь нь 06-14 цагт, 19.1 хувь нь 14-19 цагт, 16.9 хувь нь 19-22 цагт, 53.2 хувь нь 22-06 цагт тус тус бүртгэгджээ.

3929 хүн гэмт хэрэгт хамтран оролцсон нь өмнөх оныхоос 9.5 хувиар өссөн ба тэдний 25.9 хувь нь согтуугаар, 0.3 хувь нь галт зэвсгээр үйлдсэн, 5.7 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс байна.

Зохион байгуулалттайгаар 16 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оныхоос 14 хэргээр өссөн. Завхан, Баян-өлгий аймагт тус бүр 1, нийслэлийн Чингэлтэйд 2, Баянгол, Сүхбаатар дүүрэг, нисэхийн салбарт тус бүр 1, бусад газарт 9 хэрэг тус тус бүртгэгджээ.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах 12, галт зэвсэг, байлдааны хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх 2, бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусад төрлийн тус бүр 1 хэрэг тус тус бүртгэгджээ. Хэргийн 3 нь хүндэвтэр, 2 нь хүнд, 11 нь онц хүнд ангиллын хэрэг байгаа ба гэр, орон сууцанд 1, гудамж талбайд 3, олон нийтийн газарт 2, нийтийн тээвэрт 1, бусад газарт 9, даваа гарагт 3, мягмар гарагт 1, лхагва гарагт 7, пүрэв гарагт 1, бямба, ням гарагт тус бүр 2, 14-19 цагт 2, 22.06 цагт 14 хэрэг үйлдэгдэж бүртгэгджээ.

Урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн гэмт хэрэг 92 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 54 хэргээр буюу 2.4 дахин, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 0.4 хувь болж, 0.2 нэгжээр тус тус өсөв.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Баян-Өлгий, Сэлэнгэ аймагт 25.0-28.6 хувиар, нийслэлийн Багануур дүүрэгт 50.0 хувиар тус тус буурч, харин Төв, Хөвсгөл, Булган, Архангай аймагт 2.0-22.0 дахин, нийслэлд 3.5 дахин, нийслэлийн Баянгол, Чингэлтэй дүүрэгт 6.0-10.0 дахин тус тус өсч, Говьсүмбэр аймаг, нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт өнгөрсөн оны түвшинд байна.

Урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн гэмт хэргийн дотор мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах 31.5 хулгайлах хэрэг 18.5, дээрэмдэх, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэг тус бүр 4.3, хүн худалдаалах 3.3, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах 2.2, татвар төлөхөөс зайлсхийх, хориглосон үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэх, завших, үрэгдүүлэх хэрэг тус бүр 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Хэргийн 2.2 хувь нь хөнгөн, 51.1 хувь нь хүндэвтэр, 34.8 хувь нь хүнд, 12.0 хувь нь онц хүнд ангиллын хэрэг байгаа ба 5.4 хувь нь гэр, орон сууцанд, 16.3 хувь нь гудамж талбайд, 16.3 хувь нь олон нийтийн газарт, 2.2 хувь нь төрийн байгууллагад, 1.1 хувь нь төрийн бус байгууллагад, 28.3 хувь нь аж ахуйн нэгжид, 30.4 хувь нь бусад газарт, 35.9 хувь нь Даваад, 9.8 хувь нь Мягмарт, 15.2 хувь нь Лхагвад, 9.8 хувь нь Пүрэвт, 13.0 хувь нь

Баасанд, 5.4 хувь нь Бямбад, 10.9 хувь нь Нямд, 6.5 хувь нь 06-14 цагт, 19.6 хувь нь 14-19 цагт, 5.4 хувь нь 19-22 цагт, 68.5 хувь нь 22-06 цагт тус тус бүртгэгджээ.

112 хүн гэмт хэрэгт урьдчилан үгсэж тохиролцон оролцсон нь өмнөх оныхоос 15.5 хувиар өссөн ба тэдний 2.7 хувь нь согтуугаар, 17.9 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс байна.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, дээрэмдэх, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, хүн худалдаалах, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, татвар төлөхөөс зайлсхийх, хориглосон үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэх, завших, үрэгдүүлэх хэрэг бүлгээр үйлдэгджээ. Улс орны эрүүгийн нөхцөл байдлаас дүгнэн үзэхэд гэмт хэрэг үйлдлийн арга, хэлбэрийн хувьд бүлэг, зохион байгуулалттай, урьдчилан үгсэж тохиролцож үйлдэгдэх тохиолдолд багагүй байгаад дүгнэлт хийж эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, холбогдох албадын үйл ажиллагааг үр дүнтэй чиглүүлэх шаардлага байна.

§6.3. Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг

Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 41 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 2 хэргээр буюу 5.1 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 0.2 хувь болж, 0.1 нэгжээр тус тус өсөв.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Галт зэвсгээр үйлдэгдсэн хэрэг	39	41	2	5.1
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	0.2	0.2	Өмнөх оны түвшинд	

Хөвсгөл, Дорноговьд тус бүр 6, Говь-Алтай 5, Булган, Сэлэнгэд тус бүр 4, Төвд 3, Ховд, Хэнтийд тус бүр 2, Завхан, Увс, Баянхонгор, Өвөрхангай, Дорнод аймаг, нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Налайх дүүрэгт тус бүр 1 гэмт хэрэг галт зэвсэг ашиглан үйлдэгдсэний 27 нь хүндэвтэр, 11 нь хүнд, 3 нь онц хүнд ангиллын хэрэг байна.

Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэргийн дотор ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих 17, танхайрах 8, бусдын бие махбодид гэмтэл учруулах, хулгайлах хэрэг тус бүр 4, хүнийг санаатай алах 3, дээрэмдэх, бусдыг болгоомжгүй алах, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг тус бүр 1, бусад 2 гэмт хэрэг байна.

Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэргүүдээс гэр орон сууцанд 5, олон нийтийн газарт 2, төрийн байгууллагад 1, хөдөө хээрд 20, бэлчээрт 5, ойн сав бүхий газар, бусад газарт тус бүр 4 хэрэг үйлдэгдсэн байна.

Дээрх гэмт хэргийг гарсан гаргаар авч үзвэл, Даваад 1, Мягмарт 6, Лхагвад 5, Баасанд 8, Пүрэв, Бямба, Нямд тус бүр 7, 06-14 цагт 7.3, 14-19 цагт 34.1, 19-22 цагт 14.6, 22-06 цагт 43.9 хувь нь тус тус үйлдэгдсэн байна.

Галт зэвсгээр үйлдэгдсэн хэрэгт согтуугаар үйлдэгдсэн хэрэг 17.1, бүлэглэн үйлдсэн хэрэг 22.0 хувийг эзэлж байна.

Галт зэвсгээр үйлдэгдсэн 41 гэмт хэрэгт 38 хүн сэжиглэгдэн шалгагджээ. Тэднийг насны байдлаар авч үзвэл, 16-17 насны 1, 18-24 насны 5, 25-29 насны 5, 30-34 насны 6, 35-39 насны 8, 40-44 насны 5, 45-49 насны 4, 50-54 насны 3, 55-59 насны 1 хүн, нийгмийн байдлаар нь авч үзвэл, төрийн албан хаагч 3, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 3, төрийн бус байгууллагын ажилтан 2, малчин 11, хоригдол 1, эрхэлсэн тодорхой ажилгүй 18 хүн байна. Дээрх хүмүүсийн дотор боловсролгүй хүн 5.3, бага боловсролтой хүн 26.3, суурь боловсролтой хүн 23.7, бүрэн дунд боловсролтой хүн 31.6, тусгай мэргэжлийн боловсролтой хүн 2.6, дээд боловсролтой хүн 10.5 хувийг тус тус эзэлж байна.

Галт зэвсгээр үйлдэгдсэн хэргийн улмаас 2 хүн нас барж, 6 хүн хүнд, хөнгөн гэмтэж, 28 иргэн, 2 байгууллагад 124.3 сая төгрөгийн хохирол учирсны 89.1 хувийг нөхөн төлүүлж, 6.2 сая төгрөгийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд битүүмжилжээ.

Энэ онд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 23 дугаар зүйлээр 9 зөрчил илрүүлэн 9 хүнийг 110000 төгрөгөөр торгож, 3 галт зэвсгийг хураасан байна.

Харин Галт зэвсгийн тухай хуулиар 158 зөрчилд 158 иргэнд 2.8 сая төгрөгийн торгууль оногдуулж, 4 галт зэвсгийг хураан авч шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Галт зэвсгээр гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлөх шалтгаан нөхцөл нийгэм, эдийн засгийн, хувь хүний хөгжил зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Галт зэвсгээр ан агнуурыг хууль тогтоомж зөрчих, танхайрах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, хулгайлах гэмт хэргүүд голлон үйлдэгдэж, эдгээр нь нийгмийн ядуурал ажилгүйдэл, архидан согтуурахтай холбоотойгоор үйлдэгдэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь тухайн үед гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийн санаа бодол, зорилго сэдлээс хамаарч харилцан адилгүй байна. Цагдаагийн байгууллагын зүгээс галт зэвсгээр үйлдэгдэж байгаа гэмт хэргийн судалгааг гаргах, нөхөн илрүүлэх, эрэн сурвалжлагдаж байгаа болон алдагдсан галт зэвсгийн бүртгэлийг нэг мөр болгох, бүртгэлд хамрагдаагүй галт зэвсгийг илрүүлэх, гэрчилгээжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж байгаа хэдий ч ажлын үр дүн иргэдийн аюулгүй байдлын баталгаа болж чадахгүй байна.

Галт зэвсгийн тухай хуульд галт зэвсгийг хэрхэн хадгалах, аюулгүй байдлыг хангах талаар тодорхой зааж өгсөн байдаг хэдий ч энэ нь амьдралд бүрэн хэрэгждэггүй энгийн нэг хөрөөг бусдад дамжуулан хэрэглэж байгаа мэтээр бусдын гар дамжуулдаг, өөрийн эзэмшилд байгаа галт зэвсгийг улсын бүртгэлд хамруулдаггүй, хэлбэр загварыг нь өөрчилдөг гэх мэтийн зөрчил, дутагдал иргэдийн дунд байсаар байна. Энэ нь иргэдийн дунд хууль сурталчлах ажил дутмаг байгааг харуулж байна.

§6.4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 534 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 114 хэргээр буюу 27.1 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 2.4 хувь болж, 0.8 нэгжээр тус тус өсөв.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг	420	534	114	27.1
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	2.2	2.4	0.2 нэгжээр өссөн	

Орхонд 39, Дорнод, Хэнтийд тус бүр 22, Өвөрхангайд 17, Өмнөговьд 13, Дорноговьд 9, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөлд тус бүр 8, Сэлэнгэд 6, Говьсүмбэрт 4, Дундговь, Говь-Алтайд тус бүр 3, Булган, Ховдод тус бүр 2, Төв, Сүхбаатар, Дархан-Уулд тус бүр 1, нийслэлд 365, нийслэлийн Баянзүрх дүүрэгт 139, Баянгол дүүрэгт 96, Хан-Уул дүүрэгт 68, Сүхбаатар дүүрэгт 35, Багануур дүүрэгт 12, Сонгинохайрхан дүүрэгт 9, Чингэлтэй дүүрэгт 6 гэмт хэрэг гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэн бүртгэгдсэн ба **76.4 хувийг хөнгөн**, 13.5 хувийг хүндэвтэр, 6.9 хувийг хүнд, 3.2 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэн бүртгэгдсэн хэргийн дотор бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 477 буюу 89.4, хүнийг санаатай алах хэрэг 15 буюу 2.8,

танхайрах хэрэг 14 буюу 2.6, хүчиндэх хэрэг 13 буюу 2.4, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 1 буюу 0.2, бусад төрлийн хэрэг 14 буюу 2.6 хувийг тус тус эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт хэргийн 208 буюу 38.9 хувь нь согтуугаар, 38 буюу 7.1 хувь нь эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэргийн 78 буюу 14.6 хувь нь Даваа, 85 буюу 15.9 хувь нь Мягмар, 69 буюу 12.9 хувь нь Лхагва, 82 буюу 15.4 хувь нь Пүрэв гарагт, 73 буюу 13.7 хувь нь Баасан, 67 буюу 12.5 хувь нь Бямба, 80 буюу 15.0 хувь нь Ням гарагт, 15.0 хувь нь 06-14, 24.3 хувь нь 14-19, 22.7 хувь нь 19-22, 38.0 хувь нь 22-06 цагт, гэр, орон сууцанд 86.1, гудамж талбайд 3.7, олон нийтийн газарт 5.2, нийтийн тээвэрт 0.4, төрийн байгууллагад 0.2, аж ахуйн нэгжид 1.0, бусад газар 3.4 хувь нь тус тус үйлдэгджээ.

Гэр бүлийн хүчирхийлэлд 536 иргэн өртөж хохирсны 86.7 хувь нь эмэгтэй, 0.6 хувь нь 7 хүртэлх насны, 2.0 хувь нь 8-13 насны, 1.7 хувь нь 14-17, 14.9 хувь нь 18-24, 23.7 хувь нь 25-29, 22.4 хувь нь 30-34, 16.6 хувь нь 35-39, 7.5 хувь нь 40-44, 5.4 хувь нь 45-49, 3.0 хувь нь 50-54, 2.2 хувь нь 55-аас дээш насны хүн байна

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас 17 хүн нас барж, 436 хүн гэмтэж, иргэдэд 112.8 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсаны 86.9 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, 3.1 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилжээ.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн бүх гэмт хэрэгт 19734 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсаны дотор 527 буюу 2.7 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч байх ба тэдний 34.2 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлджээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийг нас, нийгмийн байдал, боловсролоор нь ангилж үзвэл, 14-15 насны 1, 16-17 насны 2, 18-24 насны 59, 25-29 насны 117, 30-34 насны 125, 35-39 насны 103, 40-44 насны 60, 45-49 насны 31, 50-54 насны 22, 55-аас дээш насны 7, төрийн албан хаагч 34, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 93, хувиараа хөдөлмөр эрхлэгч 83, төрийн бус байгууллагын ажилтан 11, малчин 30, оюутан 7, сурагч 1, ажилгүй 268 хүн байгаа ба тэдгээрийн 1.7 хувь нь боловсролгүй, 5.5 хувь нь бага, 17.3 хувь нь суурь, 45.9 хувь нь бүрэн дунд, 0.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 26.4 хувь нь дээд боловсролтой хүн байна.

Хөгжлийг дагасан саар явдал Монголын нийгэмд байсаар байна. Үүний нэг илрэл нь хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүрэн дэх хүчирхийлэл, дарамт элбэг байна. Хувь хүний ухамсар, төлөвшил, хүмүүжил, амьдралын боломж нөхцөлөөс хамаараад хүчирхийлэл бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн, бие махбодийн хүчирхийлэл байна. Төр засаг, холбогдох байгууллагаас хүчирхийлэлтэй тэмцэж, хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж байгаа ч энэ сөрөг явдал арилахгүй, таслан зогсоогдохгүй байна. Энэ нь цаана улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хувь хүний хөгжилтэй холбоотой. Үүний жишээ нь 2012 онд эхнэрээ байнга хүчирхийлэл, дарамтад байлгаж, улмаар амь насыг хөнөөсөн гэмт хэрэг юм.

Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр явуулж, гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага байна.

§6.5. Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 6450 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 484 хэргээр буюу 8.1 хувиар өсч, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 29.2 хувь болж, 1.9 нэгжээр буурчээ.


Сард дунджаар 537, хоногт 17 гэмт хэрэг гэр, орон сууцанд үйлдэгдэж байна.

Д/д	Үзүүлэлт	2011 он	2012 он	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар

1	Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг	5966	6450	484	8.1
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	31.1	29.2	1.9 нэгжээр буурсан	


Гэр, орон сууцанд 6450 гэмт хэрэг үйлдэгдсэний дотор гэрт 2643, орон сууцны байранд 1437, хувийн байшинд 1343, зуслангийн байшинд 87, хауст 17, гражд 108, амбаарт 105, агуулахад 39, орцонд 289, подвалд 59, бусад газарт 323 байна.

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэргийн 60.0 хувь нь нийслэл хотод, 39.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.




Гэмт хэргийн гаралт Дорнод, Говьсүмбэр, Өвөрхангай, Говь-Алтай, Баян-Өлгий аймагт 31.6-53.9 хүртэл хувиар тус тус өсч, Сүхбаатар, Увс, Баянхонгор аймагт 9.7-29.1 хүртэл хувиар тус тус буурсан байна.

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэргийг ангиллаар нь авч үзвэл:



**Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг
/Эрүүгийн хуулийн зүйлээр/**



Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 29,2 хувь нь гэр, орон сууцанд үйлдэгдсэн байна. Эрүүгийн хуулийн зүйл тус бүрд эзлэх хувийг үзүүлбэл:



Иргэд гэр орондоо архи согтууруулах ундаа хэрэглэж, ахуйн хүрээнд үүссэн хэрүүл маргаан нь танхайрах, хүнийг санаатай алах, бусдын бие махбодид гэмтэл учруулах зэрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл болж байна.

§6.6. Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг


2012 онд улсын хэмжээнд олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг **2944** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 267 хэргээр буюу 10.0 хувиар өсч, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 13.3 хувь болж, 0.6 нэгжээр буурчээ.

Сард дунджаар 245, хоногт 8 гэмт хэрэг олон нийтийн газарт үйлдэгдсэн байна.


д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг	2677	2944	267	10.0
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	13.9	13.3	0.6 нэгжээр буурсан	

Улсын хэмжээний олон нийтийн газарт үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 73.6 хувь нь нийслэлд, 25.3 хувь нь хөдөө, орон нутагт, 1.1 хувь нь бусад газарт үйлдэгджээ.


Үйлдэгдсэн газраар



Өсөлт бууралт



Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр



Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 1161 гэмт хэрэг бүртгэгдэж, 631 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдож, илрүүлэлт 54,3 хувьтай байна.


Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэгт 2572 хүн холбогдон шалгагдсаны 21.3 хувь нь эмэгтэй, 8.1 хувь нь хүүхэд, 37.1 хувь нь 18-24 насны, 19.7 хувь нь 25-29 насны, 30.5 хувь нь хувиараа болон хувийн хэвшилд тодорхой эрхэлсэн ажилтай, 5.8 хувь нь оюутан, 4.0 хувь нь сурагч байна. Эдгээр хүмүүсийн 25.8 хувь нь согтуугаар, 20.3 хувь нь бүлэглэн, 4.4 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс байжээ.

Тус газарт үйлдэгдсэн гэмт хэргийн халдлагад **2915** иргэн, **6** байгууллага өртөж, **3.4** тэрбум төгрөгийн хохирол учирч, түүний 54.6 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба 19 хүн нас барж, 1227 хүн эрүүл мэндээрээ хохирчээ.


1. Нийслэлийн нөхцөл байдал: Нийслэлийн хэмжээнд 2012 онд олон нийтийн газарт **2167** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 309 хэргээр буюу 16.6 хувиар өссөн статистик үзүүлэлттэй гарсан байна. Нийслэлд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 16.8 хувийг эзэлж байна.

Сард дунджаар 180, хоногт 6 гэмт хэрэг олон нийтийн газарт үйлдэгдсэн байна.


Үйлдэгдсэн газар




Өсөлт бууралт



Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр



Нийслэлийн дүүргүүдэд үйлдэгдсэн гэмт хэрэгт олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувийг үзвэл: (Дүүргүүдийн цагдаагийн 1, 2 дугаар хэлтсээр харуулав)



Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг 902 бүртгэгдэж, 466 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдож, илрүүлэлт 51.7 хувьтай байна.

Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэгт 1775 хүн холбогдон шалгагдсаны 22.0 хувь нь эмэгтэй, 6.0 хувь нь хүүхэд, 39.7 хувь нь 18-24 насны, 19.2 хувь нь 25-29 насны, 33.9 хувь нь хувиараа болон хувийн хэвшилд тодорхой эрхэлсэн ажилтай, 6.5 хувь нь оюутан, 1.9 хувь нь сурагч байна. Эдгээр хүмүүсийн 19.7 хувь нь согтуугаар, 16.9 хувь нь бүлэглэн, 4.7 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс байжээ.

Тус газарт үйлдэгдсэн гэмт хэргийн халдлагад 2141 иргэн, 3 байгууллага өртөж, 2.8 тэрбум төгрөгийн хохирол учирч, түүний 53.6 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба 10 хүн нас барж, 890 хүн эрүүл мэндээрээ хохирчээ.

Дүгнэлт, анхаарах асуудал: Улсын хэмжээнд олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэргийн дийлэнх хувь нь нийслэлд үйлдэгдсэний дотор баар, дэлгүүр, зочид буудал, нийтийн зах, бөөний худалдааны төвд бусдын бие махбодид гэмтэл учруулах, хулгайлах, танхайрах, залилан мэхлэх, дээрэмдэх, хүчиндэх гэмт хэргийн гаралт харьцангуй өндөр байна. Иймд Архидан согтуурахтай тэмцэх тухай болон холбогдох хуулийг чанд мөрдүүлэх, эргүүл хяналтыг оновчтой зохион байгуулах, олон нийтийн газрыг хяналтад авах ажлыг эрчимжүүлэх шаардлага байна.

§6.7. Аж ахуйн нэгж, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал


Улсын хэмжээнд 2012 оны байдлаар *аж ахуйн нэгжид 1681 гэмт хэрэг* үйлдэгдсэн нь (*нийт гэмт хэргийн 7.6 хувь*) өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 527 хэргээр буюу **45.7 хувиар өссөн**. Сард дунджаар 140, долоо хоногт 35 гэмт хэрэг олон аж ахуй нэгж, байгууллагад үйлдэгдэж байна. (*2008 онд 2.5 хувь, 2009 онд 5.6 хувь, 2010 онд 16.8 хувь, 2011 онд 1.3 хувь тус тус өссөн байна*)

Нийслэл хотод **1220** буюу 72.5 хувь, түүнээс нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт хамгийн их буюу 242 гэмт хэрэг, 21 аймгаас Архангай аймагт хамгийн их буюу 62 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн ангиллын хувьд:
681 буюу 40.5 хувийг хөнгөн, 774 буюу 46.0 хувийг хүндэвтэр, 164 буюу 9.7 хувийг хүнд, 62 буюу 3.7 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Гэмт хэргийн илрүүлэлт:
Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 622 гэмт хэрэг бүртгэгдэж, 308 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдож, **илрүүлэлт 49.5** (*урьд оноос 1.6 хувиар буурсан*), хэргийн ангиллаар авч үзвэл, хөнгөн хэргийн илрүүлэлт 48.9, хүндэвтэр хэргийн илрүүлэлт 52.1, хүнд хэргийн илрүүлэлт 48.2, онц хүнд хэргийн илрүүлэлт 46.6 хувиар тус тус илрүүлэлттэй байна.

Гэмт хэрэг үйлдэгдэн гарсан газрын хувьд: Үйлдвэрийн газарт **294 (17.4)**, арилжааны банканд **155 (9.2)**, хадгаламж зээлийн хоршоо 9 (0.5), валют арилжааны цэг 4 (0.2), банк бус санхүүгийн байгууллага 19 (1.1), тооцооны төв 29 (1.7), хамгаалалтын алба 5 (0.2), засвар үйлчилгээний газарт 49 (2.9), ашигт малтмал, геодези, зураг зүйн 36 (2.1), шатахуун түгээх станцад 26 (1.5), нотариатад 12 (0.7), төрийн өмчийн их, дээд сургуульд 24 (1.4), төрийн өмчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 10 (0.6), төрийн өмчийн коллеж 4 (0.2), төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль 48 (2.8), төрийн өмчийн хүүхдийн цэцэрлэг



14 (0.8), төрийн өмчийн эмнэлэг 40 (2.3), төрийн өмчийн оношилгооны төв 1 (0.05), хувийн өмчийн ерөнхий боловсролын сургууль 13 (0.8), хувийн өмчийн их дээд сургууль 25 (1.5), хувийн өмчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 1 (0.05), хувийн өмчийн эмийн сан 14 (0.8), хувийн өмчийн оношилгооны төв 3 (0.2), хувийн өмчийн хүүхдийн цэцэрлэг 3 (0.2), хувийн өмчийн эмнэлэгт 10 (0.6), **бусад газарт 833 (49.5)** хувийг тус тус эзэлж байна.

Аж ахуй нэгж байгууллагад үйлдэгдсэн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хэрэг өссөн үүний дотор үйлдвэрийн газарт үйлдэгдсэн 58 хэргээр (24.6%), арилжааны банканд 66 хэргээр (74.2%), банк бус санхүүгийн байгууллагад 6 хэргээр (46.2%), тооцооны төв 16 хэргээр (2.2%), засвар үйлчилгээний газарт 16 хэргээр (48.5%), ашигт малтмал, геодези, зураг зүйн 5 хэргээр (16.1%), нотариат 5 хэргээр (71.4%), төрийн өмчийн их дээд сургуульд 4 хэргээр (20.0%), төрийн өмчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 6 хэргээр (2.5 дахин), төрийн өмчийн хүүхдийн цэцэрлэг 6 хэргээр (75.0%), төрийн өмчийн эмнэлэг 5 хэргээр (14.3%), хувийн өмчийн их, дээд сургууль 7 хэргээр (38.9%), хувийн өмчийн эмийн сан 1 хэргээр (7.7%), бусад **345 хэргээр (70.7%)** тус тус өссөн, хамгаалалтын алба 3 хэргээр (37.5%), шатахуун түгээх станц 9 хэргээр (25.7%), төрийн өмчийн коллеж 1 хэргээр (20.0%), хувийн өмчийн ерөнхий боловсролын сургууль 4 хэргээр (7.7%), хувийн өмчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2 хэргээр (66.7%), хувийн өмчийн хүүхдийн цэцэрлэг 1 хэргээр (25.0%), хувийн өмчийн эмнэлэг 2 хэргээр (16.7%) тус тус буурсан, хувийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, валют арилжааны цэгт өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд байна.

Гэмт хэргийн бүтцийн хувьд: 318 нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (үүнээс 5 нь хүнийг санаатай алах, 11 нь бусдыг амиа хорлоход хүргэх, 297 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах), 1049 нь өмчлөх эрхийн эсрэг, (үүнээс, 501 нь хулгай, 7 нь булаах, 20 нь дээрэмдэх, 290 нь залилан мэхлэх, 118 нь завших үрэгдүүлэх), 80 нь ах ахуйн эсрэг, (үүнээс 57 нь татвар төлөхөөс зайлсхийх), 36 нь танхайрах, 56 нь хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, 4 нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 46 нь захиргааны журмын эсрэг гэмт хэрэг бүртгэгджээ.

Гэмт хэрэг үйлдэгдсэн зарим онцлог: 1387 хүн холбогдон шалгагдсаны 27.9 хувь нь эмэгтэй, 5.4 хувь нь хүүхэд, 21.4 хувь нь 18-24 насны, 16.9 хувь нь 25-29 насны, 15.0 хувь нь 30-34, 11.6 хувь нь 35-39, 8.6 хувь нь 45-49, 6.0 хувь нь 50-54, 42.1 хувь нь ажилгүй, 26.3 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 1.6 хувь нь ажилчин малчин, 4.0 оюутан, 13.6 хувь нь хувиар хөдөлмөр эрхлэгч байна. Эдгээр хүмүүсийн 39.7 хувь нь бүрэн дунд, 33.4 хувь нь дээд, 16.7 хувь нь суурь, 4.3 хувь нь бага боловсролтой хүмүүс байжээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол: Тус газарт үйлдэгдсэн гэмт хэргийн халдлагад 1474 иргэн, 49 байгууллага өртөж, 14.6 тэрбум төгрөгийн хохирол учирч, түүний 31.4 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, 800 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн ба 25 хүн нас барж, 303 хүн эрүүл мэндээрээ хохирчээ.

Шалтгаан нөхцөл: Аж ахуйн нэгж байгууллагад гэмт хэрэг үйлдэгдэхэд ажилгүйдэл, ядуурал, архидалт зэрэг нийтлэг шалтгаан нөхцөл нөлөөлж байгаагаас гадна аж ахуйн нэгж байгууллагын дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, хувь хүний хөгжил, оршин байгаа гадаад орчинтой холбоотой зарим хүчин зүйлс нөлөөлж байна.

Аж ахуйн нэгж байгууллагын хувьд:

- Аж ахуй нэгжид ажиллаж байгаа ажилтантай ажил олгогч гэрээ хийдэггүй, хийсэн ч үр дүн тооцож ажилладаггүй, түүгээр хүнээ хариуцлагажуулах бодлого төлөвшөөгүй,

- Хөгжил, дэвшлийнхээ стратегийг дэмжсэн, хууль тогтоомжийн заалттай нийцсэн байгууллагын дотоод журам төгс боловсруулагдаагүй, байгаа дотоод журмаа хэрэгжүүлэх явдал хангалтгүй,

- Харуул хамгаалалт, камержуулалтын талаар бодлогоо ончтой тодорхойлж хэрэгжүүлдэггүй, дотоодын хяналт, сонор сэрэмж сул,

- Хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжүүлэх явдал дутагдалтай,

Боловсролын байгууллагын хувьд:

- Багш сурган хүмүүжүүлэгч нар хүүхэд бүрт хүрч ажилладаггүй, сургууль эцэг эхийн зүгээс хүүхдийн хүмүүжлийн төлөвшил, сурлагын талаарх хамтын ажиллагаа орхигдсон,
- Хүүхдийн чиглэлээр зохиогдох ажлын хүртээмж дутмаг, шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа,
- Сургуулийн хүрээнд бүлэг бөөгнөрөл үүсгэх, нэгнийгээ уруу татах, бусдыг дарамтлах явдал гардаг,
- Сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин дутмаг,
- Их, дээд, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчинд согтууруулах ундааны зүйлээр үйлчилдэг цэг олноор бий болсон, тэр нь оюутан, сурагчдад муу нөлөө үзүүлж архидан согтуурах, түүнд татагдан орох нөхцөл бий болсон.

Хувь хүний хувьд:

- Хууль, эрх зүйн мэдлэг, нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагын төлөвшил,
- Хувь хүний мэдлэг боловсролын түвшин, хүмүүжлийн доголдол,
- Харилцааны соёл, аж төрөх зан үйл төлөвшил,
- Амар хялбар аргаар амьдрах, мөнгө олох, бусдыг хуурах, залилан мэхлэх сэдэл зэрэг нөхцөл байдал нөлөөлж байна.

Цаашид анхаарах асуудал: Аж ахуйн нэгжид үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлд тулгуурлан урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах асуудалд анхаарах нь зүйтэй байна.

• Аж ахуйн нэгж байгууллага бүр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” Монгол улсын хуульд заасан нийтлэг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, байгууллагын дотоод үйл ажиллагаандаа хууль тогтоомжийн заалтыг чанд мөрдөх, аюулгүй байдлаа бүрэн хангаж, хариуцлага, сонор сэрэмжээ дээшлүүлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг өгч хэрэгжилтийг хангуулах;

• Аж ахуйн нэгж, байгууллагын гадна, дотно талбай, орчинг гэрэлтүүлэх, хаалга, цонхны бэхэлгээг сайжруулах, камержуулах, харуул хамгаалалтыг чангатгах чиглэлээр зөвлөмж, шаардлага өгч гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

• Гэмт хэрэг үйлдэгдсэн болон ажилтан, алба хаагчдаас нь гэмт хэрэг үйлдсэн тохиолдол бүрт түүний шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх ажил зохиолгох талаар мөрдөн байцаагчийн мэдэгдэл өгөх, түүний мөрөөр зохиох ажлын үр өгөөжийг дээшлүүлэхэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэхэд анхаарах;

• Их, дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургуулиудын ойр орчмын автомашины зам талбайг хүүхэд аюулгүй зорчих нөхцөл бололцоог бүрдүүлж тохижуулах, согтууруулах ундааны зүйлээр үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээний горимд хязгаарлалт тогтоолгох, хэрэгжилтэд хяналт тавих;

• Аж ахуйн нэгж байгууллагууд түүний дотор гэмт халдлагад өртөж болзошгүй байгууллагуудыг эргүүлийн чиглэлд хамруулах, нутаг дэвсгэрээр нь хариуцсан хэсгийн байцаагч нараас тавих хяналт, шалгалтыг тогтмолжуулах шаардлагатай байгааг илтгэн танилцуулъя.

§6.8. Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг **3764** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 252 хэргээр буюу 7.2 хувиар өсчээ.

Сард дунджаар 313, хоногт 10 гэмт хэрэг гудамж талбайд үйлдэгдэж байна.


д/д	Үзүүлэлт	2011 он	2012 он	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар

1	Гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг	3512	3764	252	7.2
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	18.3	17.0	1.3 нэгжээр буурсан	

Гудамж талбайд **3764** хэрэг үйлдэгдсэний дотор гэр хорооллын гудамжинд 1513, орон сууцны хорооллын гудамжинд 1147, тоглоомын талбайд 16, ил зогсоолд 374, цэцэрлэгт хүрээлэнд 23, автобусны буудалд 205, төмөр замд 5, бусад газарт 481 байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн 69.6 хувь нь нийслэл хотод, 29.9 хувь нь орон нутагт, 0.5 хувь нь бусад газарт бүртгэгдсэн байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийг газар нутгийн байдлаар авч үзвэл:




Тус газарт үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт Дорнод, Завхан, Сэлэнгэ аймаг, Замын-Үүд суманд 17.2-57.1 хүртэл хувиар өсч, Увс, Дундговь, Говьсүмбэр, Ховд аймагт 28.1-40.0 хүртэл хувиар тус тус буурсан байна.

Нийслэлд Баянзүрх дүүргийн 2 дугаар хэлтсийн нутаг дэвсгэрт 17.9, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт 18.2, тус дүүргийн 2 дугаар хэлтсийн нутагт 33.6, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хэлтсийн нутагт 29.2 хувиар тус тус өсч, Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хэлтсийн нутагт 11.6, Хан-Уул дүүргийн 2 дугаар хэлтсийн нутагт 6.7, Баянзүрх дүүргийн 1 дүгээр хэлтсийн нутагт 4.6 хувиар тус тус буурсан байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийг ангиллаар нь авч үзвэл



Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн зүйлээр үзүүлбэл:



Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 17,0 хувь нь, үүний дотор булаах хэргийн 51.8, дээрэмдэх хэргийн 59.7, танхайрах хэргийн 36.5 хувь нь гудамж талбайд үйлдэгджээ.



Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн илрүүлэлт зарим газарт өндөр байгаа ч гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажилд анхаарах хэрэгтэй.

Гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалтай холбогдуулан эргүүлийн үйл ажиллагааг шуурхай, оновчтой болгох асуудлыг судлан үзэх нь зүйтэй.

§7. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙН ОНЦЛОГ

§7.1. Ажилгүй хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал

Улсын хэмжээнд 2012 онд нийт гэмт хэргийн **9380** буюу **42.5** хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй **10398** хүн үйлдсэн нь өмнөх оныхоос 310 хүнээр буюу 3.1 хувиар өсчээ. Нийт гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 52.7 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс эзэлж байна.

Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Нийт гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн тоо	17982	19734	1752	9.7
2	Гэмт хэрэг үйлдсэн ажилгүй хүмүүсийн тоо	10088	10398	310	3.1

3	Гэмт хэрэг үйлдсэн нийт хүмүүсийн дунд ажилгүй хүмүүсийн эзлэх хувь	56.1	52.7	-3.4 нэгжээр буурсан
---	---	------	------	----------------------

Гэмт хэрэг үйлдсэн ажилгүй хүмүүсийн 56.6 хувь нь нийслэлд хотод, үлдсэн 43.4 хувь нь орон нутагт байна. Ялангуяа Сэлэнгэ, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Төв, Орхон, Хэнтий аймгуудад тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд гэмт хэрэг ихээр үйлджээ.

Ажилгүй иргэдээс үйлдсэн гэмт хэргийн гаралт хөдөө орон нутагт байгалийн баялаг, ашигт малтмал ихтэй аймгуудад тухайлбал Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Дорнод, Дорноговьт, нийслэлд гэр хороолол, хөдөө орон нутгаас шилжин суурьшигчид, нийгмийн эмзэг давхаргынхан олонтой, эрүүгийн ерөнхий нөхцөл байдал хүнд нутаг дэвсгэрт хамаарагдах Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт өндөр байна.

Ажилгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн 31.8 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 26.3 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, 8.9 хувийг танхайрах, 2.7 хувийг дээрэмдэх, 5.1 хувийг залилан мэхэлж авах, бусад 25.2 гэмт хэрэг эзэлж байна.

Тэдгээрийн 29.3 хувь нь архи дан согтуурсаны улмаас, 12.1 хувь нь бүлэглэн гүйцэтгэж гэмт хэрэг үйлджээ.

Ажилгүй иргэдийн үйлдсэн нийт гэмт хэргийн дийлэнх хувь буюу 34.2 гэр орон сууцанд, 18.0 хувь нь гудамж талбай, , 12.8 хувь нь олон нийтийн газар, 8.6 хувь нь авто замд, 5.4 хувь нь аж ахуйн нэгжид, 1.3 хувь нь нийтийн тээвэрт, 1.1 хувь төрийн байгууллага, 0.9 хувь нь төрийн бус байгууллага, 17.7 хувь нь бусад газарт шөнө оройн цагаар согтуугаар үйлдэгдсэн нь дээрх шалтгаан нөхцөлтэй холбоотой юм.

Нөгөө талаас нь буюу тодорхой төрлийн гэмт хэргийн тухайд бичихэд хүнийг санаатай алах (1.3%), бусдын бие махбодид гэмтэл учруулах (31.8%), хүчиндэх (1.8%), хулгайлах (26.3%), үүний дотор халаасны хулгай (0.9%), малын хулгай (50.0%), авто тээврийн хэрэгслийн хулгай (0.7%), халаасны хулгай (0.9%), булаах (0.7%), дээрэмдэх (2.7%), залилан мэхэлж авах (5.1%), танхайрах (8.9%) гэмт хэргийг ихэвчлэн тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс үйлдсэн байна.

Ажилгүйдэл, нийгмийн ядуурал, архидалтыг даган гарах гэмт хэргийн тоо, ялангуяа бусдын эд хөрөнгийг хулгайлах, дээрэмдэх, залилан мэхлэх, танхайрах гэмт хэрэг буурахгүй байгаа бөгөөд эдгээр гэмт хэргийг үйлдэгчдийн дунд ажилгүй иргэд өндөр хувь эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд нийгэмд ядуурал газар авч, ядуу, нэн ядуу, амьдралын баталгаажих төвшнөөс доогуур орлоготой өрх, ажилгүй иргэд хүн амын дийлэнх хувийг эзлэх болж, эдгээр иргэдийн дунд архи дан согтуурах явдал нэмэгдэж байна.

Ажилгүй иргэдийн дотроос боловсролын байдлаар нь харахад дийлэнх хувийг бүрэн дунд, боловсролгүй иргэд үйлдэж байгаа нь нийгмийн ядуурлыг даган хүүхдийн хүмүүжил муудаж, хүмүүсийн мөс чанар доройтож, нийгмийн хэт хавтгайрсан халамжаас үүдэн бэлэнчлэх сэтгэлгээтэй, амар хялбар аргаар мөнгө олж амьжиргаагаа залгуулах хүсэлтэй, бүтээлч бус сэтгэлгээтэй, залхуу хойрго байдал нь эрүүгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх тал байна.

§7.2. Эмэгтэйчүүдээс гэмт хэрэг үйлдсэн байдал

Эмэгтэйчүүдээс үйлдсэн гэмт хэрэг **2761** бүртгэгдсэн нь өмнөх оныхоос **1270** хэргээр буюу **85.2** хувиар өсч, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 12.5 хувь болж, 4.7 нэгжээр өсөв.


Д/д	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Эмэгтэйчүүдээс үйлдсэн гэмт хэрэг	1491	2761	1270	85.2

Эмэгтэйчүүдээс үйлдсэн гэмт хэрэг Дархан-Уулд 79, Дорноговьд 73, Сэлэнгэд 84, Орхонд 90, Өмнөговьд 37, Баянхонгор 32, Ховдод 35, Өвөрхангайд 39, Хөвсгөлд 37, Архангайд 40, Төвд 65, Дорнодод 53, Хэнтийд 45, Булганд 18, Баян-Өлгий 26, Завхан 21, Говь-Сүмбэрт 22 ус бүр 23, Дундговьд 13, Увсад 16, , Сүхбаатарт 10, Говь-Алтайд 11, нийслэлд 1861, үүнээс Баянголд 407, Сүхбаатарт 324, Чингэлтэйд 256, Баянзүрхэд 348, Хан-Уулд 200, Сонгинохайрханд 230, Налайхад 51, Багануурт 41, Багахангайд 4, төмөр замын салбарт 30, иргэний агаарын бүсэд 3, бусад газарт 21 бүртгэгджээ.

Хөвсгөл, Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Дорнод, Орхон, Завхан, Өвөрхангай, Баян-Өлгий, Дундговь, Хэнтий Говь-Алтай, Булган Баянхонгор, Увс, Архангай, аймагт 10.0 хувиас 3.6 дахин, нийслэлд 96.3 хувь, нийслэлийн дүүргүүдэд 52.8-2.9 дахин өсч, Дархан-Уул аймагт 1.3 хувиар буурсан байна.

Эмэгтэйчүүдээс үйлдсэн гэмт хэргийн дотор 31.8 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 14.8 хувийг залилан мэхэлж авах, 13.9 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, 7.9 хувийг бусад хэрэг, 6.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, 4.6 хувийг завших, үрэгдүүлэх, 4.2 хувийг танхайрах, 3.8 хувийг хүн амын эрүүл мэндийн эсрэг, 2.9 хувийг захиргааны журмын эсрэг, 2.2 хувийг аж ахуйн эсрэг, 2.0 хувийг үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 1.6 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг, 0.9 хувийг тус тус хүнийг санаатай алах, хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, 0.7 хувийг иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, 0.4 хувийг дээрэмдэх, 0.3 хувийг тус бүр хүн худалдах, бусдын эд хөрөнгө булаах, 0.2 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 0.1 хувийг бусдыг болгоомжгүй алах гэмт хэрэг эзэлж байна.

Эмэгтэй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг
/Эрүүгийн хуулийн зүйлээр/



Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 595 гэмт хэргээс 498 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 83.7 хувьтай байна.

Эмэгтэй хүмүүсийн үйлдсэн хэргийн:

- 60.0 хувь нь хөнгөн, 36.2 хувь нь хүндэвтэр, 6.5 хувь нь хүнд, 3.4 хувь нь онц хүнд ангиллын,
- 30.9 хувь нь гэр орон сууцанд, 24.2 хувь нь олон нийтийн газарт, 11.2 хувь нь гудамж талбайд, 11.0 хувь нь аж ахуйн нэгжид, 9.0 хувь нь бусад газарт, 5.4 хувь нь

төрийн байгууллагад, 4.2 хувь нь төрийн бус байгууллагад, 3.2 хувь нь авто замд, 0.9 хувь нь нийтийн тээвэрт,

- 18.1 хувь нь Даваа гарагт, 15.9 хувь нь Лхагва гарагт, 15.0 хувь нь Баасан гарагт, 14.5 хувь нь Пүрэв гарагт, 14.0 нь Мягмар гарагт, 11.5 хувь нь Бямба гарагт, 11.0 хувь нь Ням гарагт,
- 34.0 хувь нь 14-19 цагт, 26.0 хувь нь 22-06 цагт, 25.0 хувь нь 06-14 цагт, 15.0 хувь нь 19-22 цагт,

Эмэгтэйчүүд оролцсон 2761 гэмт хэрэгт, 2667 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 3.3 хувиар буурсан ба тэдний 11.6 хувь нь бүлэглэж, 10.8 хувь нь согтуугаар, 1.5 хувь нь урьд ял шийтгэгдэж байжээ.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан эмэгтэйчүүдийн 1.0 хувийг 14-15 насны, 3.0 хувийг 16-17 насны, 21.5 хувийг 18-24 насны, 16.6 хувийг 25-29 насны, 14.0 хувийг 30-34 насны, 14.9 хувийг 35-39 насны, 11.6 хувийг 40-44 насны, 8.9 хувийг 45-49 насны, 5.3 хувийг 50-54 насны, 1.8 хувийг 55-59 насны, 0.6 хувийг 60-64 насны, 0.2 хувийг 65-69 насны, 0.6 хувийг 70 ба түүнээс дээш насны, 54.1 хувийг ажилгүй хүмүүс, 12.9 хувийг ажилчин, малчин, 9.1 хувийг тус тус хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 6.6 хувийг төрийн алба хаагч, 4.0 хувийг оюутан, 2.1 хувийг төрийн бус байгууллагын ажилтан, 2.0 хувийг сурагч, 0.1 хувийг сургууль завсардсан, тэнэмэл, хоригдол эзэлж байна.

Эмэгтэйчүүд гэмт хэрэг үйлдэх нь ахуйн хүрээний гэр бүлийн маргаан, архидалт, дарамт хүчирхийлэл, бусад хүчин зүйлүүдээс ихээхэн шалтгаалж, архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын бие махбодид гэмтэл учруулах, гэр бүлийн хүчирхийлэлд автсаны улмаас хүний амь нас, эрүүл мэндээр нь бусдыг хохироох явдал ч гарч байна.

Өрх толгойлсон, ажилгүй эмэгтэйчүүд их байгаагаас хулгайлах, хүмүүсийн хууль, эрх зүйн мэдлэг сул, итгэмтгий, шунахай байдлыг нь ашиглан итгэлийг нь эвдэх замаар залилангийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.

§7.3. Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг болон гэмт халдлагад өртсөн байдал

Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг 1076 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 486 хэргээр буюу 82,4 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 4.9 хувь болж, 1.8 нэгжээр тус тус өссөн.

№	Үзүүлэлт	2011	2012	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн хэрэг	590	1076	486	82.4
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	3.1	4.9	1.8 нэгжээр өссөн	

Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг Дархан-Уулд 43, Сэлэнгэд 41, Орхонд 38, Өвөрхангайд 34, Хөвсгөл, Хэнтийд тус бүр 30, Дорноговьд 25, Архангайд 23, Баянхонгор, Дорнодод тус бүр 21, Баян-Өлгий, Ховд, Өмнөговьд тус бүр 18, Увсад 15, Говь-Алтай, Булган, Завханд тус бүр 11, Төвд 10, Дундговь 4, нийслэлд 631, үүнээс Баянголд 129, Баянзүрхэд 116, Сонгинохайрханд 109, Чингэлтэйд 100, Сүхбаатарт 97, Хан-Уулд 50, Налайхад 20, Багануурт 10, бусад газарт 2 бүртгэгдсэн байна.

Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн 43.6 хувийг хулгайлах, 23.1 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 11.4 хувийг дээрэмдэх, 7.0 хувийг танхайрах, 2.9 хувийг хүчиндэх, 2.1 хувийг булаах, 3.8 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй

байдал, ашиглалтын журмын эсрэг, 1.2 хувь нь хүнийг санаатай алах, 1.6 хувийг залилан мэхлэх хэрэг тус тус эзэлж байна.

Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн хэргийн 30.9 хувь нь хөнгөн, 52.0 хувь нь хүндэвтэр, 14.4 хувь нь хүнд, 2.8 хувь нь онц хүнд ангиллын хэрэг, 31.1 хувь нь гэр, орон сууцанд, 25.7 хувь нь гудамж талбайд, 17.2 хувь нь олон нийтийн газарт, 6.0 хувь нь аж ахуйн нэгжид, 3.4 хувь нь төрийн бус байгууллагад, 3.2 хувь нь авто замд, 0.7 хувь нь төрийн байгууллагад, 0.9 хувь нь нийтийн тээвэрт, 11.7 хувь бусад газарт,

- 16.2 хувь нь даваа, 15.1 хувь нь мягмар, 13.8 хувь нь лхагва, 15.6 хувь нь пүрэв, 15.9 хувь нь баасан, 12.6 хувь нь бямба, 10.8 хувь нь ням гарагт,
- 16.8 хувь нь 06-14 цагт, 24.6 хувь нь 14-19 цагт, 17.1 хувь нь 19-22 цагт, 41.4 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.

Насанд хүрээгүй хүмүүс оролцсон 1076 хэрэгт **673** хүүхэд холбогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 1.3 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа ба 82 нь согтуугаар, 327 нь бүлэглэн, 18 нь урьд ял шийтгэгдсэн, 41 нь эмэгтэй, 313 нь сурагч, 69 нь оюутан, 24 нь сургууль завсардсан, 11 нь тэнэмэл амьдралтай, 198 буюу 29.4 хувь нь 14-15 насны, 475 буюу 70.6 хувь нь 16-17 насны хүүхэд байна.

Насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 130 хүн гэмтэж, иргэд, байгууллагад 74,3 сая төгрөгийн хохирол учирсан байна.

2012 онд гэмт хэргийн халдлагад 215 хүүхэд өртөж хохирсоны 3,8 хувь нь нас барж, 60,5 хувь нь гэмтсэн байна.

Насанд хүрээгүй хүүхдээс үйлдэгдэж байгаа гэмт хэргийн дийлэнхи буюу 43.6 хувийг хулгайн хэрэг эзлэж байгаа бөгөөд насны хувьд 70.6 хувь нь 16-17 настай хүүхдүүд эзлэж байгаа нь харагдаж байна.

Дээрхи нөхцөл байдлуудаас дүгнэхэд эцэг, эхчүүдийн зүгээс хүүхдэд тавих анхаарал сул, (чөлөөт цагаа хаана өнгөрүүлж байгааг мэддэггүй), гэр бүлийн таагүй орчин уур амьсгал, гэр бүл салалт, сургууль завсардалт, хэт их баян чинээлэг байдал (эцэг эх нь хүүхдэд байнга бэлэн мөнгө өгдөг), зэрэг хүчин зүйлүүд нь насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдэж байгаа гэмт хэргийн гол шалтгаан нөхцөл болж байна.

Хүүхдийг гэмт хэрэгт уруу татах, дарамт хүчирхийлэлд байлгах, гэмт хэргийн золиос болгох явдлын нөхцөл шалтгааныг судалж, түүнийг таслан зогсоох асуудлыг шийдвэрлэх.

Ядуурал, ажилгүйдлээс болж хүүхэд сургууль завсардах, гэмт хэрэгт холбогдож байгаа явдлыг бууруулах, сааруулахад чиглэсэн арга хэмжээ авах хараа хяналтгүй хүүхдийг асарч сувилян, тэдэнд боловсрол мэргэжил олгох, хүмүүжүүлэх цогцолбор сургууль, төв шинээр байгуулах, одоо ажиллаж буй сургууль төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг боловсруулах.

Ерөнхий боловсролын сургуульд хүмүүжил, ёс суртахуун, хууль эрхийн сургалт явуулж буй түвшинг сайжруулж, сургалтын агуулгыг өөрчлөх Эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн сургалт, семинар, уулзалт ярилцлагаар хүүхдийн хүмүүжил, уламжлалт ёс заншлыг сурган төлөвшүүлэх зэрэг сэдэвт асуудлуудыг хэлэлцэж зөвлөмж гарган түүнийг амьдралд хэрэгжүүлэн ажиллах.

§7.4. Гадаад улсын иргэд гэмт хэрэг үйлдсэн, гэмт халдлагад өртсөн байдал

Гадаад улсын иргэд гэмт хэрэг үйлдсэн байдал: Манай улсын нутаг дэвсгэрт гадаадын гадаадын **89 иргэн** гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 53.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Гадаадын 89 иргэний дотор БНХАУ-ын **46** (52.0%), БНСУ-ын **15** (16.8%), ОХУ-ын **13** (14.6%), Вьетнам улсын **6** (6.7%), Малайз улсын **2** (2.2%), Австрали, Турк, Филиппин, Чех, Япон, АНУ, ХБНГУ-ын тус бүр **1** (1.1%) иргэн байна.



Гадаадын иргэдээс бусдын биемахбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах хэрэгт **13**, хууль бусаар Монгол улсын хил нэвтрэх хэрэгт **12**, танхайрах хэрэгт **12**, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэгт **11**, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэгт **8**, татвар төлөхөөс зайлсхийх хэрэгт **6**, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэгт **4**, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэгт **3**, хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох хэрэгт **3**, хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших хэрэгт **2**, аюулгүй ажиллагааны журам зөрчих хэрэгт **2**, гадаадын иргэн харьяалалгүй хүн Монгол улсад оршин суух журам зөрчих хэрэгт **2**, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах хэрэгт **1**, бусдын бие махбодид хүндэтгэр гэмтэл санаатай учруулах хэрэгт **1**, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих хэрэгт **1**, алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших хэрэгт **1**, бусдын эд хөрөнгө санаатайгаар гэмтээх хэрэгт **1**, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи мансууруулах буюу хордуулах бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх хэрэгт **1**, галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих хэрэгт **1**, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах хэрэгт **1**, баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт устгах хэрэгт **1**, дураараа аашлах хэрэгт **1**, хээл хахууль өгөх хэрэгт гадаадын **1** иргэн тус тус холбогджээ.

Гадаад улсын иргэд гэмт халдлагад өртөж хохирсон байдал: Манай улсын нутаг дэвсгэрт гадаадын 21 орны **121** иргэн гэмт хэргийн халдлагад өртсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 9.0 хувиар өссөн байна. Дээрх иргэдийн **51** нь БНХАУ-ын, **17** нь БНСУ-ын, **15** нь ОХУ-ын, **9** нь АНУ-ын, **7** нь Вьетнам улсын, **3** нь тус бүр Япон, Австрали улсын, **2** нь тус бүр Швейцар, Испани улсын, **1** нь тус бүр Ангол, Индонез, Ирланд, Канад, Пакистан, Сингапур, Франц, Чех, Беларус, Мозамбик, Итали, Тайланд улсын иргэд байна.

Гадаадын иргэдээс гэмт халдлагад өртсөн тухай



Тэд бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэгт **36**, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэгт **18**, бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах хэрэгт **13**, танхайрах хэрэгт **11**, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэгт **10**, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих **10**, бусдын эд хөрөнгийг булаах хэрэгт **3**, хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших хэрэгт **3**, бусдын эд хөрөнгө санаатайгаар гэмтээх хэрэгт **2**, дураараа аашлах хэрэгт **2**, хууль бусаар Монгол улсын хил нэвтрэх хэрэгт **1**, хүнийг санаатай алах хэрэгт **1**, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэгт **1**, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах хэрэгт **1**, бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах хэрэгт **1**, хүчиндэх хэрэгт **1**, бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх хэрэгт **1**, бусдын эд хөрөнгийг завших хэрэгт **1**, алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших хэрэгт **1**, нотариатч, эрхийн улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих хэрэгт **1**, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэгт **1**, хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх хэрэгт **1**, гадаадын иргэн харьяалалгүй хүн Монгол улсад оршин суух журам зөрчих хэргийн улмаас тус бүр гадаадын **1** иргэн тус тус хохирсон байна.

§7.5. Урьд ял шийтгэгдсэн болон захиргааны хяналтад байгаа хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал

Улсын хэмжээнд 2012 онд урьд ял шийтгэгдсэн 900 хүн гэмт хэрэгт холбогдсон нь өмнөх оныхоос 94 нэгжээр буюу 10.4 хувиар, нийт гэмт хэрэг үйлдсэн хүмүүст эзлэх хувийн жин 4.6 хувь болж 0.9 нэгжээр тус тус буурчээ.

Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс Багануурт 46, Налайхад 26, Баянзүрхэд 57, Сүхбаатар дүүрэгт 60, Чингэлтэйд 74, Баянголд 146, Хан-Уулд 60, Сонгинохайрханд 74, Дорнодод 24, Хэнтийд 43, Говьсүмбэрт 8, Төв аймагт 9, Сэлэнгэ 52, Дорноговьд 24, Дархан-Уулд 42, Өмнөговьд 10, Орхонд 23, Өвөрхангайд 9, Булганд 14, Баянхонгор 12, Архангайд 27, Хөвсгөлд 15, Завханд 6, Говь-Алтайд 1, Баян-Өлгийд 16, Ховдод 12, Увсад 2, Дундговь, Сүхбаатарт 1, бусад газар 21 хүн хэрэг үйлдсэн байна. Эдгээр хүмүүсийн 27 нь буюу 3.0 хувь нь 18 насанд хүрээгүй, 48 нь буюу 5.3 хувь нь эмэгтэй хүн, 248 нь буюу 27.5 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна.

Дахин гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг боловсролоор нь авч үзвэл боловсролгүй 68, бага боловсролтой 152, бүрэн бус дунд боловсролтой 338, бүрэн дунд боловсролтой 271, тусгай дунд боловсролтой 18, дээд боловсрол эзэмшсэн 53 хүн байна.

Нийгмийн байдлаар нь авч үзвэл 652 хүн буюу 72.4 хувь нь гэмт хэрэг үйлдэх үедээ эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс байсны дээр сургууль завсардсан 1, тэнэмэл 17, хоригдол 22, малчин нэртэй гэмт хэрэг үйлдэж яваа 45 хүнийг нэмэх юм бол 737 болж 81.8 хувийг эзэлж байна.

Гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгэгдсэн, өршөөгдсөн, хорихоос суллагдсан хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж байна. Иймд Хорихоос суллагдсан хүмүүст тавих хяналтаа тогтмолжуулж, тэднийг нийгэмшүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах. Хорихоос суллагдсан, захиргааны хяналтад байгаа, хэрэг зөрчилд орж болзошгүй хүмүүстэй ажиллах ажлыг төр захиргааны байгууллагатай хамтран шинэлэг байдлаар зохион байгуулах, тэднийг нийгэмшүүлэх, ажил, мэргэжилтэй болгох, амьдралд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр тодорхой дорвитой ажил хийх нь зүйтэй.

Захиргааны хяналтад байсан хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал: Улсын хэмжээнд 2012 онд захиргааны хяналтад байсан 71 хүн гэмт хэрэг дахин үйлдэж, өмнөх оныхоос 10.9 хувиар өсчээ. Тодруулбал, өмнө нь гэмт хэрэг үйлдээд суллагдсаны дараа буюу ял хойшлогдон захиргааны хяналтад байх хугацаанд дахин гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд байна. Захиргааны хяналтад байгаа хүмүүсийн 39 нь бусдын эд хөрөнгийг хулгайлах, 9 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 5 нь танхайрах, 3 нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, 4 нь бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, 2 нь залилан мэхлэх, хүчиндэх, булаах тус бүр 1, 8 нь бусад төрлийн гэмт хэрэг үйлджээ.

Захиргааны хяналтад байгаа хүмүүст тавих хяналт үр дүнтэй хэрэгжихгүй байгаад анхаарах шаардлагатай байна.

ХОЁР. ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Монгол Улсад 2012 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Иргэдээс цагдаагийн байгууллагад хандаж 2012 онд гэмт хэрэг, зөрчлийн талаарх **141276** гомдол, мэдээлэл ирүүлсэн нь өмнөх оныхоос 9.8 хувиар өсчээ.

Үүнд нийгэм дэх ажилгүйдэл, архидалт, ядуурал, хүн амын орлого, амьжиргааны түвшин, шилжилт хөдөлгөөн, төвлөрөл, шудрага бус явдал, хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт, зарим иргэдийн ухамсар, ёс зүй, төлөвшил, хүмүүжил, эрх зүйн зүйн мэдлэг зэрэг нийгэм, эдийн засгийн шинжтэй олон хүчин зүйлс нөлөөлж байна.

Нөгөө талаас цагдаагийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт явдалтай тэмцэх ажлын хэрэгжилт эрчимжсэн, түүний дотор цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээгээ иргэд олон нийтэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байгаатай холбоотой гэж үзэж байна.

2. Улсын хэмжээнд 2012 онд 22089 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 15.1 хувь, нийслэлийн хэмжээнд 12910 бүртгэгдсэн нь 19.8 хувиар тус тус өсчээ.

➤ Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн:

- 29.6 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 28.4 хувийг хулгайлах,
- 7.6 хувийг танхайрах,
- 5.6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 5.0 хувийг залилан мэхлэх,
- 2.5 хувийг дээрэмдэх,
- 1.4 хувийг хүчиндэх,
- 1.2 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх,
- 1.0 хувийг хүнийг санаатай алах,
- 0.8 хувийг булаах төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг өмнөх оныхоос өссөн ч бусдыг болгоомжгүй алах, жолоогоо бусдад шилжүүлэх, хүчиндэх, хээл хахууль авах, өгөх, хүнийг санаатай алах, танхайрах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих хэргүүд буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь тухайн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, үйл явцтай холбоотой байдаг бөгөөд судлаачдын тогтоосноор гэмт хэргийн гаралтад 300 орчим хүчин зүйл нөлөөлдөг байна.

Манай улсын хувьд ажилгүйдэл, архидалт, ядуурал, хүн амын шилжилт хөдөлгөөн, мөнгөний инфляци, иргэдийн бүртгэлд тавих хяналт сул, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хандлага, сэтгэлгээ иргэдийн дунд төлөвшөөгүй байгаа зэрэг нь гэмт хэргийн нөхцөл байдалд гол нөлөө үзүүлж байна.

3. Хүн амын төвлөрөл, суурьшлаас хамаарч бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 58.4 хувь нь нийслэл хотод үйлдэгджээ. Энэ статистик үзүүлэлтээс дүгнэхэд улсын хэмжээний гэмт хэргийн нөхцөл байдлыг тодорхойлоход хүн ам ихээр төвлөрч суурьшсан нийслэл хотын эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал нөлөөлж байна

➤ Нийслэл хотод бүртгэгдсэн нийт 12910 гэмт хэргийн:

- 21.2 хувь нь Баянзүрх,
- 18.4 хувь нь Баянгол,
- 16.5 хувь нь Сонгинохайрхан,
- 16.2 хувь нь Сүхбаатар,
- 14.0 хувь нь Чингэлтэй,
- 9.1 хувь нь Хан-Уул,
- 2.3 хувь нь Налайх,
- 2.1 хувь нь Багануур,
- 0.2 хувь нь Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна.

➤ Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн:

- 40.9 хувь нь аймгуудад,
- 0.4 хувь нь төмөр замын салбарт,
- 0.1 хувь нь иргэний агаарын тээврийн салбарт,
- 0.2 хувь нь бусад газарт тус тус бүртгэгджээ.

Цагдаагийн байгууллагын хүн хүч, техник хэрэгсэл, шатахууны хүрэлцээ шаардлагын түвшинд хүрэхгүй байгаагаас нийслэлийн гудамж талбайг цагдаагийн эргүүлийн бүрэн хяналтанд авч чадахгүй байгаа явдал нь нийслэлийн хэмжээний гэмт хэргийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байгаа нэг хүчин зүйл болж байна.

Гэхдээ төр, засаг болон нутгийн захиргааны байгууллагаас нийслэл болон зарим аймгуудын нутаг дэвсгэрт хөдөлгөөнт эргүүл, камерын хяналтын системийг ажиллуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байгаа нь гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдэгдсэн үед гэмт этгээдийг халуун мөрөөр нь олж тогтоох ажилд ахиц, дэвшилттэй ажил болж байна.

Иймд аймаг орон нутаг дахь хүн ам төвлөрсөн суурин газруудад хөдөлгөөнт эргүүл, камерын хяналтын системийг өргөжүүлэхэд анхаарал хандуулж ажиллах нь илүү үр дүн өгөх юм.

Нийслэл Улаанбаатар хотын гэмт хэргийн нөхцөл байдлыг онцгой анхаарч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь улсын хэмжээний эрүүгийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц эерэг өөрчлөлт гарна гэж үзэж байна.

4. 2012 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй **8140** гэмт хэрэг бүртгэгдсэний 56.3 хувийг илрүүлсэн нь өмнөх оныхоос 5.2 хувиар, нийслэлийн хэмжээнд 51.7 хувьтай байгаа нь өмнөх оныхоос 7.1 хувиар тус тус буурсан байна.

Энэ нь гэмт хэрэг, зөрчлийн талаархи гомдол, мэдээлэл нэмэгдсэн, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өссөн зэрэг олон хүчин зүйлс, нөгөө талаас байгууллага, алба хаагчдын үйл ажиллагааны ажлын чанар, үйлчилгээний хүртээмж, бүртгэл, судалгааны ажилтай холбоотой гэж үзэж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэргийн илрүүлэлт 2012 оны жилийн эцсийн байдлаар улсын дундаж үзүүлэлтээс доогуур байгаа Завхан, Булган, Дорноговь аймаг, Төв аймгийн Заамар сум дахь сум дундын цагдаагийн газар, хэлтэс болон нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1, 2, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 2, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1 дүгээр, иргэний агаарын тээврийн цагдаагийн газар, хэлтсүүд үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт хийж, гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах, түүнд төрөл мэргэжлийн албадын хүчийг оновчтой зохион байгуулах, жигд ажиллагааг хангаж ажиллах шаардлагатай байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 89.0 хувийг хөнгөн, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг эзэлж байхад илрүүлэлт нь дунджаар 54.8 хувьтай байгаа нь эдгээр ангиллын гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтэнд анхаарч, төв, орон нутгийн цагдаагийн

газар, хэлтсийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлж, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хөдөлмөр зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, боловсронгуй болгоход үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

5. Статистик үзүүлэлтээр улсын хэмжээнд бүртгэгдэж байгаа нийт гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн эзлэх жин зонхилох хувийг эзэлж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт, хохирлын хэмжээ төдийлөн буурахгүй, өсөх хандлагатай байна. Тухайлбал:

Д/д	Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012
1	Бүртгэгдсэн нийт хэрэг	20704	20373	19825	19197	22089
2	Хулгайлах хэрэг	3289	6376	5777	5276	6266
3	Эзлэх хувь	15.9	31.2	29.1	27.5	28.4
4	Нийт хэрэгт эзлэх хувийн өсөлт, бууралт		+15.3	-2.1	-1.6	+0.9

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд цагдаагийн төрөл мэргэжлийн албадын хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулж, урьд үйлдэгдээд гэмт этгээд нь тогтоогдоогүй хүнд, онц хүнд, их хэмжээний хохиролтой хэргүүдийн эзэн холбогдогчийг олж илрүүлэх, хулгайн гэмт хэрэг үйлддэг бүлгүүд, тэдний хань харилцааг тогтоож хяналтанд авах, гэмт үйлдлийг нь таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнд хүргэхэд цагдаагийн шат шатны байгууллага, алба хаагч бүрийн анхаарал, хүчийг төвлөрүүлэн ажиллах нь чухал байна.

6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт 19734 хүн холбогдон шалгагдсаны:

- 52.7 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй,
- 24.3 хувь нь гэмт хэргийг согтуугаар үйлдсэн,
- 19.9 хувь нь гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэсэн,
- 4.6 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс тус тус эзэлж байна.

➤ Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн:

- 2 хүн тутмын нэг нь эрхэлсэн тодорхой ажилгүй,
- 4 хүн тутмын нэг нь гэмт хэргийг согтуугаар үйлдсэн,
- 22 хүн тутмын нэг нь урьд ял шийтгэгдэж байсан хүмүүс эзэлж байна.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос 2013 оны 01 дүгээр сард гаргасан мэдээгээр манай улсад албан ёсоор бүртгэлтэй эрхэлсэн ажилгүй иргэдийн тоо 37.2 мянга болж, 2012 оны жилийн эцсийнхээс 4.0 хувь өссөн байна. Бүртгэлтэй эрхэлсэн ажилгүй иргэдийн 19.2 мянга буюу 51.7 хувийг эмэгтэй, 21.6 мянга буюу 58.2 хувийг 15-34 насны нийгэмд байр сууриа бэхжүүлэх, боловсрол эзэмших, хөдөлмөрийн үр шимийг хүртэх насны хүмүүс байна.

Статистик мэдээний дээрх үзүүлэлтүүд нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд архидалт, ажилгүйдэл, ядуурлын түвшин нөлөөлж байгааг харуулж байна.

7. Зах зээлд нийлүүлэгдэж буй архи, согтууруулах ундааны хэмжээ, түүний хэрэглээ нэмэгдэж, архидалт согтуурах явдал нийгмийн түгээмэл үзэгдэл болсон нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэгдэх суурь шалтгаан, нөхцөл болж байна.

Хүн амын төвлөрөл, ажилгүйдэл, ядуурал, хүмүүсийн төлөвшил, хүмүүжил, ёс суртахуун, гэр бүлийн орчин, найз нөхдийн харилцаа зэргээс шалтгаалан архидалт согтуурах

явдал нийгэмд газар авч, архины хэрэглээ, түүнээс улбаалан гарах сөрөг үр дагавар, хор уршиг жил ирэх тутам нэмэгдэх хандлагатай байна.

Тухайлбал бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 23.0 хувь,

- хүнийг санаатай алах гэмт хэргийн 73.5 хувь,
- танхайрах гэмт хэргийн 57.3 хувь,
- хүчиндэх гэмт хэргийн 52.1 хувь,
- бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 37.9 хувь,
- тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 23.8 хувь,
- дээрэмдэх гэмт хэргийн 23.6 хувь,
- зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн 16.1 хувь нь тус тус согтуугаар үйлдэгдсэн байна.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчил гаргасны улмаас 118030 хүн эрүүлжүүлсэн нь өмнөх оныхоос 2.3 хувиар өссөн байна.

➤ Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн:

- 50.4 хувь нь нийслэлд,
- 47.3 хувь нь аймгуудад байна.

Тэдгээрийн :

- 74415 буюу 63.0 хувь нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан,
- 14569 буюу 12.3 хувь нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон,
- 10432 буюу 8.8 хувь нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас биеэ авч явах чадваргүй болсон,
- 10146 буюу 8.6 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон,
- 7100 буюу 6.1 хувь нь гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй,
- 1368 буюу 1.2 хувь нь гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй байсаны улмаас тус тус эрүүлжүүлэгджээ.

Цаашид архи дан согтуурах явдалтай тэмцэх ажлын хүрээнд архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортын хэмжээ, худалдаж борлуулдаг, үйлчилдэг газар, цэгүүдийн тоог зохистой түвшинд хүртэл бууруулах, архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхийн хор уршигийг иргэд олон нийтэд ойлгуулан ухамсарлуулах, энэ чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх нь нэн чухал байна.

8. Гадаадын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэх явдал өсөх чиг хандлагатай байна.

➤ Манай улсын нутаг дэвсгэрт 2012 оны байдлаар 80 эрүүгийн хэрэгт гадаадын 89 иргэн холбогдон шалгагдсаны:

- 46 нь БНХАУ-ын,
- 15 нь БНСУ-ын,
- 13 нь ОХУ-ын,
- 6 нь Вьетнам улсын,
- 2 нь Малайз улсын,
- Австрали, Турк, Филиппин, Чех, Япон, АНУ, ХБНГУ-ын тус бүр 1 иргэн байна.

Манай улсад тодорхой эрхэлсэн ажилгүй, орлогогүй хүмүүс цөөнгүй, ажлын байр ховор байгаа байдал, иргэдийн гадаадад ажиллаж, суралцан амьдрах гэсэн хүсэл зэргийг ашиглан гадаадын иргэд манай иргэдийн их хэмжээний мөнгө, эд зүйлсийг залилж авах, сэтгэл зүйн дарамт үзүүлэх, хүч, хөдөлмөрийг нь мөлжих, биеийг нь үнэлүүлэх, худалдах зэргээр гэмт хэрэг үйлдэх явдал гарч байна.

Иймд төрийн эрх бүхий шат шатны байгууллагуудын зүгээс гадаадын байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд тавих хяналт, бүртгэл судалгааг сайжруулах шаардлагатай байна.

9. Гэмт хэргийн улмаас нийгэм, ард иргэдэд учирч буй хор хохирол жилээс жилд нэмэгдэж, байнга өсөх хандлагатай байна.

➤ Гэмт хэргийн халдлагад:

- 21294 иргэн,
- 167 байгууллага, аж ахуйн нэгж өртөж,
- гэмт хэргийн улмаас 53.3 тэрбум төгрөгний хохирол учирсан,
- өмнөх оныхоос 48.3 хувиар өссөн байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирол нөхөн төлүүлэх, нуугдмал хөрөнгийг илрүүлж битүүмжлэх ажиллагаа шаардлагын түвшинд хүрэхгүй байна. 2012 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 25.1 тэрбум төгрөг буюу 47.2 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байх ба нөхөн төлүүлэлт өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар буурсан байна.

Гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрх ашиг нь зөрчигдөж хохирсон иргэн нь гэмт этгээдэд хариуцлага тооцуулах гэхээсээ илүү өөрт учирсан хохирлыг нөхөн барагдуулах сонирхолтой байна. Иймд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирлыг төлүүлэх, тэдний нэхэмжлэлийг бүрэн хангах боломжтой байцаан шийтгэх ажиллагааны бүхий л ажиллагааг шуурхай, бүрэн явуулж байх шаардлагатай байна.

➤ Гэмт хэргийн улмаас:

- 901 хүн нас барж,
- 8436 хүн гэмтсэн,
- өмнөх оныхоос нас барсан хүний тоо 2.3 хувиар буурч,
- гэмтсэн хүний тоо 4.1 хувиар өссөн байх ба цаашид хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох ажиллагааг эрчимжүүлж ажиллах хэрэгтэй байна.

10. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2012 онд 795923 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 21.8 хувиар өссөн.

➤ Зөрчил гаргасан 751571 иргэн,

- 46 албан тушаалтан,
- 1700 аж ахуйн нэгж, байгууллагыг 4.6 тэрбум төгрөгөөр торгож,
- 28718 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах,
- 13888 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

➤ Үйлдэгдсэн бүх зөрчлийн:

- 49.1 хувь нь Замын цагдаагийн газрын хариуцсан чиг үүрэгт хамаарах салбарт,
- 33.0 хувь нь аймгуудад,
- 13.0 хувь нь нийслэлийн дүүргүүдэд,
- 3.7 хувь нь хөдөлгөөнт эргүүлийн хариуцсан нутаг дэвсгэрт,
- 0.8 хувь нь төмөр замын салбарт,
- 0.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгох, энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цагдаагийн шат шатны байгууллага санал, санаачилгатай ажиллах нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд үр дүн өгнө гэж үзэж байна.

ГУРАВ. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТӨВ, ОРОН НУТГИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГӨХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Цагдаагийн төв байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр:

- Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлын аргачлал, стандарт, журмыг боловсронгуй болгох асуудлыг судалж хэрэгжүүлэх;
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, идэвх санаачлагыг нь дээшлүүлэх, өрнүүлэх, гадаад орны цагдаагийн байгууллагын туршлагыг судалж нэвтрүүлэхтэй холбоотой арга хэмжээ зохион байгуулах;
- Засаг захиргааны анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, цагдаа нарыг албаны хэрэгцээнд нь зайлшгүй шаардлагатай автомашин, холбооны хэрэгсэл, нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгслээр хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй хүн амын эрүүл мэндийн эсрэг болон байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх ажилд хууль сахиулах бусад болон мэргэжлийн хяналт, нутгийн захиргааны байгууллагуудын хүч туслалцааг авч хамтран ажиллах, энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээллийн нэгдсэн санг бий болгож, байгууллага, алба хаагчдыг шаардлагатай мэдээллээр шуурхай хангаж байх;
- Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх;
- Албаны сургалтын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгож, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, стандартын хэрэгжилтийг хангаж, үр дүнг дээшлүүлэх талаар холбогдох ажлыг зохион байгуулах;
- Цагдаагийн байгууллагын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, үнэлэмжийг нэмэгдүүлэх бодлого баримталж, урьдчилан сэргийлэх ажлыг түлхүү зохион байгуулах;
- Криминологи судалгааны орчин үеийн шинэлэг арга хэлбэр болох гэмт хэргийн цахим зураглалын мэдээллийн систем нэвтрүүлж, иргэд, олон нийтэд гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг энгийн ойлгомжтой байдлаар хүргэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх үүднээс Монгол Улсад гэмт хэргийн цахим зураглалын мэдээллийн систем (*crime mapping*) нэвтрүүлэх;

Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах, Хэрэг бүртгэх албадын чиглэлээр:

- Иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаархи гомдол, мэдээлэл бүрийг шалгах ажиллагааны явцад холбогдох маягтуудын дагуу мэдээллийг “цаг хугацаанд нь, үнэн зөв, бүрэн гүйцэд” санд оруулж хэвших;
- Хүний амь нас хохирох, бусдын эд хөрөнгийг хулгайлах, байгалийн баялаг дагасан хууль бус ажиллагаа, банк санхүү-эдийн засаг (брокер диллер, хувьцаа, мөнгө угаах, хөрөнгө оруулалт, зээл, тусламж, төслийн цаад эх сурвалжийг тодорхойлох), биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүн худалдаалах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, цахим (кибер) гэмт хэрэгтэй тэмцэх алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх;
- Түүх соёлын хосгүй, үнэт зүйлийг гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран тэдгээрийг бүртгэлжүүлэн нэгдсэн сан бий болгох, энэ талаар бие бүрэлдэхүүнд гарын авлага, зөвлөмж гарган хүргүүлэх;

- Улсын хилээр хууль бусаар эд зүйл нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагатай харилцан мэдээ, мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
- Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа хийж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх арга хэмжээг банк, татварын болон сангийн яам, нутгийн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх ажилтнуудыг чадавхжуулж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг үр дүнтэй явуулах, хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
- Хулгайгаар мод тээвэрлэгчдын зам, маршрутыг тогтоож эргүүл шалгалтыг оновчтой зохион байгуулах, мод, модон материалын захуудын үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалтыг тогтмол явуулж, түүний эх сурвалжийг тогтоох;

Нийгмийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр:

- Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил олноор, давтамжтай үйлдэгдэж байгаа газруудад хэв журмын эргүүлийг оновчтой зохион байгуулж байх;
- Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад хугацаа алдалгүй, түргэн шуурхай мэдээлэх нь иргэний үүрэг, хариуцлага болох, түүний ач холбогдлын талаар иргэдэд сурталчлан таниуццуулж байх;
- Гэмт хэргийн халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийн талаарх мэдээлэл, сэрэмжлүүлгийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлыг тогтмолжуулж, сурталчилгааны хуудас, санамжийг олон нийтийн газар, албан байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд тогтмол шинэчлэн байршуулан баяжилт хийж байх;
- Архидан согтуурснаас үүсэх хор уршиг, ялангуяа хүний бие эрхтэн, ахуй амьдралд хэрхэн нөлөөлж, ямар хор уршиг учруулах талаар ухуулга сурталчилгаа хийх;
- Хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн этгээдүүдэд тавих захиргааны хяналтыг үр дүнтэй тогтоох, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй хүмүүс, архинаас хамааралтай хүнтэй ажиллах арга барилд өөрчлөлт хийж, хамт олон, гэр бүлийн хяналт, дэмжлэгт тулгуурлан цаашид гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байхад нөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах;
- Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлийн холбогдогч, хохирогч болохоос урьдчилан сэргийлж, сэрэмжлүүлэх чиглэлийн мэдээллийг олон нийтэд тогтмол сурталчилах;
- Эд хөрөнгө, эд зүйлээ алдахаас урьдчилан сэргийлж сонор сэрэмжтэй байх талаар санамж сэрэмжлүүлэг иргэдэд өгөх;

Замын цагдаагийн албаны чиглэлээр:

- Жолооч бэлтгэх сургууль, дамжааны сургалтын чанарыг дээшлүүлэх, түүнд тавих хяналтыг үр дүнтэй болгох замаар жолоочийн үүрэг, хариуцлага, ур чадвар, хөдөлгөөнд оролцох соёлыг дээшлүүлэх;
- Замын хөдөлгөөний дүрэм зөрчигчдөд хариуцлага тооцох арга хэмжээг үр нөлөөтэй авч хэрэгжүүлэх;
- Хуурамч жолооны үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодох, тээврийн хэрэгслийн дугаар сольж хөдөлгөөнд оролцох зэрэг хууль бус үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

- Зам тээврийн осол, хэргийн тодорхой хувь нь явган зорчигчийн буруугаас болдог тул явган зорчигчийг хөдөлгөөнд зөв, соёлтой, дүрмийн дагуу оролцуулахад нөлөөлөхөөр ажлыг зохион байгуулах;

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр:

- Гудамж талбай, олон нийтийн газар, гэр хорооллын гудамжуудыг хяналтад авах зорилгоор камержуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж зохих байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэн байгууллага, аж ахуйн нэгж бүрийг гадна, дотно талыг камержуулах ажлыг өргөжүүлэх;

- Төвөөс алслагдсан гэр хорооллын гудамж, байр, орон сууцны гаднах орчин, орц, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдийг байнгын гэрэлтүүлэгтэй болгох ажлыг нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

- Орон нутагт, ялангуяа хөдөө суманд үйлдэгдсэн гэмт хэргийн 70 гаруй хувийг бусдыг эд хөрөнгийг хулгайлах, үүний дотор мал хулгайлах болон бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхайрах гэмт хэрэг эзэлж байгаа тул түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, энэ ажилд иргэдийн олон нийтийг оролцоог нэмэгдүүлэх, тэднийг татан оролцуулж байх;

- Иргэдийн идэвхи санаачлагыг өрнүүлэн архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг тууштай, үр дүнтэй өрнүүлэх, байнгын архидан согтуурдаг, архаг архичдыг орон нутагт нь албадан эмчилгээнд хамруулах, шаардагдах зардал хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгуулж байх, архи, согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ явуулдаг газруудад тавих хяналтыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж байх;

- “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг үр дүнтэй зохион байгуулах;

- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах;

- Хорихоос суллагдсан, захиргааны хяналтад байгаа, хэрэг зөрчилд орж болзошгүй хүмүүстэй ажиллах арга хэмжээг төр захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах.

МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГААНЫ ТӨВ